

Г.Нандинбилиг, Д.Нямдорж, П.Одсүрэн,  
Д.Туяа, С.Хөвсгөл, Д.Цэвээндорж

# УРАН ЗОХИОЛ

## VII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн  
7 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын  
Яамны зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2019 он

ДАА 373  
ННА 74.2  
У-457

Уран зохиол VII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 7 дугаар ангийн сурах бичиг. /Нандинбилиг Г., ба бусад; Ред Норжинлхам С. УБ. 2018, 148 х.

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99978-61-80-1



## ГАРЧИГ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ АМАН ЗОХИОЛ

1.1. МАГТААЛ.....	8
Хангайн магтаал .....	9
Таван хошуу малын магтаал.....	12
Эмээлийн магтаал .....	15
Даахины ерөөл.....	17
1.2. ТҮҮХЭН ДОМОГ .....	23
Хорь түмэд, Хоридай мэргэний түүхэн домог .....	24
Халхын дөрвөн хан цол авсан түүхэн домог .....	27
Мэргэн Жа гүний түүхэн домог .....	31
Арвайхээрийн түүхэн домог .....	34

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ

2.1. ТУУРЬ.....	40
Б.Ринчен “Шүхэрч Буниа” .....	41
Л.Түдэв “Эрээн цоохор” .....	48
Ц.Түмэнбаяр “Цагаан сүүний домог” .....	54
2.2. ӨГҮҮЛЛЭГ.....	58
Д.Нацагдорж “Хуучин хүү” .....	58
Г.Мэнд-Ооёо “Нутаг гүйсэн унаганы дууль” .....	62
П.Пүрэвсүрэн “Бурханбогд аав хоёр” .....	66

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ ЯРУУ НАЙРАГ

3.1. СУРГААЛЫН ШҮЛЭГ .....	74
Чингис хааны билиг .....	74
Оюунтүлхүүр .....	78
3.2. УЯНГЫН ШҮЛЭГ .....	83
Д.Нацагдорж “Миний нутаг” .....	83
Д.Пүрэвдорж “Чингис” .....	87
Т.Галсан “Жирмийн сүлжээ” .....	90
Д.Цоодол “Харамчийнхны дууль” .....	93
Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана” .....	96
Д.Сумьяа “Монгол шагай” .....	98
3.3. НАЙРАГЛАЛ .....	102
Ц.Дамдинсүрэн “Зугаацахаар мордсон нь” .....	102
Д.Цэвэгмид “Алагдай аварга” .....	105

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАДААДЫН УРАН ЗОХИОЛ**

4.1. ДОРНЫН УРАН ЗОХИОЛ .....	112
Ү Чэнь-энь “Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” .....	113
Я.Кавабата “Ангийн даргын мөрдлөг” .....	118
4.2. ӨРНИЙН УРАН ЗОХИОЛ.....	125
Э.Хэмингуэй “Өвгөн тэнгис хоёр” .....	125
Ж.К.Роулин “Харри Поттер” .....	136
<b>Ном зүй .....</b>	<b>148</b>



Бичих	Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүр, дүрслэлийн талаарх мэдрэмж, сэтгэгдлээ бичихдээ уран дүрслэл ашиглах		+	+	+	+	+	+	+
	Хүн, юмс, үзэгдлийн гадаад мөн чанарыг дүрслэн магтах, сайн сайхныг хүсэн ерөөх туршлагаас суралцаж шүлэглэх	+						+	
	Зохиолд дүр, орчин нэмэх, харилцан яриа оруулах замаар дэлгэрүүлж бичих				+				+
Ярих	Зохиолын дүрийн талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл, жишээ баримт, эшлэл ашиглан сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярих	+	+	+		+		+	+
	Зохиолын гол санаа, дүрийн зан төрхийг ойлгож мэдэрснээ дүр бүтээж харуулах			+	+			+	
	Шүлэг зохиолоос сонгон цээжилж, дуу хоолойн өнгө, аялга, хэмнэл, биеийн хөдөлгөөн тохируулан уран унших		+	+	+	+		+	+

## Таних тэмдэг



Уншихын өмнө



Унших чадвараа хөгжүүлье



Бичих чадвараа хөгжүүлье



Ярих чадвараа хөгжүүлье

# I БҮЛЭГ

## МОНГОЛ АМАН ЗОХИОЛ

### Судлах эх зохиол:

#### 1.1 МАГТААЛ

- Хангайн магтаал
- Таван хошуу малын магтаал
- Эмээлийн магтаал
- Даахины ерөөл

#### 1.2 ТҮҮХЭН ДОМОГ

- Хорь түмэд, Хоридай мэргэний түүхэн домог
- Халхын дөрвөн хан цол авсан түүхэн домог
- Мэргэн Жа гүний түүхэн домог
- Арвайхээрийн түүхэн домог

### Эзэмших чадвар:

#### УНШИХ

- Аман зохиолыг мэдэрч ойлгох, тусган хүлээж авах
- Монгол аман зохиолын төрөл зүйлд хэл найруулга, орчин, дүр, сэдэв, утгын задлал хийх
- Эх нутаг, байгаль, газар шороогоо хайрлан хамгаалах, түүх, ёс заншлын үнэ цэнийг ойлгож, хүндэтгэх

#### БИЧИХ

- Аман зохиолын хэлний хэрэглээ, дүр, дүрслэлийн талаар мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлж бичих
- Хүн, юмс, үзэгдлийн гадаад мөн чанарыг дүрслэн бичих, сайн сайхныг магтан ерөөх аман яруу найргийн туршлагаас суралцаж шүлэг бичих

#### ЯРИХ

- Ерөөл магтаалаас сонгон цээжилж, дуу хоолойн өнгө, аялга, хэмнэл, намба тохируулан ерөөж, магтаж сурах

## 1.1 МАГТААЛ



Уншихын өмнө

1. Хангай ханы зургийг ажиглаад, даалгаврыг гүйцэтгээрэй.



Эх сурвалж: budda.mn

1. Зураг дээр зонхилж буй гурван өнгийг нэрлэнэ үү.

2. Зураг дээрээ гэрэлтдэг цаас тавиад энэ гурван гол өнгийг хүрээлж зураарай. Ямар сэтгэгдэл төрж байна вэ? Хариултыг бичихдээ "халуун өнгө, сэрүүн өнгө, зонхилох зураас" гэх мэт үгсийг ашиглаарай.

3. "Хангай ханы хүдэр баян загал уул сүүмэлзэн харагдаад..." гэсэн дүрслэлээс үндэслэн Хангай ханыг алсаас харж байна гэж

төсөөлнө үү. Дараа нь холоос харсаар ойртож байна гэж төсөөлнө үү. Юу төсөөлөгдөж байгааг ярилцаарай.

4. Хангай ханыг Монгол Улсын газрын зургаас олж хаана байрлаж байгааг ярилцаарай.
5. Дараах ойлголтыг уншаад Хангай ханы магтаалаар баталж ярилцаарай.

Магтаалд орон зайн дүрслэлийн гурван хэлбэр байна. Үүнд:

1. Дээрээс доош дүрслэх
2. Баруунаас зүүн тийш дүрслэх
3. Холоос ойртуулан дүрслэх

Монгол магтаалчид магтан буй уул усаа ертөнцийн дөрвөн зүг, найман зовхисоос харж буй байдлаар, эсвэл сансар огторгуйгаас буюу дээрээс дорогш харсан чигт дүрслэн, байгаль дэлхийн үзэмжийг нь магтан дуулдаг.



Унших чадвараа хөгжүүлье

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя**

1. Магтаалыг унших явцдаа мэдэхгүй үг, хэллэгийг тэмдэглээд "Монгол хэлний их тайлбар толь" ашиглан утгыг мэдэж аваарай.
2. "Хангайн магтаал"-ыг бичлэгээс сонсоод магтаал хэлэх аргад суралцаарай.

## ХАНГАЙН МАГТААЛ

Хангай ханы  
 Хүдэр хүрэн баян  
 Загал уул нь сүүмэлзэн харагдаад  
 Хавцал эх бүрээс нь  
 Мөрөн далай голын ус нь  
 Цэлэлзэн урсаад байна гэдэг маань  
 Ердөө л өлзийтэйхэн Хангай чинь  
 Манай лаа Идэр, Тэрхийн  
 Өвгөн буурал, баян Хангай  
 Нутаг минь ээ!

Өрөөлдөөд тавьсан моринд нь  
 Өлөн боргоор элбэгтэйхэн  
 Өнчин буурай амьтандаа  
 Өршөөлтэйхэн Хангай чинь  
 Манай лаа Идэр, Тэрхийн  
 Өвгөн буурал, баян Хангай  
 Нутаг минь ээ!

Хангай ханы  
Гундаа шар нуруунд  
Барин түшин гарвал даа  
 Гурван тохой  
 Хурц тоорой мод нь  
 Дөрөө зуран  
 Шаагин ганхаад  
 Гурвалжин зоотой  
 Бор халзан туулайг чинь  
 Гунан хар бүргэд нь  
 Аван барин шүүрэн байна гэдэг маань  
 Ердөө л өлзийтэйхэн Хангай чинь  
 Манай лаа Идэр, Тэрхийн  
 Өвгөн буурал, баян Хангай  
 Нутаг минь ээ!

Хангай ханы  
Харанхуй хар модондоо  
Барин түшин орон очвол  
 Ханцуйтай гарын чинээ  
 Хар халиун хэрэм нь  
 Халин дүүлээд  
 Халиун цагаан буга нь харайлдаад л  
 Харцгаа түрэн урамдаад  
 Минжийн олон согоогоо дагуулав гэлээ  
 Ийм л сайхан Хангай чинь  
 Манай лаа Идэр, Тэрхийн  
 Өвгөн буурал, баян Хангай  
 Нутаг минь ээ!

Хангай ханы  
Баруун талыг нь  
Барин түшин гарвал даа  
 Бар, ирвэс, баавгай, шилүүс нь  
 Бархиралдан ноцолдоод л  
Зүүхэн талыг нь  
Барин түшин гарвал даа  
 Зүр гур нь зөрөлдөөд  
 Зүйл зүйлийн амьтан бужигнаад  
 Зурам, тарвага нь  
 Тачигнаад байдаг гэнээ  
 Ийм л сайхан Хангай чинь  
 Манай лаа Идэр, Тэрхийн  
 Өвгөн буурал, баян Хангай  
 Нутаг минь ээ!

Хангай ханы  
Хажуухан талыг нь  
Барин түшин гарвал даа  
 Хар халзан тэх  
 Хамаг олон гөрөөс нь  
 Харгалдан зөрөлдөөд  
 Халзан цагаан аргал нь  
 Багшраад байдаг гэнэ.  
 Ам судаг өөд нь  
 Өгсөөд харвал даа  
 Суу халиу, суусар булга  
 Минж, согоо, мэгж, бодон  
 Мэхээрийн бор хүртэл  
 Элбэгтэйхэн байдаг гэнэ  
 Ердөө л өлзийтэйхэн Хангай чинь  
 Манай лаа Идэр, Тэрхийн  
 Өвгөн буурал, баян Хангай  
 Нутаг минь ээ!

Ам бүрийг нь харвал даа  
 Рашаан тамир нь ханхалсан  
 Арван гэрийн хүн амьтны  
 Архаг өвчнийг эдгээсэн  
 Арвин баян Хангай минь  
 Манай лаа Идэр, Тэрхийн  
 Өвгөн буурал, баян Хангай  
 Нутаг минь ээ!

("Монгол ардын аман зохиолын дээж бичиг"  
 УБ., 1978, 129-130 дахь тал)

**Үг, хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг шинжилье**

1. Магтаалд тоочин нэрлэсэн ан амьтдын дуу чимээ болон зүс зүсэмтэй холбоотой үгсийг түүж бичээд, монгол малын зүс зүсэмтэй харьцуулан тайлбарлаж бичээрэй.

Эшлэл	Тайлбар
Халзан цагаан аргал	
Гурвалжин зоотой туулай	

2. Магтаалын бадгуудад байгаа "...харайлдаад, ...зөрөлдөөд, ...ноцолдоод, ...бужигнаад" гэсэн үйл үгс ямар нөхцөлөөр хэлбэржсэнийг ажиглаад, шүлэгт ямар үүрэгтэй байгааг тайлбарлана уу.
3. Магтаалын бадаг бүрд байгаа "...барин түшин гарвал" хэмээх үг энэ магтаалд ямар үүрэг, зорилготой байгааг тодруулаарай.
4. Бадаг бүрийн төгсгөл дэх "...нутаг минь ээ" гэсэн үг магтаалын шүлэглэлд ямар үүрэгтэй байна вэ? Яруу хэрэглүүрийн ямар хэв маягт хамаарах вэ?
5. Хангай ханыг хэрхэн тоочиж магтсаныг ажиглан, дүрслэлээс эшлэл авч, тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
Гундаа шар нуруу	

6. Магтаалд ямар уран дүрслэл байна вэ? Зохиолоос эшлэл авч, уран дүрслэлийн ямар хэлбэр болохыг тодорхойлон тайлбарлаж бичээрэй. Тухайлбал, дөрөвдүгээр бадгийн дөрвөөс тавдугаар мөрд ямар дүрслэх арга хэрэглүүрийг ашигласан байна вэ?

Эшлэл	Тайлбар

**Магтаалын бүтэц, зохиомжийг шинжилье**

1. Хангай ханы магтаалаас зүг чиг заасан үгсийн доогуур зурж тэмдэглээрэй.
2. Хангай ханыг магтахдаа хэдэн талаас нь ямар дарааллаар магтсан байгааг хүснэгтэд бичээрэй.

Аль талаас нь хэрхэн магтсан бэ?	Эшлэл
Баруун талаас нь хэрхэн магтсан байна вэ?	
Хойд талаас нь хэрхэн магтсан байна вэ?	
Зүүн талаас нь хэрхэн магтсан байна вэ?	
Урд талаас нь хэрхэн магтсан байна вэ?	

3. Магтаалын бүтэц нь Хангайн нурууны ямар онцлогтой холбогдож байна вэ?
4. Магтаалын хэсэг тус бүрд ямар орчин дүрслэгдэж байна вэ?



**Сэдэв, гол санааг тодорхойлъя**

1. Магтаалын гол санаа нь хэддүгээр бадгийн хэддүгээр мөрүүдэд илэрч байна вэ? Яагаад?
2. Магтаалын шүлгийн холбоц, айзам хэмнэлийн онцлогийг жишээгээр тайлбарлана уу.
3. Шүлгийн холбоц, айзам хэмнэлийн онцлог нь гол санааг илрүүлэхэд ямар үүрэгтэй байна вэ?
4. “Хангайн магтаал”-д хүний сэтгэлийн ямар өнгө аясыг илэрхийлж байна вэ? Энэ нь гол санааг илрүүлэхэд ямар үүрэгтэй байна вэ?
5. Эхийн сэдвийг гарчигтай холбон тайлбарлана уу.



Ярих чадвараа хөгжүүлье

1. “Хангайн магтаал”-ын бичлэгийг сонсоод дагаж магтаал хэлж сураарай.

Шалгуур	Маш сайн	Сайн	Сайжруулах шаардлагатай
Магтаалыг цээжилсэн эсэх			
Магтаалыг аялгуулж хэлсэн эсэх			
Бусдын сонирхол татахаар уншсан эсэх			

2. Бид яагаад магтаалыг уншиж, цээжилж, магтаж сурах ёстойг ярилцаарай.



Бичих чадвараа хөгжүүлье

**Юмсын гадаад шинжийг дүрслэн магтаж бичье**

1. Өөрийн өссөн нутаг, гудамж, гэр, байшингаа дүрслэн шүлэглэнэ үү. Бичихдээ:
  - Өмнө талаас эхлэн, нар зөв тойрох юм уу, баруун зүүн талд юу юу байгааг хараанд өртөх дарааллаар бичнэ.
  - Тоочиж байгаа зүйлээ тэмдэг нэр, адилтгал, амьдчилал, хэтрүүлэл зэргээс ашиглан дүрсэлж бичих
  - Магтаж, бахдах байдлаар эерэг өнгө аястай бичих
2. Бичихдээ дараах мэдээллийг уншаад бүтээлчээр ашиглаарай.

**Тайлбар:** “Хангайн магтаал”-д Хангайн нурууны үзэмжийг тоочин дүрслэхдээ холоос ойртон ирэхэд нүдэнд харагдах үзэмж болоод баруун талаас нь эхлэн зүг бүрээс нь харан дүрслэх байдлаар үзүүлжээ. Ургамал, мод, ан гөрөөний баялгийг нь бахдан дүрслэхдээ “Хангай ханы гундаа шар нуруунд барин түшин гарвал даа” гэхчлэн ямагт доороос дээш өгсүүлсэн чигтэй уулын оройд авиран гарч ажигласнаар дүрсэлсэн байна.



## Уншихын өмнө

1. “Таван хошуу малын магтаал”-ыг уншихын өмнө бог, бод малаас аль нэгийг сонгож, дөрвөн мөр магтаал зохиогоорой.
2. Өөрийнхөө зохиосон магтаалд тухайн малын ямар шинжийг, яагаад ингэж онцлон дүрсэлснийг найздаа тайлбарлаж өгөөрэй.



## Унших чадвараа хөгжүүлэе

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя**

1. “Таван хошуу малын магтаал”-ыг уншихдаа танил биш үгийг тэмдэглэж уншаад “Монгол хэлний их тайлбар толь”-оос харж утгыг мэдэж аваарай. Жишээ нь:  
Дөмөн - дөмөн дөмөн алхах.  
Ороо - зугтамтгай.  
Сайвар - адууны жороо мэт боловч алгуур явах явдал.
2. Монголчуудын зүг чигийн бэлгэдэл таван хошуу малын магтаалд хэрхэн туссаныг анхаарч уншаарай.

**ТАВАН ХОШУУ МАЛЫН МАГТААЛ**

Баруун хөндийгөөр  
 Бараантан байдаг  
 Хулан хоёр чихтэй  
 Хумбан дөрвөн туурайтай  
 Хөөхөд ороо  
 Хөтлөхөд сайвар  
 Унахад номхон  
 Уралдахад хурдан  
 Дөрвөлжин ташаагаа  
 Дүүрэн жороолдог  
 Дөрвөн туурай нь  
 Яралзан харагддаг  
 Дөмөн сайн адууны чинь  
 Буян хишиг дэлгэртүгэй  
 Хатирч хүрэхгүй бэлчээртээ  
 Харваж хүрэхгүй зэлэндээ  
 Зуун унаганы  
 Зуузай нийлүүлж

Мятаршгүй  
 Мянга хүрэх болтугай!  
 Хойд хөндийгөөр дүүрэн  
 Хонгортон байдаг  
 Хонин шар нүдтэй  
 Хондон ухаа зүстэй  
 Ширээ бөхтэй  
 Ширэм тавагтай  
 Өндөр бөхтэй  
 Өргөн тавагтай  
 Дааж босох нь таатай  
 Далдаас харах нь сүртэй  
 Гоо сайхан биетэй  
 Гучин хуруу зогдортой  
 Шилдэг ат  
 Ширвэдэг тайлаг  
 Шигшрэг ингэ  
 Шилбэ бага торомны чинь



Буян хишиг дэлгэртүгэй  
 Тэртээ говийг  
 Тэмээгээрээ дүүргэж  
 Тэлж татсан зэлийг  
 Ботгоороо дүүргэж  
 Төдөлгүй  
 Түм хүрэх болтугай!  
 Урд хөндийгөөр  
 Улааран байдаг  
 Эргээд барагддаггүй  
 Ивэлгээд хүчрэгддэггүй  
 Урт богино эвэртэй  
 Уянга сайхан дуутай  
 Ухаа хондон үхрийн чинь  
 Хангай царамд нутагтай  
 Хандгай бугын гүйдэлтэй  
 Сүүл саваг сайтай  
 Сүү шим ихтэй  
 Жад оронгон эвэртэй  
 Жартгай дайсанд амтай  
 Хар тарлан  
 Хайнаг, сарлагийн чинь  
 Буян хишиг дэлгэртүгэй  
 Сайхан хангайн уулыг  
 Сарлагаараа дүүргэж  
 Үелж ургасан дэрсийг  
 Үхрээрээ дүүргэж  
 Үелүүлж татсан зэлийг  
 Тугалаараа дүүргэж  
 Бууралтгүй  
 Бум хүрэх болтугай!

Зүүн хөндийгөөр  
 Зүсрэн байдаг  
 Төө эвэртэй  
 Төгрөг сүүлтэй  
 Даргай эвэртэй  
 Далбан чихтэй

Халив сүүлтэй  
 Хавтгай ууцтай  
 Хунгийн дуутай  
 Дунгийн зүстэй  
 Баян сүрэг хонины чинь  
 Буян хишиг дэлгэртүгэй  
 Хонхор хотгорыг  
 Хониороо дүүргэж  
 Хоёр гурван гэрийг  
 Хургаараа дүүргэж  
 Сааралтгүй  
 Сая хүрэх болтугай!

Хангай говьд  
 Хосолмол нутагтай  
 Хонин сүргийн хамт  
 Холын холд бэлчээртэй  
 Ямагт хошуучлах ааштай  
 Янгир сайхан дуутай  
 Хаданд явахад цуцахгүй  
 Халтирч унахыг мэдэхгүй  
 Сэргэх тургих чимээтэй  
 Сэлмэн дэрлэгэр эвэртэй  
 Цэцэг цоохор зүстэй  
 Цэвэр нарийн ноолууртай  
 Үнэ бүгдийг агуулсан  
 Үржил сайтай ямааны чинь  
 Буян хишиг дэлгэртүгэй  
 Яргуйтай газрыг  
 Ямаагаараа дүүргэж  
 Эгнүүлсэн хөгнийг  
 Ишгээрээ дүүргэж  
 Залхалтгүй  
 Живаа хүрэх болтугай.

*(“Монгол ардын зан үйлийн  
 аман зохиол”  
 УБ., 1987, 180 дахь тал)*

1. Магтаалын бүтэц, зохиомжийг шинжилье “Таван хошуу малын магтаал”-ын шүлэг хэдэн хэсгээс бүтэж байна вэ? Бүтэц хэсгүүд хэрхэн ялгарч, ямар зүй тогтлыг илрүүлж байна вэ?
2. Таван хошуу малыг магтахдаа аль зүгээс, ямар малаас эхэлж, ямар дарааллаар магтсан байна вэ? Зүг чиг заасан үгсийн доогуур зурж тэмдэглээд, дараах хүснэгтэд бичээрэй.

	Адуу			Ямаа
--	------	--	--	------

Зүг чиг					
---------	--	--	--	--	--

### Үг, хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг шинжилье

1. Магтаалд таван хошуу малын шинж байдлыг хэрхэн тоочин дүрсэлснийг ажиглаж, шинжүүдийг гүйцээн бичээрэй.

	Адуу	Тэмээ	Үхэр	хонь	Ямаа
Зан авир					
Явдал					
Нас шүд					

2. Тэмээний насыг шүлэглэсэн мөрүүдээс зан авирыг хэрхэн дүрсэлснийг ярилцаарай.
3. Магтаалд дурдсан малын зүс зүсмийг түүж бичээрэй.
4. Монголчууд ямар малын ямар зүсийг бэлгэшээдгийг дүгнээрэй. Жишээ нь: Адууг бараан (хилэн хар, хүрэн, хээр зэрэг), тэмээ хондон ухаа...
5. Хүснэгтээ өөрийн мэдэх зүсээр нэмэн баяжуулаарай.

	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
Зүс, зүсэм					

6. Магтаалд таван хошуу малын ашиг шимийг хэрхэн тоочин дүрсэлснийг ажиглаж, шинжүүдийг гүйцээн бичээрэй.

	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
Ашиг шим					

7. Магтаалд ямар ямар дүрслэх арга хэрэглүүрийг хэрэглэсэн байна вэ?

Эшлэл	Тайлбар

8. Магтаалд тооны нэрээр хэрхэн уран ахиулал бүтээснийг ажиглаж, мал тус бүрд тохирох бэлгэ дэмбэрлийн үгийг магтаалаас эшлэн бичнэ үү. Жишээ нь:

	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
Эшлэл	Зуун унаганы зуузай нийлүүлж Мятаршгүй мянга хүрэх болтугай				



Уншихын өмнө

1. “Эмээлийн магтаал”-ыг уншихын өмнө зургийг хараад бүрдэл хэсгүүдийг нэрлээрэй. Жишээ нь: Хойд, урд ганзага, тохом, бүүрэг, баавар, олом, жирэм...
2. Бүтсэн эдийн онцлогийг магтаалд хэрхэн дүрслэх талаар таамаглаж ярилцаарай.
3. Эмээлийн тухай өөрсдийн мэддэг магтаалаас ангийнхандаа уншиж сонирхуулаарай. Жишээ нь: Жийжүү мөнгөн дөрөөтэй...



Эх сурвалж:  
mongolcom.mn



Унших чадвараа хөгжүүлье

### Зохиолыг мэдэрч ойлгож уншъя

1. “Эмээлийн магтаал”-ыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглэж уншаад утгыг ойлгож мэдээрэй.
2. “Эмээлийн магтаал”-ыг айзам хэмнэл тааруулж, уран уншъя.

### ЭМЭЭЛИЙН МАГТААЛ

Ажнай морины чимэг болсон  
 Арван хоёр шид бүрдсэн  
 Алтан сайхан эмээлээ  
 Аялгуу тааруулан магтмуу  
 Наран, саран бүүрэгтэй  
 Навчин хоёр хажуутай  
 Нарийн ноосон тохомтой  
 Зааны ясан хавтаалтай  
 Загасны ясан заадалтай  
 Малын арьсан захтай  
 Магнаг торгон тохомтой  
 Толь дүгрэг хазаартай  
 Торгон утсан оломтой  
 Хүрэл болд дөрөөтэй  
 Хөмөлдрөг хударга чимэгтэй  
 Ажнай морины чимэг болсон  
 Арван хоёр шид бүрдсэн  
 Алтан сайхан эмээлээ  
 Аялгуу тааруулан магтмуу.

(“Монгол ардын зан үйлийн аман зохиол”  
 УБ., 1987, 144 дэх тал)

### Магтаалын бүтэц, холбоо хамаарлыг шинжилье

1. “Эмээлийн магтаал”-ын эхлэл, гол, төгсгөл хэсгээр нь зурж тэмдэглээд

хосоороо ажиллаж, яагаад эхлэл хэсэг гэж үзсэн гэх мэтээр учрыг тайлбарлаж ярилцаарай.

2. Эхлэл, төгсгөл хэсэгт юуны тухай магтсан байна вэ? Яагаад?
3. Гол хэсэг нь эхлэл, төгсгөл хэсгээсээ ямар ялгаатай байна вэ? Яагаад?
4. Магтаал нь цаг хугацааны хувьд хэдий үе рүү хандаж байна вэ? Яагаад?

**Үг, хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг шинжилье**

1. Магтаалд уран дүрслэлийн ямар арга хэрэглэснийг түүж бичээд, ярилцаарай.
  - Нэгийг нөгөөтэй зүйрлэж адилтгах аргаар бүтсэн дүрслэл: .....
  - Дүрслэгдэхүүнийг байгаагаас нь ихэсгэж юм уу, багасгаж дүрсэлсэн дүрслэл: .....
  - Амьдчилах аргаар бүтсэн дүрслэл: .....
2. Шүлгийн гол хэсэг дэх шад бүрийн сүүлийн үгсийг ажиглаад тоочин дүрсэлсэн гэдгийг баталж тайлбарлаарай.
3. Эмээлийн бүтэц хэсгүүд, тэдгээрийг юугаар хэрхэн хийдэг тухай хэрхэн дүрсэлснийг тайлбарлаарай.

Эмээлийн бүтэц хэсгүүд	Юугаар хийдэг вэ?	Хэрхэн дүрсэлсэн байна вэ?
Бүүрэг	модоор	Урд бүүргийг наран, хойд бүүргийг саран гэж хэлбэр болон бэлгэдлээр нэрлэжээ.



**Бичих чадвараа хөгжүүлье**

1. Эмээлийн магтаал зохиож бичээрэй.  
Бичихдээ:
  - Толгой холболтыг анхаарах. Жишээ нь: АААА, ААББ, АБАБ гэх мэт
  - Тоочиж байгаа зүйлийнхээ бүтсэн эдийн онцлогийг гаргах
  - Тоочиж байгаа зүйлээ сүүл холбож төгсгөх.
2. Эмээлийн тухай өөр нэг магтаалын хэсэглэлээс уншиж санаа аваарай.  
Зээ энх сайн жаргаланхан болтугай  
Аглаг ууланд ургасан ацаг хоёр мод  
Агтын нуруунд сөхийсэн аварга хоёр уул  
Авьяаслаг уран дархны урлаж зассан мод  
Ариун Монгол үндэстний өдөржин давдаг уул  
Холоос униартах уул мэт холбоо хоёр бүүрэгтэй  
Хурмастын цагаан оёдол мэт хоёр мөнгөн хөвөөтэй  
Эгц хадны хавцал мэт эрэлхэг хоёр хавтагатай  
Ээрэм хөндий тал мэт эвлэг уужим суудалтай...

Эх сурвалж: <http://tsl.ttcy.com/Songs/s2743.html>



**Уншихын өмнө**



“Даахины ерөөл”-ийг уншиж судлах тул ерөөлийн нэрээс сэдэвлэн, уг ерөөлийг хэзээ хаана хэлдэг болохыг таамаглан ярилцаарай.



Унших чадвараа хөгжүүлье

1. “Даахины ерөөлийг уншихдаа танил биш үгийн утгыг мэдэж аваарай.  
Жишээ нь: Намгүр - Асар цагаан гэсэн утгатай төвөд үг. Хадагны нэгэн зүйл  
Найман тахил - Буддын шашны ёсонд эрдэнийн шүхэр, алтан загас, алтан хумх, бадамлянхуа, цагаан лавай, өлзий утас, эрдэнийн утас, алтан хүрд зэргийг найман тахил гэдэг.

### ДААХИНЫ ЕРӨӨЛ

...Наанаа нанжин хээтэй

Цаанаа чамин хээтэй

Намгүр нэртэй

Найман тахилтай

Нанжин их хадгаа бариад

Намайг ерөө гэлээ.

Эрхэм хайрт танайх болбол

Зургаан үндсэн хуанлид үзээд

Зуугаас ирсэн зурхайчид үзүүлээд

Түмэн жилийн өлзий бүрдсэн

Түгээмэл жилийн түвшин сайн энэ өдөр

Эрхэм хайртай хүүгийнхээ

Алтан хонгор даахийг үргээж

байгаа учир

Ивээл жилтэй хүнийг эхлэн залж

Эрхэм олон түмнээ урьдчилан хэлж

Ган цагаан хайч

Гавшгай цагаан тонгоргийг бэлдээд

Алтан хайчны амыг нээж

Амь насыг нь даатгаж

Мөнгөн хайчны амыг нээж

Мөнх насыг нь даатгаж

Ган хошуутай алтан бариултай хайчаа

Гар мутар бүрийдээ дамжуулан үргээж

Гарсан төрсөн нас буяныг нь

Уртатгаж өгөөд

Баруун талын шанаанаас нь эхлэн

үргээхэд

Бадамлянхуа цэцэг дэлгэрч байгаа

юм шиг

Зүүн талын шанаанаас нь авч үргээхэд

Зүйл бүрийн эрдэм цацарч байгаа мэт

Орой дээрээс нь авч үргээхэд

Ой билиг нь хурцдаж

Оюун ухаан нь нэмэгдэж байгаа мэт

Ар шилэн дээрээс нь авч үргээхэд

Агуу их хүчин төгөлдөр

Атаа хүчин нэмэгдэж байгаа мэт

Эрхэм хайртай хонгор хүүгийн

Эцгийн билгийг ярихад

Номд мэргэн, нойронд сэргэг

Үйлэнд уран, үгэнд цэцэн

Хуульд шударга, хуримд цовоо

Дайнд баатар, далайд усч

Галд халдаггүй, галавт шантардаггүй

Элгээрээ энх сайхан жаргаж

Төрлөөрөө төв сайхан оршиж

Төв их нутгийнхаа дунд

Үрээ танихгүй олон

Үрээгээ танихгүй баян

Яруу алдар, есөн хүсэл

Өсөх нас, өрнөх буян

Суух заяа, сурах эрдэм

Баярлах наадам, бахтай жаргал

Нас сүүдрээр урт

Найр цэнгэлээр их

Эгүүрд номын ёсоор

Баярын магнайгаар

Балданлхам, баатар дагинастаа

Алгасалгүй эргэж өршөөхийн

Бэлгэ ерөөлийг дэвшүүлэн өргөж

айлтгая!

(Монгол ардын аман зохиолын дээж бичиг.

УБ., 1978, 120-121 дэх тал)

**Ерөөлийн үг хэллэгийн сонголт,  
уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг  
тодорхойлъя**

1. “Даахины ерөөл”-д гарах дараах үгсийн утгыг толь бичгээс харж, тайлбарлан бичээд, зохиолд ямар үүрэгтэй байгааг ярилцаарай.  
Даахь, шанд, лонх, агар, завьяа, нанжин, хуанли
2. Ерөөлийн бичвэрт “архи” гэдэг үгийг “сархад” гэж, “гар” гэдэг үгийг “мутар” гэсний учир юу вэ? Мөн “үүрд” гэсэн үгийг яагаад “эгүүрд” гэж бичсэн байна вэ? Эдгээрээс үндэслэн ерөөлийн хэл найруулгын онцлогийг тодорхойлоорой.
3. “Даахины ерөөл”-ийг уран сайхан болгохын тулд дүрслэлийн ямар аргууд хэрэглэснийг түүж бичээд ярилцаарай. Үүнд:
  - Нэгийг нөгөөтэй зүйрлэж адилтгах аргаар бүтсэн дүрслэл
  - Дүрслэгдэхүүнийг бодит байдлаас нь ихэсгэж юм уу, багасгаж дүрсэлсэн дүрслэл

**Ерөөлийн бүтэц, зохиомжийн дарааллыг тайлбарлая**

1. “Даахины ерөөл”-ийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг товчлон хурааж бичнэ үү.

Ерөөлийн эхлэл хэсэг	Ерөөлийн гол хэсэг	Ерөөлийн төгсгөл хэсэг

2. Дараах асуултад хариулан дүгнэж бичнэ үү.
  - Ерөөлийн эхлэл хэсэгт юуны тухай голлон бичсэн байна вэ?
  - Ерөөлийн гол хэсэг эхлэл болоод төгсгөл хэсгээсээ ямар ялгаатай байна вэ?
  - Ерөөлийн төгсгөл хэсэг цаг хугацааны хувьд хэдий үе рүү хандаж бичигдсэн байна вэ?
3. Хүүхдийн даахийг аль талаас хэрхэн үргээх дарааллыг ерөөлд яаж тусгасан байна вэ? Дараах хүснэгтэд түүж бичээрэй.

	Хүүхдийн даахийг урд талаас нь үргээхдээ хэрхэн магтсан байна вэ?			
Эшлэл				

4. Хүүхдийн даахь үргээх ёс заншилд монголчуудын зүг чигийг эрхэмлэх ёс хэрхэн хадгалагдаж байгааг дүгнэж ярилцаарай.

**Сэдэв, гол санааг тодорхойлъя**

1. Яагаад “Даахины ерөөл” гэж нэрлэсэн юм бол? Та нар юу гэж бодож байна?
2. Даахины ерөөлд хамгийн их чухалчилсан санаа юу байна вэ?
3. Даахины ерөөл нь ямар бэлгэдлийг өөртөө агуулж байна вэ?
4. Монголчууд “Ерөөлийн үзүүрт тос” гэж хэлдэг. Энэ хэлц үгийн утга ерөөлийн бэлгэдэлтэй хэрхэн холбогдож байгааг тайлбарлан ярилцаарай.
5. Хүүхдийн даахийг үргээх ёс уламжлалын талаар сурвалжлан мэдээрэй. Жишээ нь:
  - Нутаг нутгийн болон ястан бүрийн онцлогтой холбоотой ямар нийтлэг



- болон ялгаатай тал байгаа
- Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн нас, хүйстэй холбоотой гэх мэт.

**Шүлгийн айзам хэмнэл, холбоцыг тайлбарлая**

1. Шүлгийн шадыг тоолно уу.
2. Шүлгийн шадуудын үгсийг дээрээс нь доош нь харалдаа харалдаагаар нь уншиж, юу ажиглагдаж байгааг ярилцаарай (Архи, сархад, дарс гэсэн үгсээр толгой холбогдсон бол чанартай гэсэн үгээр сүүл холбогдсон байгааг олж харж ярилцаж болно).
3. Ерөөлийн шүлгийн айзмыг ажиглаж, ярилцана уу.
4. Уншаад ойлгох чадвараа дараах шалгуураар үнэлээрэй.

Шалгуур (чадвар)	Маш сайн	Сайн	Хангалттай	Сайжруулах шаардлагатай
Хурд сайтай уншсан				
Даалгаврыг сайн ойлгож, бүрэн хийсэн				
Гол санааг ойлгож, тайлбарласан				
Далд утгыг ойлгож тайлбарласан				



Бичих чадвараа хөгжүүлье

**Хүн, юмс, үзэгдлийн гадаад шинжийг дүрслэн магтаж бичье**

1. Ерөөлийн шүлгийн зүй тогтол, дүрслэлийн аргуудыг ашиглаж, шүлэг бичээрэй. Бичсэн шүлгээ дараах шалгуураар үнэлээрэй.

Шалгуур	Тийм	Үгүй
Толгой холбосон		
Сүүл холбосон		
Мөрөн дэх үгийн тоо тэнцүү		
Дүрслэх хэрэглүүр ашигласан		
Сайн сайхныг хүсэн ерөөсөн		

2. “Даахины ерөөл”-ийн:  
*...Номд мэргэн, нойронд сэргэг  
 Үйлэнд уран, үгэнд цэцэн  
 Хуульд шударга, хуримд цовоо  
 Дайнд баатар, далайд усч...*

гэсэн шүлгийн зүй тогтлыг ажиглаад, дуурайн шүлэг бичиж, гэр бүлийнхэн, анги хамт олон, багшдаа уншиж өгөөрэй.



Ярих чадвараа хөгжүүлье

Магтаалын тухай мэдээллийг уншаад хосоороо ярилцаж, мэдлэгээ

өргөжүүлээрэй.

Монгол аман зохиолын үндсэн төрөл зүйлийн нэг нь магтаал билээ. Хүн орчин тойрныхоо юмс үзэгдлийг сүслэн дээдэлж, улмаар үгийн уран сайхнаар магтан мялааж шүлэглэсэн аман зохиолын төрөл зүйлийг магтаал гэнэ.

*Магтаалын гол онцлог нь:*

- Дүрсэлж буй зүйлийнхээ хамгийн гол шинжийг дөвийлгөн магтаж сайшаах тул уран тоочилт хийгээд ихэсгэлийн аргыг түлхүү ашигладаг.
- Магтаалыг магтан дуудаж аялгуулан дуулж уншдаг байна.

Магтаал монгол аман зохиолын үндсэн зүйлийн нэг боловч хожим Монголын бичгийн уран зохиолд тодорхой хэмжээгээр шинэчлэгдэн бичигдэж иржээ.

Монгол аман зохиолын уламжлалд “Алтайн магтаал”, “Хангайн магтаал”, “Дүнжингаравын магтаал”, “Хан Хөхүйн магтаал”, “Хөгнө ханы магтаал”, “Авзага уулын магтаал”, “Арц Богдын магтаал”, “Баян-Агтын магтаал”, “Гурван сайхны магтаал”, “Говийн магтаал”, “Баян давааны магтаал”, “Хэрлэн голын магтаал” зэрэг уул усны олон магтаал бий. Монголчууд тууль хайлахын өмнө Алтайн юм уу, Хангайн магтаалыг хэлдэг.

### **Ерөөл, магтаалаас цээжилж, дуу хоолойн өнгө, аялга, хэмнэл, биеийн хөдөлгөөн тохируулж уран уншъя**

Ерөөл, магтаалаас цээжилж ерөөлч магтаалчдын адил ерөөж, магтаж уншаарай. Ерөөл, магтаал унших чадвараа дараах шалгуураар үнэлээрэй.

Шалгуур	Маш сайн	Сайн	Сайжруулах шаардлагатай
Ерөөл, магтаалыг цээжилсэн эсэх			
Ерөөл, магтаалыг аялгуулан уншсан эсэх			
Биеийн илэрхийлэл тохирсон, оновчтой байсан эсэх			
Дуу хоолойн өнгө аяс тохирсон			
Айзам хөгийг зөв тохируулсан			
Сонирхол татахаар байсан эсэх			

**ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ**

1. Ерөөл гэж юуг хэлдэг вэ? Ерөөлийн тухай ойлгосон ойлголтоо өөрийнхөө үгээр товч бичнэ үү.  
 Ерөөл гэж .....  
 Магтаал гэж юуг хэлдэг вэ? Магтаалын тухай ойлгосон ойлголтоо өөрийнхөө үгээр товч бичнэ үү.  
 Магтаал гэж .....

2. Хүүхэд бүр нэг магтаал зохиож бичээрэй.  
 .....

3. Х.Сампилдэндэвийн эмхэтгэн хэвлүүлсэн “Монгол ардын зан үйлийн аман зохиол” (1987) номыг авч, магтаалуудаас сонгон уншаарай.


4. Монгол магтаалд нийтлэг ямар шинж байна вэ? Жишээгээр батална уу.

	Магтаалын онцлог	Жишээ
Орчин	Одоо цагт	
Дүр	Уул ус, мал идээ, эдлэл хэрэглэл гэх мэт	
Утга	Магтан бахдах	
Найруулга	Тоочин дүрслэх	

5. Уул усны магтаал хийгээд таван хошуу малын магтаалыг харьцуулна уу.
6. Уул усны магтаалд тухайн уул усныхаа тогтоц хийгээд байгалийн баялгийг магтдаг гэвэл таван хошуу малын магтаалд чухам юуг онцолдог вэ? Жишээгээр тайлбарлаарай.
7. Уншсан магтаалын дүр, дүрслэлийн онцлогийг дараах хүснэгтэд дүгнэж бичээрэй.

	Хангайн магтаал	Таван хошуу малын магтаал	Эмээлийн магтаал	Даахины ерөөл
Уул усны магтаал				
Мал, амьтны магтаал				
Эдлэл хэрэглэлийн магтаал				
Хүний магтаал				

8. Монгол магтаалын талаарх мэдлэгээ дараах бүдүүвчид дүгнэж бичээрэй.



### ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

	Шалгуур	Үнэлгээ	Гүйцэтгэл
<b>УНШИХ</b>			
1	Ерөөл, магтаалыг мэдэрч, ойлгож уншсан эсэх	1-5 оноо	
2	Ерөөл, магтаалд сэдэв, утга, хэл, уран сайхны задлал зөв хийсэн байдал	1-5 оноо	
3	Уншсан зүйлийнхээ талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байдал	1-5 оноо	
<b>БИЧИХ</b>			
1	Уншсан ерөөл, магтаалаа дуурайн өөрийн хүссэн зүйлийн тухай ерөөл, магтаал бичсэн	1-5 оноо	
<b>ЯРИХ</b>			
1	Монгол аман зохиолын үндсэн төрөл зүйлийн нэг болох ерөөл, магтаалын тухай тодорхой мэдлэгтэй болж, ерөөл, магтаалын зориулалт, ач холбогдлыг зөв ярьсан	1-5 оноо	
2	Ерөөл, магтаалын сэдэв утгын холбоо хамаарлыг ухаарч ярихдаа эшлэл, жишээ, уран дүрслэл ашиглаж ярьсан	1-5 оноо	
3	Ерөөл, магтаалаас цээжилж, амьдрал ахуйдаа хэрэглэсэн	1-5 оноо	

## 1.2 ТҮҮХЭН ДОМОГ



### Уншихын өмнө

1. “Хорь түмэд, Хоридай мэргэний түүхэн домог”-ийг уншихын өмнө “нуурын хөвөө”, “хун хувцас”, “цоожтой авдар”, “гэрлэлт” гэсэн түлхүүр үгсийг ашиглан бяцхан зохиомж хийнэ үү. Эдгээр үг ямар үйл явдал, дүрүүдийг та нарт бодогдуулж байна вэ? Дараах зохиолд эдгээр үг оролцсон гэвэл та нар зохиолын үйл явдлыг хэрхэн тааварлах вэ? Энэ хэллэгтэй холбогдох ямар үйл явдал тохиолдож болох вэ? Санал бодлоо хуваалцана уу.
2. Домгийг уншихын өмнө дараах үгсийн утгыг мэдэж аваарай.

Басган - нөхөрт гараагүй бүсгүй

Сөөргөө - эргээд, буцаад

Тунтуу - адууны хомоолын нэр

Бөө - Монгол, Төв Ази, Сибирийн уламжлалт шүтлэгийн зан үйл гүйцэтгэдэг хүн

Уг гарваль - удам угсаа, өвөг дээдэс

Сэргэ - морины уяа



### Унших чадвараа хөгжүүлье

#### Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя

Домгийн хэсэглэл тус бүрийг уншаад цаашид юу болох талаар хүснэгтэд өөрсдийн таамаглалыг бичээрэй. Үүнд:

- “Та юу болно гэж бодож байна?” гэсэн асуултын доорх зайд таамаглалаа бичнэ.
- “Ямар нотлох баримт байна вэ?” гэсэн асуултын доорх зайд тухайн таамаглалд хөтөлсөн гол үйл явдлыг товч тэмдэглэнэ.
- “Юу болсон бэ?” гэсэн хэсэгт дараагийн хэсгийг уншаад юу болсныг бичнэ.
- “Өөрийн таамаглалд үнэлгээ өгөх” хэсэгт зөв, дөхсөн, өөр байсан гэсэн үнэлгээний аль нэгийг сонгож бичээрэй.

#### Таамаглалын хүснэгт:

Хэсэглэл	Та юу болно гэж бодож байна вэ?	Ямар нотлох баримт байна вэ?	Юу болсон бэ?	Өөрийн таамаглалд үнэлгээ өгөх (зөв, дөхсөн, өөр байсан)
1				
2				
3				

**ХОРЬ ТҮМЭД, ХОРИДАЙ МЭРГЭНИЙ ТҮҮХЭН ДОМОГ****Хэсэглэл 1**

Эрт нэгэн цагт Байгал нуурын урд биеэр нутагладаг нэгэн айлд Хори, Хоридай гэж хоёр хөвүүн байжээ. Тэр хоёрын Хори нь их элдэвтэй, арга зальтай, бэрх хөвүүн байж л дээ.

Хори нэг өдөр Байгалийн урд хөвөөгөөр явж байтал Ойхон арлын зүүн биеэр гараад есөн цагаан хун шувуу цэх шулуун нисэн ирж явав гэнэ. Хори Байгалын урд хөвөөнд адууны тунтуу болоод хэвтэж байжээ. Есөн цагаан хун ирээд буухад хамгийн сүүлчийнх нь эм хүний дуутай байв гэнэ. Хори ч бэрх хүн болохоороо “Яатуу чамайг нэг сайн чадах юм хуна” гэж дотроо боджээ.

- *Хори чухам ямар зорилгоор биеэ нуун, адууны хомоолд хувилсан гэж та нар бодож байна вэ?*
- *Зохиолд яагаад хамгийн сүүлийн хун шувууг эм хүний дуутай гэж өгүүлсэн бэ? Домгийг үргэлжлүүлэн уншина уу.*

**Хэсэглэл 2.**

Тэгтэл есөн цагаан хун, хун хувцсаа сэлгэж, есөн сайхан дагина болоод нуурт шунгаж, дуулж, бөөлж, цэнгэж байжээ. Тэгж наргиж байхад нь Хори хамгийн сүүлчийнх нь хун хувцсыг нуугаад, сөөргөө буцаад адууны тунтуу болжээ. Есөн дагина наргиж, жаргаж ханаад буцаж нисэх гэтэл нэгнийх нь хувцас үгүй гэнэ. Нөгөө найм нь хувцсаа өмсөж хун дүрдээ хувилаад, нисэж одов гэнэ. Нэг хун гүнж л яах ч аргагүй болоод үлдчихэж гэнэ.

Хун гүнж Хорийн гэргий болж, гурав хонолгүй гэрийн гадуур адуу мал багширсан жигтэй баян айл болж гэнэ. Тэгж хэдэн жил суугаад арван нэгэн хөвүүн төрүүлж, нэг ч басган үгүй байжээ.

Нэгэн өдөр Хори бариул барьж, гал тогоон дээрээ хоол цайгаа хийгээд, Хун шувуун ээж нь орон дээрээ оёдол үйл хийн сууж байгаад хэлжээ:

- Чи одоо миний хун хувцсыг минь өгөөч дээ. Адуу идээ, үр хөвүүд дутуу юм үгүй болоо биш үү дээ. Одоо би нутгаа буцах минь гэхэд нь Хори тас зөрөөд хөдлөх ч үгүй байжээ.

- *Домогт Хорийг яагаад заавал хамгийн сүүлийн хун гүнжийн хувцсыг авснаар өгүүлсэн бэ?*
- *Хун гүнжийг гэргий болгонгуут Хори яагаад гэнэт баяжсан бэ?*
- *Хори эхнэрээ шударга бусаар өөртөө үлдээсэн үү, эсвэл? Та нар юу гэж үзэж байна вэ? Домгийн төгсгөлийг уншина уу.*

**Хэсэглэл 3.**

Тэгэхэд нь Хун шувуун ээж аргаа бараад:

- Үгүй би ядахдаа хувцсаа өмсөөд үзье дээ. Үүдээр л гаралгүй хаагуур гарах вэ? Чи үүдээ бөглөж суугаа хойно гэж гуйжээ. Хори бяцхан бодож байснаа, “Үгүй нээрээ, үүдээр л гаралгүй хаагуур гарах вэ дээ” гэж санаад ташаандаа салгалгүй явдаг түлхүүрээ гаргаад, хоймрынхоо авдрыг түлхэж, хун хувцсыг нь авч өгөв гэнэ. Хун ээж маань хувцсаа өмсөж л. Даль жигүүрээ засаж, хун дүрсдээ хувилж байхыг нь Хори ч гэсэн үүдэн тушаагаа харж л байж. Тэгтэл Хун ээж гэнэт дүрр-д хийгээд өрхөөрөө гарах гэхэд нь Хори сандан мэгдэн хар хөөтэй бариулаараа хоёр шилбэнээс нь татаж:



- Хүүе, хүүе байгаач дээ. Чи явсандаа яв. Арван нэгэн хөвүүндээ нэр хайрлаач гэж гуйхын ихээр гуйв гэнэ.

Тэгэхэд “Хүгдүүд, Галзууд, Хуацай, Халвин, Шарайд, Бодонгууд, Худай, Харгана, Батнай, Гучид, Цагаангууд” гэж арван нэгэн нэр өгсөн юм гэнэ. Хун ээж тонон дээгүүр хэд эргэхдээ:

“Дайнд дарагдахгүй

Цэрэгт сэжигдэхгүй

Баатар хүчтэй сайн зон болоорой” гэж хөвүүдээ ерөөгөөд явсан юм гэнэ.

Өнөө энэ арван нэгэн хөвүүд нь Буриадын арван нэгэн эцэг болсон юм гэдэг. Нөгөө Хоридой гээч нь бас л их цэцэн мэргэн, харвах намнахдаа сайн хүн байсан гэх. Баргужин Худрын буриад зон түүний хүүхдүүд болох юм. Түүнээс хойш хун шувуу хар шилбэтэй болсон гэдэг. Буриадын бөө нар уг гарвалиа дуудахдаа:

Хун шувуун гарвал минь

Хусан модон сэргэ минь

гэж хэлэх нь ийм учиртай гэлцдэг.

*(Энэ домгийг 1975-7-26-д Хэнтий аймгийн Батширээт сумын 90 нас сүүдэр зооглосон Хүгдүүд омгийн буриад баавай Бадамын Дамдин гуайгаас профессор С.Дулам тэмдэглэн авчээ. Хувилбар: МААЗ-ын дээж бичиг, УБ., 1978, 214 дэх тал)*

- Хори эхнэртээ эргэж хун болох боломж хэзээ ч олгодоггүй байсанд та нарт ямар сэтгэгдэл төрсөн бэ?
- Хун ээж яагаад бүрмөсөн явах болсон нь хун хувцсыг олон жил тас нууснаас болсон уу, эсвэл...?
- Хори яагаад Хун ээжийг өрхөөр гарч болохыг мартсан бэ?
- Та нар өөрсдийн уг гарвал, овгийн талаар хосоороо ярилцаарай. Монгол угсаатны гол гол овгуудыг нэрлээрэй. Хиад боржгин, хатагин, олхонуд гэх мэт.
- Та бүхэн өөрөөсөө дээш хэдэн үеийг нэрлэж чадах вэ? Аав, өвөө... гэх мэт

### **Үг, хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг шинжилье.**

1. Домогт гарч буй чимээ дуурайх үгийг олж, түүнтэй ойролцоо үгсийг нэрлээрэй.
2. Жигүүртэн шувуудын хэл гэж байдаг уу? Шувуудын дуу чимээг нэрлэх үгсийг ярилцаарай. Жишээ нь: Галуу ганганах, шаазгай шагшрах, нугас нуугих, хэрээ гуаглах гэх мэт.
3. Хун цэнгийн дуугарахыг монголчууд юу гэж нэрлэдгийг мэдэж, мэдээлэл солилцоорой.

### **Зохиолын төрөл зүйлийн онцлогийг шинжилье**

1. Хун хүн хоёроос хүн үүссэн энэ домгийг ямар домог гэж нэрлэвэл зохих вэ? (Угсаатны гарлын домог, Хүний үүслийн домог гэх мэт).
2. Хун ээж хөвгүүддээ юу гэж ерөөсөн бэ? Энэ нь монгол аман зохиолын ямар төрөл зүйлд хамаарах вэ?
3. Хүн амьтан болж хувилах, хүн амьгүй эд юм болж хувилах, эсвэл амьтан хүн болж хувилах өгүүлэмж ямар зохиол, урлагийн бүтээлд элбэг байдаг вэ?
4. Энэхүү домог нь хун шувуу яагаад хар шилбэтэй болсон тухай домог мөн үү? Мал амьтны эд эрхтний бүтэц гарал үүслийн тухай өгүүлсэн ямар ямар домог мэдэх вэ?

5. Халх, ойрад бусад монгол угсаатныг ямар амьтнаас үүсэл гаралтай гэж домоглодог тухай сурвалжлан цуглуулж, домгийг мэдэж ирээд мэдээлэл солилцоорой. Хиад боржгин Бөртэ Чино, Хоа маралаас үүссэн гэх мэт.
6. Тэнгэр - газар, далай - хуурай газрын амьдрал хийгээд тэдгээрийн хил хязгаар, харшлалын тухайд асуудал дэвшүүлэн ярилц.
7. Зохиолд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн асуудал хөндсөн байна гэж та нар үзэж байна уу?
8. Мэдээллийг уншиж хосоороо ярилцаж дээрх ойлголтоо бататгаарай.

Түүхэн домог бол үнэн болсон явдлыг уран сэтгэмжээр баяжуулан дүрсэлсэн хүүрнэн өгүүлэх аман зохиолын нэгэн зүйл мөн. Түүхэн домгийг дотор нь угсаатны түүхэн домог, газар усны түүхэн домог, түүх хүний түүхэн домог, аж байдлын түүхэн домог гэхчлэн ялгаж болно. Дээр өгүүлсэн “Хун гүнжийн домог” бол Хорийн арван нэгэн эцгээс буриад зон үүссэн болохыг уран сэтгэмжээр баяжуулан дүрсэлсэн угсаатны түүхэн домгийн жишээ болно.



Ярих чадвараа хөгжүүлье

**Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан, сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярь**

1. Хун гүнжийн домгийг сэтгэл хөдлөм сайхнаар ярьж өгөөд, “Хун ээж хөвгүүддээ эргэн ирэх үү?” сэдвээр санал бодлоо солилцоорой.
2. Өөрсдийн ярих чадварыг хүснэгтийн дагуу хосоороо үнэлээрэй.

Үнэлгээний шалгуур	Үнэлгээ (маш сайн, сайн, дунд)
Зохиолын үг хэллэгээс 5-аас доошгүйг ашигласан	
Зохиолын уран дүрслэлээс 2-оос доошгүйг ашиглаж ярьсан	
Зохиолоос эшлэл ашиглаж ярьсан	
Сонирхолтой байхаар дууны өнгө аялга, зогсоц, биеийн хөдөлгөөн ашигласан	
Ярьсан зүйл нь сэтгэлд хүрсэн	



Бичих чадвараа хөгжүүлье

**Зохиолд дүр, харилцан яриа оруулж нэмэн дэлгэрүүлж бичье**


“Нэгэн өдөр Хорийн арван нэгэн хөвгүүдийн гэр, хотын дээгүүр нэгэн хун шувуу эргэцэн нисэж, уйтгартай дуугаар гунганан дуугарч байжээ...” хэмээн домгийг үргэлжлүүлэн зохиож бичээрэй.





Уншихын өмнө

1. “Халхын дөрвөн хан цол авсан нь” түүхэн домгийг уншихын өмнө Монголын засаг захиргааны зурагт үзүүлсэн дөрвөн аймаг нь одоогийн аль аймгуудын газар нутгийг хамарч байсныг ярилцаарай.



Эх сурвалж: [touristinfocenter.mn](http://touristinfocenter.mn)



Унших чадвараа хөгжүүлье

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя**

1. Түүхэн домгийг уншаад өөрсдийн таамаглаж ярьсантай харьцуулаарай.

**ХАЛХЫН ДӨРВӨН ХАН ЦОЛ АВСАН НЬ**

Халхын дөрвөн хан Манжийн хаанаас хэргэм цол авахаар очсон байна. Энэ дөрвөн ханыг орж очмогц ширээ тойруулан суулгаж, олсон хэлхээтэй шүрэн эрих нэг нэгийг бариулжээ. Тэгсэн нэг дэх нь хүзүүндээ углаж, дараах нь чихэндээ өлгөж, гурав дахь нь бугуйндаа зүүжээ. Дөрөв дэх хан:

- Аа би олсоор оосорлуулж, чулуугаар дөнгөлүүлэх болоогүй гэж хэлээд, эрихийг эвхэж цагариглаад тавьчихжээ.

Дараагаар нь тавьж болохгүй бөмбөгөр ёроолтой шилэн аягатай цай оруулж ирсэнд дөрөв дэх хан цагаригласан эрих дээрээ авч тавиад дажгүй сууж, бусад нь гар хуруугаа халааж сандарцгааж байж гэнэ.

Тэгтэл тэдний өмнүүр эмээлтэй хазаартай тоглоомон морь давхиулсанд нэг дэх хан “Яасан сайхан морь вэ?” гэж, хоёр дахь хан эмээлийг нь ойчих вий гэж түшээд гаргаж, гурав дахь хан эмээлийг нь засаад гаргаж, дөрөв дэх хан:

- Монгол хүн малаа иддэг юм гэж хэлээд эмээлийг нь авч тавиад, дотроос нь халуун хоол гаргаж ирээд, идэж суужээ.

Ингээд “Сайн морь” гэснээр нь “Сайн ноён хан”, түшсэнээр нь “Түшээт хан”, зассанаар нь “Засагт хан”, эмээлийг нь авч, идээ будааг нь гаргаж, мэргэн цэцэн ухаан гаргаснаар нь “Цэцэн хан” гэсэн цол хүртээсэн байна.

(Монгол домог. Эмхэтгэсэн Х.Сампилдэндэв.  
ШУАХЗХ, УБ., 1984, 59 дэх тал)

## 2. Дараах үгсийн тайлбарыг уншаад, зохиолын агуулгыг сайтар ойлгоорой.

Хан - эртний монголчууд овог аймгийн тэргүүн ахлагчаа хан гэдэг байсан байна. Тиймд энэ зохиолд халхын дөрвөн аймгийг ахалсан хүнийг хан гэж бичжээ. Мөн монголчууд эрхэм хүндтэй шүтэж биширдэг зүйлээ хан гэж өргөмжилдөг байна. Жишээ нь: Богд хан уул, Хан хурмаст гэх мэт.

Манж - улсын нэр. Хятадын зүүн хойд хэсгийн Манжуур хавийн нутгаар нутаглаж байсан Зөрчид угсаатан. Манж хэлтэй байсан ч хожмоо хятад хэлтэн болсон түүхтэй. Манж нар 17 дугаар зууны эхнээс хүчирхэгжин 1644 онд Манж Чин улсыг байгуулж 1912 он хүртэл оршин тогтнож байжээ.

Хэргэм - ямар нэг албан тушаал хашиж байгаа хүнд олгодог цол. Хэргэм гэдэг үг цол гэсэн үгтэй хоршиж хэргэм цол, цол хэргэм гэж ярьж, бичиж заншсан байна.

Шүр - далай тэнгисийн усны ёроолын хад асгад амьдардаг нэгэн зүйлийн суумал амьтны эдээр хийсэн чимэглэлийн эдийг хэлнэ. Шүрэн эрих, шүрэн хөөрөг гэх мэт.

Эрих - ямар нэг эрхэм чухал эдийг тодорхой тоогоор хэлхэн маань мэгзэм уншсан тоогоо тэмдэглэх хэрэгсэл. Ихэвчлэн 21 юм уу 108 тоотой байдаг.

Дөнгөлөх - хэрэгтний хөл, хүзүүнд углах зориулалттай дундаа нүхтэй, зүймэл дөрвөлжин хавтгай модыг дөнгө гэнэ. Дөнгөлөх гэж дөнгөтэй болгох, дөнгө зүүх үйлийн нэршил.

**Үг, хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг шинжилье**

## 1. Дээрх үгсээс өөр танил биш үгийг хүснэгтийн дагуу ажиллаж мэдэж аваарай.

	Утга санааг нь мэдэхгүй үг, хэллэг	Өгүүлбэрийн хам утгаас ойлгосон чиний тайлбар	Толь бичигт тайлбарласан утга
1			
2			
3			

## 2. Түүхэн домгийн дүрслэлийг уран сайхантай болгож байгаа дүрслэлийг түүж бичээд, ямар ямар дүрслэл хэрэглэснийг тайлбарлаж бичээрэй

## 3. Түүхэн домогт уран дүрслэлийн ямар арга ашигласнаар дүрслэл хэрхэн өөрчлөгдөж байгааг ярилцаарай

**Зохиолын сэдэв, гол санааг тодорхойлъё**

## 1. Мэдээллийг уншаад дээрх зохиолоор баталж тайлбарлаарай.

- 17 дугаар зууны үед халх монголчууд Түшээт хан, Засагт хан, Сэцэн хан гэсэн гурван хэсэг аймагт хуваагдсан түүхтэй. Хожим 1725 онд Түшээт хан аймгийн нутгаас 19 хошууг таслан авч Сайн ноён хан аймгийг байгуулжээ.
- Халх монголчууд 1691 онд Манжид дагаар ороод, 1911 онд Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнүүлсний үр дүнд тусгаар тогтнолоо эргүүлэн олж авсан юм.

2. Зохиолын сэдэв, гол санааны тухай ойлголтыг уншиж, ойлгоод хосоороо ярилцаарай.

*Сэдэв гэж зохиолчийн зохиолдоо бичихээр олж авсан санаа бодлын цогцолборыг хэлнэ. Гол санаа гэж зохиолчийн зүгээс уншигчдад хандаж хэлье гэж онцлон өгүүлсэн утга санааг хэлдэг.*

3. Зохиолын сэдэв, гол санаатай холбоотой гэж үзэж байгаа өгүүлбэрийг олж тэмдэглээрэй.
4. Дээрх түүхэн домогт Халхын дөрвөн хан Манжийн хааны явуулсан тоглоомон модон моринд ямар үйлдэл үзүүлснийг бичээрэй.

Хан цолтон	Хийсэн хариу үйлдэл
Цэцэн хан	
Засагт хан	
Сайн ноён хан	
Түшээт хан	

5. Ямар ханы хийсэн ямар ямар үйлдэл хамгийн зөв байсан бэ? Яагаад?
6. Зохиолын гол өгүүлбэрийн утгыг бусад өгүүлбэрүүдтэй холбон авч үзээд зохиолын гол утга санааг тодруулаарай.
7. Манжийн хаан ямар зорилгоор Халхын ноёдод эрх, тавих суурьгүй аягатай цай өгч, тоглоомон морь өмнүүр нь давхиулсан бэ?
8. Зохиолын гол утга санаа нь зохиолын сэдэвтэйгээ хэрхэн холбогдож байгааг ярилцаарай.
9. Түүхэн домог, хууч ярианы онцлогийг уншаад дээрх зохиолоор баталж тайлбарлаарай.
  - Түүхэн домог, хууч яриа нь аман хүүрнэл зохиол бөгөөд ямагт өнгөрсөн үеийн тухай өгүүлдэг. Өнгөрсөн үе рүү хандсан энэ шинж хамгийн гол онцлог нь юм. Өөрөөр хэлбэл хойч үеийн зүгээс өнгөрсөн түүхээ үзэх уран сайхны сэтгэлгээний өвөрмөц шийдэл юм.
  - Түүхэн домог, хууч яриа нь ямар нэгэн түүхэн үнэн, бодитой үйл явдлын учир шалтгааныг уран сэтгэмжээр хүүрнэн тайлбарласан байдаг.
  - Хүүрнэл гэдэг нь зохиолч өөрөө юм уу, аль эсвэл хөндлөнгийн өгүүлэгчийн хэл яриагаар зохиолын үйл хөдөлгөөний дэс дарааг гаргах явдал юм. Хүүрнэл нь голдуу хөндлөнгөөс ерийн өгүүлж буй нэг талын яриагаар илэрдэг ба хүүрнэлийг дотор нь гуравдугаар биеэс хүүрнэх, нэгдүгээр биеэс хүүрнэх, ярианы хэлбэрээр хүүрнэх гэж ялгаж болно.

**Өгүүлэгдэхүүний бүтэц, холбоо хамаарлыг дүрийн үйлдлээр тайлбарлая**

1. Түүхэн домгийн өрнөлд хамаатай хэрэг явдлуудыг бүртгэн хооронд нь харьцуулаарай.
2. Түүхэн домгийн гол гол хэрэг явдал хэний талд шийдэгдэж байгааг шинжлээрэй.
3. Дээрх дасгалыг гүйцэтгэхдээ нэг үйл хэрэг нөгөө үйл хэрэгтэйгээ хэрхэн холбогдож байгаа, нэг дүр нөгөө дүртэйгээ ямар хамааралтай байгаа зэргийг судлан зохиолын үйл явдлын холбоо хамаарлыг шинжлээрэй.

4. Дөрвөн багаар ажиллаж:
  - Зохиолын эхлэл хэсэг
  - Зохиолын өрнөл хэсэг
  - Зохиолын туйл хэсэг
  - Зохиолын тайлал хэсэг
  - Зохиолын төгсгөл хэсгийг олж тэмдэглүүлээрэй.
5. Баг тус бүр зохиолын үйл явдлыг тус бүрд нь олсноо бусдадаа тайлбарлан, алдаа мадагтай зүйл гарсан бол засаж залруулж аваарай.
6. Түүхэн домгийн үйл явдлын уялдаа холбоо нь эхийн утгад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлан ярьж, дүгнэж бичээрэй.
7. Түүхэн домгийн үйл явдлын өрнөл, утга санааны холбоо хамаарлыг ярьж бичихдээ аль болох өөрийн хувийн үзэл бодлоо тусгаарай.

### Орчин, нөхцөл байдлыг тайлбарлая

1. Түүхэн домгийн үйл явдал хаана өрнөж байна вэ? Зохиолын үйл явдал өрнөж байгаа газар орны байр байдал, онцлогийг олж тусгайлан тэмдэглээрэй.
2. Тухайн үеийн Монголын нийгмийн орчин нөхцөл ямар байсан гэж та нар төсөөлж байна вэ? Түүхэн домгоос тухайн үеийн нийгмийн нөхцөл байдал, соёлын онцлогийг олж тэмдэглээрэй.
3. Халхын дөрвөн ханыг ямархуу орчин нөхцөл, уур амьсгал угтаж байна вэ? Халхын дөрвөн ханд цол хэргэм тийм чухал хэрэгтэй байсан юм болов уу? Та нар юу гэж бодож байна?
4. Түүхэн домгийн үйл явдал өрнөж байгаа газар орон, тэр үеийн нийгмийн нөхцөл байдал, соёлыг өнөөгийн нөхцөл байдал, соёлтой холбож тайлбарлан ярилцаарай.
5. Харь газрын орчин нөхцөл, соёлын хүрээнд монгол ноёдын дүр хэрхэн дүрслэгдэж үлдсэнийг ярилцаж, дүгнэж бичээрэй.
6. Сонгон үзэж байгаа түүхэн домгийн орчин нөхцөл нь бусад түүхэн домгоос юугаараа ялгаатай байгааг ярилцаарай.



### Бичих чадвараа хөгжүүлье

Зохиолд орчин, дүр, үйл явдал нэмж бичихдээ дараах зааврыг ашиглаарай.

Зохиолд эхлэл хэсгийг нэмж бичээрэй.

1. Халхын 4 хан цол авахаар явах гэж байгаа үеийн нутаг орны байдлыг дүрсэлж бичээрэй. Тэр үеийн Монгол орны нийгмийн байдлыг түүхийн хичээлтэйгээ холбож таамаглаарай.
2. Үдэж байгаа ард олныг төлөөлөл болгож дүр нэмэхдээ ямар ямар үйлдэл гаргахыг 4 хан тус бүрийн зан чанар, үйлдэлтэй холбож, төсөөлж, дүрсэлж бичнэ.

Зохиолын төгсгөл хэсгийг нэмж бичээрэй.

1. Цол аваад ноёд бие биедээ ямар зан авир, үйлдэл үзүүлэхийг төсөөлж бичнэ.
2. Ард олон хэрхэн угтаж авч, ямар зан, үйлдэл үзүүлэхийг төсөөлж бичнэ.



## Уншихын өмнө

1. “Мэргэн жа гүний түүхэн домог”-ийг уншихын өмнө дараах хуучирсан үгстэй танилцана уу.

Тайж - хааны агь. Хан буюу ноёны угсаа залгамжлагч.

Гүн - феодалын байгууллын таван хэргэмийн тэргүүн зэрэг. Манж Чин улсын үеийн дөрвөн хэргэмийн дөтгөөрх.

Доодос – доогуур хүмүүс, ядуус.

Дээдэс - дээд зэрэгтэн, баяд ноёд.

Шадар - ойр дөт, дэргэд.

Журган - Манж Чин улсын үед эзэн журган яам гэж байжээ. Журмаар засах зургаан яам гэсэн утгатай манж хэлнээс орж ирсэн үг.

Жасаа - тогтмол хугацаагаар ээлж халалцан гүйцэтгэх алба.

Жасаалах - жэлж дараатайгаар тогтмол хаах албанд суух.

Түгээмэл Элбэгтийн 8 дугаар он - аргын тооллын 1858 оны орчим.

2. Монголчуудын хэт цахиуртай холбоотой үг хэллэгийг уншаад зураг дээр тайлбарлаж ярилцаарай.

- Хэт бэл – ган суулгасан саран сүхний хэлбэртэй төмөр дээр уул, цахиур агуулах зориулалт бүхий ширэн сав хадаж, сэнж оосор гаргасан гал ноцоох хэрэглэл.
- Хэт цахих – уулыг цахиурт наалдуулан барьж хэтийг хавиран гал гаргаж ноцоох.
- Хэтний ган – хэт цахих хэсгийн саран сүх хэлбэртэй галт төмөр.



Эх сурвалж: [touristinfocenter.mn](http://touristinfocenter.mn)



## Унших чадвараа хөгжүүлье

### Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя

“Мэргэн Жа гүний түүхэн домог” уншихдаа дээрх үгийн тайлбаруудаа сэргээн санаж, зохиолын агуулгыг сайтар ойлгоорой.

### МЭРГЭН ЖА ГҮНИЙ ТҮҮХЭН ДОМОГ

Сайн ноён хан аймгийн Жонон засгийн хошууны тэргүүн зэрэг тайж, улсад туслагч гүн Жамсранжавтан бол төрийн гүн бодлоготон, нутаг хошуу, хил шадартаа төдийгүй хилийн чанад, харийн газар ч сэцэн мэргэн арга ухаанаараа гайхуулсан



нэгэн байжээ. Монгол нутаг хошууны бусад ноёд түшмэд, доодос, дээдэсгүй цөм түүнийг “Мэргэн Жа гүн” хэмээн алдаршуулан цоллож байжээ.

Мэргэн Жа гүнтэн нэг удаа Бээжингийн Монгол журганы газраа жасаалан суух ээлж тохиож, гурван жилийн өмнөөс шахам Далай Чойнхор вангийн Чавганц дархан гэдэг зартай сайн гангийн дарханд хэтний ган захиалан хийлгүүлжээ. Жасаалах цаг мөч дөхөх тусам дахин давтан бие хүн илгээж, хэтний гангаа авах гэсэн боловч “Бэлэн болоогүй байна” гэж буцаасаар байгаад, аргагүй зарлигт автан, Бээжинд морилжээ.

Манжийн Монгол журганы газар жасаалан суухад, манж ноёд түшмэдийн ааль зан нэн ихэмсэг танхилзуур, хэр барагтай үг тоож дуугарахгүй, хэрэг хэлэлцэхгүй ярвалзан, “хэг ёг” гэсэн болоод л өнгөрдөг байж гэнэ.

Мэргэн Жа гүн ч Чавганц дархнаас хэтний гангаа байн байн нэхүүлсээр нэг өдөр шинэ хэт бэлтэй болсон ажээ. Төдий удалгүй манж ноёдыг урьж залаад, нэг их дайллага ёслол хийх үеэр Мэргэн Жа гүн Монгол журганы их ноёны өөдөөс харж суугаад, зоог идээ барьж гүйцээд, жишүүлдэсхийн харж, хэтээ цахин, тамхиа асаах юм болов. Буруу жишүү хараад, хэтээ ганцхан цохих шиг болсон унжирсан улаан гал шиг юм сунаж ирээд, манж ноёны хоёр урт живэр сахлынх нь өрөөснийг оргүй хуйхлаад, “Халхай, түлхэй” гэлцэж байхад Жа гүн үл мэдэгч царайлж, яаралгүй гэгч нь тамхиа шившиж эргээд харахад нь манж ноён аль хэдийн өрөөсөн сахалтай болчихоод, “Хай, танай энэ яасан их галтай?” гэж толгой сэгсэрч суусан юм гэдэг.

Тамхиндаа мансуураад ийм тоогүй юм болсныг анзаарсангүй ухааны ганц хоёр үг хэлээд өнгөрсөн гэнэ. Чухам тэр цаг мөчөөс хойш, манж ноён түшмэдийн ааш зан илт засарч, юлган зөөлөн гэдэг нь жигтэйхэн, хэрэг хэлэлцэхэд төвөг яршиггүй болсон юм гэдэг.

Энэ явдлын гол утга учир нь тэр цагийн Манж Чингийн төрийн бодлоготнууд монголчуудыг хагархай хар ширмэн тогооноос өөр гартаа барих төмөр эдлэл зэр зэвсэггүй гар мухарлаж аваад, бодсон санасан бүхнээ тулган хүлээлгэж байхаар тооцоолж, түүнээсээ болоод ийм их тэнхэлзүүр, ихэмсэг зантай болцгоосон байсан аж. Чингэмэгц монгол дархны ур ухаанаар бүтсэн гангийн галын гайхамшигийг ганц удаа үзүүлээд л нугас загас шиг болгож номхруулж байсан юм гэлцдэг билээ.

Мэргэн Жа гүн төрийн хэрэг, ном эрдмээ хослуулсаар Түгээмэл Элбэгтийн 8-р оны орчим тэнгэрт хальж, түүний хөвгүүн хошуу олондоо “Огтор сэцэн гүн” хэмээн алдаршсан улсад туслагч гүн Равдандорж засаг ноёны зэрэг залгажээ.

(С.Дулам, Н.Нарангэрэл. “Баянхонгорын түүх домгийн чуулган”.  
УБ., 2011, 28-31 дэх тал)

### Үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг шинжилье

1. Түүхэн домогт утгыг мэдэхгүй, хуучирсан үг хэллэг байвал түүж бичээд, эхийн хам сэдвээс утгыг таамаглаж, дараа нь толь бичгээс харна уу.
2. Дараах хүний зан байдал заасан үгсийн утгыг толь бичгээс харж, тайлбарыг бичнэ үү.

Үгс	Тайлбар
Танхилзуур	
Хэг ёг гэсэн	
Юлган	зөлдөг зөөлөн

- Түүхэн домгийн дүрслэлээс уран дүрслэлийн жишээг түүж бичээд, утгыг тайлбарлана уу.

**Өгүүлэгдэхүүний бүтэц, холбоо хамаарлыг дүрийн үйлдлээр тайлбарлая**

- Мэргэн Жа гүний түүхэн домгийн үйл явдлын эхлэл, гол, төгсгөл хэсгийг тодорхойлно уу. Үүний тулд дараах асуултад хариулж бичээрэй.
  - Хэт захиалж хийлгэх тухай санааг хэн гаргасан бэ? Ямар зорилгоор хэт захиалж хийлгэхээр болсон бэ?
  - Тэр санааг нь хэн дэмжиж, үйл хэрэг болгосон бэ? Тэрхүү үйл хэргийг бүтээх замд ямар саад бэрхшээл тулгарсан бэ?
  - Тэр саад бэрхшээлийг хэрхэн даван туулсан бэ?
- Зохиолын зөрчлийг тодорхойлно уу.
  - Түүхэн домогт гарч буй дүрүүдийн хооронд ямар зөрчилт харилцаа байсан бэ?
  - Үүний үндэс шалтгаан нь юу вэ?

**Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг тодорхойлъё**

- Түүхэн домогт ямар дүрүүд гарч байна вэ? Эдгээр дүрийн хэн хэн нь түүхэн бодит хүмүүс, хэн нь уран сайхны дүр вэ?
- Түүхэн домгийн дүрүүдийг хэлсэн үг, хийсэн үйлдлийг бүртгэн бичнэ үү.

Дүрүүд	Хэлсэн үг	Хийсэн үйлдэл
Жа гүн		
Чавганц дархан		
.....		

- Түүхэн домогт гарч буй дүрүүдийн тухай та нар өмнө нь сонсож байсан уу? Мэргэн Жа гүн ямар зорилготой Чавганц дарханд хэт захиалсан бэ?

**Орчин, нөхцөл байдлыг тайлбарлая**

- Тус түүхэн домогт Монголын түүхийн ямар цаг үеийг хэрхэн тусган харуулж байна вэ?
- Түүхэн домгоос орон, цаг заасан үгсийг зурж тэмдэглэнэ үү. Түгээмэл Элбэгтийн 8 дугаар он гэдэг нь аргын тооллын хэдэн он бэ?
- Түүхэн домогт Манжийн ноёрхлын үеийн монголчуудын амьдрал, нөхцөл байдлыг хэрхэн мэдээлсэн байна вэ?

**Сэдэв, гол санааг тодорхойлъё**

- Түүхэн домгийн түүхэн үндсийг ярилцана уу? Жа гүн гэж мэргэн ухаантай түүхэн бодит хүн байсан уу?
- Монголын гангийн дарх урлалын хөгжлийг үзүүлэх түүхэн домгийн өгүүлэмжийн гол утга санаа юу байна вэ?



**Ярих чадвараа хөгжүүлье**

- Түүхэн домогт өгүүлсэнчлэн Манжийн ноёрхолд байсан үеийн монголчуудын амьдралыг та нар төсөөлж байна уу? Манжийн ноёрхлоос чөлөөлж, тусгаар тогтнолыг авчирсан түүхт хүмүүсийн ач гавьяаг ярилцаарай.
- Манжийн үеийн Монголын түүхийг судалж, домгийн өгүүлэмжтэй харьцуулан хэлэлцэнэ үү.



## Уншихын өмнө

1. Газар усны нэр хэрхэн үүсдэг гэж та нар бодож байгаагаа дараах түүхэн домгоос санаа авч тайлбарлаарай.

Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутагт байдаг Хатан Сэврэй уул нь алсаас харахад хэвтэж буй цоохор ирвэсийн дүртэй гэлцдэг бөгөөд мөн энэ ууланд ирвэс элбэг тул хонь мал руу өнгийх тохиол гардаг байж. Уулын нэр нь анх Ирвэс уул нэртэй байхад энэ араатан ихэд догширч хонь мал барих нь ширүүссэн тул нутгийн мэргэн ардууд нэрийг нь сольж эерүүлэн нэрлэхийн тул Ирвэс нэрийг тонгоргож, Сэври болгосон юм гэлцдэг. Сэври нэр нь сүүлдээ Сэврэй болж энэ араатны догшрох нь багассан (Монголын газар усны нэрийн домог, УБ., 2001 он, 240-р тал) гэж домоглодог.

2. “Арвайхээрийн түүхэн домог”-т юуны тухай өгүүлэх гэж байгааг тааварлаж ярилцаарай.



## Унших чадвараа хөгжүүлье

**Зохиолыг мэдэрч ойлгож уншъя**

“Арвайхээрийн түүхэн домог”-ийг уншихдаа танил биш үгийг тэмдэглээд утгыг мэдэж аваарай.

**АРВАЙХЭЭРИЙН ТҮҮХЭН ДОМОГ**

Агь Үйзэн гүний хошууны ард Гомбо үзэсгэлэнт нэгэн охинтой байжээ. Гэтэл охиныг нь нутгийн баян Балбар гэгч ганц хүүдээ гэргий болгон богтлон сүйлж аваад, өргөн их найр хурим хийжээ. Үүний маргааш өглөө шинэ бэр нь эртлэн босож, өрхөө татчихаад алга болж гэнэ. Хадам эх нь гайхахдаа босоод гарч харсан чинь тэр баруун талд буусан аянчны гадаа уяатай буй нохой шиг хар юмыг эргэн тойрч, энд тэндээс нь хараад байгаа харагдаж гэнэ. “Энэ бэр чинь солиоров уу?” гэж гайхаш тасраад орж иржээ.

Удалгүй бэр ч ирж, галаа түлж, цайгаа чанаж болгоод, хар хүндээ хэлжээ.

- Энэ баруун голын цаад хөвөөн дэх аянчны гадаа чи бид хоёрыг алс нь инээлгэх адуу нэг байна. Энэ аянчдыг хөдлөхөөс өмнө адуугаа ойртуулаад ир. Наад талын цэнхэр майханд нэг буурал толгойтой өвгөн байна. Тэр л эзэн нь болов уу? Аягүй бол дөрвөн гүүнээс нааш өгөхгүй гэж үнэрхэх байх даа. Тэр гадаа нь уяатай буй хар даагыг өртөг хайрлалгүй худалдаж аваад ир гэжээ.

Хархүү хүүхнийхээ ажигч шинжээч байдлыг мэдэх учир аргагүй үгэнд нь орж адуундаа яваад, аянчны гадаа очоод үзвэл арчаагүй муу атигар хар даага байв. Ингээд хархүү зүүн зүгээс яваа аянчидтай уулзан, наймаа хэлэлцвэл хар даагыг



дөрвөн унагатай гүүгээр өгнө гэж үнэрхжээ. Иймд “Авна гэвэл эцэг эх минь уурлана, авахгүй гэвэл эхнэр маань унтууцна” хэмээн эргэлзээд буцаж эхнэртээ хэлбэл:

- Дөрвөн гүүний мэдэлгүй амьтан уу чи гэж уурлаад, өөрийн эцэг эхдээ
- Энэ хар даагыг үнэ хайрлалгүй авч өгөөч гэж гуйсанд малч хичээнгүй, авхаалж сэргэлэн охиноо нэгэн учиртай хэлээ биз гэж санаад, хэлсэн ёсоор нь авч өгчээ.

Эсэргэн жил нь нөгөө хар шүдлэнгээ наадамд уяж уралдуулсанд түрүүлэн ирж, асрын үүдэнд айргаар мялаалган, “Арвагар хээр” хэмээн цоллуулж, ард олонд алдар нэрээ цуурайтуулжээ.

Үүнээс хойш долоон хошуу даншиг наадамд хорь шахам жил түрүүлсээр эцэстээ Арвагар хээр арга буюу хөгшрөн зөнөжээ. Тэднийх уламжлал ёсоор хурдан морьдоо уяж сойход Арвагар хээр уяан дээр нь өөрөө ирж зогсоод явдаггүй байжээ. Морь үсэргэж хурдлуулахад унасан хүүхэдгүй хэр нь дагаж уралддаг байв гэнэ. Мөн хурдан морьдын хамт уяа тойрч, сул тарлан, биеэ шавхруулдаг байсан гэнэ.

Нэгэн удаа наадам болж, наадамчид морио хөтлөн гарахад арвагар хээр хойноос нь бүдчин ядан дагажээ. Гэтэл эзэн нь “Зөнөг хээр яах нь вэ?” гэж хэчнээн хөөвч хангинатал янцгаан, торомгор хар нүднээсээ нулимс бөмбөрүүлээд байсанд эхнэр нь “Заяа нь гомдоно. Хөтлөөд яв” гэж нөхөртөө хэлжээ. Арвагар хээрийг ногтлон хөтлөөд наадамд очиж, их насны морьдын уралдаанд давхиулжээ. Морьд уралдан давхихад өвгөн хээр хамгийн түрүүнд явж гэнэ. Гэтэл Балбар ноёны нэг морь хойноос нь гүйцэж, зөв талд нь зуузай холбон явснаа яг барианд орохын даваан дээр гэнэт түрүүлэн гарахад түүний сүүлийн угийг арвагар хээр хазаж аваад, дороо үсрэн ойчсон гэнэ. Наадамчид цуглан ирэхийн сацуу Балбар баяны бэр нүднийхээ нулимсыг мэлмэрүүлэн, толгойг нь түшихэд Арвагар хээр дахин нэг өндийн янцгаагаад, амьсгал хураажээ. Наадамчин олны хүсэлтээр түрүүлсэн морины бай шагналыг Арвагар хээр моринд эцсийн удаа олгон, эзэн хүүхэнд нь гардуулжээ.

Тэр хүүхэн нөхөртэйгөө хоёул Арвагар хээр мориныхоо толгойг анх удаа наадамд уралдан түрүүлсэн Шар талын дундах нэг толгойн энгэрт аваачиж оршуулжээ. Үүнээс хойш Агь Үйзэн вангийн хошууны Шар талыг Арвагар хээрийн тал гэдэг байсан боловч уг нэр хувирсаар Арвайхээрийн тал хэмээн нэрлэгдэх болжээ. Мөн Арвагар хээрийн толгойг тавьсан толгойг Арвай толгой гэх болсон гэнэ. Эдгээр газар Өвөрхангай аймгийн төвийн орчим Тарагт сумын нутагт бий.

*(Монгол домог. Эмхэтгэсэн Х.Сампилдэндэв, редактор Д.Цэрэнсодном. ШУА ХЗХ, УБ., 1984, 211-213 дахь тал)*

### **Өгүүлэгдэхүүний бүтэц, холбоо хамаарлыг дүрийн үйлдлээр тайлбарлая**

1. Асуултад хариулж Арвайхээрийн түүхэн домгийн үйл явдлын эхлэл, гол, төгсгөл хэсгийг тодорхойлно уу.
  - А. Арвагар хээрийг худалдаж авах санааг хэн гаргасан бэ?
  - Б. Тэр санааг нь хэн дэмжиж, үйл хэрэг болгосон бэ? Тэрхүү үйл хэргийг бүтээх замд ямар саад бэрхшээл тулгарсан бэ?
  - В. Тэд саадыг хэрхэн даван гарч зорьсондоо хүрсэн бэ?
2. Зохиолын зөрчлийг тодорхойлно уу.
  - А. Арвагар хээрийг авах гэхэд эсэргүүцсэн юм уу, эсвэл саад учруулсан хүн байсан уу?
  - Б. Түүхэн домгийн баатруудын зөрчилдөх шалтгаан нь юу байж болох вэ?

**Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг тодорхойлъя**

1. Түүхэн домогт ямар дүрүүд гарч байна вэ? Дүрүүдийг хэлсэн үг, хийсэн үйлдлийг бүртгэн бичнэ үү.

Дүрүүд	Хэлсэн үг	Хийсэн үйлдэл
Бэр (эхнэр)		
Нөхөр		
.....		

2. Бэрийн зорилго нь юу байсан бэ? Тэр зорьсондоо хүрсэн үү?
3. Тус түүхэн домогт гарч буй бэрийн дүр нь та нарт өөр нэгэн зохиолын баатрыг санагдуулж байна уу? Арвагар хээрийг шинжин таньсан бэрийн дүрийг Цэцэн бэрийн үлгэрийн баатартай харьцуулан ярилцаарай.

**Орчин, нөхцөл байдлыг тайлбарлая**

Түүхэн домгоос орон, цаг заасан үгсийг эшлэн, орчныг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлана уу.

**Үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тодорхойлъя**

1. Дээрх түүхэн домогт мэдэхгүй үг хэллэг байвал түүж бичээд эхийн хам сэдвээс утгыг таамаглаж, дараа нь толь бичгээс харна уу.

Танил бус үг	Толь бичгийн тайлбар	Хам сэдвийн утга
.....		

2. Түүхэн домгоос уран дүрслэлийн жишээг түүж, утгыг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
...	

**Сэдэв, гол санааг тодорхойлъя**

1. Хурдан морины нэрээс газар усны нэр үүссэн тухай түүхэн домгийн гол утга санаа юу юунд оршиж байна вэ?
2. Та гол санаа гэж үзэж байгаагаа тодорхой баримтаар баталж тайлбарлаарай.



Ярих чадвараа хөгжүүлъя

**Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярья**

1. Түүхэн домгийг ярихдаа харилцан яриа хийгээд зан төрхийг хэрхэн гаргаах төлөвлөж, сонирхолтой байдлаар яриарай.
2. Та нарын сонссон ямар газар усны түүхэн домог байна вэ? Энэ тухай нөхдөдөө ярьж өгөхдөө үнэлгээний хүснэгтийг ашиглаарай.

**ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ**

1. Хүснэгтэд дурдсан уул усны нэрээс санаа авч, оршин суугаа нутаг орныхоо газар усны нэрийн жагсаалтыг гарган, сэдэвчлэн бичээрэй.

Шинж чанар	Уул, усны газрын нэр
Байгаль цаг уурын үзэгдлээр нэртэй	Салхит, Бороогийн гол, Наран толгой
Эрдэс баялгийн нэртэй	Төмөрт уул, Рашаант, Хужирт
Амьтан ургамлын нэртэй	Мойлт, Нэрст, Могойт, Шаазгайт
Үндэстэн, овогтон, угсаатны нэртэй	Их монгол, Боржигины тал
Түүхэн хүн, үйл явдлыг тусгасан	Цогтын хадны чулуу, Бичигт хад
Цол хэргэмийн нэртэй	Вангийн цагаан уул
Өнгө зүс заасан	Бор-Өндөр, Эрээн нуур
Шинж чанар заасан	Хүйтэн гол, Шорвог нуур
Тоо заасан	Гурван булаг, Гучин Гурван Хөхий
Хэмжээ заасан	Бүдүүн ухаа, Их Богд
Зүг чиг заасан	Баруун Хараа
Хэлбэр төрхөөр нь нэрлэсэн	Майхан уул, Толь хад
Бөө мөргөлийн шүтлэгт	Даян дээрхийн агуй, Бөөгийн зоо
Буддын шашны шүтлэгт	Мааньт, Суварган говь
Үлгэр домгоос сэдэвлэсэн	Орлой гурван зээрд
Үг сунжирч үүссэн	Арвайхээр, Шивэрт

2. Түүхэн домгуудад нийтлэг ямар шинж байгааг бичээрэй.


	Жишээ, баримт	Тайлбар
Орон цаг		
Үйл явдал		
Баатар, дүр		
Утга санаа		
Үг хэл		

3. Уншсан түүхэн домгуудаа дараах хүснэгтийн дагуу харьцуулан дүгнэж бичээрэй.

	Хорь түмэд, Хоридай мэргэний домог	Халхын дөрвөн хан цол авсан нь	Мэргэн Жа гүний түүхэн домог	Арвайхээрийн түүхэн домог
Угсаатны түүхэн домог				
Түүхэн түүхэн домог				
Аж байдлын түүхэн домог				
Уул усны түүхэн домог				

4. Угсаатны түүхэн домгийн баатар хийгээд уул усны түүхэн домгийн баатрыг харьцуулна уу.
5. Аж байдлын түүхэн домгийн баатар мэргэн ухааныг сургадаг гэвэл угсаатны түүхэн домогт чухам юуг онцолдог вэ?
6. Уул усны түүхэн домог хийгээд аж байдлын түүхэн домгийг харьцуулан адил ба ялгаатай талыг тодруулна уу.

7. Уул усны түүхэн домогт уул усны тогтоц хийгээд нэрийн гарал чухал бол түүхэн түүхэн домогт юуг эрхэмлэн үзүүлдэг вэ? Жишээгээр тайлбарлаарай.



**Түүхэн домгийн төрөл зүйлийн онцлог**

- Үйл явдал нь хурц зөрчилтэй, хураангуй шинжтэй байна.
- Утга санаа нь голдуу түүхийн сургамжийг сануулах утгатай байна.
- Үг хэл нь ардын ярианы хэл найруулгатай, хүүрнэл аястай байна.
- Орон, цаг нь түүхэн, бодит, тодорхой газар орон, он цаг байна.
- Дүрүүд нь түүхэн, бодит, оноосон нэр устай хүн байна.

**ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ**

Шалгуур	Үнэлгээ	Гүйцэтгэл
<b>УНШИХ</b>		
Түүхэн домгийг уншаад зөв мэдэрч ойлгон утга санаа, дүр дүрслэлийн онцлогийг үйл явдлын уялдаа холбоо, орчин нөхцөлтэй нь зөв хослуулан шинжилж тайлбарласан байдал	1-5 оноо	
<b>ЯРИХ</b>		
Уншсан түүхэн домгоо үйл явдлын өрнөлийн дагуу өөрийн үгээр зөв цэгцтэй тодорхой ярьж байгаа байдал	1-5 оноо	
<b>БИЧИХ</b>		
Уншсан түүхэн домгийн үг хэл, дүрслэлийн аргыг дуурайн бичиж, өөрийн бичих чадвараа нэмэгдүүлсэн байдал	1-5 оноо	

# II БҮЛЭГ. МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ

## Судлах эх зохиол:

### 2.1. ТУУРЬ

- Б.Ринчен “Шүхэрч Буниая”
- Л.Түдэв “Эрээн цоохор”
- Ц.Түмэнбаяр “Цагаан сүүний домог”

### 2.2. ӨГҮҮЛЛЭГ

- Д.Нацагдорж “Хуучин хүү”
- Г.Мэнд-Ооёо “Нутаг гүйсэн унаганы дууль”
- П.Пүрэвсүрэн “Бурханбогд аав хоёр”

## Эзэмших чадвар:

### УНШИХ

- Зохиолыг мэдэрч ойлгох, тусган хүлээж авах
- Туурь, өгүүллэгийн онцлогт тохирсон хэл найруулга, орчин, дүр, сэдэв, утгын задлал хийх
- Монголын түүх, соёл, уламжлалын үнэт зүйлийг ойлгож, хүндэтгэж сурах

### БИЧИХ

- Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүр, дүрслэлийн талаарх мэдрэмж, сэтгэгдлээ уран дүрслэл ашиглаж бичих
- Зохиолд дүр, орчин нэмэх, харилцан яриа оруулах зэргээр дэлгэрүүлж бичих

### ЯРИХ

- Зохиолын дүрийн талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярих
- Зохиолын гол санаа, дүрийн зан төрхийг ойлгож мэдэрснээ дүр бүтээж харуулах




## 2.1. ТУУРЬ



## Уншихын өмнө

1. “Шүхэрч Буनिया” зохиолыг уншихын өмнө зохиолчийн намтар, уран бүтээлийн талаар товч мэдээллийг уншаад, хосоороо ярилцаарай. Зохиолчийн талаарх өөрсдийн мэддэг зүйлийг нэмж яриад, баяжуулан судлаарай.

## Бямбын Ринчен



(1905-1977)

1905 онд Булсарай (Одоогийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум)-д төржээ.

Орос, чех, польш, франц, англи, эсперанто, герман хэлтэй соён гэгээрүүлэгч бичгийн их хүн. 1956 онд "Монгол хэлнүүдийн харьцуулсан түүхэн хэлний зүй" бүтээлээрээ Унгар улсад хэл бичгийн ухааны эрдмийн зэрэг хамгаалж, Монголын анхны шинжлэх ухааны доктор цолтой эрдэмтэн болжээ.

1923 онд уран бүтээлээ эхэлж "Үүрийн туяа" гурамсан роман, "Заан залуудай", "Бэр цэцэг", "Гүнж", "Сандоо амбан", "Их нүүдэл" зэрэг ном хэвлүүлжээ. 1946 онд БНМАУ-ын Төрийн шагнал, 1965 онд МЗЭ-ийн шагнал хүртжээ.

2. Зохиолын нэрийг уншаад дараах асуултын дагуу ярилцаарай.
  - А. Дэлхийн түүхэнд хамгийн анх шүхэр хэрэглэж ниссэн хүний талаар та нар юу мэдэх вэ? Ярилцаарай.
  - Б. “Буनिया бандийн шүхрийг хэрэглэн Тэнгэр тэтгээгчийн аравдугаар онд нисэж торлогдуулан үхсэн....” гэснээс зохиолд хэзээ болсон, ямар үйл явдал гарахыг таамаглаж ярилцаарай.
3. Уншихын өмнө дараах үгсийн утгыг тайлбарлаж ярилцаарай.
 

Цам - чөтгөр, сахиулсан, араатан гөрөөсний толгойн дүртэй баг өмсөж бүжиглэх шашны ёсны бүжиг

Цогдом - ерөөлийн хурлын эхний өдөр олон хуврагийг донгодон сургах шашны зан үйл

Хударга - эмээлийн хавтасны хойд талд уяж, морь малын сүүл бөгсөнд тогтоох бэхэлгээ оосор

Хошоо -

Хөлтэй -

Уран арга хэрэглэх -

Хатангир-



## Унших чадвараа хөгжүүлье

## Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя

1. Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглээд “Монгол хэлний их тайлбар толь” ашиглан утгыг мэдэж аваарай.

**ШҮХЭРЧ БУНИЯА**

(Туурь)

Манж Дайчин улсын Тэнгэрийг тэтгэсэн хааны аравдугаар он билээ. Улиастайд суугаа зарлигийн манж сайд Автай сайн хааны байгуулсан Эрдэнэ Зуугийн хийдийг сонирхон үзэх гэж зуны дэлгэр сайхан цагаар Зуугийн цамын үест очсон байжээ.

Ойр хавийн монгол ноёд тайж, ард олон цам үзэх гэж Зуугийн орчин тойронд их л хөлтэй. Энд тэндгүй эрээн майхан, гоёлын хувцас өмссөн хүрэн улаан царайтай, өргөн их хэнхдэгтэй, идэр талын хүдэр эрчүүд, чилгэр сайхан биетэй, сайхан царайтай хүүхэн, тэгшхэн зассан дэлтэй, гоё эмээл хударгатай морио унацгаан, хэд хэдээрээ дөрөө зэрэгцэн өргөн талд давхиж явахыг манж сайд үзээд, моринд чадамгай, бие чийрэг, зориг хатан энэ монголчууд, манай манжаас давуу эртний соёлт, эрх чөлөөнд дуртай улс ажээ. Уран арга эс хэрэглэвэл, захирахад амаргүй улс, Шарын шажнаар номхотгох гэж Тэнгэр тэтгэгч эзний явуулж байгаа бодлого маш мэргэн ажээ хэмээн бодсоор Эрдэнэ Зуугийн цамын баг хэрэглэл маш нарийн гоёмсгийг гайхан, монгол урчуудын чадлыг бахдан үзжээ.

Баруун зүг шинэ хязгаар, хошоо аймгийг байлдан дарах аянд явалцсан манж сайд бие хатангир, моринд сүрхий эр. Нойр багатай эрт босдог хүн байжээ. Зуугийн их ламтнаас зарлигийн сайдад тусгайлан барьсан гэрээс нар битүүгээр гарч, хээр талын сайхан өвс цэцгийн үнэр анхилсан агаарыг амьсгалаад гадаа орчин тойрныг үзэж, Эрдэнэ Зуугийн олон сүм дуганы оройг хартал, Зуугийн их сүмийн орой дээр нэг юм хөдлөх шиг болжээ. Шувуу гэхэд дэндүү том, хүн гэхэд тийм эрт хар үүрээр сүм дээр хэн гардаг билээ гэж тэр зүг гайхан хартал, үнэхээр хүн бололтой.

Энэ ямар хүн, юу хийж байгаа билээ? гэж ажиглан ширттэл, нэг хүн, сүмийн орой дээрээс доошоо үсрэх шиг боллоо. Араас нь шүхэр шиг нэг юм дэлгэж, тэр хүн шүхэрт өлгөгдөн үүрийн зөөлөн салхи даган намрын цэнхэр өдөр шүлсээ дэлгэн нисэх аалз мэт гар арваганан, шүхрийнхээ татлагыг татан залж нэлээд нисээд далд оржээ.

Баахан удасхийгээд бас дахин Зуугийн өндөр сүмийн орой дээр өглөөний тэнгэрт маш тодхон зурайж үзэгдээд, бас харайжээ. Манж сайд түүнийг их л жиг болгож дахин сүм дээрээс үсрэн буухыг хэчнээн хүлээтэл үзэгдсэнгүй. Сайдын бараа болж явсан цэргийн дарга нь гарч орон, амбаныг ёсолсонд хариу ёслон дохисхийгээд гэртээ орж, хойш өглөө юу болдог бол, бас л энэ үед гадаа гарч үзье гэж боджээ.

Хойш өглөө мөн өнөөх сүмэн дээрээс тэр шүхэрчин харайжээ. Хүн амьтан цөм унтаастай гэж бодсон бололтой. Үймүүлэн цочоох хүнгүй тул дөрөв дахин харайгаад үзэгдэхгүй болсонд түүнийг алсаас харж байсан манж сайд дотроо гайхан, цамчин цөмөөрөө хэдийн буцсан тул, манж сайд тэр өдөр Улиастайд буухаар болж, их ёслолоор Зуугийн лам тушаалтан мяндагтан үдэх үед амбан сайдаас зуугийн их ламд хоёр өглөө үзсэнээ гайхан хэлжээ.

Зуугийн лам, махлаг том биетэй олныг захирч сурсан эзэрхэг царайтай өвгөн, тэр манж сайдын үгийг сонсоод,

- Танхай банди нар дүрсгүйтэж байгаа бол уу? Учрыг нягталж мэдээд, номын сахилга бат алдсан тэр хуврагийг хэрхэн шийтгэснийг сайдад дараа айлтгая гэжээ.

\* \* \*

Эжий нь эвлэг зөөлөн гараараа ар нурууг нь илж байх шиг болж, Буनिया тэгэхэд нүдээ нээж үзвэл хамаг бие хөшиж, нуруу зоо тэсгэлгүй хорсон өвдөж,



нэг мэдэхнээ баруун гараа дэрлээд, зүүн гараа бие дагуу сунгаж, «Хэвтэж байгаа арслангийн маягаар» хуучин муу журам дээрээ эзгүй хээр ууланд хэвтэж байснаа гайхан мэджээ. Тэр нурууг нь зөөлөн гараараа илж байсан нь эжий нь биш сагсгар үстэй нохой долоож байснаа, жаал бандийн хөдөлсхийхэд, нүүрийн тушаа ирж, нэг долоочхоод оцойн сууж сүүлээрээ газар пад пад цохилж, Буनियाгийн царайг цэцэн нүдээрээ ширтэж, босож өндийж үз гэсэн юм шиг харжээ.

Буनिया тэр нохойг, өдөр бүр яс мах хаяж өгдөг золбин халтар гэж таниад, хөдөлж босох гэтэл, бүх бие хөшин, уруул хатаж, ам тэсгэлгүй цанган, толгой заадсаараа задрах гэж байгаа мэт машинд өвджээ. Хамаг бие хэмх зад буусан юм шиг, нүд эрээлжлэн зовхио аньсхийж нэгэн хэсэг хэвтээд, дахин нээж урьд нь харагдаж байгаа газрыг гайхан хартал, Зуугийн лам нарын яс тавьдаг газар мөн бололтой. Тэнгэр баахан үүлтэй, хээрийн сэрүүн салхи сэнгэнэн, жаал хүүгийн халууран өвдөж байгаа биеийг дэвүүрээр дэвэх мэт сэрүүцүүлэх ажээ.

Буनियाгийн ухаан санаа ороолдон зангирч жуушаан утас мэт хөврөн эх захгүй болж, юунд энд яс тавьдаг газар хүрч ирээд хэвтэж байгаа билээ? Хэдийн таньдаг энэ газар дэлхий, хөх тэнгэр яагаад жигтэй шарлаж, сонин өнгөтэй танигдашгүй хачин үзэгдэх болов? Би энд хэчнээн хэвтэв гэж бодтол гэнэт ухаан орсон юм шиг сэтгэлд нь хамаг юм тов тодхон санагдлаа.

Улиастайн амбан сайд явсны хойш өглөө, нар битүүгээр Зуугийн гол сүмийн орой дээрээс дахин нисэх гэж шүхрээ үүрч гараад, татлага холбоог нь хоёр суган дороо бэхлээд доошоо үсрэн татлагыг нь ээлж ээлжээр татаж залсаар урьд урьд өглөөнийхөөсөө нэлээд хол буусандаа бахдаж шүхрээ яаран эвхэж, дахин сүм өөд сэмхэн хөл нүцгэн гүйхдээ, анх лойлинд орхимжоо дэлгэн нисэж явсан лам нарын бяцхан баримлыг үзсэнээсээ санаа авч хулгайгаар ламын хэрэглэл, номын баринтгийн хуучин даавуу сэм зүүж багшийнхаа хуучин шүхрийн үлгэрээр хийгээд хашаан дээрээсээ үүрийн шөнөөр үсэрч шүхрийнхээ голд нь салхи дээшээ гарах нүхтэй болгож тэр хэмжээг нь их болгосоор давхар илүү байшингийн дээрээс зүрхлэн үсэрч сургуулийг нь хийж шүхрээ хүн унтсан хойно хулгайгаар засаж, сэлбэсээр Зуугийн бага шиг дуган дээрээс үүрийн шөнөөр үсрэн хальж, эцэс сүүлдээ өндөр сүм дээрээс үсэрч, шүхрээ залж улам улам ахиулан нисэж байснаа санаж, нүдээ аниад амбан явсны хойт өглөө болсон явдлаа бодоход сайн ниссэндээ улам урамшиж дахиж сүм дээр авиран нистэл доошоо нэг харсанд хэдэн чийрэг дуганч нар сүмийн довжооны хайсны цаана бүгж байснаа өндийн харах нь үзэгдэж одоо л хэрэг биш боллоо гэж, агаарт шүлсэндээ асан нисэж яваа аалз шиг гараа арвагануулан салхины аясыг дагаж хэрэв даваад буудаг бол ухаантай юмсан гэж бодтол нь, сүмийн довжоон дээрээс гутал нижигнэх чимээ гарч билээ.

“Одоо л намайг барих нь, тэнгэр минь, салхи минь тусалж энэ хэрэм дээгүүр саадгүй давуулаасай” гэтэл хөлөөс нь нэг юм шүүрээд авах шиг болж, “Барь!, барь!” гэж хашхиралдан, өөрийн эрхгүй доошоо татагдан ойчсон билээ.

- Чи муу яаж байгаа чинь энэ вэ? гэж гүйж амьсгаадсан бүдүүн цоохор дуганч, Буनियाг тас тэвэрч хэдэн дуганч нар шүхрийг нь мулт татаж аваад их гэсгүйд хүргэсэн нь санаанд оров.

- Горьгүй юм боллоо! гэж Буनियाгийн зүрх түгшин, хоёр талаасаа чийрэг дуганч нарт шахуулан, их гэсгүйд хүртэл эрт унтаж, орой босдог гэсгүй лам хэдийн босож өргөөндөө хүрдээ эргүүлэн хоймортоо сууж байснаа:

- Задарсан хар тархи, чи яаж байгаа нь энэ вэ? Орон хийдэд түмэн төвөг татаж, зарлигийн амбан сайдад ёсон бус явдлаа мэдэгдсэн чамайг зад торлогдож, олон шавь нарт цээрлэл үзүүлнэ гэж нүүр нүдгүй загнаж, Зуугийн ламд муу нохой бандийг ёсон бус хэрэгслийн хамт барьсныг айлтга гэж шавь нараа зарж, удалгүй Зуугийн ламын шавь нь ирж

- Багш, Буनियाг яаж ниссэнийг үзэх гэж байна. Сүмийн тэнд аваачна уу гэж иржээ.

Шүхрээ татлагаар нь хоёр сугандаа торгоод нисдэг тэр сүмийн тэнд хийдийн мяндагтан цөм нэгэн зэрэг зарласан мэт хэдийн цуглаж, зүрх түгшин айж эмээсэн Буनियाг тэр их багш лам нарын өмнө сөгдөн суулгаад, Зуугийн их лам:

- За, чи бидний өмнө нэг нисээд үз. Ямар буг шулам чамд ийм арга зааж өгсөн юм бол! гэхэд гэсгүйд зандруулан Буनिया, бүх бие чичрэн, айн эмээж, дахин тэр сүмэн дээр гараад, шүхрээ татлагаар нь хоёр сугандаа торгохдоо, айсандаа болж ухаан нэг орж, нэг гарч байх шиг болж өндөр сүмийн орой дээрээс улаан шар хувцастай ихэс лам нарыг харахад, бор шувуу шиг жижигхэн харагдаад, их гэсгүйг гараараа зангаж, үсэр гэж дохиход, миний энэ шүхэр минь хангардийн далавч шиг болж, эндээс намайг долоон уулын цаана буулгадаг ч болоосой гэж аман дотроо ээжий минь! гэж шивнээд үсэрсэн нь санаанд нь оржээ.

Шүхэр нь пад хийгээд дэлгэж Буनियाг хоёр суганаас нь өргөж, олон удаа үсрэн нисэж, бие нэг соньхон болоод ирдэг байдал нь мэдэгдэж, үүрийн зөөлөн салхины аясаар шүхрээ татлагаар нь залж, дор ногоон зүлгэн дээр сууж байсан ихэс лам нарын дээгүүр нисэн өнгөрөхдөө зуугийн их ламын гуулин шанага шиг хүрэн халзан толгой нь тов тодхон, ив илхэн үзэгдсэн нь Буनियाгийн санаанд орж, гайхан цочицгоосон лам нар, гар хуруугаараа зааж, дүнгэр дүнгэр дуугаралцаж байсан нь дуулдаж, олон суваргат хэрмийн ёроолд буучхаад өөдөөс нь айсуу лам нарын зүг эмээн харж байсан нь Буनियाгийн санаанд орж ирлээ.

Тэгээд, тэр өдөр, олон лам хуврагийн өмнө их гэсгүй бэрээгээрээ багана цохин цогдомдож, Винайн ёсонд хувраг хүний зарчимд үл нийлэлцэх явдал өдүүлсэн банди Буनियाг шүхрий нь шатааж, зуу торлогд гэж ял оноосон, чийрэг дуганч нар зоон дээр нь торлогдож эхэлсэн нь санаанд оржээ.

Зиндааны нөхөд нь айн сандарсан нүдээр харж, торлог нуруун дээр нь буух нь тэсэхийн аргагүй өвчтэй, ижий ижий! гэж бархирч байсан “арав, арван нэг, арван тав, арван зургаа” гэж торлог тоолж байсан дуганчийн дуу дуулдаж байснаа юу ч мэдэхээ больсон, одоо зуугийн лам нарын яс тавьдаг газар хэвтэж байгаагаа бодвол, намайг үхсэн гэж, энэ рүү авчран хаяжээ гэж бодоод толгой өндийх гэтэл, ар нуруугаар нь хутгалах шиг өвдөөд шилэн хүзүүгээр хатгуулах шиг болж ёолсонд золбин халтар, сүүлээ шарван босож, Буनियाгийн омголтсон уруулыг долоожээ.

Өндийж босох гэтэл, зад нүдүүлсэн бие тэсгэлгүй өвдсөнд Буनिया түр ухаан алдаж, дахин мэдээ ороход, өнөөх золбин халтар ч байхгүй, улам ч ганцаардсан шиг болж, нүднээсээ нулимс цувруулан цорхиртол уйлах гэтэл, зодуулж бархирсаар сөөсөн хоолойноос шуухинах чимээ гарахаас биш дуу гарч өгсөнгүй, ижий ижий гэж шивнэн, омголтсон уруулаа долоож, цангаж хатсан амаа дэмий л ангалзлаа. Торлогдуулсан нуруу зоо нь улайсгасан төмрөөр хайрч байгаа юм шиг өвдөж, жаал хүүгийн бүх бие халуурч, толгойг төмөр боолтоор шахаж боосон юм шиг, хоёр чамархайд нь лүг лүг, лүг лүг гэж лантуугаар цохиж байх адил, багадаа цоорхой хар гэртээ ижийнхээ дэргэд хэвтэж байх шиг хүүгээ дэмий ч лам болгов

уу даа гэж тэр жил хэлж байсантайгаа адил, ижий нь гасалж, нурууг нь илж байх шиг, зөөлөн хуруугаараа хөлөөс нь өөд нь илэх бүр өвдөх нь барагдан, бие тун сонин хөнгөхөн болж байх шиг, шүхэртээ өлгөгдөн агаарт хөвж нисэж байх шиг, санагдсаар, ижий ижий! гэж шивнэсээр Буनिया мэдээ алдаж, үхэтгэхийн өмнө,

- Хүү минь ээ, наашаа ир, чи хаана байна? гэж аль хэдийн нас барсан эжий нь холоос дуудах шиг чихэнд нь дуулдаж, ээ, би энд байна аа! гэх гээд хоолой нь хэрчигнэж, нэг юм дуугарах шиг болоод хөлөө жийн бүх бие нь тавигджээ.

\* \* \*

Монгол улсын арван наймдугаар онд Герман улсын монголч эрдэмтэн Эрих Хеништэй баруун аймгаар явахдаа Улиастай хотод орос Цэрэн гэдэг өвгөнийг Улиастайн Гэсэр сүмд орон нутгийн тун соньхон музей үүсгэн байгуулсанд нь тэр үеийн Судар бичгийн хүрээлэнгээс музейн модон тэмдэг хүргэж өгөөд, өвгөн Цэрэнгийн байгуулсан музейн нэг байшинд Улиастайн амбаны хуучин данс бичиг байсныг сонирхон сөхөж үзэхэд Тэнгэр тэтгэсний аравдугаар оны бичиг хэргийн дансанд Эрдэнэ Зууд шүхэр хэрэглэж ниссэн банди Буनियाг торлогдон шийтгэсэн учрыг мэдүүлсэн бичиг үзэж, Европт Отто Лиликталь гэдэг герман хүн анх шүхэр хэрэглэж нисэхийг оролдсоноос аль эрт Эрдэнэ Зууд нэг ядуу жаал банди Буनिया, цовоо ухаан санаагаараа шүхэр хэрэглэж нисэх гэж оролдоод, торлог даасангүй үхсэнийг нь Улиастайн амбанд айлтган мэдэгдсэн бичгийг гашуудан үзсэн билээ. Парашют гэж манайхны гадаад үгээр хэлдэг нь монголоор шүхэр гэсэн үг тул ах дүү Өвөр монголд парашютч гэдгийг шүхэрч гэж дэлхий нийтийн ёсоор тэр үгийн утгыг өөрийнхөө эх хэлээр орчуулан нэрлэдэг нь бахтай хэрэг. Гагцхүү улирал бусын цагт төрөөд, урьдын үест ардын хэчнээн авьяастан хүн ингэж, хөөрхий Буनिया шиг авьяас чадлаа гаргаж чадалгүй амь бие хохирч байсныг санахад гашуудалтайг хэлэх үү!

Миний тэмдэглэлийн дэвтэрт хорин есөн жилийн өмнө Улиастайн амбаны хуучин данснаас Гэсэр сүмд байгуулсан музейд Буनिया бандийн шүхрийг хэрэглэн, Тэнгэр тэтгэгчийн аравдугаар онд нисэж торлогдуулан үхсэнийг үзэв гэж товч тэмдэглэл хийснээ энэ 1957 оны зуны сүүл сард туурь болгож бичсэн учир гэвэл, Улиастайд өвгөн Цэрэнгийн байгуулсан музейг намайг тавин таван онд Чехословакийн эрдэмтэн Поухатай Улиастайгаар явахад байхгүй болж, Гэсэр сүм нь ч байхгүй болж, Улиастайн амбаны хуучин данс хар нь ч үрэгдэж, үгүй болоод, ойрын хэдэн жилд шинэчлэн байгуулсан орон нутгийг судлах кабинетад ч амбасын хуучин данс хар үгүй тул, монгол шүхэрчийн тухай түүхэнд орох гашуудалт тэр баримт нь үгүй боловч уран зохиолын нэг өгүүллэгт нэр нь орж хойчийн уншсан хүнд дурсагдаж гэж үүнийг бичлээ. Уг бичиг нь байвал, сүрхий лам түшмэл зохиож, хөөрхий Буनियाгийн өгсөн өчиг нь арван тав зургаатай хүүхдийн амнаас гарсан үгийг тэр хэвээр нь тун аятайхан тэмдэглэн авч, хэрхэн торлогдон шийтгэсэн мөн тэр шийтгэлийг даалгүй үхсэн зэргийг сүрхий бичсэн бичиг байсан билээ. Орос Цэрэн өвгөн тэр жаалыг гол нь тасраагүй байхад хаячихсан гэж хууччуулын амнаас багадаа дуулсан гэж хэлсэн үг нь миний цээжинд одоо хүртэл тодорхой бий. Гагцхүү тэр бичгийн доторх нарийн үг өчгийг он удаж мартжээ.

1957

*(Б.Ринчен. "Гүнж", Монголын зохиолчдын хорооны хэвлэл.  
УБ., 1969 он, 97-105 дахь тал)*

2. Уншсанаа дараах асуултын дагуу ярилцаж бататгаарай.
  - А. Зохиолын гарчиг, зохиолын эхлэл хэсгээс хэзээ өрнөж байгаа ямар үйл явдлын тухай уншсанаа хосоор ярилцаарай.
  - Б. Манжийн амбан монголчуудын талаар “Уран арга эс хэрэглэвэл, захирахад амаргүй улс, шарын шашнаар номхотгох гэж Тэнгэр тэтгэгч эзний явуулж байгаа бодлого маш мэргэн ажээ” гэж бодох болсон шалтгааныг зохиолоос таваас доошгүй баримт гарган батлаарай.
  - В. Зохиолын эхлэл хэсэгт байгаа түүхэн ойлголтын тухай товч мэдээллийг уншаад хосоороо ярилцаж, ойлголтоо бататгаарай.

Түүхийн тайлбар:

- Тэнгэрийг тэтгэгч хааны он тоолол нь 1736 оноос хойш 1795 оны хооронд 60-аад жил үргэлжилжээ.
- Монгол Улс 1636-1911 онд Манж Чин улсын эрхшээлд байжээ.
- 1911 онд Монголд өрнөсөн эрх чөлөөний тэмцлийн дүнд манжийн дарлалаас чөлөөлөгдсөн.
- Автай сайн хан (1554-1588). 1580 онд Автай сайн хан, дүү Түмэнхэн ноёны хамт гутгаар Далай ламтай уулзаж, өөрийн нутагт сүм хийд байгуулахаа амласанд Далай лам Хархорум хотын нэгэн хуучин сүмийг сэргээхийг зөвлөсний дагуу 1585 онд эртний Тахай балгасан дахь сүмийг сэргээн босгож дуусгасан нь одоогийн Эрдэнэ Зуу хийдийн гол сүм юм.
- Эрдэнэ Зуу хийд нь Монгол Улс дахь хамгийн эртний Бурханы шашны хийд. Хийд нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвийн ойролцоо, эртний хот Хархорумын туурийн хажууд байрладаг.

**Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг дүгнэе**

1. Туурь өгүүллэгийн Буниагийн дүрийг дүгнэхдээ хүснэгтийн дагуу ажиллаарай.

Дүрийн зорилго	Зорилго 1	Зорилго 2	Зорилго 3
	Шүхэр хийж, шүхрээр нисэж сурах	Шүхрээ сайжруулж, улам өндрөөс нисэх	Шүхрээр өндөрт, хол нисэж баригдахгүй байх
Зорилгодоо хүрэх арга зам			
Сонгосон арга зам нь зөв эсэх			
Ямар үр дүнд хүрсэн			
Хэрвээ би байсан бол?			
Дүрийг тодорхойлбол	Шинийг санаачлагч, оролдлоготой, зоригтой		

2. Өгүүллэгийн дүрийн дотоод ертөнцийн зөрчилт байдлыг хэрхэн уран нарийн дүрсэлснийг нэг дүрийг сонгон авч тайлбарлаарай.



**Өгүүлэгдэхүүний бүтэц, холбоо хамаарлыг дүрийн үйлдлээр тайлбарлая**

1. “Шүхэрч Буनिया” өгүүллэгийн эхлэл хэсэгт манж амбаны монголчуудын тухай бодлыг оруулсан нь Буनियाгийн үйлдэлтэй хэрхэн холбогдож байгаа талаар дүгнэж ярилцаарай. Жишээ нь: “Эрдэнэ Зуугийн цамын баг хэрэглэл маш нарийн гоёмсгийг гайхан, монгол урчуудын чадлыг бахдан үзжээ” гэдгээс монголчуудын ямар ур чадварыг бахадсаныг харьцуулах гэх мэт.
2. Багаар ажиллан зохиолын гол гол үйл явдлын өрнөх шалтгааныг илрүүлж, тэдгээр гол үйл явдлын аль нь түрүүлж болсноор нь эрэмбэлээд, яагаад гэдгийг тайлбарлаарай. Үүнд:
  - Зуугийн цамын баяр болж манж амбан ирсэн
  - Буनियाг зуу торлогдсон
  - Манж амбан өглөө олж харснаа Зуугийн лам нарт хэлсэн
  - Манж амбан шүхрээр нисэж байгаа Буनियाг олж харсан
  - Манж амбан эрт босдог гэх мэт.

**Сэдэв, гол санааг тодорхойлъя**

1. Харийн дарлалд нэрвэгдэн дарлагдсан цаг үед ч монгол хүн эрдэм номд хичээн суралцаж, соёл иргэншлээ хөгжүүлэхэд нэгэн адил зүтгэж байсныг зохиолын үйл явдлаар баталж тайлбарлаарай.
2. Урьдын цагт ард түмний ухаантай сэргэлэн хүүхдүүд билиг авьяасаа хөгжүүлж чадахгүй хувь заяа, амь нас нь хохирч байсныг харуулсныг зохиолын үйл явдлаар баталж тайлбарлаарай.

**Төрөл зүйлийн онцлогийг таньж мэдье**

1. Туурийн тухай дараах ойлголтыг уншиж ярилцаарай.
2. Өгүүллэгээс ялгагдах онцлогийг хүснэгтэд тэмдэглэсний дагуу зохиолоороо батлаарай.

Хүүрнэл зохиолыг хэлбэрийн хувьд өгүүллэг, тууж, туурь, роман гэж ялгадаг. Өгүүллэг гэдэг нь тодорхой нэг тохиолдлын үйл явдал, хэсгийг тод уран хэллэгээр товч тодорхой өгүүлэн бичсэнийг хэлнэ.

Туурь нь туульсын зохиолын төрөл зүйлд хамаарах нэг зүйл өгүүллэгийн өвөрмөц хэлбэр юм. Өгүүллэгтэй харьцуулбал хурц зөрчил, хураангуй өгүүлэмж, үйл явдлын эргэлт бүхий уран тайллаар ялгардаг богино хэмжээтэй хүүрнэл зохиолыг туурь гэнэ. Өдөр бүр тэр болгон тохиолддоггүй, сонин содон үйл явдлыг үзүүлдэг.

№	Туурийн онцлог	Б.Ринчен “Шүхэрч Буनिया”
1	Хурц зөрчилтэй	
2	Хураангуй өгүүлэмжтэй	
3	Уран тайлалтай	
4	Өдөр бүр тохиолддоггүй, сонин содон үйл явдалтай	
5	Богино хэмжээтэй	



Ярих чадвараа хөгжүүлье

### Зохиолын гол санаа, дүрийн зан төрхийг ойлгож мэдэрснээ дүр бүтээж харуулъя

Дэлхийн түүхэнд хамгийн анх шүхэр хэрэглэн ниссэн, зохион бүтээгч Буनियाгийн амь насыг хөнөөснийх нь төлөө Эрдэнэ Зуу хийдийн лам нарыг шүүх хурлыг зохион байгуулж байна гэж төсөөлж, дүр бүтээж тоглоё. Багт хуваагдан дараах дүрүүдээс сонгоорой.

*Нэгдүгээр баг: Шүүгчид*

Хурлыг удирдаж байгаа шүүгчдийн өмнөөс лам нараас асуух асуултыг бэлтгэх

*Хоёрдугаар баг: Лам нар*

Шүүгчдийн асуултад өөрсдийн буруугүйг нотлох хариулт бэлтгэх

*Гуравдугаар баг: Лам банди нар*

Гэрч болж мэдүүлэг өгөх

*Дөрөвдүгээр баг: Өмгөөлөгчид*

Буनिया болон лам нарыг өмгөөлөх хоёр хэсэг болж, асуулт, хариулт бэлтгэх

*Тавдугаар баг: Сурвалжлагчид*

Цаг үеийн байдлыг олон түмэнд зөвөөр хүргэх мэдээ бэлтгэх

*Зургаадугаар баг: Олон түмний төлөөлөл*

Өөрсдийн дуу хоолойг хүргэхээр сурвалжлагчид яриа өгөх

#### Нэг, дөрөвдүгээр багийн хувьд:

- Зохиолд байгаа ямар гол чухал хэсгээс сонголт хийвэл оновчтой болох вэ?
- Асуулт нь ямар байвал үйл явдлын учир шалтгааныг тодруулж болох вэ?
- Дэлгэрэнгүй хариулт авахаар ярилцлагын асуултыг хэрхэн бэлтгэх вэ?
- Ярилцлага бичихдээ ямар цэг цэглэлийн дүрэм хэрэглэх вэ?
- Асуулт нь ойлгомжтой, найруулгын хувьд зөв байх шаардлагыг хэрхэн хангах вэ? гэх мэтээр сайтар төлөвлөх

#### Хоёр, гуравдугаар багийн хувьд:

1. Зохиолын аль хэсэгт өөрсдийн хариулттай холбоотой зүйл байгааг олох
2. Сурвалжлагчийн асуултыг зөв ойлгож, оновчтой, товч тодорхой хариулт өгөхийн тулд тухайн цаг үе, өөрсдийн байр суурь, эрх мэдэл, хүн чанар, үзэл бодолтой холбоотой асуудлыг сайтар уншиж, зөвшилцсөн байх
3. Хэн ямар асуултад хэрхэн хариулах талаар санал нэгдсэн байх гэх мэтээр төлөвлөх

#### Тав, зургаадугаар багийн хувьд:

- Мэдээ гэж юу болох, түүнийг хэрхэн бэлтгэдэг талаар судална.
- Юу?, хэзээ?, хаана?, хэн?, яагаад?, хэрхэн? гэсэн асуултад хариулт өгөхөөр байх
- Болж байгаа үйл явдалд өөрсдийн дуу хоолой, үзэл бодол, үнэлэлт дүгнэлтээ тусгах гэх мэтээр төлөвлөх



## Уншихын өмнө

1. Хүүхдүүд ээ. Та нар нүдээ аниад Монголын Төв номын сангийн эртний ховор номын тасагт орж байна гэж төсөөлнө үү. Танд хамгийн түрүүнд ямар дүр зураг төсөөлөгдөх вэ? Яагаад?
2. “Мэддэгт мэргэн цоохор, мэддэггүйд эрээн цоохор” гэсэн оньсого болон зохиолын нэрээс ургуулж юуны тухай унших гэж байгаагаа таамаглаж ярилцаарай.



## Лодонгийн Түдэв

Говь-Алтай аймгийн Наран суманд төржээ. “Сайн байцгаана уу, хүүхдүүд ээ”, “Жаалууд”, “Хорвоотой танилцсан түүх”, “Уулын үер”, “Нүүдэл суудал”, “Оройгүй сүм”, “Эргүүлэг” зэрэг олон ном зохиол туурвиж, 1971 онд Монгол Улсын Төрийн шагнал, 1989 онд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол, 1997 онд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол тус тус хүртжээ.



## Унших чадвараа хөгжүүлье

## Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя

1. Зохиолын “Хэсэглэл 1”-ийг уншаад асуултын дагуу ярилцаж, ойлгосноо бататгаарай.

## ЭРЭЭН ЦООХОР

(Туурь)

## Хэсэглэл 1.

Номын сангийн тавиур дээр алгын чинээ дөрвөлжин эрээн цаас хэвтэж байлаа. Тэгтэл нэгэн залуу түүнийг авч,

- Энэ муу эрээн цаас юу юм бэ? гээд хогийн сав руу шидэх гэтэл номын санч бажгадан сандарч,

- Хүүе, яаж байна? Наадах чинь ховор эрдэнэ байхгүй юу? гэж ухасхийн босжээ. Нөгөө залуу:

- Хэ, энэ ямар үхсэний нь эрдэнэ байх билээ гэж тоомсоргүй хэлтэл номын санч тэрхүү алгын чинээ эрээн цаасыг булаан аваад:

- За чам шиг залуу л үүнийг бүтээж чадахгүй юм даг. Наад алгын чинээ цаасан дээр чинь бүхэл бүтэн ном багтсан юм гэж хэлэв. Залуу гайхан эргэлзэж “Ямар юм бичээстэй юм бол?” гэж асуухыг завдсан боловч нэрэлхээд чадсангүй.

- Одоогийн зарим залуу хүн их хөнгөн хийсвэр, бас бардам зантай байх юм. Улсад байтугай дэлхийд ховор, бараг байхгүй зүйлийг гартаа барьж үзсэн мөртөө “эрээн цаас” гэж байхыг нь харав уу? Ёстой өнөө “Мэддэгт мэргэн цоохор, мэддэггүйд эрээн цоохор” гэгч болж дээ гэж ховор номын фондоч өвгөн хажуугаас нь давс нэмлээ.



Залуу эр түүнд уур хилэн нь түр зуур ассан боловч сониуч зан нь дийлж тэрхүү “эрээн” гэгдсэн цаасны үнэ цэнийг мэдэхийг хүсэв. Эрх танхи өссөн хүн ямар нэгэн юм хүсвэл тэр санаандаа заавал хүрэхээр зүтгэдэг шиг мань залуу бас л хүссэндээ тэмүүлэн эхлэв.

- Ах аа, та тэгвэл наадхынхаа учрыг хэлээд өгөөч. Мэдэхгүй минь үнэн. Гэвч мэдээд авмаар байна. Дипломын ажилд ч хэрэг болох юм билүү? гэж залуу шамдуулав. Өвгөн фондоч халзан толгойгоо сэгсрэн хэсэг зуур дуугүй суулаа. Бага насаа дурссан бололтой.

- Ах аа та хэлээд өгөөч гэж өнөөх залуу дахиад л шаардав. Өвгөн бас л дуугүй суусаар байв. Залуугийн тэсвэр алдагдав. Тэгтэл,

- За чи мишил аваад аль. Цаад ширээн дээр чинь байна гэж өвгөн шаардав. Төдхөн эргэсэн залуу томруулагч шилнээс өөр юм харагдахгүйд:

- Мишил гэдэг чинь юу юм бэ? гэв.

- Мишил дуран гэдэг чинь томруулагч шил шүү дээ. Одоогийн та нар өвгөд биднийхээ хувцсыг бараг бүрэн хаясан. Үгсийг маань бас л нэг нэгээр гэж барах нь уу? Тэгвэл сүүлд юугаараа хэл залгуулна даа гэж өвгөн ёжлов.

- Шинэ үг олныг нэмж байгаа шүү гэж залуу оюутан мөчөөгөө өгсөнгүй. Мишил дуран гэж өвгөний нэрлэсэн томруулагч шил нь их хүчтэй эд байжээ. Нөгөөх алга дарам эрээн цаасыг түүгээр харахад үнэхээр номын үсэг дурайж байлаа. Зүү тавих зайгүй чигжүү бичжээ.

- Ямар бичиг юм бэ? Өөх, мөн тодхон байна даа гэж залуу гайхлаа.

- Харин ямар бичиг байна. Та нар оюутан улс мэдэж байгаа биз гэж өвгөн тавлах мэт асуув.

- Ердөө бүү мэд. Миний л мэдэхгүй бичиг байна. Тэгээд ч манай газар зүйн ангид эртний бичиг заах биш гэж оюутан биеэ өмөөрөв. Өвгөн инээмсэглэж,

- Чи л мэдэхээ байж л дээ. Түүнээс чиний өвөө эмээ бол үүнийг уншдаг байлаа. Наадах чинь төвөдөөр бичсэн “Ногоон дарь эхийн магтаал шүлэг” шүү дээ гэж тайлбарлав.

- Яаж ийм жижигхэн бичсэн юм бол? Микроскопоор бичээ болов уу? гэж залуу гайхлаа. Өвгөн доогтой инээж:

- Тэр үед ямар элэнцгийн чинь микроскоов байхав дээ. Ердөө л ном доо, энэ гэв.

- Хэн гээч хүн яаж бичсэн юм бэ? Та мэдэж байгаа бол хэлээд өгөөч гэж оюутан улам цааш ахив.

- Хүнд юм мэдүүлэх буян гэдэг юм даа яахав, итгэвэл яриад өгье гэж өвгөн дурамжхан хэлэв.

- Итгэлгүй яахав. Танд ер нь итгэхгүй хүн байдаг юм уу?

- Байлгүй яахав. Одоо та нарын үеийн залууст юм ярихаар хоцрогдсон зөнөсөн гэхчлэнгээр гоочлоод тохуу хийгээд байдаг болж билээ гэж өвгөн тунирхав. Оюутан залуу:

- Би тэгдэггүй. Та над яриад өгөөч гэв.

- *Зохиолд өгүүлж буй бяцхан үсэгт номын тухай та нар өмнө нь сонсож байсан уу?*
- *Оюутан залууг зэмлэсэн номын санч өвгөний үг та нарт юуг бодогдуулав? Энэ зүй ёсны хэрэг мөн үү?*
- *Оюутан залуу тэр номын үнэ цэн, утга учрыг мэдэхгүй байсан явдалд хэн буруутай вэ?*

- *Зохиогчоос асуух зүйл байна уу? Дээрх хэсэгт зохиогч ямар санааг хэлэх гэсэн юм бол?*
- *Зохиогч залуу үеийнхэнд хандан хэлэхийг хүссэн үгээ номын санч өвгөний үгээр хэлсэн нь ямар учиртай вэ?*
- *Та нар оюутан залуугийн нэгэн адил “Тэр цагт яаж ийм жижигхэн бичсэн юм бол?” гэж гайхаж байна уу?*

## Хэсэглэл 2

Өвгөн нүдний шилээ авч дээгүүр харан, адар ширтэж сууснаа:

- Би тэр үед чамаас ч бага байж дээ. Нэгэн нарлаг сайхан өдөр юмсан. Шагж багшийнд сүү аваачиж өгөхөөр явлаа. Тэднийх Дунд голын хөвөөнд зусланд гарсан байлаа. Гэрт нь хүрээд очсон чинь өрхөө бүтээгээд үүдээ түгжихсэн байлаа. Миний айсан гэдэг нь. Хүн өөд болчихоор л гэрийн өрхийг бүтээгээд үүдийг түгжихдэг заншилтай болохоор тэгж их айлаа л даа. Шагж багш тэр цагт бараг л чам шиг залуухан хүн байсан. Тийм насандаа арай өөд болчихмооргүй юм гэж би эргэлзсэн боловч үнэхээр хачин байлаа. Гэрийн гаднаас ум хумгүй зугтах гэтэл гэр дотор хүн дуугарах шиг боллоо. Лавлаад сайн чагнасан чинь хүн байх шиг. Тэгэхээр нь:

- Шагж багш аа, сүүгээ ав гэж хэлээд чимээ чагнав. Таг чиг байлаа. Дахиад бас нэг хэлсэн, бас л таг чиг, тэгэхээр нь айгаад гэрийн зүг гүйчихлээ. Ээж аавд ирээд хэлсэн чинь:

- Битгий дамшиглаад бай. Өнөө өглөө л гэрээ тойроод явж байхчив лээ. Дуугүй яв. Аваачиж өг гээд буцаагаад хөөлөө.

Дахиад хүрч очлоо. Гэр нь мөн л янзаараа. Тэгэхээр нь хаяагаар нь чимээ чагнаад явж байтал гэр дотор хүн найтаалаа шүү. Хүн байна гэж мэдээд “Шагж багш аа сүүгээ аваач” гэтэл бас таг чиг. Тэгэхээр нь хатавчаар нь туургыг сөхөн сэмхэн шагайж харлаа шүү. Юу харсан гэж бодно? Шагж багш хоймртоо модон шогол дээр алгын чинээ цаас тавиад түүнээ будаж байх шиг харагдлаа. Гэрт тас харанхуй. Ганцхан тэр алгын чинээ цаасан дээр нь хаанаас ч юм бүү мэд, их хурц гэрэл тусаж байлаа. Цаасан дээгүүр гүйх гар нь бийртэйгээ үе үе харагдана. Тэр жижигхэн цааснаас ойсон гэрэл Шагж багшийн нүүрэнд алдаг оног тусаж нэг тодорч, нэг бүдгэрч байлаа. Цаасан дээрээ юм бичээд байх шиг харагдсан. Би түүнийг удтал гөлрөн харж суутал ар далан дээрээс нэг хүн цавхийн атгаж аваад гэдрэг татаж:

- Айл ухах нь уу? Хэсрий царайт минь. Таргийнхаа савыг бүтэн дээр зайл. Харсаар байтал эзгүй гэр байхад чи ухах гээд л санаархаа биз гэж загнаад хацар луу минь алгадав. Би айж гэрийн зүг зугтсан юм. Хожим сонсвол Шагж багш алгын чинээ цаасан дээр бүтэн ном багтаан бичиж байсан юм билээ. Нартай өдөр өрхөө бүтээж, үүдээ хаагаад гэрт өчүүхэн ч гэрэл орохооргүй бүх юмаа таглаж хаагаад түүнийгээ бичсэн юм гэнэ лээ. Харин өрхөө хуруун чинээ газар цоолоод, түүгээр хойморт туссан нарны гэрэлд тэр цаасаа тавьж, нэг ширхэг хялгасны үзүүрээр бийр болгоод түүнийгээ бичсэн гэдэг юм. Өрхний нүхээр үд дундын нар харанхуй гэрт цаасан дээр буухдаа айхтар хурц тод болгодог юм гэнэ лээ. Тийм аргыг яаж бодож олсон юм бүү мэд. Бодвол өвөг дээдсээс сураа биз. Хэчнээн ч хоног тэгж суусан бол. Мөн ч их тэсвэр шүү гэж өвгөн фондоч толгой сэгсрэв.

Оюутан залуу ч гайхан алмайрав.

- Чиний тэр эрээн цаас гэж ад үзээд байсан юм чинь ингэж л бүтсэн эд дээ гэж өвгөн нотлон хэллээ.

- Би бол ч яагаад ч барахгүй юм байна гэж оюутан үнэнээ хэлэв.

- Ялгаа чинь яг л тэр мөн. Тэсвэр хатуужил хэрэгтэй. Шагж багш бас “Алтангэрэл” судрыг тэр мэт жижгээр бичсэн гэдэг юм. Энгийн нүдээр харвал үнэхээр “эрээн цаас” л даа. Гэхдээ эрдэмтэй эрээн цаас шүү. Нүүдэлчний амьдрал, ухаан хоёроос төрсөн арга даа гэж өвгөн яриагаа дуусгалаа.

(Монголын уран зохиолын дээжис. 5 дугаар боть. УБ., 1995 он, 293-296 дахь тал)

2. Асуултын дагуу ярилцаж уншиж мэдэрч ойлгосноо бататгаарай.

- А. Монгол хэл бичгийн анхны эрдэмтдийн нэг С.Шагж багш (1886- 1938) -ийн тухай та бүхэн урьд өмнө сонсож байсан уу? Энэ хүний бүтээл туурвилаас мэдэхийгээ нэрлээрэй.
- Б. Шагж багшийн номоо туурвисан аргыг уншаад танд ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байна вэ?
- В. “Дархан хүн бурхан ухаантай” гэсэн хэлц үг энэ зохиолтой хэрхэн холбогдож байна вэ?
- Г. Зохиогч ямар учраас зохиолоо ийнхүү төгсгөсөн бэ? Зохиогч бидэнд юуг ойлгуулж бодуулахыг хүссэн юм бол?
- Д. Шагж багш яагаад ийм бяцхан ном бүтээх болсон бэ? Номыг бичил бяцхан хийхэд ямар ашигтай давуу тал байх вэ? Та нарын мэдэх хамгийн бяцхан ном ямар ном байсан бэ?
- Е. Гиннесийн номд орсон дэлхийн хамгийн жижиг номуудын тухай мэдээллийг уншаарай.

1985 онд Шотландын Ренлен хотод хэвлэсэн 1,25x1,25 инчийн “Old king Cole” хэмээх номыг уншихын тулд хуудсыг зүүний үзүүрээр эргүүлдэг гэнэ.

Дэлхийн хамгийн жижиг номыг Япон улсад бүтээжээ. Энэ ном ердөө 0.75 мм хэмжээтэй бөгөөд энгийн нүдээр унших боломжгүй. 22 хуудастай Shiki no Kusabana (Flowers of seasons) нэртэй энэхүү номыг Torpan Printing компанид бүтээсэн байна. Torpan Printing компани нь 1964 оноос хойш микро номыг бүтээсээр ирсэн бөгөөд үсгийн хэмжээ нь 0.01 мм байдаг аж.

- Ё. Дээрх мэдээллээ “Эрээн цоохор” туурьтай харьцуулж ярилцаарай.
- Ж. Хамгийн том номын талаар мэдээллийг цахим болон бусад эх сурвалжаас олж уншаад ярилцаарай.

**Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг тодорхойлъя**

1. Залуу оюутан, өвгөн номын санч хоёрын зан чанар, мэдлэг туршлагын тухай харьцуулан ярина уу.
2. Номын фондоч өвгөн бага насандаа Шагж багшийн бяцхан номоо бүтээж байгааг харсан явдал нь түүний ирээдүй хойчийн ажил амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?

3. Энэ зохиолын гол баатар нь хэн бэ? Номын санч өвгөн үү? Оюутан залуу юу? Шагж багш уу? Бяцхан ном уу?

### Сэдэв, гол санааг тодорхойлъя

1. Зохиогч яагаад зохиолоо “Эрээн цоохор” гэж нэрлэсний учрыг ярилцаарай.
2. Зохиолын гол утга санааг төлөөлж чадах түлхүүр үг дөрвийг сонгоно уу?
3. Түлхүүр үгээ ашиглан Шагж багшийн бяцхан номын тухай гэрийнхэндээ ярьж өгнө үү.
4. Зохиолын төрөл зүйлийг туурь хэмээн нэрлэсэн нь ямар учиртай вэ? Өгүүллэгээс ямар ялгаатай байна вэ?

### Өгүүллэгдэхүүний бүтэц, холбоо хамаарлыг дүрийн үйлдлээр тайлбарлая

1. Зохиолын “Хэсэглэл 1”, “Хэсэглэл 2”-ийн хүүрнэн өгүүллэгчид нь хэн бэ? Энэ хоёр ямар ялгаатай вэ?
2. Хоёр дахь хэсэглэлд өвгөний ярианаас “... гэнэ лээ”, “... гэдэг юм” хэмээн төгсгөж буй өгүүлбэрүүдийг түүж бичээд, гол үйл үг ямар цагт байгааг ажиглаж, яагаад гэдгийг тайлбарлаарай.
3. “Гэ” язгуурт үйл үг бидэнд юуг мэдээлж байна вэ? Хариултыг зохиолоос хайгаарай.
4. Номын санч өвгөний бага насаа эргэн дурсаж байгаа хэсэг нь зохиолд ямар үүрэгтэй байгааг ярилцаарай.
5. Зохиолын хоёр хэсэглэл хоорондоо хэрхэн холбогдож байна вэ?
6. Зохиолд монгол гэрийн өрхтэй холбоотой ямар ёс заншлыг өгүүлсэн байна вэ? Энэ нь зохиолд ямар үүрэгтэй байна вэ?

### Үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тодорхойлъя

1. “Эрдэмтэй эрээн цаас” гэсэн хэллэг ямар дүрслэх хэрэглүүрээр бүтсэн байна вэ?
2. Зохиолд яагаад “микроскоов” гэж бичих болсон бэ? Микроскопыг мишил дуран гэсэнтэй адил орчин үеийн техникийг орчуулсан монгол нэр томъёог олж бичнэ үү. Жишээ нь: интернет – цахим өртөө гэх мэт.
3. “Таргийнхаа савыг бүтэн дээр зайл” гэсэн өгүүлбэрийн таргийн сав гэсэн хэллэгийн утгыг тайлбарлаарай.



### Ярих чадвараа хөгжүүлъя

Монголын хамгийн ховор, үнэтэй номын талаар судалгаа хийж ярилцлага өрнүүлээрэй. Жишээ нь:

#### Хамгийн өвөрмөц хамгийн үнэтэй хосгүй ном

“Сундуйн жүд” буюу “Нууцын хураангуй” хэмээх энэ номыг XIX зууны сүүлч XX зууны эхээр алдарт уран дархан Дагва тэргүүтэй монголын чадварлаг урчууд одоогийн Төв аймагт байдаг Манзуширын хийдэд урлан хийжээ. Уг номыг хийхэд цаас ер ашиглаагүй бөгөөд зөвхөн мөнгө давтаж хийсэн нимгэн мөнгөн хуудаастай ба номын үсгийг алтаар цутгаж шаржээ. Боть бүрийн эхний болон төгсгөлийн үг зарим бурхан суваргын зургийг цэвэр алтаар урлан, шүр сувдаар чимэглэн хийжээ. “Сундуйн жүд” хэмээх энэхүү номыг бүтээхэд 52кг алт, 400кг мөнгө оржээ.



Уншихын өмнө

1. “Цагаан сүүний домог” туурийг уншихын өмнө зохиолчийн товч намтар, уран бүтээлтэй танилцаарай.



**Цэрэнтулгын Түмэнбаяр**

1959 онд Улаанбаатар хотод төрсөн. 1985 оноос уран бүтээлээ эхэлж, “Удган”, Мэргэнд буусан чоно”, “Согоо суман”, “Дөргөнэ хатны алтан зоос” зэрэг тууж, өгүүллэг, шүлгийн арав гаруй ном хэвлүүлжээ.

1999 онд МЗЭ-ийн, 2006 онд Д.Нацагдоржийн, 2008 онд С.Удвалын, 2011 онд С.Буяннэмэхийн нэрэмжит, 2011 оны шилдэг бүтээлийн “Алтан өд” шагнал хүртжээ.

2. Домог гэж юу вэ? Ертөнцийн юмс үзэгдэл яагаад домогшин үлддэг вэ?
3. Уншихын өмнө дараах үгсийн утгыг тайлбарлаж ярилцаарай.

Тулгар - жирэмсэн, бие давхар

Хатавч - монгол гэрийн хаалга, хана хоёрын уулзвар газар

Хиа - засаг ноёд том хэргэм зэрэгтнийг даган үйлчилж явах доод тушаалтан, бараа бологч

Хүй -

Шивэгчин -

Асар -

Хөхөл -



Унших чадвараа хөгжүүлье

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя**

1. Дараах үг хэллэгийг анхаарч уншаад, хам орчноос нь утгыг мэдэж ярилцаарай.
  - Уухайлан хашхирах -
  - Цагаан тоос манарах -
  - Ойрадын Шарбаатар -
  - Халхын баатар жанжин -
  - Гэрийн үүдийг сөхөх -
  - Шилэмтэн шунах -
  - Алалдан байлдах эрчүүдийн хилэнт царай -
2. Өгүүллэгийн эхний болон сүүлчийн өгүүлбэрийн байгалийн дүрслэлийг харьцуулан уншаад юу өөрчлөгдсөн бэ? Яагаад гэдгийг таамаглаж ярилцаарай.
3. Өөрчлөгдөх шалтгаан нь чухам юу болсныг зохиолыг уншиж мэдье.



## ЦАГААН СҮҮНИЙ ДОМОГ

(Туурь)

Амьтай бүхэн цэнгэн жаргамаар тунгалаг сайхан зуны өдөр. Тэртээ холоос уухайлан хашхирах дуу бүдэг бадаг сонсогдож, тэнгэрийн хаяанаа цагаан тоос манарна.

Аарцаг яс нь задран алдтал өвдөх хоёр тулгар бүсгүй. Гэрийн баруун хатавчинд Ойрадын Шарбаатарын залуу хатан Насан, тэр тушаа гадаа хаяанд олзны бүсгүй, хоёул ханын үдээр шажигнатал зуурч ёолон гиншинэ. Олзны бүсгүйн эр нөхөр Халхын баатар жанжин дөнгөж өчигдөрхөн Шарбаатарын хурц илдийн ирэнд, хүүг нь тээж үлдэх залуу хатныхаа нүдэн дээр амь эрсэдсэн. Ойрадын жанжин “Олзны хатнаас охин төрвөл өршөөнө. Хүү төрвөл дор нь ална. Миний хатнаас голомт залгах хүү төрвөл Халхтай байлдахыг зогсооно” гэж зарлиг буулгасан нь бүсгүйн чихэнд хадна.

Насангийн нүдэнд алалдан байлдах эрчүүдийн хилэнт царай, улангасан дайрч амь өрсөн бие биеэ хядах, хурц ирэнд хяргагдан унах үе тэнгийнхний нь танил толгой харагдаж, шархандаа тарчлан татвалзаж, амь тэмцэх хүмүүсийн өршөөл эрсэн, хараан зүхсэн гаслант чимээ, өвдөлт ширүүсэх тусам улам тод сонсогдож байсан...

Хатан тэсэхүйеэ бэрх өвдсөндөө уруулаа хөхөртөл тас зууж, нүүрэнд нь борооны дусал шиг хөлс бөнжигнөн, ар нурууг нь даган урсах хөлсөнд нимгэн тэрлэг нь нэвчин биеийг нь барина. Гэрийн хаяанд өвдөх олзны бүсгүйгээс ямар хүүхэд төрөхийг үзэх гэж хоёр шивэгчин манаж зогсоно. “Ижий” гэж амь тэмцэн хашхирахтай зэрэгцэн хоёр хүүхэд дуу дуугаа авалцан часхийв. Дөнгөж төрсөн хоёр хүүхдийн хүйг таслан бооход охин төрүүлсэн Насан хаяанд амаржсан бүсгүйн хүүг харлаа. Шарбаатарын хатан хажуудаа тавьсан охиноо өндийж аваад, тамирдангуй дуугаар:

-Монголжин! гэв. Олзны бүсгүй хатны зүг хардангуй харцаар цэрвэн харахад, Насан цээж нь ялихгүй түхэлзэн амьсгаадаж,

-Чи бид хаяа, хатавч хоёрт алтан ясаа хэлтэлж, алаг махаа тасалж эх боллоо! Май, миний охиныг ав! Хүүгээ аль! Чамд үүнээс өөрөөр хүүгийнхээ амийг аврах арга байхгүй. Охиныг минь өрнөөсөө унагасан үр шигээ өврөөсөө салгалгүй өсгөөрэй гэлээ... Монголжин гайхан өндийж,

-Юу гэсэн үг вэ? Эзэн чинь мэдчихвэл... гэтэл Насан,

-Түргэл! Хүн харахаас урьт! гэж шаардангуй хэлэхэд олзны хатан тээнэгэлзэн нэг үг хэлэх гээд өндийсхийтэл:

-Май гээд охиноо ханын нүдээр цээжин дээр нь зөөлөн унагалаа. Монголжин ч хүүгээ зөрүүлэв.

\* \* \*

Аяны асарт ташаа тулан бодлогоширч суух Ойрадын Шарбаатар өмнөө сөхрөн унасан хиаг цоо ширтэн

-Миний хатнаас хүү төрж, олзны хүүхнээс охин гарсан юм биз дээ. Хэн хэлүүлэв? гэж нухацтай агаад догшин асуув. Хиа:

-Таны залуу хатан Насан ахайтан гэж түргэн хариулаад, өршөөл эрсэн хүлцэнгүй харцаар нүд цавчилгүй ширтэв. Шарбаатарын зүрх нь цээжиндээ багтахгүй дэлбэрэх нь үү гэмээр түхэлзэж,

-Би өөрийн нүдээр үзнэ гэж намуухан хэлснээ, хөмсөг өргөн,

-Морь бэлд! гэлээ.

Шарбаатар мориныхоо амыг таталгүй суран ганзага сарвайтал цогиулсаар шөнө дундаас хойно дайны газраас алсхан барьсан аяны гэрүүдийн гадаа ирлээ. Тэр хөхөл нь сэгсэлзэж зүрх нь хөөрсөн борлог мориныхоо амыг татан ангалзуулж, түмпэнтэй ус барьж, гүйх шахам явсан шивэгчнээс “Хүүхдүүд хаана байна” гэж өндөр дуугаар асуув.

-Тэр! гэж жижигхэн гэрийг заахад Шарбаатар мориноосоо үсрэн бууж, сул орхиод, гэрийн үүдийг ширүүн сөхлөө.

Гэвч орчин тойрондоо юу болж байгааг гадарлах ч үгүй нам тайван зэрэгцэн унтаж байгаа алгын чинээхэн хоёр нялх амьтныг хараад зогтосон хэсэг алмайрав. Цэрвэн дайжсан, аль нэг юмнаас айж эмээсэн, шилэмтэн шунасан итгэж цөхсөн аль нь үл мэдэгдэх харцаар хүүхдүүдийн зүг бүлтийн ширтсээр болгоомжлох мэт алгуур дөхөж очлоо. Цээжиндээ багтахгүй оволзох зүрхээ бахим том гараараа дарахад, төвөнх нь гүрэлзэж, хөл нь чичирч байлаа. Тэр өлсгөлөн бүргэд гэнэт олз харсан мэт догшин нүдээр хүүхдүүдийн дээрээс цоо ширтээд “Тэгнээ тэр, аман хүзүүгээр минь тас харвах атаатны зулзага төрж” гэж шивнэв. Бүсэндээ хавчуулсан илдийнхээ ишнээс чанга атгаснаа хөмхийгөө зуухад түүний чамархайн судас луг луг цохилж, тархи нь задарчих шахан ангалзан өвдөнө. Уур хилэн, гомдол цухал шингэсэн хүрлэгэр өнгөөр царай нь хувирч, гэрээс ухасхийн гарлаа.

Хатны гэрийн зүг түргэн түргэн алхсаар үүдэнд нь ирэхэд, гэрээс домботой цай барьж гарах шивэгчний “Хатны бие тааруу байгаа шүү” гэж анхааруулах, гуйх зэрэгцсэн өнгөөр хэлэхийг ч анзааралгүй, шууд л яваад орчхов. Тэр арай ядан амьсгаагаа дарж, сая амаржсан хатныхаа зүг хэлмэгдсэн хүний гомдолтой агаад шаардангуй аясаар “Чи юунд намайг мэхлэв?” гэж хоолой чичрүүлэв.

Тамирдаж туйлдсан хатан нь Шарбаатарын зүг толгойгоо алгуур эргүүлэв. Насангийн царай шөнийн сар шиг цонхийж, улаа бутарч асан гэрэлт хацарт нь судлын төдий ч цусны туяа байсангүй. Тормос тормос тоглож асан алаг нүдний нь харц сулран сүүмийж, нулимс гүйлгэнэнэ. Тэр цээл тунгалаг атлаа сонсогдох төдий намуун зөөлөн дуугаар

-Өршөө намайг! Ах дүү нарынхаа цусыг урсгасан аян дайны явдалд алжаан сульдлаа, би. Зүрх шимширч, өр минь өмөрлөө. Энэнээс цаашыг давж чадахгүй нь. Цус нулимсны өнгөнд нүд минь өвдөж байна. Би өөрөө ч одоо үхэх нь. Үхэх хүний сүүлчийн гуйлтыг биелүүлээч! Хүүгийн амийг өршөө! Та минь өршөө! өршөө! гэх дуу нь суларсаар огцом агдасхийв. Түүний өрөвдөн нигүүлсэж, хайр дүүрсэн мэлмийнх нь гал аажим буурахад, танхилхан болцгор гар нь сул унжлаа. Шарбаатар ухасхийн гарыг нь атгаж, суун тусаж сөхрөв. Хатны нүд “өршөө, өршөө” гэсэн үгийг давтах номхон харцаар ширтсээр...

Шарбаатар нүдний нь зовхийг алгаараа зөөлөн илж, буулгахад задгай цээжинд нь уураг чинэн томбойх хун цагаан хөхнийх нь товчин дээр сүү түрэн бөнжийснөө, сугыг нь даган нулимс адил урслаа.

Шарбаатар яахаа мэдэхгүй манан дунд төөрсөн мэт алмайран халаглахад, түүний хайрлаж дурлаж явсан жаргалтай мөчүүд нь зүүд мэт зурсхийн үзэгдлээ. Тэр гүнзгий эхэр татсанаа, хэзээ ч нулимс гарч байгаагүй болов уу гэмээр хурц догшин нүдэнд нь яах ийхийн зуургүй харуусал гуниг дүүрч, хатныхаа хар үсээр эмжээрлэгдсэн



хөөрхөн духыг нь удаан үнслээ. Түүний хучлагыг алгуур дээшлүүлэн нүүрийг нь бүтээгээд үлгэн салган амьтан арай ядан хөлөө зөөж гараад, үүдэнд зогсож:

-Тунхаглан зарла. Миний хатнаас хүү төрсөн! хэмээн хоолой зангируулан хэлээд, гуйвлан цааш алхав. Тэртээ зүүн хаяанаас тэнгэр өндөрсөн үүрийн сүүн цагаан туяа орчлонг гийгүүлэн мандав аа.

1991 он

(Ц.Түмэнбаяр. “Дөргөнэ хатны алтан зоос” (өгүүллэгүүд). УБ., 2014, 37-40 дэх тал)

### **Орчин нь дүр, зохиолын сэдэвт хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлая**

1. Өгүүллэгт гарч байгаа энэ үйл явдал хэзээ, хэдий үед болсон гэж бодож байна вэ? Хэрэв дайны сэдвийг гол сэдэв болгосон бол үйл явдал хэрхэн өрнөж болохыг ярилцаарай.
2. Яагаад Насан хатныг хатавчинд, олзны бүсгүйг хаяанд зэрэг төрж байгаагаар зохиолч бичив? Гэрийн хатавч, хаяа гэсэн хоёр үгийн утгыг зохиолчийн санаатай холбон тайлбарлаарай.
3. Насан хатны нүдэнд юу юу харагдаж ямар чимээ сонстож байсан бэ? Энэ нь түүний шийдвэрт нөлөөлсөн эсэхийг ярилцаж саналаа солилцоорой.

### **Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг хэлэлцье**

1. Шарбаатарын зогсолтгүй давхисныг ямар үгээр дүрслэн бичсэн бэ?
2. Хиагаас мэдээ сонсоод цочирдон уурласан учрыг өөрийн нь андгай үгтэй нь холбон тайлбарлаарай.
3. Өлгийтэй хоёр хүүхдийг харсан Шарбаатар юу гэж хэлсэн бэ? Хүүхэд хоорондоо солигдсоныг хэрхэн мэдсэн тухайд санал дэвшүүлэн мэтгэлцээрэй.
4. Тамирдаж сульдсан Насан хатан, Шарбаатарт чухам юуг өгүүлэв? Яагаад?
5. Хатны “Хүүгийн амийг өршөө! Та минь өршөө! өршөө!” гэсэн үгийн далд утгыг юу гэж ойлгосноо хэлэлцээрэй.

### **Зохиолын үг хэллэг, уран дүрслэлийг шинжилье.**

1. “Ойрадын жанжин “Олзны хатнаас охин төрвөл...” гэж зарлиг буулгасан нь” хэмээсэнтэй адил утгатай үгийг Рашпунцагийн “Болор эрх” зохиолд юу гэж хэлсэн байдгийг олж харьцуулаарай.
2. Энэ нь ямар дүрслэх хэрэглүүр вэ? Өөр зохиолд ийм дүрслэх хэрэглүүр ашигласныг олж үүнтэй харьцуулаарай.
3. Зохиолч яагаад “амьтай бүхэн цэнгэн жаргамаар” гэж бичсэн бэ? Зохиолын үйл явдалтай харьцуулан шинжлээрэй.
4. “Амьтай бүхэн цэнгэн жаргамаар тунгалаг сайхан зуны өдөр” гэсэн өгүүлбэрийн жаргамаар гэсэн үгэнд орсон “-маар” нөхцөл нь ямар утгатай нөхцөл вэ?
5. “Жарга” гэсэн үгийн язгуурт -маар нөхцөл залгаснаар зуны дэлгэр цаг, дайны хар сүүдэр хоёрыг эсрэгцүүлсэн гэж үзэж болох уу? Энэ нь зохиолын утга санаатай хэрхэн холбогдож буйтай жишээрэй.
6. Шарбаатарын хэлсэн үгийг дэс дараалан түүж бичээд зохиолын болон зохиогчийн санааг тайлбарлаарай.
7. Эхийн сүүг нулимстай зүйрлэсний учрыг тайлбарлаарай.

- “Тэнгэрийн хаяанаас тоос манарна” гэсэн дүрслэлт үг хэллэг ямар утгыг илтгэж байна вэ? Нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай нь холбон дүгнээрэй.
- Хоёр бүсгүйн өвдөлт яагаад тийм хүчтэй байв? Сэтгэл санаа нь нөлөөлсөн эсэхийг харилцан ярилцаж зохиолч ямар үгээр илэрхийлсэнтэй харьцуулан бататгаарай.

**Зохиолын сэдэв, санааг тодорхойлъя**

- Эхийн элбэрэл хайр юунаас ч илүү хүчтэй гэсэн санааг илтгэсэн үг хэллэгүүдийг зохиолоос олж ярилцаад нэг өгүүлбэрт багтаан бичнэ үү.
- “Цагаан сүүний домог” өгүүллэгийн сэдэв, гол санаа, зохиолчийн үүдэл санаа юу вэ? Дараах санаанаас авч найруулан бичээрэй.
  - Цагийн хүнд шалгуур, ямар ч бэрх үед эхийн хайр ялагдашгүй, бас мөнхөд байдаг.
  - Үр хүүхдээ хайрлах эхийн хайр
  - Ах дүүсээ хайрлах эхийн хайр
  - Улс үндэстнээ хайрлах эхийн хайр
- Эсрэг утгатай үгс зохиолд ямар үүрэгтэй байна вэ? Эдгээр үгсийг харьцуулан бичээрэй.

Эсрэг утгатай үгс		Тайлбар
Хаяа	Хатавч	
Сүү	Нулимс	



**Ярих чадвараа хөгжүүлъя**

**Зохиолын дүрийн талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан сонирхол татаж сэтгэлд хүрэхээр ярья**

- Дараах цахим хаягаар нэвтэрч “Цагаан сүүний домог” киног үзээрэй.  
<https://www.youtube.com/watch?v=Lh6rJe2bZyk>
- Зохиолын дүрүүдэд хэн гэдэг жүжигчин, хэрхэн тоглосон, уншаад төрсөн мэдрэмж, сэтгэгдэл, киног үзээд төрсөн мэдрэмж, сэтгэгдэл хоёрт ялгаа гарсан уу? Яагаад?

	Цагаан сүүний домог (кино)	Цагаан сүүний домог (туурь)
Мэдрэмж		
Сэтгэгдэл		
Дүгнэлт		

- Зохиолын дүрүүдээс сонгож үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан гэрийнхэндээ болон найз нөхдөдөө сонирхолтой байдлаар ярьж өгөөрэй.
- "Хув Нагваралын тууж" зохиолыг уншаад "Цагаан сүүний домог" туурьтай харьцуулж ярилцаарай.

## 2.2 ӨГҮҮЛЛЭГ



## Уншихын өмнө

1. “Хуучин хүү” өгүүллэгийг уншихын өмнө зохиолчийн намтар, уран бүтээлийн талаар товч мэдээллийг уншаад, хосоороо ярилцаарай. Өөрсдийн мэддэг зүйлийг нэмж ярилцаад, баяжуулан судлаарай.




(1906-1937)

## Дашдоржийн Нацагдорж

1906 оны 11 сарын 17-д хуучин Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошуу, өнөөгийн Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг Гүн Галуутай гэдэг газар ядуу тайжийн гэр бүлд төржээ.

"Ушаандар", "Сандо амбаны харгис явдал" жүжиг, "Учиртай гурван толгой" дуурь, "Миний нутаг", "Од", "Октябрь" зэрэг олон арван шүлэг, "Хуучин хүү", "Цагаан сар ба хар нулимс", "Харанхуй хад" зэрэг өгүүллэгээрээ алдаршжээ.

2. Зургийг харахад та бүхэнд ямар сэтгэгдэл төрж байна вэ? Монголчуудын амьдралын ямар ямар онцлог дүрслэгдсэн байна вэ?
3. Дараах өгүүллэгийг уншихдаа зохиолын дүрслэлийг зургийн дүрслэлтэй харьцуулан бодож, адил төсөөтэй сэтгэгдэх зүйлсийг анхаарч уншаарай.



Б.Шарав. “Монголын нэг өдөр”



## Унших чадвараа хөгжүүлэе

## Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя

1. Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглээд “Монгол хэлний их тайлбар толь” ашиглан утгыг мэдэж аваарай.

## ХУУЧИН ХҮҮ

Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн улирал ороо бусгаа, элстэй шанд, буттай цайдмыг дагаж хааяа нэг хар гэрээс утаа суунаглана. Дөрвөн зүгт цэв цэлийн

уйтгартай цагаан униар тунана. Зуны лүгхийм халуун эсгий гэрийг шарж, малчин хүний сэтгэлийг бухимдуулна. Айлын хаяагаар үхрийн баас үргэлжилжээ. Үүгээр түүгээр хэдэн тугал оодгонон давхина. Хөлд орохоос аваад үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийг эргэн тойрон нутагласаар энэхүү ертөнцийг эцэслэнэ. Гавж Жамбал хоймор сууж, бурхан ном гэж буруу зөв чалчих ба зайсан Намжил гаднаас ирж, хууль ёс гэж худал үнэн ярихыг сонссоор, өдөр сарыг улируулна. Тэртээ уулыг өнгөрвөл айлгүй гэж бодож, тэнгэрийн хаяанаас цааш газаргүй гэж сэтгэсээр түмэн хэргээс хоцорч дэлхийн боловсролоос гээгдэнэ. Гагцхүү өглөө бурханд залбирч, үдэш тэнгэрт мөргөсөөр, нэг насыг харанхуй манан дотор барна.

Хуучин хүү хул морин дээрээ хөндлөн сууж хатируулсаар хүрч ирэв. Цагаан даавуу алчуураар толгойгоо ороожээ. Ширэлдсэн хар гээгний сэввийсэн хэдэн үс нь шанаа уруу нь унжина. Урагдаж навтарсан хар ханцуйг сугалдаргалж, хиртэж сайртсан бор тохойг гаргажээ. Тав хийтэл мориноосоо бууж, тас хийтэл жолоогоо сойгоод, тоосонд дарагдсан урд хормойгоороо наранд шарагдсан нүүрнийхээ хөлсийг арчиж, нусаа хүр хийтэл нийгээд гэрт оров. “Балдангийнх эсгийгээ хийж байна. Цэндийнх хонио хужирлаж байгаа, Дамба морь эрэхээр явсан, Гомбо хангай ороод ирсэн” гэх зэрэг хэвийн хэдэн үгийг ах зах хүмүүстээ сонин болгон ярьж, гавж гуай гэж доогуур харан, зайсан гуай гэж дорой дуугарсаар зуухны хажууд сууна. Авгай хүүхдээс аяга тараг, хэсэг хусам олж идээд, тэндээс гарч, баян Балжирын дунд унага татаж өгч, айраг олж уугаад нэг үдийг өнгөрүүлнэ. Дэндэв тайжийнд хонь гаргаж өгч, гэдэс олж идэн нэг үдшийг дуусгана. Хэдийгээр ухаан сэргэлэн боловч зүүн хошууны захад хүрсэнгүй, баруун мөрний тэртээ гарсангүй, зөвхөн гурав дөрвөн өртөө эргэн тойрон газрын дотор оршин суусан тул юуг үзэж мэдэж, юуг сонсох аж. Нас хэдийгээр залуу боловч, үгээгүй ядуу, өнчин балчир тул нутаг сумын хэдэн баячууд ээлжлэн зарагдсаар олигтой аж амьдралын замыг нэгэнт алджээ. Өвлийн хүйтнийг адуу манаж өнгөрүүлэн, зуны халууныг хонь хариулж гэтэлгэх бөгөөд намар ичиж, хавар гарагч тарваганаас зовлонтойгоор он жил нөгцүүлнэ. Өтгөс хуучид энэ хоёрын үгээс өөр үнэн юмгүй, өвөлжөө, зуслан, хаваржаа, намаржаа энэ дөрвөөс өөр явах газаргүй гэж санаж, хөмөрсөн тогооны доторхтой адил хөдөөгийн бүдүүлэг байдалд хүмүүжнэ.

Юутай гомдолтой зэрлэг амьдрал, юутай хайрлалтай залуу нас юунд шинэ ертөнцийг үзэхийг үл хүснэ. Хүмүүжил нь ийм гуньхралтай байдлыг хуучин хүү өөрөө яахан мэднэ. Хуучин феодал ба лам нарын гайг мөн хэрхэн танина. Дэмий л дадсан байдалд автагдаж, зовлон нь жаргал, зэрлэг нь цэнгэл болоод, нэг аймаг улсын ихэнх, хуучин хүүгийн адил нүдээ аньж, чихээ бөглөж, ертөнц гэгч чухам юу болохыг үзэлгүй, мэдэлгүй хөндий тал хоосоор хоцроход тулжээ. Хайран, хайран, хөөрхий, хөөрхий.

Гэтэл хуучин хүүгийн нэг нөхөр нь хувьсгалын бууг тавьсан өдрөөс эхлэн хөмөрсөн тогооны дотор гэрэл тусаж, нэг аймаг улс сэргэв. Тэнгэрийн хаяанаас цаана газар байдгийг мэдэж, таван далай, таван тивийг танин, шинэ ертөнц дээр хамт явах замыг нээв.

Хөх Монгол улаан Монгол болов.

Хуучин хүү шинэ хүү болов.

Юутай завшаан, юутай баяр

1930 он  
(Монголын уран зохиолын дээж. 9 дүгээр боть. УБ., 2005 он,  
217-218 дахь тал)



2. Үгийн утгыг ойлгох чадвараа “Нутаг гүйсэн унаганы дууль” зохиолд ашигласан үнэлгээний хүснэгтийн дагуу үнэлээрэй. (63 дугаар тал)
3. Асуултын дагуу ярилцаж, ойлгож мэдсэнээ бататгаарай.
  - А. Зохиолын эхлэл хэсгийг хөгжмөөр илэрхийлбэл та нар түргэн цоглог эсвэл удаан гунигтай аялгуу сонгох уу? Яагаад?
  - Б. Зохиолын эхлэлийг зургаар илэрхийлбэл ямар өнгө будаг голлох вэ? Яагаад?
  - В. “Хөх Монгол”, “Улаан Монгол” гэсэн нь юуг бэлгэдэж байна вэ? Эдгээр өнгөний бэлгэдлийн учрыг тайлбарлаж ярилцаарай.

### Үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг хэрэглээг тайлбарлая

Дараах хэсгүүдэд ямар ямар дүрслэх хэрэглүүр, бэлгэдэл ашигласан байгааг дэлгэрүүлэн тайлбарлаарай.

- “Ширэлдсэн хар гээгний сэрвийсэн хэдэн үс нь шанаа руу унжина”
- “дөрвөн зүг цэв цэлийн уйтгартай униар тунана”
- Хөлд орохоос аваад үс цайхыг хүртэл.
- “...Намар ичиж хавар гарагч тарваганаас зовлонтойгоор он жил нөхцүүлнэ”
- “Тэртээ уулыг өнгөрвөл айлгүй гэж бодож, тэнгэрийн хаяанаас нааш газаргүй гэж сэтгэсээр...”
- “...хөмөрсөн тогооны доторхтой адил хөдөөгийн бүдүүлэг байдал”
- “Хөмөрсөн тогооны дотор гэрэл тусаж”

### Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг тодорхойлъё

1. Хуучин хүүгийн хийсэн үйлдлийг хүснэгтэд бичээд үүгээр зохиолч юу хэлэхийг зорьсныг тайлбарлаарай.

Хуучин хүүгийн хийсэн үйлдэл	Уншигчдад хэлэх гэсэн санаа
хул морин дээрээ хөндлөн сууж хатируулсаар хүрч ирэх	Зохиолч Хуучин хүүг моринд эрэмгий, залуу хүн болохыг илэрхийлсэн

2. Хуучин хүүгийн хөрөг дүрийг дүрсэлсэн хэсгийг олоорой. Сонгосон хэсгээ чухам ямар шинжээр нь хөрөг дүр хэмээн үзэж байгаагаа нотлоорой.
3. Хуучин хүүгийн энэ дүр нийтлэг дүр мөн үү? Мөн хэдий цаг үед илүү холбогдох вэ?

### Орчин, нөхцөл байдлыг тайлбарлая

1. “Зүүн хошууны захад хүрсэнгүй, баруун мөрний тэртээ гарсангүй” гэсэн дүрслэлээс амьдралын ямар хэв маяг харагдаж байна вэ? Үүнтэй нэгэн утга илэрхийлэх бусад дүрслэлүүдийг олж тайлбарлаарай.
2. Байгалийн дүрслэл бүхий зохиолын эхлэл хэсгээр зохиолч юу хэлэхийг хүссэнийг тайлбарлаарай.
3. Зохиолын эхлэл хэсгийг тоочин дүрсэлсэн тоочимж болохыг батлаарай.
4. Өөрсдийн төрж өссөн ба амарч зугаалсан хөдөө нутгийн байдлаар аман зураглал хийж, тоочин дүрслээрэй.

### Зохиолын гол санаа тодорхойлъя

1. Зохиолд юуны тухай өгүүлж байна вэ? Үүнийг зохиолын доторх түлхүүр өгүүлбэрээр илэрхийлбэл та аль өгүүлбэрийг сонгох вэ? Яагаад?
2. Энэ өгүүлбэрт зохиолчийн хэлэх гэсэн ямар ямар санаа багтаж байна гэж та нар үзэж байна вэ?
3. Зохиолын гол санаа юу болох талаар өөрсдийн саналыг дэвшүүлж, баталж нотолж ярилцаарай.



Бичих чадвараа хөгжүүлъя

### Зохиолд дүр, орчин нэмэх, харилцан яриа оруулах зэргээр дэлгэрүүлж бичье

1. Хуучин хүү шинэ хүү болоод амьдрал байдал нь өөрчлөгдөж байгаа тухай “Шинэ хүү” гэсэн хүүрнэмж бичээрэй.

Бичихдээ:

- Шинэ орчин нэмж бичээд энэ нь Хуучин хүүг Шинэ хүү болоход хэрхэн зөрчил үүсгэн нөлөөлж байгааг бичих
  - Шинэ орчин, нөхцөл байдалд дасаж зохицоход нөлөөлөх сайн найзын дүр нэмэх
  - Харилцан яриа оруулж бичих
2. Д.Нацагдоржийн “Хуучин хүү” зохиолын хэлбэр, бичлэгийн хэв маягийг ашиглан Хуучин хүүгийн өнөөгийн дүр төрх сэдвээр зохиож бичээрэй.

Бичихдээ:

- Өнөөгийн нийгмийн талаарх тоочсон дүрслэл
- Өнөөгийн залуусын нийтлэг дүр төрхийн тоочсон дүрслэл
- “Хуучин хүү” зохиолын төгсгөл шиг гэгээлэг, өвөрмөц шийдэл



Ярих чадвараа хөгжүүлъя

“Хуучин хүү” зохиолын тухай судлаачдын дүгнэлтийг уншаад өөрийн үзэл бодолтой харьцуулж дүгнэн, хосоороо ярилцаарай.

“Хуучин хүү” зохиолдоо нийгмийн болоод хувь хүний харанхуй бүдүүлэг байдал, түүнийг халж өөрчилсөн хувьсгалт их үйл хэргийн тухай өөрийн эргэцүүлэл бодлоо илэрхийлсэн. Энэ зохиол нь тухайн цагийн нийгэм дэх хүмүүсийн нийтлэг хэв шинж болсон хуучин хүүгийн нийгэм, орчин ахуй сэтгэлгээ нь хоцрогдож “Тэнгэрийн хаяанаас цааш газаргүй, тэртээ уулыг өнгөрвөл айлгүй” гэж бодох боловч түүний тавхийтэл мориноосоо буугаад тас хийтэл жолоогоо сойгоод ... гэж эрийн хийморь, эрэмгий цоглог шинжийг нь харанхуй бүдүүлэг байдлынх нь цаанаас нэвт гэрэлтүүлж тэдний ирээдүй хойчид итгэсэн итгэлээ илэрхийлж улмаар хуучин хүү шинэ хүү болж хөх монгол улаан монгол болсон нийгмийн их өөрчлөлт шинэ үеийг бахархан талархсан зохиолчийн бодол юм. Б.Содном





## Уншихын өмнө

1. Зохиолын нэрийг уншаад дараах асуултын дагуу санал бодлоо солилцоорой.
  - Нутаг руугаа эргэж буцаж ирсэн амьтдын тухай Та юу мэдэх вэ?
  - Унага нутаг руугаа яагаад гүйх болсон юм бол?
  - Нутагтаа хүрэх замд нь ямар ямар эрсдэл тохиолдож болох вэ?
  - Эрсдэлийг даван туулах ямар боломж бий вэ?



(1952)

**Гомбожавын Мэнд-Ооёо**

Сүхбаатар аймгийн Онгон суманд төржээ. 1970-аад оноос уран бүтээлээ туурвиж, “Бодлын шувуу”, “Алтан овоо”, “Жиргээ хөөрхөн шувуухай”, “Уулнаас өндөр тэмээ”, “Утгын болор сүм” зэрэг яруу найраг, хүүрнэл зохиолын төрлөөр олон ном зохиол хэвлүүлжээ.

1996 онд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол, 1998 онд МЗЭ-ийн шагнал, 2015 онд “Чингис хаан” одонгоор тус тус шагнуулжээ.

2. Уншихын өмнө дараах үгсийн утгыг тайлбарлаж ярилцаарай.  
Ус унхиалах, дааганы мундаа, нуурт тээрэх, хулмайн дайрах, хомбон туурай, гаадаагүй мөн



## Унших чадвараа хөгжүүлэе

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя**

1. Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглээд “Монгол хэлний их тайлбар толь” ашиглан утгыг мэдэж аваарай.

**“НУТАГ ГҮЙСЭН УНАГАНЫ ДУУЛЬ”**

Хөөрхий нэг өнчин ухаа унага гүвээ даваад урамгүйхэн шогшиж явна. Эхтэйгээ байхад эрх цовоо гэж туйлгүй сэн. Эхээсээ хойш энэлэн шаналах гэж тоймгүй еэ. Өмнүүр нь алтан хараацай ээрэн нисэж явна. Хөөрхий тэр амьтан хаашаа яваагаа эс мэдэвч ямар нэг үл үзэгдэх далдын совин билиг түүнийг аль нэг тийш нь хөтөлж явна. Эхээсээ хагацсан амьтныг гангийн наран гундаан шарж, эцэнхий муу нуруун дээр нь өлөн тоос дагтаршин шигээд, ялаа батгана нүүр нүдийг нь бүрхээд, зовлон дээр нь зовлон нэмнэ. Хөөрхий амьтан өөрийнхөө тоосонд булуулсаар ус унхиадан нуурт тээрсэн адууны дэргэд ирж хул зүсэм болгоны зүг шогшин ойртож, айж хулгасаар дөхөж очих боловч аль нь ч эс хавьтуулан, хулмайн дайрах гэнэ. Сүүлээ хавчин адуу тойрох хөөрхийг нэг асман хар үрээ хасан элдэв.

Ганц унага шогшсоор л байлаа. Тэр хөөрхий амьтан хаашаа яваагаа эс мэдэвч ямар нэг үл үзэгдэх далдын совин билиг түүнийг нэгэн тийш хөтөлсөөр авай. Урт хоногийн тоосонд даруулж усан борооны хураар угаагдаж, хад чулуунд туурайгаа нухуулж, хавсарга салхинд дэлээ хийсгэн явсаар нарийн хөл нь байргашин, намхан бие нь

өндөрсөн өссөөр буйг алтан хараацайнаас бишид нь эс анзаарвай. Түүнийг хаана ч явсан хэдэн алтан хараацай өмнүүр хойгуур нь өрөөлдөн зэрэх бөгөөд хурмастын тэр жигүүртнүүд хөөрхий муу амьтныг эс ганцаардуулан, дэл сүүлийг нь шүргэн, гэдсэн доогуур нь шурган, турьхан хөлийг нь солбин нисэлдэж, ээнэгшин ижилсэх нь чухам ямар учир шалтгаантай, урьдын болоод хожмын ерөөлтэйг хэн яахин мэднэм билээ.

Хөөрхий өнчин амьтан шогшсоор л байлаа. Халирсаар тэр адуунд дөхөж очсон боловч азарга болоод асман үрээнүүд нь цаанаа л нэг ёозгүй янзтайд холуурхан дөлсөөр чанагш шогшвой. Энэ мэт адуунаас адуу, айлаас айл ухаа гүвээнээс ухаа гүвээг дамжин хэгжсээр гагцхүү чанх хойд зүгийг барин үл мэдэх нэгэн татах үзүүр лүү явсаар л авай.

Тийн гангийн улаан тоосон дундуур ганган эрээн цэцгэн дундуур шогшиж, намрын шар навчсыг сэргигнүүлэн алхаж, төдөлгүй нэвсийсэн цагаан цас шажигнуулан гэлдэрч явлаа.

Хөөрхий амьтан хаа хол торойн үзэгдэх хэдэн адууг харан гэнэт үүрсэж, тэгснээ салхи сэвэлзүүлэн хангинатал лимбэдэн янцгаагаад сүүлээ хатган давхив. Юуны учир эс танигдах тэр сүргийн зүг сүүл хатган давхиж, мөнөөх хэдэн адуу нь бусадтай адил эс хажиглан, өнчин унаганы дотор өвлөөр боловч өнө дулаан болбай.

Талын таван уулын сугад бэлчих сүргийнхээ захад очиж явсан адуучин эр хүлгийнхээ амыг шороо манаруулан зог тустал татаад мөнөөх ухаа унагыг харахдаа тэнгэрээс бууж ирсэн мэт тэр бяцхан амьтныг гайхахын ихээр гайхан, харьд худалдсан ухаагч гүүнээс нь гарсан хонгор азарганы үр төл гаадаагүй мөн бололтойд оньсого мэт орчлонгийн ээдэрсэн утас шиг хэрээсэнд төөрөн орвой.

Харьд худалдагдсан хээлтэй гүүний унага нутагтаа гүйж ирсэнд эс итгэмээр боловч үзээд бариад ирэхээр үнэмшихээс аргагүй энэ явдлыг адуучин эр нэг бол миний зүүд, эс бол хорвоогийн зүүд гэж бодох авч аандаа байгаль ертөнцийн зөн совин хэмээх нууцлагийн учир начир зүрхэнд нь уусан байв аа.

Адуучин эр бүл нэмсэн адуугаа туусаар гэрийн зүг хатируулах мөчид жигүүргүй боловч хомбон дөрвөн туурай нь газар хүрэн алдан цогих тэр дааганы мундаан дээгүүр тэнгэрийн элчүүхэй хоёр хараацай сүлжин ниссээр байвай.

1989 он

(Г.Мэнд-Ооёо. “Оюун санааны хээр тал”. УБ., 2016, 13-15 дахь тал)

2. Үгийн утгыг ойлгох чадвараа дараах хүснэгтийн дагуу үнэлээрэй.

Чадвар	Шалгуур	Үргэлж	Ихэвчлэн	Хааяа
Үгийн утгыг ойлгох	Үгийн утгыг ойлгохын тулд “Тайлбар толь” ашигладаг			
	Үгийн утгыг ойлгохдоо өгүүлбэрийн хам бүтцээс гаргадаг			
	Үгийн ойролцоо утгаас зөв сонголт хийдэг			
	Мэддэг үгийнхээ бүтцээс хөөж, үгийн утгыг ойлгодог			
	Үгийн сангийн баялаг мэдлэгтэй (Ямар ч сэдвээр бичсэн эхийг ойлгох)			

3. Асуултын дагуу багаар ярилцаж, ойлгож мэдсэнээ бататгаарай.
- Унага нутаг руугаа шууд л давхиад явахгүй яагаад шогшоод байгаа юм бол?
  - Зохиолч “хөөрхий, урамгүйхэн” гэсэн үгсийг яагаад сонгох болсон бэ?
  - Энэ унага өмнө нь бас л ийм ноомой байсан юм бол уу?
  - Зохиолч “далдын совин билиг” гэдгээр юуг илэрхийлэхийг зорьсон бэ?
  - Зохиолч алтан хараацайг “тэнгэрийн элчүүхэй” гэж нэрлэсний учир юу вэ?
  - Адуучин эр хонгор азарганы үр төл гэдгийг яаж мэдсэн байх боломжтой вэ? Үүгээр дамжуулж монгол уламжлалын талаар юу хэлэхийг зорьсон бэ?

### Дүрийн үйлдлийг дүгнэе.

1. Дараах онолын ойлголтыг уншиж судлаад даалгаврыг хийж гүйцэтгээрэй.

Зохиолд өгүүлэгч болон баатрууд өөр өөрийн үйл хэрэг, зорилгоо хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй хийх үйл ажиллагааны тодорхой хэсгийг үйлдэл гэнэ. Зохиол бүхэлдээ хоорондоо холбогдсон үйлдлүүдийн тогтолцоо юм. Үйлдэл нь баатрууд ба өгүүлэгчийн хүүрнэлд олон янзын (ухамсартай, ухамсаргүй, зорилготой, зорилгогүй, ганцаар, олуул, биеэр болон оюун ухааны ертөнцөд гэх зэрэг олон хэлбэрээр илрэх бөгөөд энэ бүхэн нэгдэн холбогдсоноор зохиол нэг цогц ертөнц болдог) үүрэг, хэлбэрээр хийгдэх бөгөөд биеийн болон оюуны үйлдэл бүр нь зохиолыг бүхэлд нь амьд, сонирхолтой, зөрчил тэмцэлтэй болгоход чиглэнэ”

(Галбаатар.Д “Уран зохиолын нэвтэрхий толь” УБ., 2012, 438-439 дэх тал)

2. Унаганы ижил сүргээ олоогүй ба олсон үеийн үйлдлийг түүж бичээрэй.

Ижил сүргээ олоогүй байх үеийн  
12 үйлдэл

- Урамгүйхэн шогшиж явах
- .....
- .....

Ижил сүргээ олсон байх үеийн 5  
үйлдэл

- Сүүл хатган давхих
- .....
- .....

3. Дээрх үйлдлүүд дүрийг тодруулахад ямар үүрэгтэй, ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байгааг эх доторх үг хэллэгээр баталж, багаар ярилцаад дүгнэж бичээрэй. Дүгнэж бичихдээ жишээ болгосон хэсгийг гүйцээн бичиж санаа авч, нэмж баяжуулж болно.

*Жишээ нь: Эхлээд “шогшиж”, дараа нь “....”, сүүлд нь “....” гэсэн үгсийг сонгон маш их ядарсан тул явдал нь саарсаар бараг л унах нь уу даа гэмээр сэтгэгдэл төрж, унаганы хувьд их л таагүй байсан боловч ... гэдэг нь харагдаж байлаа гэх мэтээр дүгнэж бичээрэй.*

4. Унаганы үйлд туслан ба сөрөн үйлдэгч болж байгаа юмсыг үйлдэлтэй нь хамт жагсаан бичээрэй.

Дөрвөн туслан үйлдэгчийн үйлдэл  
Хэдэн алтан хараацай:  
- ээрэн нисэх  
- ерөөлдөн зэрэх  
- шүргэн нисэх гэх мэт

Сөрөн үйлдэгчдийн үйлдэл  
Гангийн нар- гундаан шарах  
Асман үрээ- хасан элдэх гэх мэт

5. Дээрх сөрөн ба туслан үйлдэгчид дүрийг тодруулахад ямар үүрэгтэй байна вэ? Ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байгааг багаараа дүгнэж ярилцахдаа учир шалгаан болон үгийн утгын зүйлчлэлтэй холбоорой.
6. Унагыг ганцаардуулалгүй хань болж байсан хараацайд зориулсан талархлын захиа бичээрэй.

### Талархлын захиа

#### Зохиолын сэдэв, санааг тодорхойлъя

Асуултад хариулж ярилцан зохиолын сэдэв санааг тодорхойлоорой.

А. Унага төөрч будилж явсаар юу юуг олсон бэ?

- .....
- Эзэн
- .....

Б. Унаганы хувьд дээрх зүйлс яагаад чухал байсан бэ?

В. Зохиолч эхийнхээ хээлд зарагдсан унагыг гол дүр болгон сонгож авснаараа юуг илүү чухалчлахыг хүссэн бэ?

Г. Эхийн гарчиг нь зохиолын сэдэв, санаанд хэрхэн холбогдож байна вэ?



Бичих чадвараа хөгжүүлье

#### Зохиолд үйл явдал, дүрслэл нэмж дэлгэрүүлж бичье

А. Нутаг руугаа гурван улирал дамжин гүйхдээ унага хэрхэн өсөж, том болж байгааг дүрслэн бичих. Үүнд:

Эхний хэсэгт: Орчныг дүрслэн бичих

Гол хэсэгт: Унаганы өсөж том болж байгааг дүрсэлж бичих

Төгсгөл хэсэгт: Санаанд оромгүй сонин төгсгөл хийх

Б. Унаганы ээжийг хэзээ, хаашаа, ямархуу хүнд, яагаад худалдах болсон шалтгааныг нэмж бичих. Үүнд:

Эхний хэсэгт: Эзнийх нь худалдах болсон шалтгааныг бичих

Гол хэсэгт: Аль нутагт амьдардаг хүнд худалдсан болон ээж нь нутгаасаа явахдаа ямархуу байдалтай байсан талаар дүрсэлж бичих

Төгсгөл хэсэгт: Унага нутаг гүйсэн шалтгааныг бичих



## Уншихын өмнө

1. *“Бурханбогд аав хоёр” зохиолыг уншихын өмнө зохиолчийн намтар, уран бүтээлийн талаар товч мэдээллийг уншаад, хосоороо ярилцаарай. Өөрсдийн мэддэг зүйлийг нэмж яриад, баяжуулж судлаарай.*



(1938-2013)

## Пүрэвжавын Пүрэвсүрэн

1938 онд Баянхонгор аймгийн Баацагаан суманд төржээ. 1958 оноос уран бүтээлээ эхэлж, "Хүний тухай дууль", "Бүргэдийн дууль", "Гал", "Хүслийн зарлиг", "Цэцгийн хувь", "Чин хайрын өргөл" "Уран захидлын хариу", "Зууны цэцэг", "Тавилан" зэрэг ном хэвлүүлжээ. 1973 онд МЗЭ-ийн шагнал, 1989 онд БНМАУ-ын Төрийн шагнал тус тус хүртжээ..

2. *Зохиолын нэр, “Хань минь өөд болж би гэдэг амьтан элий балай явсаар нэг жил өнгөрч байхад нэг өглөө...” гэсэн хэсэглэлийг уншаад ямар үйл явдал гарахыг таамаглаж ярилцаарай.*



## Унших чадвараа хөгжүүлэе

## Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя

1. Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглээд “Монгол хэлний их тайлбар толь” ашиглан утгыг мэдэж аваарай.
2. Өөрсдийн таамаглалаа зохиолын үйл явдалтай харьцуулж уншаарай.

## БУРХАНБОГД ААВ ХОЁР

Бурханбогд энэ өглөө цагаасаа эрт босов. Гэсэн ч аав нь аль эрт ажилдаа явжээ. Бор дүрхэн тавилгатай жижигхэн байшин нь зэврүүхэн. Харин ширээн дээр элсэн чихэр түрхсэн хоёр зүсэм талх, будаг нь халцарсан халуун савтай цай бэлэн байлаа. Бурханбогд өглөө болгон ийм унд уугаад хичээлдээ явдаг юм. Гэлээ ч ядуухан амьдралдаа гутрах нь үгүй. Харин муу аавыгаа л их өрөвддөг байлаа. Тэр мэдээ орсон цагаасаа л аавтайгаа өссөн юм.

Бурханбогд чихэр түрхсэн зузаан талхаа хар цайгаар даруулан тухтайхан захлах зуураа бага насаа дурсан санав. Тэднийх хоёр өрөө өвлийн, бас зуны том дүнзэн байшинтай, ногооны жаахан талбайтай сайхан хашаатай байсан сан. Тэр багаасаа усаа зөөж, түлээгээ хагалж, ногооны зэрлэг зулгааж, ер нь ажилд сурсан юм. Аав нь насаараа л манаач хийж явжээ. Бурханбогд ядуухан айлын хүү боловч өлсөж цангаж, юухан хээхнээр дутаж явсангүй. Хүүдээ амиа тавьдаг аав нь өөрийнх нь төлөө аль байдгаа тэмтэрсээр иржээ. Арван хэд хүртлээ аавынхаа өвөрт унтаж билээ. Аавынхаа туранхай цээжинд наалдан дотно сайхан үнэрээр нь амьсгалан



унтах юутай жаргалтай. Гэртээ ч, манааны шовгорт ч аавтайгаа байхаас сайхан юмгүй.

Есдүгээр ангид орсон жил аав нь өсөж дассан байраа, шинэ хорооллын хаяа түшсэн энэ өмгөр байшинтай, жижигхэн хашаагаар солив. Хүүгээ дургүйцэхэд “Миний хүү удахгүй дээд сургуульд орно. Мөнгө хэрэгтэй” гэжээ. Тэгээд хүүгээ дагуулан явж, зөрөөнд нь авсан мөнгөө банкинд хадгалуулаад, үлдсэнээр нь хувцас хунар авч өгчээ. Өнгөрсөн хавар жижигхэн хашааныхаа нэг буланд дагтаршсан газар хагалан нүдэж зөөллөөд, ойрхон газраас хар шороо үүрч зөөн хольж, жаахан төмс, байцаа тарьсан нь овоо ургажээ. Гэвч мөнгө... Өдөр болгон юмны үнэ нэмэгдэж байгаа болохоор мах, талх, хааяахан авах сүүнд нь өвгөний тэтгэврийн мөнгө хүрэхгүй. Өнгөрсөн зун Бурханбогд нэг дэлгүүрт ачигч хийж цөөн төгрөг олсон боловч юун удах билээ.

Гэтэл өнгөрсөн намраас аав нь ажилтай боллоо. Өглөө бүхэн үүрээр явна. Харин Бурханбогдыг ирэхэд нь гэртээ хүлээж суудаг байв. “Хаана ажилладаг юм бэ?” гэхэд “Аа нэг компанид хашаа цэвэрлэдэг юм” гэжээ. Нэг удаа “Аав аа би арав төгсөөд ажил хийнээ” гэвэл эцэг нь ихэд сандарч “Миний хүү тэгж яаж болох вэ. Би хүүгээ дээд сургуульд оруулна. Өөр шигээ хүн болгохгүй. Аав нь хүүдээ дандаа баярлаж явдаг шүү” гээд хоолой нь зангирчээ. Өвгөн “Мөнгөний гарз” гээд тамхинаасаа ч гарчав.

Өнгөрсөн зун Бурханбогд анхныхаа цалин аваад аавдаа нэг шил архи авч өгчээ. Өвгөн ихэд баярлан хэдэн хундага уугаад, халамцан малилзаж, амаа арчин хүүгийнхээ толгойг илэн үнсээд “Миний бурхан, сайхан үр минь” гэж багынх шиг нь өхөөрдөж билээ. Бурханбогд багадаа “Надад яагаад ийм хачин нэр өгсөн юм бэ?” гэхэд “Чи миний шүтээн болоод л тэр” гэсэн аж. “Ээж ямар хүн байсан бэ?” гэхэд “Сайхан хүн байсан юм аа” гэхээс өөр үг хэлдэггүй байлаа. Хүү ч сүүлдээ ухаан суугаад аавынхаа сэтгэлийг зовоохгүйн тул тэр тухай дахин асуухаа больсон юм. Харин хүүгийнхээ авчирсан архинд халамцсан тэр орой “Миний хүү том эр болжээ. Аав нь удахгүй өнхрөөд өгнө. Хүүд минь сурсан эрдэм л хэрэг болно шүү” гэж сургамжлаад хэсэгхэн дуугүй сууснаа ихээр санаа алдаж “Би хүүгийнхээ ээжийг даанч мэдэхгүй юм даа” гэжээ. Бурханбогд бүр гайхаж “Юу гэнээ” гэвэл “Аа миний хүү одоо мэдэж ав даа. Хань минь өөд болж би гэдэг амьтан элий балай явсаар нэг жил өнгөрч байхад нэг өглөө муу байшингийн минь довжоон дээр өлгийтэй хүүхэд байж байсан юм даа. Тэр бол чи. Ингэж би хүүтэй, чи аавтай болсон хэрэг. Бурхан ханийн минь сүнсийг хүү болгож надад илгээж гэж сүжиглээд чамд ийм нэр өгсөн” гэж хуучилжээ. Бурханбогд үүнээс хойш аавыгаа улам ч өрөвдөж “жаргаах сан” гэж хүсэх болсон юм.

...Тэр ундаа ууж, гэрээ цэвэрлээд гарав. Бурханбогд сургуульд орсон цагаасаа хойш онцоос өөр дүн авч байсангүй. Үүнд аав нь дандаа баярлаж “Миний хүү эрдэмтэн болно” хэмээн бахархана. Хүү ч аавыгаа баярлуулж байхын тулд мэрийсээр арав төгсөхөд хэдэн сар үлдээд байгаа нь энэ.

Бурханбогд өнөөдөр зам хазайв. Өчигдөр ангийнхаа үерхдэг охин Өнөрцэцэгийг дайрч очих, тэр нь гадаа хүлээж байх болзоо тавьсан юм. Нэг байрны хажуугаар өнгөрч явтал өглөөний бүүдгэр гэрэлд хоёр хүн хог ухаж байгаа нь харагдав. Хүү “ядуу хүний зовлон” гэж бодоод, Өнөрцэцэгийнхээ болзоонд яаран цаашиллаа. Дараагийн байрны хогийг бас нэг хүн ухаж байна. Санаандгүй ойртож яваад зог тусав. Аавынх нь ажилдаа өмсдөг хувцас. Зогсоод ажиглав. Хог дотроос пийжүүний

хэдэн шил, хоёр гурван төмөр лааз гарган уутанд хийж байна. Хөдөлж явах нь яг л аав. Бурханбогдын дотор палхийн “Өнөө компанийн хашаа гэдэг нь...” гэж бодонгуут гүйх шахуу очиж, чичирхийлсэн хоолойгоор “Аав аа” гэтэл өвгөн цочиж, төмөр дэгээгээ ханхийлгэн унагаад, хэсэг алмайран харж зогсов. Тэгээд нүүрээ тагласан амавчны цаанаас “Миний хүү” гэж цахиртсан хоолойгоор дуугарлаа.

- Та яаж байгаа юм бэ?
- Аав нь шил, лааз л түүдэг юм. Өөр юу ч авдаггүй.
- Аав аа харья!
- Миний хүү сургуульдаа яв аа.
- Үгүй би ажил хийнэ.

Ийм хэдэн үг солиод Бурханбогд аавыгаа сугадан эргэв. Өвлийн жаварт өглөө аав, хүү хоёулаа уйлж явлаа.


1998

3. Асуултын дагуу ярилцаж ойлголтоо бататгаарай.
  - А. Хүүгийн нэрийн учир утгыг тайлбарлаж ярилцаарай. Өөрийнхөө нэрийн бэлгэдлийн утгыг найз нартаа сонирхуулаарай.
  - Б. Хүүг сайн хүн болоход нөлөөлсөн хүчин зүйлүүдийг тоочин нэрлэж, тайлбарлаж ярилцаарай.
  - В. Дараах хэлц үгийн утгыг эхтэй холбон тайлбарлаж ярилцаарай.
 

Бор дүрхэн (тавилга) -	Мэдээ орох (цаг) –
Аль байдгаа тэмтрэх-	Ухаан суух-

### Орчин, нөхцөл байдлыг тайлбарлая

1. Бурханбогдын гэр, өглөөний цайны тухай орчны дүрслэл, түүнд хандаж байгаа дүрийн хандлагыг нөхөж бичээрэй.



2. Бор дүрхэн тавилгатай жижигхэн байшин зэврүүхэн байгаагаар зохиолч ямар санаа гаргасныг зохиолын үйл явдлаар батлан тайлбарлаарай. Тайлбараа “Хариултын хана босгох” аргаар нэгтгэхдээ дөрөвдүгээр цогцолборыг анхаарч уншаарай.
3. Өмнөх байшин, одоогийн амьдарч байгаа байшин хоёрыг хэрхэн дүрсэлснийг харьцуулаад зохиолч үүгээр юуг тодотгож, ямар санаа гаргасныг тайлбарлаарай.
4. Зохиолч ямар зорилгоор ийм орчин, нөхцөлийг бүтээсэн юм бол?
5. Ийм орчинд ямар уур амьсгал мэдрэгдэж байна вэ? Бурханбогдод амьдарч байгаа орчин, идэж байгаа хоол унднаас чухал, хамгийн үнэ цэнтэй зүйл нь юу болохыг эхийн жишээ баримтаар баталж нотолж тайлбарлаарай.
6. Дээрх асуултын дагуу гаргасан саналаа “Бод, хамтар, хуваалц” аргаар хийгээрэй. Үүнд:
  - А. Эхлээд асуултын талаар ганцаарчлан бодно. Өөрөөр хэлбэл бусдын дэм авахгүй өөрөө шийд гаргахыг хичээнэ. Шийдвэрээ гаргахын тулд зохиолоо

дахин гүйлгэн унших, зохиолын жишээ баримтаар өөрийн хариултыг дэмжих.

- Б. Дараагийн шатанд өөрийн саналыг түнштэйгээ хамтран харилцан ярилцана.
- В. Төгсгөлд нь хамтран тохирсон саналаа цөөн хүүхэдтэй бол ангийнхандаа, хэрвээ олон хүүхэдтэй тохиолдолд хэд хэдэн дэд баг болж багууд саналаа нэгтгэн танилцуулна.

**Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг дүгнэе**

1. Бурханбогдын аав гэж хэн бэ? Түүний хүүдээ хандах хандлагыг зохиолын хэсгүүдээр батална уу. Энэ дүрээр зохиогч бидэнд юуг хэлэхийг хүссэн юм бол? Даалгаврыг хосоор болон багаар хийж болно. Аавын дүрийг дүгнэхдээ дараах хэсгүүдийг нөхөж гүйцээн, учир шалтгааны тайлбарлаарай.

- Аав нь насаараа л ..... хийж явжээ.
- Мах, талх, ..... өвгөний тэтгэврийн мөнгө хүрэхгүй.
- Өнгөрсөн намраас аав нь ажилтай боллоо. Өглөө бүхэн үүрээр явна.
- “Мөнгөний гарз” гээд ..... гарчхав.
- Хань минь өөд болж би гэдэг амьтан элий балай явсаар нэг жил өнгөрч байсан
- Нэг өглөө муу байшингийн минь довжоон дээр ..... байж байсан юм даа.
- Тэр бол чи.
- Ингэж би хүүтэй, чи аавтай болсон хэрэг. Бурхан ханийн минь сүнсийг хүү болгож надад илгээж гэж сүжиглээд чамд ийм нэр өгсөн.
- Хүүдээ амиа тавьдаг аав нь өөрийнх нь төлөө ..... тэмтэрсээр иржээ.
- Хүүгээ ..... оруулна. Өөр шигээ хүн болгохгүй.
- Аав нь хүүдээ дандаа баярлаж явдаг шүү
- Хүүгийнхээ толгойг илэн үнсээд “Миний бурхан, сайхан үр минь” гэж ..... сурсан эрдэм л хэрэг болно шүү” гэж сургамжилсан

2. Хүү, аав хоёрын хийсэн үйлдэл, хэлсэн ярьсан зүйл юугаараа ижил юугаараа ялгаатай байгааг багаар ажиллан дүгнэж бичээрэй.

Дүр	Ижил тал	Ялгаатай тал
Аав		
Хүү		
Дүгнэлт		

**Сэдэв, гол санааг тодорхойлъя**

- 1. Эд хөрөнгө, ядуу тарчиг амьдралаас үнэтэй зүйл хүү болон аавын хувьд хэн бэ? Яагаад?
- 2. Дээрх задлан шинжилсэн үйлүүдээ ашиглан зохиолын сэдэв, санааг тодорхойлж бичээрэй.

3. Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, бие биеэ хайрлах их хайр юу юунаас илүү чухал болохыг гаргасан гэсэн санаатай та нар санал нийлж байна уу? Яагаад гэдгийг тайлбарлаарай.



Ярих чадвараа хөгжүүлье

### Зохиолын дүрийн талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл эшлэл ашиглан сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярья

Дараах асуултын дагуу ярилцахдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан ярилцаарай.

#### Ярилцлагын асуултууд:

- Зохиолч ямар зорилгоор шинэ нөхцөл байдлыг нэмсэн бэ? Шинэ нөхцөл байдалд дүрүүдийн үг яриа, үйл хөдлөл өөрчлөгдсөн үү? Ямар учраас....
- Дүрүүдийн харилцан яриагаар дамжуулж уншигчдад юуг танин мэдүүлэхийг зорьсон байна вэ? Энэ нь түүний үзэл бодол, үйл хэргийн талаар ямар нэгэн зүйлийг бидэнд мэдээлж байна уу?
- Дүрүүдийн хооронд зөрчил нь юу байсан бэ?
- Энэ нь хүмүүсийн харилцаатай илүү холбоотой байна уу? Эсвэл...
- Энэ дүр таны урьд өмнө уншиж байсан зохиолын ижил төстэй дүрүүдээс юугаараа өвөрмөц онцлогтой вэ?
- Зохиолын дүрийн сэтгэл зүй нь зохиолын гол санаатай хэрхэн холбогдож байна вэ?
- Энэхүү дүрээр дамжуулан илрүүлж буй зохиолчийн үзэл бодол хандлагатай чи хэр зэрэг санал нийлж байна вэ? гэх мэт



Бичих чадвараа хөгжүүлье

### Зохиолд үйл явдал нэмэн дэлгэрүүлж бичье

Дараах хоёр даалгаврын аль нэгийг сонгож хийгээрэй.

1. Зохиолын төгсгөлийг цааш үргэлжлүүлэн бичээрэй. Бичихдээ:
  - Эхлэл хэсэгт аав, хүү хоёрын хооронд гэртээ очоод ямар яриа өрнөснийг бичих.
  - Гол хэсэгт тэдэнд ямар гарц байгааг бодитойгоор харж зөв шийдвэр гаргахад нь туслахаар ирсэн гэж өөрийгөө төсөөлж бичих.
  - Аз жаргалтай төгсгө.
2. Дүрийн талаар мэдрэмж, сэтгэгдлээ бичихдээ уран дүрслэл ашиглаж бичье  
Бичихдээ:
  - Аав хүү хоёрын дүрээс аль нэгийг сонгон дүгнэж бичих.
  - Дүгнэж бичихдээ эхээс оновчтой эшлэл ашиглах.
  - Өөрийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэхдээ дүрслэх хэрэглүүр, хэлц ашиглах.

**ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ**

Уншсан зохиолынхоо зохиолчдоос нэгийг сонгоод

- Зохиолчийн талаар судалгааны асуулт зохиож, судалгаа авч дүгнэлт гаргах
- Зохиолчтой ярилцах асуулт зохиож, бусад багийн сурагчдаас хариулт авч үнэлгээ хийх гэх мэт даалгавраас сонгож ажиллаарай. .

**Ажиллах заавар:**

- Сурагчид 4-5 хүнтэй багт хуваагдан зохиолчийн намтрын судалгаа хийх явцдаа асуулгын хуудас, ярилцлагын асуултаас аль нэгийг сонгож хийнэ.
- Ярилцлагын асуултыг хийхдээ өөрсдийгөө тухайн зохиолчтой уулзаж байна гэж төсөөлж, түүнээс асуух асуултыг бэлтгэнэ.
- Гишүүн бүр өөрсдийн асуулгын хуудсаа бусад багуудад өгч багуудын хуудсыг сольж авч бөглөнө.
- Гишүүд бусад багийнхныг бөглөж байх явцад асуудал тулгарвал багаараа ярилцаж, тухайн асуултад хэрхэн хариулах талаар саналаа нэгтгэнэ.
- Багууд асуултын хуудсыг буцаан өгсний дараа хариултыг нэгтгэн судалгааны дүнд боловсруулалт хийж графикаар үзүүлнэ.
- Багуудын хийсэн ажлыг нэгтгэснийхээ дараа дүгнэлтээ танилцуулна.

Жишээ нь:

Судалгааны хуудас:  
Бидний судалгаанд оролцож байгаа танд талархал илэрхийлье.

1. Г.Мэнд-Ооёог танигдахад дэлхийд нөлөөлсөн баримтаас гурваас доошгүйг тоочиж бичнэ үү.
2. “Нутаг гүйсэн унаганы дууль” зохиолын талаар сонирхолтой санагдсан гурваас доошгүй зүйлийг бичнэ үү.
3. Зохиолчийн намтрын хуудаснаас танд хамгийн сонирхолтой санагдсан нэг зүйлийг бичээд яагаад? гэдэгт товч тайлбар хийнэ үү гэх мэт.

.....

.....

Ярилцлагын асуулт:  
Бид Монголын нэрт зохиолч Д.Нацагдоржтой уулзаад байна.

**Сур:**Та “Хуучин хүү” зохиолынхоо санааг анх яаж олсон бэ?

**Сур:**Таны амьдралд тохиолдсон бэрхшээл бүхэн уран бүтээл болдог байсан уу? Тухайлбал:

**Сур:**Таны “Хуучин хүү” зохиолыг шүлэглэсэн хэлбэрт хувиргаж болдог өвөрмөц зохиомжтой гэдэг. Ийм хэлбэрээр бичсэн өөр ямар зохиол байдаг вэ? гэх мэт.



3. Бид Монголын орчин үеийн шилдэг өгүүллэг, туужаас сонгон уншлаа. Эдгээрийг сайн өгүүллэг, тууж гэдгийг батлах гурван шалгуур үзүүлэлт зохионо уу?
4. Зохиолын гол санааг гаргаж чадаж байгаа эсэхээ дараах шалгуураар үнэлээрэй.

	1	2	3	4
Гол санаа болон таамаглалаа дэмжсэн нотолгоо үндэслэл гаргасан эсэх	Дэмжсэн үндэслэл гаргаагүй гол санааг таасан (1 оноо)	Үндэслэл гаргасан ч тэр нь оновчтой бус буюу гол санааг гаргахад дөхүүлсэн (2 оноо)	Гол санааг зөв тодорхойлж, хамааралтай үндэслэл гаргасан ч гүйцэд биш (3 оноо)	Гол санааг зөв тодорхойлж, шууд ашиглаж болох олон янзын маш сайн үндэслэл гарган тайлбарласан (4 оноо)
Оноо 1-4				

5. Өөрсдийн шинээр мэдсэн уран зохиолын онолын ойлголтоос сонгон схем, зураглалаар илэрхийлж, нөхдөдөө тайлбарлаарай.
6. Уншсан өгүүллэгүүдээс өөрт хамгийн үнэ цэнтэй ямар зүйлийг олж мэдсэнээ жагсаан бичээрэй.
7. Чамд хамгийн их таалагдсан дүрүүд хэн байв? Яагаад?
8. Дүрүүдээс чамтай төстэй эсвэл ялгаатай ямар зан чанар илрэв? Чи аль зан чанарыг өөртөө шингээхийг хүсэв? Яагаад?
9. Сэтгэлд тань үлдсэн хэсэг, үг хэллэг, дүр дүрслэлээс сонгож бичээд, учрыг тайлбарлаж найзтайгаа ярилцаарай.

**ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ**

Шалгуур	Үнэлгээ	Гүйцэтгэл
<b>УНШИХ</b>		
Туурь өгүүллэгийг уншаад зөв мэдэрч ойлгон утга санаа, дүр дүрслэлийн онцлогийг үйл явдлын уялдаа холбоо, орчин нөхцөлтэй нь зөв хослуулан шинжилж тайлбарласан байдал	1-5 оноо	
Монголын түүх, соёл, уламжлалын үнэт зүйлийг ойлгож, хүндэтгэж сурснаа илэрхийлж байгаа байдал	1-5 оноо	
<b>ЯРИХ</b>		
Зохиолын дүрийн талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярьсан байдал	1-5 оноо	
Зохиолын гол санаа, дүрийн зан төрхийг ойлгож мэдэрснээ дүр бүтээж харуулсан байдал	1-5 оноо	
<b>БИЧИХ</b>		
Зохиолд дүр, орчин нэмэх, харилцан яриа оруулах зэргээр дэлгэрүүлж бичсэн байдал	1-5 оноо	

# III БҮЛЭГ

## МОНГОЛ ЯРУУ НАЙРАГ

### Судлах зохиол:

#### 3.1. СУРГААЛЫН ШҮЛЭГ

- Чингис хааны билиг
- Оюунтүлхүүр

#### 3.2. УЯНГЫН ШҮЛЭГ

- Д.Нацагдорж “Миний нутаг”
- Д.Пүрэвдорж “Чингис”
- Т.Галсан “Жирмийн сүлжээ”
- Д.Цоодол “Харамчийнхны дууль”
- Д.Нямаа “Шөнийн талд ядуу янцгаана”
- Д.Сумьяа “Монгол шагай”

#### 3.3. НАЙРАГЛАЛ

- Ц.Дамдинсүрэн “Зугаацахаар мордсон нь”
- Д.Цэвэгмид “Алагдай аварга”

### Эзэмших чадвар:

#### УНШИХ

- Шүлэг, найраглалыг мэдэрч ойлгох, тусган хүлээж авах
- Яруу найргийн зохиолын онцлогт тохирсон хэл найруулга, орчин, дүр, сэдэв, утгын задлал хийх
- Үндэсний хэл, соёл, ёс заншлын үнэт зүйлийг ойлгож, хүндэтгэж сурах

#### БИЧИХ

- Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүр, дүрслэлийн талаар мэдрэмж, сэтгэгдлээ уран дүрслэл ашиглаж бичих
- Хүн, юмс, үзэгдлийн гадаад мөн чанарыг дүрслэн магтах аргаас суралцан шүлэглэж бичих

#### ЯРИХ

- Шүлэг, найраглалыг цээжилж, дуу хоолойн өнгө, аялга, хэмнэлийг тохируулж уран унших
- Туульсын найраглалын гол санаа, дүрийн зан төрхийг ойлгож мэдэрснээ дүр бүтээж харуулах

## 3.1 СУРГААЛЫН ШҮЛЭГ



## Уншихын өмнө

1. Хүүхдүүд ээ, та нар Эзэн Чингис хааны талаар хэр ихийг мэдэх вэ? Өөрийн уншсан сонссон зүйлээсээ ангийн нөхөдтэйгөө хуваалцана уу.
2. Хүний амьдралд ямар ямар тэмдэглэлт баяр тохиодог вэ? Тэдгээрээс хамгийн эрхэм баяр нь юу вэ? Бодлоо хуваалцаарай. “Чингисийн билиг” зохиолд ямар баярыг эрхэм баяр гэж нэрлэснийг таамаглаж ярилцаарай.
3. “Чингис хааны билиг” хэмээх зохиолын нэрийн утгыг тайлбарлана уу? Үүний тулд нэгэн ижил дуудлагатай дараах үгсийг ажиглаарай.



Билиг - оюун билиг  
Бэлгэ - бэлгэ тэмдэг  
Бэлэг - бэлэг дурсгал

Чингис хааны хөвүүд, дүү нар, шадар өрлөгүүддээ зориулан зохиосон сургаалыг “билиг” хэмээн нэрлэж ирсэн.



## Унших чадвараа хөгжүүлье

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя.**

Зохиолыг уншихын өмнө дараах үгсийн утгыг ойлгож, мэдэж аваарай.

хангирсах- улиран одох	шилжрэх- өөрчлөгдөх
надад ухваас-	богт-
булха хүн-	аху-
амуулбаас-	нугад-
шүүрч хүн-	

**ЧИНГИС ХААНЫ БИЛИГ****Цагаадайгаас хуримын дээдийг асууруун**

Чингис хаан, Цагаадай хөвгүүнээсээ “Хуримын дээд хурим аль буй?” хэмээн асууваас, Цагаадай өгүүлрүүн:

“Хуучин он бидний  
Хангирсаж одох хэмээн  
Шинэ он бидний  
Шилжирч ирэв гэж  
Өлзийт хутагт хэмээн хуримлалдах  
Хуримын дээд тэр буй за” хэмээн  
өгүүлбээс Чингис хаан зарлиг болруун:  
Нярайгаас хагацаад  
Нэр эс өгвөөс

Хэвлийгээс унаад  
Гэгээнийг эс үзвээс  
Хэний шинийг шинэлэх та  
Хэний нэрийг нэрлэх та  
Үүнээс хойшид  
Эцгээс үүдэж  
Эхээс төрсөн өдрөө  
Олж хүндлэлдэн уулдваас  
Дээд хурим тань энэ болой”  
хэмээн зарлиг болсон ажгуу.

### **Чингис хаан хөвүүд лүгээ цэнгэлдэн хуримларуун**

Чингис дөрвөн хөвүүд лүгээ дарс уулдаад тархсан ажгуу, Маргааш эрт хурж, өчигдөр өдрийн согтсон шалтгаанаа өгүүлэлдээд хаан зарлиг болруун:

Хөвгүүд минь та энд сууж өчигдрийн явдлаа яригтун. Би урд тусдаа сууж өтгөс ихэстэй улсын үйл өгүүлэлдсүгэй хэмээн урд тусдаа сууж, «Харагтун та» гэж нэгэн хүмүүнийг «Одож ухаж ирэгтүн, хөвгүүд минь юун үг өгүүлэлдмүй» хэмээн илгээвээс: Хөвгүүд нь үгээ улмаас өгүүлэлдээд жаргалангийн сайн аль вэ? хэмээвээс: Зүчи өгүүлрүүн,

“Надад ухваас  
Олон адуугаа хичээн адуулан,  
хичээн таргалуулж  
Орд гэрээ буудал зохиож  
Хуримлан цэнгэлдэн сууваас  
Жаргалын сайн энэ аху”  
хэмээн өгүүлжээ.

Цагаадай ах өгүүлрүүн,

“Надад ухваас  
Дайсан хүнийг дарж  
Булха хүнийг бурчиж  
Ботгодыг буйлуулж  
Богттойг уйлуулж  
Авч ирвээс  
Жаргалангийн сайн энэ аху”  
хэмээн өгүүлжээ.

Өгэдэй өгүүлрүүн:

“Надад ухваас,  
Сод хаан эцгийн  
Зовон зөөсөн  
Их улсыг амуулан  
Хөл хөсөр  
Гар газар тавиулж,  
Улс иргэнээ уртад агуулж  
Төр ёсноо төвшинд барьж

### **Шүлгийн бүтцийг шинжилье**

“Чингис хааны билиг” сургаалын зохиолын бүтцийг ажиглаж, хэсэг тус бүрийг өнгөөр ялгаж тэмдэглээд дүгнэлт хийгээрэй.

Өтгөс ихсийг жаргуулж  
Өсөх залуусыг амуулбаас  
Жаргалангийн сайн энэ аху”  
хэмээн өгүүлжээ.

Тулуй өгүүлрүүн:

“Надад ухваас  
Хөвүүд хүлгүүдээ засан тэргүүлж  
Хөгшин харцгайг бариулбаас  
Гүн нуурыг бядан явж  
Хөхөгчид нугадыг бариулбаас  
Алгууд хүлгүүдээ засан тэргүүлж  
Ал начнаа бариулбаас  
Уул горхидыг бядан явж  
Алагчуун нугадыг бариулбаас  
Жаргалангийн сайн энэ аху”  
хэмээн өгүүлжээ.

Энэ үгийг тэр хүн шүүрч, одоо Чингис хаанаа төгс өчвөөс хаан зарлиг болруун: “Зүчи өчүүхнээс адгуусанд амраг бөлгөө. Тэрбээр тийнхүү өгүүлжээ. Цагаадай өчүүхнээс над лугаа хамт улс байгуулдлаа. Тэрбээр тийнхүү хэлжээ. Тулуй өчүүхэн хүний үг өгүүлжээ. Өгэдэйн үг маш зөв аху” хэмээн зарлиг болсон ажгуу.

### **Чингис улс юугаан хайрларуун:**

Алд биеэ амс хэмээвээс  
Аху төр минь алдруузай  
Бүтэн биеэ амс хэмээвээс  
Бүрэн улс минь сандруузай  
Алд бие минь алжааваас алжаатугай  
Аху төр минь бүү алдартугай  
Бүтэн бие минь зовбоос зовтутай  
Бүрэн улс минь бүү сандартугай  
хэмээв.

*Ц.Дамдинсүрэн. "Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой". УБ., 1957. 43-45 дахь талаас хэсэглэн авав.*





- Чингис хааны хөвүүд жаргалын дээдийг хэлэлцэхэд хэн юу гэж хэлсэн тухай Чингис хаан элчээсээ сонсоод, хэний үгийг маш зөв гэж сайшаасан бэ? Яагаад? Мөн Чингис хаан хэний үгийг өчүүхэн хүний үг гэж хэлсэн бэ?
- “Цагаадайгаас хуримын дээдийг асууруун” гэдэг хэсэгт Чингис хаан Цагаадай хөвүүнээсээ хуримын дээд хурим аль вэ? хэмээн асууваас Цагаадай ямар баярыг хэлсэн бэ? Дараах бүдүүвчид Чингис хаан, Цагаадай хоёрын хэлсэн үгийг нөхөж бичээд цээжилж тогтоогоорой.

Чингис хаан хөвгүүдээсээ асууруун:	Цагаадай	Чингис хаан
<ul style="list-style-type: none"> <li>Хуримын дээд нь аль буй?</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>.....</li> <li>.....</li> <li>.....</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>.....</li> <li>.....</li> <li>.....</li> </ul>

- “Чингис хаан улс юугаан хайрларуун” гэсэн хэсэгт чухам юуны талаар сургасан байна вэ? Зохиолоос эшлэл авч тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар

- Сургаалаас аль нэгийг сонгож, өөрсдийн эерэг үйлдэл, үйл ажиллагаагаар жишээ татаж учрыг дэлгэрүүлэн тайлбарлаарай.  
Чи өөрийн үйл ажиллагаандаа нэн тэргүүнд аль сургаалыг хэрэгжүүлэх вэ? Яагаад?

**Үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тодорхойлъя**

- “Чингисийн билиг” сургаалаас хуучирсан үг хэллэгийг түүж бичээд, хам сэдвийн хүрээнд утгыг тайлбарлана уу.
- Сургаалаас уран дүрслэл ашигласан жишээг түүж, дүрслэлийн үүргийг тодорхойлно уу.



Бичих чадвараа хөгжүүлье

**Зохиолд дүр, орчин нэмж, харилцан яриа оруулж дэлгэрүүлж бичье**

“Чингис хааны билиг” сургаалын аль нэг хэсгийг сонгоод, тухайн хэсгийн гол санаагаар эх зохион бичээрэй.

Бичихдээ:

- Дүр бүтээх
- Орчныг тодорхой дүрсэлж гаргах
- Үйл явдалтай байх
- Харилцан яриатай байх
- Гол санаа нь дээрх сургаалын санааг илтгэсэн байх гэх мэт.



## Уншихын өмнө

1. Зохиолыг уншихдаа дараах үгсийн утгыг толь бичгээс тодруулаарай.
 

шастир	тойн	төрхөм
манагаар	буг	цуцрах
хилэнц	оорцог	дорго
2. “Оюун түлхүүр” гэсэн үгийг тайлбарлан ярилцаарай.

“Оюунтүлхүүр” бол XIII зууны үеэс бичгээр уламжлан ирсэн монгол сургаалын зохиолын чухал цоморлог болно. Уг зохиолын агуулгыг нягтлан үзвээс XIII зууны үеийн монголчуудын төр ёсны зохиолын дурсгал бичиг “Их засаг” хэмээх хууль зүйн бичиг болон эзэн Чингис хааны зарлиг сургаал болох “Чингисийн билиг” зохиолын гол санааг уламжлан авч, улмаар XIII зууны үеэс монгол утга зохиолд нэвтэрч ирсэн “Рашааны дусал”, “Субашида” зэрэг хос ёсны сургаалын нөлөө тусгалаар баяжиж ирсэн байна. (Д.Цэрэнсодном. Монголын уран зохиолын товч түүх УБ., 2002, 194 дэх тал)



## Унших чадвараа хөгжүүлье

## “ОЮУН ТҮЛХҮҮР”

нэрт шастир

**Эртний богд Чингисийн зохиосон шастирыг өчүүхэн сануулахын учир**

... Өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн  
 Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун  
 Олны дотор үгээ бэхэл  
 Ганцаар суухдаа сэтгэлээ шинжил  
 Олон хүмүүн лүгээ найран зохилдож  
 Ер авах гээхийн ялгалыг шинжлэн мэд.  
 ... Тойн хүний хамаг эрдмийн дотор  
 Нигүүлсэхүй сэтгэл нэн эрдэм.  
 Хаан хүний гучин таван эрдмийн дотор  
 Хайрлах сэтгэл нэн эрдэм.  
 Хатан хүний арван таван эрдмийн дотор  
 Сайхан ааль нэн эрдэм.  
 Түшмэл хүний есөн эрдмийн дотор  
 Төвшин сэтгэл нэн эрдэм.

Тойн хүн хамаг эрдмийг төгс суравч  
 Дотроо нигүүлсэхүй сэтгэл үгүй болбоос  
 Тоолшгүй эрдэмтэй боловч тун тус үгүй.  
 Хаан хүн хамаг эрхийг төгсөвч  
 Хайрлах сэтгэл үгүй болбоос  
 Хамагт аргагүй хөнгөн болмуй.  
 Хатан хүн хамаг сайхныг төгсөвч  
 Ааль муутай болбоос



Харин төрхөмдөө буцаж буг болмуй.  
Түшмэл хүн есөн эрдмийг төгсөвч  
Төвшин сайн сэтгэл үгүй болбоос  
Хорт чоно мэт жигшигдэхүйн тул  
Төв сэтгэлийн зөийг хичээ.

Арслан мэт ноёдыг  
Барс мэт түшмэд дагах  
Барс мэт ноёдыг  
Ирвэс мэт түшмэд дагах  
Ирвэс мэт ноёдыг  
Чоно мэт түшмэд дагах  
Чоно мэт ноёдыг  
Үнэг мэт түшмэд дагах тул  
Хамагт зовлон болмуй.

...Арслангийн омог баатар мөн арсландаа зохих  
Үнэгний уран арга мөн үнэгэндээ зохих  
Арслангийн баатар омог үнэгэнд тусгүй  
Үнэгний уран арга арсланд тусгүй.  
Арслан үнэг мэт явбаас түргэн гутах  
Үнэг арслан мэт явбаас түргэн үхэх хэмээсэн үлгэрийг  
Хэн хүн хянан үзэж, хэр хэрээ мэдэж  
Чинээ чинээгээ бодож явбал сайн.

Ер хоёр хүн эвтэй болбоос  
Төмөр хүрээ мэт бэх.  
Хорин хүн эвгүй болбоос  
Эвдэрхий хүрээ мэт хэврэг.  
Өнөр хүн эвгүй болбоос  
Өнчин хүний элэг болох.  
Олон хүн эвгүй болбоос  
Оорцог хүний идэш болох.  
Цувж явсан барсаас  
Цуглаж суусан шаазгай дээр гэлээ.  
Тиймийн тул эв эеэ нэн бэхлэгтүн...


#### **Үүнээс үлэмж сударт номлосон нь:**

...Алтыг арчваас улам сайхан өнгө гарах  
Нүүрсийг угааваас улам харлах  
Мэргэдийг хорсговол улам эрдэм гарах  
Мунхгуудыг хорсговол баас гарах

Муу хүн нэг ч эрдэмгүй болбоос  
Дээрээ шүдтэйгээс бус үхэр лүгээ адил.  
Сургаал үл сонсох бөгөөд гагцхүү цадахыг санагч хүн  
Үсгүйгээс бус гахай лугаа адил.  
Авах идэхүйд шунагч өнгөч зусарч хүн  
Сүүлгүйгээс бус нохой лугаа адил.

...Мангаар үхэх боловч эрдмийг  
 Хичээн суралцах хэрэгтэй  
 Хэрвээ эс суравч хойд төрөлдөө  
 Сайны авьяас болох тул хичээгтүн  
 Адгуус ч эрдмийг сурах бөгөөтөл  
 Эрдэнэт хүний бие олсон тул  
 Хүний сурсан эрдмийг болгоомжтой болбол  
 Сурах хялбар  
 ...Борооны ус түргэн урсавч  
 Үтэр замхрах  
 Их мөрөн дөлгөөн урсавч  
 Их далайд цутгах  
 Чин сайн эрдэмт хүн  
 Чоно хонь хоёрыг нэгэн онгоцонд услах мэт.  
 Чингис Богдын зохиосон сургаал үүгээр  
 Шашин, төр хоёр энх амгалан тогтох болтугай.

### Үлгэрлэвээс мэргэд эрдэнийн хэлтэрхийг шинжлэх



(Товчлон авав)

“Оюун түлхүүр” нэрт шастир. Эхийг харьцуулан кирилл үсэгт хөрвүүлж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. МУИС, МХСС, УБ., 2006.

### Шүлгийн бүтцийг шинжилье

“Оюун түлхүүр” сургаалын зохиолын бүтцийн талаар судлаачдын дүгнэлтийг уншаад зохиол дээр гурван хэсэг тус бүрийг ялгаж тэмдэглэнэ үү.

“Оюун түлхүүр” нь зохиомж бүтцээрээ хоорондоо ялгаатай гурван хэсгээс бүтнэ.

- “Эртний богд Чингисийн зохиосон шастирыг өчүүхэн сануулахын учир” нь гэж эхэлсэн эхний хэсэгт жинхэнэ монгол билиг сургаалаас гаралтай иргэний сургаалууд голлон орсон.
- “Үүнээс үлэмж сударт номлосон нь” гэж эхэлсэн хоёрдугаар хэсэгт шашин номын утгатай мөр бадаг энд тэнд нэлээд орж шинээр нэмэгдсэн.
- “Үлгэрлэвээс мэргэд эрдэнийн хэлтэрхийг шинжлэх” гэж эхэлсэн гуравдугаар хэсэгт Энэтхэг, Төвөдийн сургаалын шүлэгт хэвшмэл байдаг дүр дүрслэл, тогтсон хэллэгүүдийг зориуд хэлхэн нийлүүлж, уран сайхны боловсруулалт хийсэн байдаг.

**Зохиолын сэдэв, санааг тодорхойлъя**

1. Сургаалын сэдэв, гол санааг хүснэгтийн дагуу тодорхойлоорой.

Сэдэв	Эшлэл	Гол санаа
Хүмүүсийн зан чанарын тухай		
Эв нэгдлийн тухай		
Эрдэм сурах тухай		

- Эв нэгдэл, эрдэм ном, ёс журмын тухай сургаалуудыг жагсаан бичиж цээжлээрэй.
- Цэгийн оронд нөхөж бичин гол санааг тайлбарлаарай.  
Тойн хүний хамаг эрдэм дотроос ..... нэн эрдэм буй  
Хаан хүний гучин таван эрдмийн дотроос ..... нэн эрдэм буй  
Хатан хүний арван таван эрдмийн дотроос ..... нэн эрдэм буй  
Түшмэл хүний есөн эрдмийн дотроос ..... нэн эрдэм буй  
а) хайрлах сэтгэл нэн эрдэм  
б) сайхан ааль нэн эрдэм  
в) төвшин сэтгэл нэн эрдэм  
г) нигүүлсэхүй сэтгэл нэн эрдэм
- Хилэн ихтийг яахин өнгөрүүлэх, хилэнц ихтийг юугаар тэтгэх вэ?
- Хаан юуг, хатад алийг үл мэдэх учиргүй вэ? Өөрийн үгээр илэрхийлээрэй.
- Шашны нөлөө орсон ямар сургаал үгс байна вэ? Та нар санал нийлж байна уу? Сэдэвлэн ангилаарай.
- Муу хүн нэг ч эрдэмгүй бол юутай адил гэж сургасан бэ?
- Маргааш үхэх боловч юуг хичээн суралцах хэрэгтэй гэсэн бэ?
- Алив хүнд юу юу хичээн сурахыг сургасныг олж мэдэв?
- Тэвчих зүйлсийг жишээлэн бичиж дүгнэн ярилцаарай.
- Ямар хүмүүсийг ямар ямар амьтадтай адилтгасан байна вэ? Шүүмжлэн ярилцаарай.

Эшлэл	Тайлбар

12. Чи өөрийн үйл ажиллагаандаа нэн тэргүүнд аль сургаалыг хэрэгжүүлэх вэ? Сургаалаас нэгийг сонгож, өөрсдийн эерэг үйлдэл, үйл ажиллагаагаар жишээ татаж учрыг дэлгэрүүлэн тайлбарлаарай.



Бичих чадвараа хөгжүүлье

**Сургаалын шүлгийн хэлбэрийг дуурайн бичье**

Бичихдээ:

- Толгой холболтыг анхаарах. Жишээ нь: АААА, ААББ, АБАБ гэх мэт
- Хоёр зүйлийг харьцуулж, учир шалтгааныг гаргаж бичих
- Бичиж байгаа зүйлээ сүүл холбож төгсгөх
- Сургамжтай санаа гаргах



**ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ**

1. Сургаалын зохиол гэж ямар зохиолыг хэлэх вэ? Ямар хэлбэрээр ихэвчлэн бичсэн байна вэ?
2. Сургаал бүрийн гол ба туслах санаануудыг харьцуулан тайлбарлаж ялган бүртгээрэй.
3. Сургаалын зохиолын онцлогийг нэгтгэн дүгнээрэй.

Онцлог	Чингисийн билиг	Оюунтүлхүүр
Шүлгийн бадаг		
Уран дүрслэл		
Сургамжит санаа		

4. Эдгээр сургаалын зохиолууд та нарын өмнөх ангиудад үзсэн сургаалын шүлгээс ямар ялгаатай болохыг харьцуулж бичээрэй.
5. Сургаалын зохиолын үндсэн ач холбогдол гэвэл юуг юуг нэрлэх вэ?  
.....
6. Доорх зүйр цэцэн үг, хэлцэд тохирох хэсгийг уншсан сургаалын шүлгээс олж бичээрэй.
  - А. Инээсэн бүхэн нөхөр биш  
Уурласан бүхэн дайсан биш
  - Б. Сайнтай нөхөрлөвөл сарны гэрэл  
Муутай нөхөрлөвөл могойн хорлол
  - В. Уур биеийг зовооно  
Уул морийг зовооно
  - Г. Хуурсаар хуурсаар худалч  
Хумсалсаар хумсалсаар хулгайч
7. Арслангийн омог баатар мөн арсландаа зохих  
Үнэгний уран арга мөн үнэгэндээ зохих  
Арслангийн баатар омог үнэгэнд тусгүй  
Үнэгний уран арга арсланд тусгүй гэсэн утгыг тайлбарлан баримтаар нотолж бичээрэй.
8. Зөв тохируулан харгалзуулаарай.
 

1. Чингисийн билиг	а. Наадан цэнгэн явахдаа нялх унага мэт яв
2. Оюунтүлхүүр	б. Ер авах гээхийн ялгалыг шинжин мэд
	в. Итгэсэн хойно үгээ бүү нуу
	г. Аху төр минь алдруузай
	д. Үг үл мэдэх мунхаг хүн лүгээ үг бүү тэмц
9. Эртний сургаалд хүний ямар зан чанарыг эрхэмлэхийг сургасан бэ?
 

Чингисийн билиг	Оюун түлхүүр
.....	.....
.....	.....
10. Орчин үед хүний ямар зан чанарыг эрхэмлэх тухай хэрхэн сургаж байна вэ?
 

Бусад хүмүүс чамд	Чи бусдад
.....	.....
.....	.....

## 3.2 УЯНГЫН ШҮЛЭГ



## Уншихын өмнө

1. “Миний нутаг” шүлгийг уншихын өмнө их зохиолч Д.Нацагдоржийн товч намтрыг сэргээн санаж ярилцаарай.
2. Дараах бүлэг үгсийн утгыг урьдчилан таамаглаад, дараа нь зохиолын хам орчноос утгыг тодруулан ярилцаарай.

Нуруу, хөвч, манхан, тойром, бүрд, мөрөн, рашаан, хайрхан, цайдам, сарьдаг, шил, хоолой



## Унших чадвараа хөгжүүлье

Мэдэрч, ойлгож уншъя

## МИНИЙ НУТАГ

Хэнтий, Хангай, Саяаны өндөр сайхан нуруунууд  
Хойд зүгийн чимэг болсон ой хөвч уулнууд  
Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд  
Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд  
Хотол олны эм болсон горхи булаг рашаанууд  
Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нуурууд  
Хүн малын ундаа болсон тойром бүрд уснууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Орхон, Сэлэнгэ, Хөхүйн онц сайхан голууд  
Уурхай баялгийн охь болсон олон уул даваанууд  
Хуучин хөшөө дурсгал хот балгадын сууринууд  
Хол газар одсон харгуй дардан замууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Холхи газраас гялалзсан цаст өндөр хайрхнууд  
Хөх тэнгэр цэлмэсэн хөдөө хээр цайдмууд  
Холын бараа харагдсан ноён шовх сарьдгууд  
Хүний сэтгэл тэнийсэн уудам амьсгалт талууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Хангай говийн хооронд халхын уудам нутаг  
Хар бага наснаас хөндлөн гулд давхисан газар  
Гөрөөс араатан авласан урт урт шилүүд  
Хүлэг морин уралдсан хөндий сайхан хоолойнууд



Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон  
Салхины үзүүрт найгасан соргог нарийн ногоотой  
Саруул талд яралзсан сонин янзын зэрэглээтэй  
Сайн эрс цугларсан байц бэрх газартай  
Сүлд тахилга улирсан сүмбэр их овоотой  
Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон  
Нарийн өвс ургасан малын сайхан бэлчээртэй  
Нааш цааш сүлжих тэнэгэр сайхан нуруутай  
Дөрвөн цагийн улиралд дураараа нүүх нутагтай  
Таван зүйлийн тарианы хөрс шороот газартай  
Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон  
Өлгий сайхан ууланд өвгөдийг тавьсан газар  
Үр ач хүүхдийн үржиж өссөн орон  
Таван хошуу мал тал дүүрэн бэлчсэн нутаг  
Монгол хүн бидний сэтгэлийг сорсон нутаг  
Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон  
Өвлийн тэсгэм цагт цасан мөсөн бүрхээд  
Болор шилийн өнгө гялтганаж гялалзсан орон  
Зуны найртай улиралд цэцэг навч дэлгэрээд  
Жигүүртэн шувуу холоос ирж гангар гунгар донгодсон орон  
Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон  
Алтай, Хянганы завсарт атар баялаг орон  
Аав ээжийн минь оршсон ашдын заяасан нутаг  
Алтан нарны туяанд энхжин тогтносон орон  
Мөнгөн сарны гэрэлд мөнхжин гялалзсан орон  
Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон  
Хүннү, Сүннүгийн үеэс хөгшид өвгөдийн минь нутаг  
Хөх Монголын цагт хүчирхэг боссон орон  
Он онд идээшиж олон жилд дассан нутаг  
Одоогийн шинэ Монголын улаан туг бүрхсэн орон  
Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон  
Өссөн төрсөн бидний үндэсний хайртай нутаг  
Өнгөлзөгч дайсан ирвээс үтэр өшиглөн хөөнө  
Хувьтай энэ орондоо хувьсгалт улсаа мандуулж  
Хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяаг байгуульа  
Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон

1933

(Д.Нацагдорж. Бүрэн зохиол 1. ШУА, ХЗХ. Хэвлэлд бэлтгэсэн Дожоогийн Цэдэв. УБ., 2016, 132-133 дахь тал)

Шүлгийг уншихдаа газар усны нэрсийг тэмдэглээд ажиглаарай.

- А. Шүлэгт ямар ямар газрын нэрс байна вэ? Шүлгээс эшилнэ үү.
- Б. Шүлэгт газар усны нэрсийг өгүүлсэн дарааллыг ажиглаад томоохон уул усыг газрын зураг дээр заан ярилцаарай.
- В. Таны оршин суугаа нутгийн уул усыг шүлэгт нэрлэсэн байна уу? Хэрэв нэрлэсэн бол газрын зураг дээр тэмдэглэнэ үү.

**Үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тодорхойлъя**

1. Шүлгээс уул, тал, хоолой, шил, гол, мөрөн, манхан, цайдам... гэх мэт газрын тогтцын нэрсийг түүж бичээд, зохиолд ямар үүрэгтэй орсныг ажиглаарай. Дараа нь эдгээрийг “Уул”, “Ус” гэсэн хоёр хэсэгт ялган бичээрэй.
2. Нэгээс тавдугаар бадгийн шадууд ямар дагавраар төгсөж байна вэ? Ийнхүү ижил дагавраар төгсгөн холбохыг ямар холбоц гэх вэ? Шүлгээс ойролцоо утгат үгсийг түүж бичээрэй.
3. Энэ шүлэгт ямар дүрслэх ба яруу хэрэглүүр ашигласныг хүснэгтийн дагуу ажиллаарай.

Эшлэл	Дүрслэх хэрэглүүр	Тайлбар
Алтан нарны туяанд энхжин тогтсон орон		
Мөнгөн сарны гэрэлд мөнхжин гялалзсан орон		

**Шүлгийн бүтцийг шинжилье**

1. “Миний нутаг” шүлэг хэдэн бадгаас бүтсэн байна вэ? Бадаг тус бүр хэдэн мөрөөс бүтэж байна вэ?
2. Шүлэгт хэддүгээр биеэс өгүүлж байна вэ? Та юуг үндэслэн ....-р биеэс өгүүлж байгааг баталж байна вэ?
  - А. 1-р биеэс
  - Б. 2-р биеэс
  - В. 3-р биеэс
3. Уянгын яруу найрагт хэддүгээр биеэс өгүүлдэг гэж та мэдэж авсан бэ?
4. Энэ шүлэгт зохиогчийн сэтгэл санааны ямар байдлыг илэрхийлж байна вэ?
  - А. Ёгтлох өгөөдөх
  - Б. Сайшаах зөвтгөх
  - В. Магтах бахдах
5. Зохиогчийн сэтгэл санааны байдлыг илэрхийлсэн шүлгийг ямар шүлэг гэх вэ?
6. Та нарын бодлоор шүлгийн давталт ямар үүрэгтэй вэ?

**Орчин, нөхцөл байдлыг тайлбарлая**

1. Шүлэгт Монголын түүхийн ямар ямар үеийг тусган өгүүлсэн байна вэ?
2. Энэ шүлэгт Монгол Улсын өнгөрсөн, өнөө, ирээдүй гурван цагийг дүрсэлсэн гэвэл, шүлгийн хэддүгээр бадгийн хэддүгээр мөрүүдэд байна вэ?
3. Монгол Улсын түүхийн ямар ямар үеийг тусган өгүүлсэн байна вэ?
4. Дээрх хэсгээр хойч үеийнхэнд чухам юуг эрхэмлэн захиж байна вэ?

5. Монгол орны цаг улирлын онцлогийг шүлгийн агуулгад хэрхэн тусгасан байна вэ? Бадаг, шадаас эшлэн ярилцаарай.
6. Нүүдэлчин ахуйтай холбоотой дүрслэл хэддүгээр бадгийн хэддүгээр мөрүүдэд байна вэ?
7. “Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийг уншихад уудам монгол орноо эгшин зуур тойрон үзсэн мэт болдог” гэсэн эрдэмтэн Ц.Дамдинсүрэн гуайн дүгнэлтийг зохиолоор батална уу.



Ярих чадвараа хөгжүүлье

### Шүлгийг дуу хоолойн өнгө, аялга, хэмнэл, биеийн хөдөлгөөн тохируулан уран уншъя

Шүлгийг аялгуулан уран уншаарай.

Шүлэг унших чадвараа дараах шалгуураар шалгаарай.

Шалгуур	Үнэлгээ (1-5 оноо)	Үнэлгээний тайлбар
Шүлгийг бүрэн цээжилсэн		
Дууны чанга, сулыг зөв тохируулсан		
Зогсолтыг зөв тохируулсан		
Биеийн хөдөлгөөнийг зөв тохируулсан		
Бусдын сэтгэлд хүрэхээр уншсан		



Бичих чадвараа хөгжүүлье

### Юмсын гадаад шинжийг дүрслэн магтаж бичье

Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн хэлбэрийг ашиглан, та өөрийн төрсөн нутгаа магтан шүлэглэнэ үү. Үүний тулд:

- Та өөрийн төрсөн нутгийнхаа газар усны нэрсийг жагсаан бичээрэй.
- “Миний нутаг” шүлэгт газар усны нэрийг хэрхэн дараалуулсныг ажигласнаа ашиглаарай. Жишээ нь: мөрөн, горхи, булаг, рашаан гэж хэмжээний хувьд томоос бага руу дараалуулсан байгаа гэх мэт.
- Газар усныхаа гадаад шинжийг товойлгон магтах





## Уншихын өмнө

*Шүлгийг уншихын өмнө дараах үгсийн утгыг толь бичгээс тодруулаад, дараа нь зохиолын хам орчноос утгыг таамаглан*

Нум, хөвч, зэв, өрлөг, ооно, загал, хасаг, нурам



(1933-2009)

## Дэндэвийн Пүрэвдорж

1933 онд Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт төржээ. 1960-аад оноос “Хаврын дуу”, “Талын туяа”, “Жигүүрт цагаан гэр”, “Сэгс цагаан богд”, “Хөх даалимбан тэрлэг”, “Шоовдор шүлгүүд” зэрэг ном хэвлүүлжээ. 1969 онд МЗЭ-ийн шагнал, 1981 онд БНМАУ-ын Төрийн шагнал, 1996 онд Ардын уран зохиолч, 2009 онд Хөдөлмөрийн баатар цол хүртжээ.



## Унших чадвараа хөгжүүлье

## ЧИНГИС

Тэмүжин нумын хөвчнөөс төрөөгүй юм  
Тэмүжин сумын зэвнээс гараагүй юм  
Тэмүжин Өэлүн эхээс төрсөн юм  
Тэмүжин өрлөг түүхээс гарсан юм.

Амар заяа хомс доголон нулимст хорвоод  
Аврах тавилан мөхөс долоон үеийн тэртээд  
Атаа хорслын манцуйд Есүхэйн хөвгүүн өсөж  
Аян дайны онгодоор есөн тугаа тахисан юм

Оонын халиун зоо шиг халхын саруул талд  
Онгин цагаан тамга шиг гэрээ тэр барьсан юм  
Онон мөрний савд хур шиг шаагих адуунаас  
Онгон хоёр загалыг мөнгөн хяруунд сойсон юм

Эх орноо өмчилсэн гурван хасгийн хүрээлэнг  
Элгэн ургаа өмөөрсөн дөрвөн тотгоор түшүүлж  
Тулгар төрийнхөө баганыг хорол тоононд өргөн  
Туурга тусгаар Монголын голомтыг тэр тулсан юм

Омог билгүүн төгс тэнгэр эзний жигүүрт  
Од мэт сарнисан овгийн өдөс гуурсалж  
Хөнөөх аюул нөмөрсөн ахуй цагийн үймээнд  
Хөө хуяг нөмөрсөн Их Монгол дэвсэн юм

Хатуу цагийн эрх хүнд мөрийг дархалж  
Хасаг их тэрэгний хүрд дугуйг түлхэж



Түмэн-эхийн харайсан эх нутгийн бэлчирт  
Түмний газар зурагын цагаан тоос татсан юм

Хөх Монголын дэвээн тэнгисийн шуургыг ярж  
Хөмхий зуусан ертөнц Чингисийн өмнө сөхөрсөн юм  
Хүлэг морьдын туурай өрнө дорныг цөмлөж  
Хөл нүцгэн хорвоо халуун нурам гишгэсэн юм

Тийм ээ! Дайны мөрөөр цагаан сүү урсаагүй  
Тиймээ! Дайчин сүрийг цагийн саалт мартаагүй  
Тийм ээ! Чингис өндөр Алтайн зартай юм  
Тийм ээ! Чингис өнөөдөр ч гэсэн нэртэй юм

Хойч үедээ тэр хар буруу санаагүй  
Хорин гангийн гачаалд хатан Онон ширгээгүй  
Чингисийн их Монгол ядарсан, гутарсан, задарсан  
Чиний хөх Монгол ялсан, хөгжсөн, мандсан

Ямар ч байсан Чингис хан гарди шиг хальж  
Ял, гавьяа хоёроо хойч үедээ даатгасан юм  
Гал усанд элэгдсэн буурал замбативийн магнайд  
Ган сэлмийнхээ ирээр Монгол гэж бичсэн юм

Чингис нумын хөвчнөөс төрөөгүй юм  
Чингис сумын зэвнээс гараагүй юм  
Чингис Өэлүн эхээс төрсөн юм  
Чингис өрлөг Монголоос гарсан юм.

1962

(Монголын уран зохиолын дээжис. 2-р боть. УБ., 1994 он. 193-194 дэх тал.)

### Шүлгийн үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тайлбарла

1. Тэмүжиний дүрийг тодорхойлсон эхний бадагт сонгож авсан эсрэг утгат үгсийг тэмдэглээд, шүлэгт гүйцэтгэж буй үүргийг тодруулаарай.
2. Шүлэгт буй орон зай, цаг хугацааны утга бүхий үгс, холбоо үгсийг түүж, утгыг тайлбарлаарай. Эдгээр үг нь зохиолын ямар утга санааг хэрхэн тодотгож байна вэ?
3. Шүлэгт буй “ертөнц, хорвоо, замбатив” гэх мэт ойролцоо утгат үгсийг түүж бичээд эдгээр үгийн өмнөх тодотголын гол санааг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
Амар заяа хомс доголтон нулимст хорвоо	
Хөмхий зуусан ертөнц	
Хөл нүцгэн хорвоо	

4. Шүлэгт дүр дүрслэлийг бүтээхдээ ямар дүрслэх хэрэглүүрийг голлон хэрэглэсэн байна вэ? Шүлгээс эшлэн, ямар дүрслэх хэрэглүүр хэрэглэснийг тайлбарлаарай.
5. Шүлэгт ямар ямар оноосон нэр гарсан бэ? Түүж бичээд эдгээр нь Тэмүжинтэй ямар холбоотой болохыг тайлбарлана уу.

Дүрүүд	
Тэмүжин	
Өэлүн	
Есүхэй	

6. Шүлгээс орон, цагийг тодруулсан дүрслэлийг түүж бичээд, түүхэн хам сэдвийн хүрээнд утгыг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
Амрах тавилан мөхөс долоон үеийн тэртээд	
Оонын халиун зоо шиг халхын саруул талд	
Онон мөрний савд	

7. Шүлэгт Чингис хааныг юу юу хийсэн гэж бичсэн байна вэ? Шүлгээс түүний хийсэн үйл хэргийг түүж бичээд, түүхийг тодруулж буй гол өгүүлбэрийн доогуур зурж тэмдэглээд, гол санааг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
Аян дайны онгодоор <u>есөн тугаа тахисан</u> юм.	
Онгин цагаан тамга шиг <u>гэрээ тэр барьсан</u> юм	
Туурга тусгаар <u>Монголын голомтыг тэр тулсан</u> юм	

**Шүлгийн сэдэв, утга санааг тайлбарлая**

1. Зохиолч энэ шүлгээ яагаад Тэмүжин гэлгүй “Чингис” гэж нэрлэсэн бэ? Энэ хоёр нэр ямар ялгаатай вэ? Шүлэгт энэ хоёр нэр хаана хэдэн удаа давтагдаж байгааг ажиглаж ярилцаарай.
2. Монгол Улсын мандал буурлын үеийг хэрхэн дүрсэлж байна вэ? Дүрслэлүүдийг зэрэгцүүлэн бичээд харьцуулан тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
Хөө хуяг нөмөрсөн их <u>Монгол дэвсэн</u> юм	
Хөх Монголын дэвээн тэнгисийн шуургыг ярж	
Чингисийн их Монгол ....	
Чиний хөх Монгол...	

3. Хөх Монгол гэсэн хэллэг бидний өмнө үзсэн ямар зохиолд гарч байсныг сэргээн санаж, харьцуулан ярилцана уу.
4. Шүлгийн доторх батлах өгүүлбэрүүдийг ялган тэмдэглээд, ямар яруу хэрэглүүр болохыг тайлбарлаарай.
5. Шүлэгт “ял, гавьяа хоёр” гэж бичжээ. Та нарын бодлоор Чингис хаан ямар ял, ямар гавьяа байгуулсан бэ?
6. Шүлгийн эхлэл, төгсгөлд давтаж буй дөрвөн мөрийн утгыг ярилцаарай. Тэмүжинийг чухам яагаад “өрлөг түүхээс төрсөн” гэж хэлсэн бэ?

**Шүлгээс суралцан бүтээе**

1. Шүлгээс өөрсдийн сэтгэлд нийцсэн мөр бадгуудыг сонгон цээжилж, урнаар уншаарай
2. Шүлгийн хэл найруулгаас суралцан, Чингис хааны тухай дөрвөн мөрт шүлэг зохионо уу



## Уншихын өмнө

1. Шүлгийг уншихын өмнө дараах холбоо үгсийн утгыг урьдчилан таамаглан ярилцаарай.

Жирмийн сүлжээ

Үхрийн гулууз

Гандирсын балгад

Молор эрдэнэ



(1932)

## Тангадын Галсан

1932 онд Баянхонгор аймгийн Заг суманд төржээ. 1950 оноос уран бүтээлээ эхэлж “Төрсөн хүүгийн чинь үг”, “Өнөр хүний зүрх”, “Өгсүүр замын дуу”, “Үнэнч хүүгийн чинь өчил”, “Жирмийн сүлжээ” зэрэг ном хэвлүүлжээ. 2003 онд Соёлын гавьяат зүтгэлтэн, 2005 онд Ардын уран зохиолч цол хүртжээ.



## Унших чадвараа хөгжүүлье

## “ЖИРМИЙН СҮЛЖЭЭ”

хэмээх дөрвөн мөртөөс

## Жирмийн сүлжээ

Эзэн богд Чингисийн төрийн хүлэг дөрөв  
Эртний ерөөлөөр мэндэлсэн тэнгэрлэг хөвүүд дөрөв  
Эх дэлхийг доргиосон хүлгийн туурай дөрөв  
Энэ миний шүлгийн жирмийн сүлжээ дөрөв

## Мэлмий бадаг

Үхрийн гулуузыг аав шуллаа  
Үнхэлцэг дотор нь айвуухан багтаалаа  
Үлгэр дуурайлыг би ааваасаа авлаа  
Үлэмж найргийг дөрвөн мөрөнд багтаалаа

## Үнэний өчил

Чи... би... та үгүй бол Ард түмэн үгүй  
Чингүнжав... Магсаржав үгүй бол Баатар үгүй  
Чингис... Мандухай үгүй бол Хаад үгүй  
Чилдэн тэнгэрийн доор Монгол үгүй бол Түүх үнэнгүй

## Дагшин орон

Ган хэврэгшим мөсөн туйл Монголд бий  
Гавал цагаан мөнх цаст уулс минь тэр ээ  
Галын нөөлөгтэй халуун орон Монголд бий  
Гандирсын балгадтай ханх хүнх говь минь тэр ээ.

## Дуу хуурын өлгий

Цаашлан цаашлан хүүшилдэг цанхилзуур намар нь уртын дуутай  
Цан шамарга цацагладаг цатгалдуу өвөл нь “Жангар”-ын туультай  
Цаваг туурга нимгэлдэг уянгын хавар нь цоортой цууртай  
Цараа тавиун нутгийн минь улирал бүхэн хууртай дуурьтай



## Цагаан сарын шинийн нэгэн

Шижир цацрагт наран дэлхий тойрч нас нэмсний дан баяр  
 Шидрүүн мөнгөн өвлийг өнтэй давсны давхар баяр  
 Шинэдэн цэцэглэх хавартайгаа энх золгосны гурамсан баяр  
 Шинийн нэгэн гэмээ нь эгнэн давхацсан гурван баяр аа

## Монгол найр

Өвгөн нь хуурдаж, эмгэн нь дуулах аж  
 Өнөр ач жич нь бий бийлэн шуранхайлах аж  
 Өргөө гэрийн найр авьяасын тайлан аж.  
 Өө, үзэгч нь дуучин, дуучин нь үзэгч аж.

## Уртын дуу

Уудам саруулхнаараа яг л монголын дорнод тал  
 Утга гүнзгийгээрээ яг л гүн ухааны нэвтэрхий толь  
 Уяхан хүнлэгээрээ яг л эх хүний сүүн сэтгэл  
 Уртын дуу, монгол дуу, удахгүй сансрын аялгуу

## Афган андын асуулт

Танай нутагт эрийн гурван наадам болдог гэл үү?  
 Таван зуун бөх барилдаж нэг нь түрүүлдэг гэл үү?  
 Талд багтахгүй морь уралдаж ганц нь магнайлдаг гэл үү?  
 Та бүхэн тэр өдөр амрагийн болзоогоо ч мартдаг гэл үү?

## Ардын цэнгэл

Монгол бөхийн сүр нь баруун хойт талдаа  
 Молор эрдэнийн сор нь зүүн өмнө талдаа  
 Молцог харваачдын манлай нь төв талдаа  
 Морьтон ардын наадам дэлхийд ганц даа

## Дааганы уралдаан

Займарч хадурч давхиваас түрүү алдаж сүүлдэх  
 Замаа алдалгүй хурдалбаас түмэн дааганаас ч түрүүлэх  
 Зальхайлж булхайлж айрагдавсаас бай шангаас хасагдах  
 Завсаргүй давхисаар сүүлдвээс “Баян ходоод” өргөмжлөх

## Өлгийн шившлэг

Наадмын дэвжээг тавантаа хотолзуулж  
 Начин болох хүү төрлөө, хурай хурай хурай  
 Нарлаг монголынхоо шархыг хөвөрдөх  
 Нанзадбаатар нэгээр нэмэгдлээ, хурай хурай хурай

## Үр ач өсөж торнихын нууц

Идээ ундаа элбэгтэй айлд хүү сөөм өсдөг  
 Инээд баясал цалгиастай гэрт тохой өсдөг  
 Итгэл хайр тэгшрээстэй орчинд дэлэм өсдөг  
 Ирмүүн ажил, эрдэм хослоход алд өсдөг

*Т.Галсан. “Жирмийн сүлжээ”. УБ., 2001 он, номоос түүвэрлэн авав.*



**Шүлгийн онцлогийг таньж мэдье**

1. Шүлгийн холбоцын талаарх онолын ойлголтыг уншиж, ойлгосноо ярилцаарай.  
Шүлгийн шадын эхний авиаг ижилсүүлэхийг толгой холбоц гэнэ. Монгол шүлэгт толгой холбоц чухал үүрэгтэй. Сүүл холбох ёс нь толгой холбох ёстой адил бөгөөд зөвхөн шадын төгсгөлүүдийг холбож хэмжээ тэнцүүлдгээрээ ялгаатай. Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэгт олон тооны “-ууд” дагавраар сүүл холбосон нь шүлгийн айзам хэмнэлд чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг бол Т.Галсангийн “Жирмийн сүлжээ” шүлэгт монгол шүлгийн толгой холбох ёсыг хатуу баримталж зохиожээ.
2. “Жирмийн сүлжээ” хэмээх энэхүү шүлгийнхээ талаар зохиогч “Э”, “Ү” авиагаар толгой холбосон шүлэгтээ хэрхэн өгүүлсэн байна вэ? Үүнээс үзэхэд “Жирмийн сүлжээ” шүлгийн өвөрмөц онцлог нь юунд оршиж байна вэ?

**Шүлгийн үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тодорхойлъя**

1. Эдгээр шүлэгт уламжлалт соёлын үг хэллэгийг түүж бичээд, тэрхүү соёлын ярилцана уу.

Эшлэл	Тайлбар
Үхрийн гулууз	
Бий бийлэх	
Шуранхайлах	
Баян ходоод өргөмжлөх	

2. Эдгээр шүлэгтээ яруу найрагч адилтгалыг хэрэглэсэн байна уу? Шүлгээс эшлэл авч тайлбарлана уу.
3. “Жирмийн сүлжээ”-д монгол урлаг соёлын талаар ямар үсгийн бадагт хэрхэн дүрсэлсэн байна вэ? Ямар ямар урлагийн төрөл зүйлийг хэрхэн дүрсэлснийг ажиглаж, шүлгээс тэдгээр нэр томъёог ялган жагсаан бичээрэй.
4. Монгол орны байгаль, цаг агаар, улирлын онцлогийг ямар үсгийн шүлгүүдэд хэрхэн дүрсэлснийг ажиглаж, эшлэл авч тайлбарлана уу.
5. Монгол түмний баялаг соёлыг яруу найрагч дөрвөн мөрд хэрхэн багтаан шүлэглэсэн байна вэ? Түүхийн хичээлийн мэдлэгтэйгээ холбон тайлбарлана уу.
6. “Афган андын асуулт” шүлэгт ямар яруу хэрэглүүр ашигласныг тайлбарлана уу

**Шүлгийн сэдэв, утга санааг тодорхойлъя**

1. Монголын уламжлалт ёс заншил, хурим найрын зан үйлийн талаар ямар шүлэгтээ хэрхэн дүрсэлснийг шинжилж, зан заншлаас ярина уу.
2. Шүлэгт монгол угсаатны гол баяр цагаан сарын талаар хэрхэн дүрсэлснийг тайлбарлана уу.
3. Монголчуудын уламжлалт эрийн гурван наадмын тухай ямар шүлэгтээ хэрхэн дүрсэлсэн байна вэ?
4. Т.Галсан “Жирмийн сүлжээ” (УБ., 2001 он) номыг уншиж, дөрвөн мөрт шүлгүүдийг толгой холбон зохиохдоо ямар дарааллыг баримталсан байгааг ажиглаарай. Дараа нь өөрсдийн сонгосон үсгээр толгой холбон, “Жирмийн сүлжээ” зохиож бичнэ үү.



Уншихын өмнө



(1944)

**Дөнгөтийн Цоодол**

1944 онд Төв аймгийн Бүрэн суманд төржээ. 1970 оноос уран бүтээлээ эхэлж, “Тогоруун цуваа”, “Он жил”, “Нутгийн зургаан өнгө”, “Саруул талын ногоо”, “Алаглан харагдах уулс” зэрэг ном хэвлүүлжээ. 1996 онд Монгол Улсын Төрийн соёрхол, 2005 онд Соёлын Гавьяат зүтгэлтэн цол, 2009 онд Ардын уран зохиолч цол тус тус хүртжээ.

1. Зохиолын нэрийг уншаад, зохиолд юуны тухай гарахыг таамаглаж ярилцаарай.
2. Уншихын өмнө дараах хэлцийн утгыг тайлбарлаж ярилцаарай.  
Гар чанга, амаа мэдэх, үгийн хачир болгох, гар тэнийх, хар амлах
3. Уншихын өмнө дараах үгийн утгыг толь бичгээс мэдэж аваарай.  
Адлах, үрээ, агт, цурамхийх, цурхирах, суман, салаа



Унших чадвараа хөгжүүлье

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя**

1. Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглээд “Монгол хэлний их тайлбар толь” ашиглан утгыг мэдэж аваарай.

**ХАРАМЧИЙНХНЫ ДУУЛЬ**

Айхавтар гар чангатай ах дүү нар байлаа  
 Адалж, хүмүүс тэднийг Харамчийнхан гэдэг байлаа  
 Сансар Эмгэдийн бэлийг хонь нь бүрхэн  
 Сарваа цуцахын хөндийгөөр адуу нь багтаж ядаж  
 Үе дамжсан баян харамчийнхны хот айл  
 Үүл мэт нэвсийцгээн аж төрдөг байлаа  
 Гэм нь тэднээс бүтэн дээлтэй нь ховор,  
 Гэр нь бүрээс сайтай өвөлжлөө гэвэл худлаа,  
 Арван чимэгтэй эмээл, сайн морь эрчүүд нь эдлэхгүй  
 Амаа мэдэхгүй үрээтэй пөг пөг шогшицгооно  
 Хүүхнүүд нь дээлээ гурван наадмаар солихгүй  
 Хүүхдүүд нь цас ортол гутлын бараа харахгүй  
 Хониндоо барагтай бол хүрэхгүй, зээр гөрөөсхөн эргүүлж  
 Холоос гийчин ирвэл хоормог тарагхан дөхүүлцгээнэ  
 Ганц хайрцаг чүдэнз хажуу айл нь гуйхад  
 “Гал гаргадаггүй өдөр өө” гээд халгаахгүй буцаачихна



Хавийн улс амьтан хөх инээдээ барж  
 Харамч муугийн үлгэр, үгийн хачир болгоно  
 Тэр л янзаар он жилүүд өнгөрсөөр  
 Тэртээ жил гэнэтхэн дайн гарав  
 Халхын гол руу агт туух юм болж  
 Хамгийн овоо гэснийгээ Бүрэнгийнхэн хөтөлж ирцгээв  
 Харамчийнхан л яадаг бол, гар тэнийхгүй дээ гэж  
 Хар амлацгаасан улс гайхаж гүйцэв  
 Суналзсан уургаа барьсаар мань Харамчийнхан  
 Сумын төв дээр адуугаа багширтал хурааж ирлээ  
 Буруу зөвгүй номхон, аль хурдан хурцыгаа  
 Бузар дайсныг намнах баатрын хүлэг бол гэж өгцгөөлөө  
 Агт хөдлөөд хэдхэн хонотол  
 Ах дүүсээс хоёр харамч цэрэгт мордсон юм  
 Хошуу нутагтаа алдартай харамч эцэг нь  
 Хоёр хүүгээ амьтнаас түрүүн цэрэгт өгсөн юм  
 Цурамхийлгүй хүлээх ээж нь хоёр хүүгээ харамласангүй  
 Цурхиртал уйлах гэргий нь ханиа харамласангүй  
 Цуутай Харамчийнхан юугаа ч харамласангүй ээ  
 Бүрээн дуунаар нөхдөө давших цагт  
 Бүгдийн түрүүнд хоёр Харамч явсан гэдэг юм  
 “Сумаа харамлаж байж энэ хоёр сүйд болно доо” гэж  
 Суман, салааныхан нь дооглож үлдсэн гэдэг юм  
 Унахын учиргүй уул шиг хоёр сайхан хархүү  
 Ургахын улаан нарнаар хоёулаа унасан гэдэг юм  
 Хамгийн хүнд мөчид Эх орон танаасаа  
 Харамчийнхан амиа бас харамласангүй ээ.

*Дөнгөтийн Цоодол. “Сөгдөж айлтгая” (Шүлэг, дууль, найраглал). Тэргүүн дэвтэр. “Мөнхийн Үсэг”, УБ., 2015 он. 343-344 дэх тал*

Асуултын дагуу ярилцаж, ойлгож мэдсэнээ бататгаарай

- А. Хүмүүс тэднийг яагаад Харамчийнхан гэж нэрлэх болсон бэ?
- Б. Зохиолч “чанга гартай”, “гар тэнийх” гэсэн хэлцийг яагаад сонгох болсон бэ?
- В. Тэд хонь, адуу нь багтаж ядсан үе дамжсан баян айл мөртөө яагаад тийм бага хэрэглээтэй байсан гэж та нар бодож байна? Тэдний аж төрөл хэрэглээний талаар зохиолд хэрхэн мэдээлсэн бэ?
  - ..... бүтэн дээлтэй нь ховор
  - Гэр нь бүрээс сайтай өвөлжлөө гэвэл худлаа...
  - .....
  - .....
- Г. Харамчийнхан дандаа амаа мэдэхгүй үрээ унадаг байсны учир юу вэ?
- Д. Буруу зөвгүй номхон морьдтой байж уналгүй хэрэгтэй цагт эх орныхоо төлөө өгч байгаагаар зохиолч юу хэлэхийг хүссэн бэ?

- Е. Харамчийнхан номхон болон хурдан хүлэг морьд, хөвгүүдээ яагаад харамлаагүй вэ?
- Ё. Зохиолч эх орныхоо төлөө амиа харамлаагүй эх орончдыг “харамчийнхан” гэж нэрлэсний учир юу вэ? Энэ үгээрээ бидэнд чухам юуг хэлэхийг зорьсон бэ?

**Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг тодорхойлъё**

- 1. Зохиолд ямар ямар хүмүүс гарч байна вэ? Тэд хэрхэн бодож санаж, хэлж ярьж, үйлдэж байсан бэ? Тэдний үг хэл, бодол санаа, үйлдлийг жагсаан бичээрэй.

Дүрүүд	Бодол санаа	Үг хэл	Үйлдэл
Хүмүүс			
Харамчийнхан			
Хавийн улс			
Суман салааныхан			

- 2. Дайн болоход Харамчийнхны хийсэн үйлдлийг хүмүүсийн үг хэл, бодолтой харьцуулан бичнэ үү.

**Харамчийнхны үйлдэл**

1. Халх гол руу агт туухад адуугаа багширтал хурааж ирсэн
2. ....
3. ....

**Хүмүүсийн үг хэл, бодол**

1. ....гар тэнийхгүй дээ гэж ярьж байсан
2. ....
3. ....

- 3. Дээрх үйлдлүүд дүрийг тодруулахад ямар үүрэгтэй байгааг эх доторх үг хэллэгээр баталж, багаар ярилцаад дүгнэж бичээрэй.
- 4. Зохиолыг уншаад төрсөн сэтгэгдлээ багаараа дүгнэж ярилцахдаа учир шалтгааны уялдаа холбоог гаргаарай.

**Зохиолын сэдэв, санааг тодорхойлъё**

- 1. Асуултад хариулж ярилцан, зохиолын сэдэв санааг тодорхойлоорой.
  - А. Харамчийнхан юу юуг харамлаагүй вэ?

.....  
 Цурамхийлгүй хүлээх ээж нь хоёр хүүгээ харамласангүй  
 Цурхиртал уйлах гэргий нь ханиа харамласангүй  
 .....

- 2. Харамчийнхан дээрх зүйлсийг харамлаагүйн учир юу вэ?
- 3. Зохиолч гол дүрээ "Харамчийнхан" гэж сонгож авснаараа юуг илэрхийлэхийг хүссэн бэ?
- 4. Эхийн гарчиг нь зохиолын сэдэв, санаанд хэрхэн холбогдож байна вэ?



Уншихын өмнө



(1939-2018)

**Долгорын Нямаа**

1939 онд Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт малчны гэрт төржээ. 1960 оноос уран бүтээлээ эхэлж, “Галуун цуваа” “Тэнгэрийн хаяа”, “Их газрын чулуу”, “Тэмээний нутаг”, “Шинэ тэнгэр”, “Шөнийн талд адуу янцгаана” зэрэг яруу найргийн түүвэр хэвлүүлжээ. 1993 онд Монгол Улсын Төрийн шагнал, 2009 онд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртжээ.



Унших чадвараа хөгжүүлье


1. “Шөнийн талд адуу янцгаана” шүлэгт байгалийг үгээр урлан зурахдаа өмнөх яруу найрагчдаас ихээхэн ялгаатай арга замаар үзүүлсэн онцлогийг анхаарч уншаарай.

**ШӨНИЙН ТАЛД АДУУ ЯНЦГААНА**

Эртний домог шиг буурал тал  
Эргэн тойрон чимээ алдарна.  
Алс замын алжаал тайлж  
Аяны хүн талдаа хононо.

Гүн харанхуйд тэнгэрийн заадас  
Гүүн зэл шиг сунайн цайрна.  
Амгалан талын аяс хөндөж  
Алдуурсан унага шиг од харвана.

Эртний домог шиг буурал тал  
Эргэн тойрон чимээ алдарна.  
Оддын дундаас ижлээ үзсэн шиг  
Шөнийн талд адуу янцгаана.



1967

(Монголын сонгомол яруу найраг (Эртнээс эдүгээ хүртэл).

Сонгож эмхэтгэсэн Г.Аюурзана, Л.Өлзийтөгс нар. УБ. 2008. 143 тал)

2. Шүлэгт юуг харуулж байна вэ? Байгалийн болоод ахуйн ямар дүр зургийг хэрхэн үзүүлж байна вэ? Бүртгэн бичнэ үү.

Байгаль	Ахуй	Хүмүүн
Тал	Адуу	Аянчин
Од		

3. Тус шүлэгт юуны талаар өгүүлсэн болохыг нэг өгүүлбэрээр тодорхойлон бичнэ үү.



4. Шүлэг хэдэн бадагтай байгааг дараах ойлголтыг уншаад батлаарай.

Бадаг гэдэг бол холбоц хийгээд аялгын нэгэн хэмнэлд захирагдаж, тодорхой утга төгссөн айзам бүхий өгүүлбэр зүйн нэгж юм.

**Орчин, нөхцөл байдлыг тайлбарлая**

1. Шүлэгт үзүүлсэн цаг улирлын байдлыг та хэрхэн төсөөлж байна вэ?
2. Шүлгээс орон, цагийг тодруулна уу. Холбогдох дүрслэлийг эш татан тайлбарлана уу.

	Эшлэл	Тайлбар
Цаг	Шөнө	
Орон	Тал	

3. Шөнийн харанхуй болоод аниргүйн дундах гэрэл хийгээд анирыг яруу найрагч ямар үгсээр илэрхийлсэн байна вэ? Энэ үг бидэнд ямар мэдрэмж төрүүлж байна вэ?

**Үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тодорхойлъё**


1. Яруу найрагч эхний бадагтаа шөнийн талыг дүрслэхдээ хүний ямар ямар мэдрэхүүд хандан хэрхэн дүрсэлсэн байна вэ? Түлхүүр үгсийн доогуур зураад ажиглаж ярилцаарай.
2. Шүлгийн 2 дугаар бадгийн харааны мэдрэхүүд хандсан дүрслэлийг дахин уншиж үзнэ үү. Бидний оюун санаанд ямар дүр зургийг буулгаж байна вэ?
3. Уран дүрслэлийн жишээг шүлгээс эшилж бичээд чухам ямар арга хэрэглүүр болохыг тодорхойлно уу.

Эшлэл	Дүрслэл	Тайлбар
Гүүн зэл шиг...	Зүйрлэл	

4. Шүлгийн гуравдугаар бадгийн дүрслэл нь хүний ямар мэдрэхүүд хандаж байна вэ? Яруу найрагч аниргүйн дундах анирыг бүтээсэн нь ямар мэдрэмж төрүүлж байна вэ?
5. Уран дүрслэлийн жишээг шүлгээс эшилж бичээд чухам ямар арга хэрэглүүр болохыг тодорхойлно уу.

Эшлэл	Дүрслэл	Тайлбар
Эртний домог шиг...		

6. Шүлгийн агуулгаар оюуны зураглал хийнэ үү. “Шөнийн талд адуу янцгаана” шүлгийн бадаг бүрээс та юу юуг олж ажигласан талаараа тус бүр нэг нэг өгүүлбэр бичээрэй. Дээрх дасгалын үед бичсэн өгүүлбэрүүдээ нэгтгэн, шүлгийн агуулга ба бүтцийн онцлогийг тоймлон бичнэ үү.





## Уншихын өмнө



(1957)

## Доржпаламын Сумьяа

Завхан аймгийн Ургамал суманд төржээ. 1980-аад оноос уран бүтээлээ эхэлж, “Марал” (1991), “Уул усны зүүд” (1995), “Сэтгэлийн орон” (2005), “Нутаг амьтай аав” (2006), “Агинастын шувуу” (2012) шүлгийн түүврүүд хэвлүүлжээ. 2015 онд Нацагдоржийн нэрэмжит шагнал хүртжээ.

1. Шүлгийн нэрийг уншаад, шүлэгт юуны тухай гарна гэж таамаглаж байгаагаа ярилцаарай.
2. 6 дугаар ангид “Ертөнцийн үүслийн домог”-ийг судлах үедээ шагайгаар “Алаг мэлхий” өрж наадаж байснаа сэргээн санаарай.
  - Алаг мэлхийг хэдэн шагайгаар хэрхэн яаж өрдөг вэ?
  - Алаг мэлхий тоглоом нь ямар утга бэлгэдэлтэй вэ? гэх мэтээр ярилцаарай.
3. “Монгол шагай” шүлгийг уншихын өмнө дараах үг хэллэгийн тайлбарыг уншиж ярилцаарай.

Хишиг- өглөгийн хүндэтгэл нэр. Амны хишиг гэвэл ногдсон хувь. Идэж уух, өмсөх зүүхээр элбэг хангалуун явах хувь гэсэн утгыг илэрхийлнэ.

Төөрөг- хувь зохиол, заяа. Төөргийн шагай гэвэл хүний амь бие, хувь тавилан, хийморь сүлд, ажил амьдрал ямар байхыг мэргэлэх гэсэн утгыг илэрхийлнэ.

Өрөг- харваж наадахаар өрсөн сур, шагай.

Хурайлах- хүссэн зүйлээ ирээсэй гэж, “Хурай, хурай” хэмээн уриалан дуудах

Хөөөөг- хөө хуяг гэсэн үгээс сунжирсан нэр. Эртний баатрын хөө хуягийн тасархайг шагай атган шүүрэх наадмын үед сум болгон, дээш шидэж наадна.



## Унших чадвараа хөгжүүлье

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя**

## МОНГОЛ ШАГАЙ

Хоймортоо тоглох хүүгийнх нь наадгай шагай  
Хотондоо налайх сүргийнх нь хишиг шагайндаа  
Хожим уулзах залуусын болзоо шагайндаа  
Хотол монголын сайны бэлгэдэл шагайндаа

Эрчүүлийнх нь андгай тангараг шагайндаа  
Эцэг эхийнх нь эртний буян шагайндаа

Эргэж уулзахын итгэл ерөөл нь шагайндаа  
Эв нөхөрлөлийн эрхэм бэлгэдэл шагайндаа

Тэгш дөрвөлжин шагайндаа  
Тэнгэрлэг хувь буянаа хурааж  
Таван хошуу малынхаа хишгийг  
Талын монголчууд атгаж явдаг юм

Амгалан энхийн цагтаа  
Асгасан шагай шигээ нүүж ээ суудаг  
Аян дайны ширүүн цагтаа  
Атгасан шагай шигээ хурж ээ нэгддэг

Алаг мэлхийгээ өрж, атгаж наадаж  
Амны хишгээ даллан хурайлдаг  
Хөөөөг шидэж, шагай хормойлж  
Хишиг буянаа хурайлан далладаг

Төр улсын төвшин заяа нь төөргийн шагайндаа  
Түмэн ардын амар амгалан нь тэгш шагайндаа  
Мянган оны ирэх зөн билиг нь мэргийн шагайндаа  
Түмэн жилийн туулсан түүх нь өргийн шагайндаа

Тахилгат уулсынх нь хишиг буян шагайндаа  
Тал дүүрэн бэлчих малынх нь хишиг шагайндаа  
Мөнх тэнгэрийн оноо хувь нь шагайндаа  
Мөхөлгүй орших Монгол заяа шагайндаа

Тэгш дөрвөлжин шагайндаа  
Тэнгэрлэг хувь буянаа хурааж  
Таван хошуу малынхаа хишгийг  
Талын монголчууд атгаж явдаг юм

Амгалан энхийн цагтаа  
Асгасан шагай шигээ нүүж ээ суудаг  
Аян дайны ширүүн цагтаа  
Атгасан шагай шигээ хурж ээ нэгддэг

Алаг мэлхийгээ өрж, атгаж наадаж  
Амны хишгээ даллан хурайлдаг  
Хөөөөг шидэж, шагай хормойлж  
Хишиг буянаа хурайлан далладаг.

*Доржпаламын Сумьяа “Агинастын шувуу” УБ., 2012, 48-49 дэх тал*

1. Шүлэгт юуны талаар өгүүлсэн болохыг нэг өгүүлбэрээр тодорхойлон бичнэ үү. Үүний тулд хамгийн олон удаа давтагдан орсон үгсийг тэмдэглээд ажиглаарай.
2. Шүлэгт “хишиг” гэдэг үг хэдэн удаа орсон байна вэ? Хишиг гэдэг үгтэй ойролцоо утгатай ямар үгс байна вэ?



3. Хишиг гэдэг үг нь ямар үгстэй хэрхэн холбогдож байгааг шүлгээс түүж бичээд утгыг тайлбарлаарай.

Эшлэл	Тайлбар
Сүргийн хишиг	
Амны хишиг	

4. Яруу найрагч эхний бадагтаа шагайг дүрслэхдээ монгол ахуй соёлыг хэрхэн тусгасан байна вэ? Түлхүүр үгсийг ялган бичээд утгыг өөрийн үгээр тайлбарлана уу.

Эшлэл	Түлхүүр үг	тайлбар
Хоймортоо тоглох хүүгийнх нь наадгай шагай	Наадгай	
Хотондоо налайх сүргийнх нь хишиг шагайндаа	Сүргийн хишиг	
	Залуусын болзоо	
	Сайны бэлгэдэл	

**Үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тодорхойлъё**

1. Шүлгийн хоёрдугаар бадагт “шагайндаа” гэдэг үгтэй холбогдож байгаа холбоо үгсийг түүж бичээд, шагайгаар бэлгэдэх монгол заншлыг шад бүрээр эш татан тайлбарлана уу.

Эшлэл	Түлхүүр үг	тайлбар
Эрчүүлийнх нь андгай тангараг шагайндаа	Андгай тангараг	
	Эртийн буян	
	Итгэл ерөөл	
	Эрхэм бэлгэдэл	

2. Шүлгийн дахилтад монголчуудын хишиг буянаа хурайлан даллах шагай наадмын ямар хэлбэрүүдийг таниулж байна вэ? Эш татан тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
Алаг мэлхий өрж	

3. Шүлгийн гуравдугаар бадагт эхний бадгуудын санаа хэрхэн гүнзгийрч байна вэ? Түүхийн өнгөрсөн болоод ирээдүй цагийг яруу найрагч хэрхэн илэрхийлсэн нь та нарт ямар мэдрэмж төрүүлж байна вэ?

Эшлэл	Түлхүүр үг	Тайлбар
Төр улсын төвшин заяа нь төөргийн шагайндаа	Төвшин заяа	
Түмэн ардын амар жаргалан нь тэгш шагайндаа	Амар жаргалан	
	Зөн билиг	
	Түүх	

4. Шүлгийн дөрөвдүгээр бадагт санааг хэрхэн төгсгөсөн байна вэ? Яруу найрагч бидэнд юуг мэдүүлж, юуг хэлэхийг зорьж байна вэ?

Эшлэл	Түлхүүр үг	Тайлбар
Мөнх тэнгэрийн оноо хувь шагайндаа	Оноо хувь	
Мөхөлгүй орших монгол заяа шагайндаа	....	

5. Шүлгийн гуравдугаар бадагт шагайг хэрхэн тодотгосон байна вэ? Энэ нь ямар монгол заншлыг илэрхийлж байна вэ? Эшлэл авч тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
Төөргийн шагай	
Мэргийн шагай	
Өргийн шагай	

6. Шүлгийн дахилтыг дахин уншиж үзнэ үү. Шүлгийн дахилт нь шүлгийн санааг хэрхэн баталж байна вэ?
7. Шүлгийн дүрслэл нь уншигчийн оюун санаанд ямар дүр зургийг буулгаж байна вэ? Шүлгээс “шиг”, “мэт”, “адил” гэсэн үгсээр тодотгон холбосон дүрслэлийн жишээг түүж бичээд, уран дүрслэлийн ямар арга болохыг тайлбарлаарай.

Эшлэл	Тайлбар
Асгасан шагай шиг	



Ярих чадвараа хөгжүүлэе

"Монгол шагайн бэлгэдэл" сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлээрэй. Дараах зүйлд анхаараарай.

- Таамаглал дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөөрэй.
- Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглээрэй.
- Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргаарай.

**ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ**

Шалгуур	Үнэлгээ	Гүйцэтгэл
<b>УНШИХ</b>		
Шүлгийг уншаад, мэдэрч ойлгон, сэдэв, утга санаа, шүлэглэлийн зүй тогтлыг зөв тайлбарласан байдал	1-5 оноо	
<b>ЯРИХ</b>		
Шүлгийг цээжилж, уран яруу унших чадвар	1-5 оноо	
Шүлгийг уншаад төрсөн сэтгэгдэл, мэдрэмж, хувийн хандлагатай харьцуулж өөрийн үгээр зөв цэгцтэй тодорхой ярих чадвар	1-5 оноо	
<b>БИЧИХ</b>		
Шүлгийн уран дүрслэл, үг хэллэгээс суралцан, шүлгийн шад, бадаг зохион бичих чадвар	1-5 оноо	



## 3.3. НАЙРАГЛАЛ



Уншихын өмнө



(1908-1986)

## Цэндийн Дамдинсүрэн

Дорнод аймгийн Матад суманд төржээ. 1928 оноос уран бүтээлээ эхэлж, “Гологдсон хүүхэн”, “Буурал ижий минь”, “Хачин хурим” зэрэг түүвэр зохиол ном хэвлүүлжээ.

XIII зууны үед зохиогдсон “Монголын нууц товчоо” бүтээлийг орчин цагийн монгол хэлээр хөрвүүлэн хэвлүүлснээр орчин үеийн уншигчид уг алдарт бүтээлтэй танилцах таатай боломж нээгдсэн байна.

1945, 1947, 1950 онуудад БНМАУ-ын Төрийн шагнал, 1986 онд Ардын уран зохиолч цол хүртжээ.

*Хүүхдүүд ээ. Өнөөдөр тэнгэрт үүлтэй байна уу? Хэрэв үүлтэй байвал үүлсийг ажигла. Үүлэн дундаас ямар дүрс тодорч байна вэ? Энэ үүлсийг юутай зүйрлэх вэ?*



Унших чадвараа хөгжүүлэе

## Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя

1. Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглээд “Монгол хэлний их тайлбар толь” ашиглан утгыг мэдэж аваарай.
2. Уншихдаа найраглалын айзам хэмнэл, хөг аялгууг хэрхэн тэгшилснийг анхаарч уншаарай.

## ЗУГААЦАХААР МОРДСОН НЬ

## ҮҮЛ

Хөх мөнх тэнгэрийн  
ариун хүрээлэнгийн дунд  
Хөвөн цагаан үүл  
мөнгөн цагаан үүл  
Хөх огторгуйн мандалд  
чимэг болон хөвсийж  
Хөх агаарын төвд  
цэцэг болон мандаж байна  
Цав цагаан үүл  
хаш цагаан үүл  
Цааш нааш давхцаж  
сүлжин ороон тогтоод  
Цаадах хөх огторгуйд  
цасан угалз болж

Цагаан луу хээтэй  
хөх торгоны адил  
Эрвэгэр цагаан үүл  
эрдэнийн цагаан үүл  
Энэ үүл эвхрэн  
тэр үүлтэй давхцаад  
Элдэв зүйл юмны  
дүрс болон сүглийгээд  
Эргэцүүлж сайн харвал  
амьд амьтны адил  
Амраг хөөрхөн бүсгүй минь  
ажиглаж сайн хар  
Арслан барс хоёр  
ноцолдож байгаа ч юм шиг  
Ачаатай цагаан тэмээ  
хэвтэж байгаа ч юм шиг

Араг үүрсэн эхнэр  
 бүжиглэж байгаа ч юм шиг  
 Хувилгаан цагаан үүл  
 хурмастын цагаан үүл  
 Хуурмаг өнгө гаргаж  
 гэгээн наранд гялбалзана  
 Хуурай янз гаргаж  
 уул мэтээр сүмбэрлэвч  
 Хоромхон зуур хувилж  
 хурын ус болно  
 Хонгор хайртай хүү минь  
 цув юугаа авсан уу?  
 Хоймор байгаа үүлний  
 хормой бие нь бараалж  
 Холын өндөр ууланд  
 бороо орж эхэллээ.  
 Хоёр нэг цаг болоод  
 үүгээр орох ч болзошгүй.

**УУЛ**

Цагаан үүлний дунд  
 цаст уул сүмбэрлэж  
 Цангам зуны халуун  
 цасан хүрэм өмссөн  
 Цавчим цахир хаднаас  
 хүйтэн булаг урссан  
 Цардмал мөнгөн өнгөт  
 гантиг чулуун уул байна.  
 Зуны дулаан цагт  
 өвлийн шинжийг хадгалсан  
 Зуурам балчиг халуунд  
 сэрүүн салхийг сэнгэнүүлсэн  
 Зугаалах баярлах ардын  
 санаа зоригийг сэргээсэн  
 Зуун бээрийн газраас  
 гялалзан харагдах уул байна

Мөнгөн дээд орой нь  
 мөс цасанд хучигдмал  
 Мөнх хөх тэнгэрийн  
 мөнгөн цагаан багана  
 Мөчит дөрвөн хөлтний  
 мөр нь гараагүй оргил  
 Мөгөөрс нимгэн хоолойтны  
 дуу нь хүрээгүй оргил  
 Мөрөн гол горхинууд  
 ам бүрээс нь асгарсан  
 Мөндөрт хур бороо  
 өдөр бүр цутгасан  
 Мөлт мөчиг харвал  
 үүл гэмээр уул байна  
 Мөшгиж сайн харвал  
 үүлнээс өндөр уул байна  
 Элгэн их хаданд нь  
 бүргэд шувуу хальсан  
 Эрэг жалга бүгдэд нь  
 араатан гөрөөс шивээлсэн  
 Эелдэг уужим тохойд нь  
 айл малаар дүүрсэн  
 Элдэв жимсний модоор  
 эгэл бие нь хучигдсан  
 Энгүй их бараатай  
 сүртэй сайхан уул байна  
 Эргэн тойроод явахад  
 сэтгэлийг баясгах хангай байна  
 Эртний өвгөдийн үед  
 мөргөж биширсэн хайрхан байна  
 Энэ бидний үед  
 шинжилж үзэх нуруу байна...

1936

(Монголын уран зохиолын дээж 8  
 боть. 2 дугаар боть. УБ., 1994. 44-51 дэх  
 талаас хэсэглэн авав.)

**Үг хэллэгийн сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тодорхойлъя**

1. “Хувилгаан”, “хурмаст”, “хайрхан” хэмээх үгсийн утгыг толь бичиг ашиглан тайлбарлаарай.
2. Үүлний энэ хувирамхай шинжийг зохиолд хэрхэн дүрсэлсэн байна вэ? мөр бадгийг нэрлээрэй.
3. Зохиолд ямар дүрслэх хэрэглүүрийг хэрэглэсэн байна вэ?

Эшлэл	Тайлбар
Цагаан луу хээтэй хөх торгоны адил	
“Мөлт мөчиг харвал үүл гэмээр уул байна”	

**Зохиолын сэдэв, утга санааг тодорхойлъя**

1. Зохиолын 4-5 дугаар бадгийг уран зургаар дүрсэлбэл ямар зураглал гарах вэ? Энэ зураглалыг уран зохиолын онолд юу гэж нэрлэх вэ?  
 А. Байгалийн зураглал                      Б. Хөрөг дүр  
 В. Тодорхойлол                                Г. Аян замын тэмдэглэл
2. Зохиолын дотроос өөрт хамгийн уран яруу сэтгэгдэл төрүүлсэн мөр бадгийг сонгон цээжилнэ үү.
3. Уул хэмээх шүлэглэлд буй байгалийн зураглалыг тодруулна уу  
 Энэ зохиолд гарч байгаа уулыг уран зургаар дүрсэлбэл ямар өнгө будаг хэрэгтэй вэ?




Бичих чадвараа хөгжүүлье

1. "Мөчит дөрвөн хөлтний мөр нь гараагүй оргил  
 Мөгөөрс нимгэн хоолойтны дуу нь хүрээгүй оргил" хэмээх дүрслэлээс сэдэвлэн байгаль орчныг онгон төрхөөр нь хэрхэн хайрлан хамгаалах сэдвээр ярилцаж дөрвөн мөрт шүлэг бичээрэй.
2. Зуны дэлгэр цагт зугаацахаар мордсон дурсамжаа сэргээн санаж, аян замын тэмдэглэл бичээрэй. Байгалийн байдлыг дүрслэн бичихдээ чимэг үг, адилтгал ашиглан зохиогоорой.



Ярих чадвараа хөгжүүлье

1. Найраглалын тухай ойлголтыг уншаад хосоороо ярилцаарай.



2. Энэ найраглал нь аль ангилалд багтах вэ? Яагаад гэдгийг дүгнээрэй.
3. Найраглалын онцлогийг хүснэгтэд гүйцээн бичээд батлаарай.

Найраглалын онцлог	Зугаацахаар мордсон нь
Шүлэглэсэн	
Шүлгээс хэмжээний хувьд урт	



## Уншихын өмнө



(1915-1991)

**Дондогийн Цэвэгмид**

1915 онд Дорнод аймгийн Баяндун суманд төржээ. 1930 оноос уран бүтээлээ эхэлж “Хоньчин Найдан”, “Сурагч Ганбат”, “Булшин дээр”, “Алтайн цаадах говьд” зэрэг ном хэвлүүлжээ. 1942 онд БНМАУ-ын Гавьяат багш цол хүртжээ.

*Дараах оньсогыг таагаад юуны тухай зохиол унших гэж байгаагаа таамаглан ярилцаарай.*

“Ээрэм талын мангас

Эр эмгүй сахалтай” (Тэр юу вэ?)



## Унших чадвараа хөгжүүлье

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя**

1. Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглээд “Монгол хэлний их тайлбар толь” ашиглан утгыг мэдэж аваарай.
2. Уншихдаа найраглалын айзам хэмнэл, хөг аялгууг хэрхэн тэгшилснийг анхаарч уншаарай.


**АЛАГДАЙ АВАРГА**

Он жилийн цэлмэгт  
 Онгон тэнгэрийн сайханд  
 Оргил цагаан титэм нь  
 Од болон гялалзсан  
 Өдөр шөнийн бүрхэгт  
 Өглөө үдшийн буданд  
 Уул үүл уулзан золгож  
 Учир нэгнийг шивнэлдсэн,  
 Алтай хааны архан бие  
 Асгат Хайрханаар нутагладаг  
 Эгэл малчны ямаан сүрэгт  
 Ихэр гурван ишиг төржээ.  
 Эхэлж гарсан эгчмэдийг  
 Эрээн цоохор толбоор нь  
 Дагаж гарсан дараа дахийг  
 Даруу орог зүсээр нь  
 Хожуу гарсан отгоныг

Хондлой алаг тэмдгээр нь  
 Эрээдэй, Орогдой, Алагдай гэж  
 Эзэн нь эрхлүүлэн нэрлэв.  
 Ажиж сайтар харвал  
 Алагдай тун ч соньхон,  
 Цавиараа цагаан алаг,  
 Хүзүүгээрээ хөх алаг,  
 Магнайдаа саран толботой  
 Хошуундаа ногтон зурвастай  
 Овоо эелдэг зантай  
 Цовоо хөөрхөн ааштай ажээ.  
 Өнөө гурван ишиг  
 Өдөр ирэх бүр  
 Том болон өссөөр  
 Торниж тэнхээ орсоор  
 Өөдөө сөөргөө цойлдог  
 Өндөрт авирч чаддаг

Урагш хойшоо тонгочин  
 Уралдаж мөргөлддөг болов.  
 Ялангуяа Алагдай ишиг  
 Ямаа бүхнээс онцгой.  
 Асга дамжихдаа адтай  
 Ирмэг дагахдаа идтэй  
 Юу юуны түрүүнд  
 Хөлөө дэвсэн эрвэлзэнэ,  
 Юм юмны эхэнд  
 Хүзүү сунган сэрвэлзэнэ.  
 Тэртээ өндрөөс түүнийг  
 Тэх янгир хараад:  
 “Шууман харцага шувуу шиг  
 Шуугьж явдаг хэн бэ?” гэхэд нь  
 Хаднаас хаданд дүүлж  
 Чулуунаас чулуунд дэвхэрч  
 Хандсан зүг бүрдээ  
 Харвасан сум шиг хурдална.  
 Тийшээ ч булт үсэрч  
 Тэнхээ чадлаа харуулна.  
 Ийшээ ч халби харайж  
 Ид шидээ гайхуулна.  
 Алагдай гарамгай тамирчныг  
 Амьтан бүхэн магтаж  
 “Ямар мундаг ишиг вэ?  
 Яасан догь ямаа вэ?” гэлцэнэ.  
 Магтаал сайшаал сонсоод  
 Мань Алагдай бүр ч гаарч  
 Хайр чулууг харжигнатал  
 Хад асгыг доргитол  
 Тэв тэв гишгэлнэ  
 Тэнд энд цовхорно.  
 Годон сүүлээ өргөж  
 Гоё ганган зогсоно.  
 Намрын нэгэн өдөр  
 Нармай янгир гөрөөсний  
 Сүргийн наадам болох  
 Сүржин зарлал тархав  
 Өчүүхэн гурван ишиг  
 Үүр цүүрээр босож  
 Үс зүсээ янзлан  
 Үзэмж өнгөө засаад  
 Сайр өгсөн цахилсаар  
 Хайрга бутарган хатирсаар  
 Янгирын наадмын газар  
 Яаран сандран хүрэхэд

Уртын харайлтаас эхлэн  
 Уралдах харвалдах дараалан  
 Янгирын барилдаан хүртэл  
 Янз бүрийн тэмцээн болов.  
 Айлын ямааг төлөөлж  
 Алагдай уралдаанд оролцоод  
 Алсын тавианд түрүүлж  
 Аварга цол шагнуулаад  
 Эргэж сүрэгтээ ирэхэд нь  
 Ээж нь сэтгэл хангалуунаар  
 “Эвий хөөрхөн ишиг минь  
 Энхрий хайрт үр минь  
 Янгирын наадамд манлайлж  
 Ямаа нэрээ мандууллаа  
 Ялалтын өндрийг эзэмшиж  
 Яруу алдраа дуурсгалаа  
 Уртын аян харгуйд  
 Ундаасаа биз, сүүгээ уу  
 Өнжин саатан явж  
 Өлсөө биз, мээмээ хөх” гэхэд нь  
 Алагдай аварга ширвэлзэж  
 Амаа мурийтал ярвалзаж  
 Дэргэдхээ дэгс харж  
 Хажуудхаа хальт хялайж  
 “Талын уудмаар давхиж  
 Таанын үзүүр шилэх  
 Тагийн аглагийг зорьж  
 Тансаг идээг таних  
 Ээжийн мээмээс холдож  
 Эрдэм чадлаа сорих  
 Эрийн цээнд хүрсэн  
 Эрхэм аварга боллоо” гээд  
 Эрхийн чинээхэн эврээ өрж  
 Эрвэгэр хэдхэн сахлаа илж  
 Үүдэн хойморт ханхалзан  
 Үүлтэй тэнгэр өөд өлийхөд нь





Боролжны ёроолоор бөмбөрдөг  
 Борхон туулайн бөжингүүд  
 Цохио дамжин харайдаг  
 Цоохор жирхийн зулзагууд  
 Ямар сүртэй “сэрх” вэ? гэж  
 Яасан жавхаатай “эр” вэ? гэж  
 Шаг шууг бололцон  
 Шагшран магтаж гайхалцав.  
 Аварга цолын халуунд  
 Алагдайн нойр нь ихдэж  
 Гэдсээ цүндийтэл идээд  
 Гэдийн хэвтэх нь олшров.  
 Эрээдэй, Орогдой хоёр  
 Эртний нарнаар босож  
 Хатирах тэших сургууль  
 Харайх гүйх дасгал хийнэ.  
 Ээж нь Алагдайг сэрээж  
 “Энхрий хүү минь бос  
 Халих дүүлэхийн дасгалд  
 Хамаг ишиг гарлаа” гэхэд нь  
 Ноохойдоо хоргодсон Алагдай  
 Нойрондоо дарагдсан аварга маань  
 “Би түүнийг чадахаа л чадна  
 Битгий намайг сэрээ” гээд  
 Үүрэглэж нүдээ нухан  
 Үд болтол унтаад  
 Өдөр дундын үесээр  
 Өндийж нэг харахдаа  
 Уралдаж байгаа унага  
 Оодорч байгаа тугал  
 Дэвхэрч байгаа ишгийг  
 “Борви нь тушилдсан болхиодой  
 Хөл нь хөшилдсэн хөглөөхэй  
 Нэр гутаам нэвсгэрүүд  
 Цол гутаам цордгорууд” гэж шоолно.  
 Идэж ууж, сунаж хэвтсээр  
 Эрт унтаж, орой боссоор  
 Өрөөлийн мууг шоолж  
 Өөрийн сайныг гайхсаар  
 Гэнэхэн хонгор аварга маань  
 Гэдсээ цүлхийн таргалж  
 Гэдийж хэд алхахаас цааш  
 Гэрээс холдож чадахыг байлаа  
 Гэлээ ч гэсэн санаа нь үүлэнд  
 Гэдгэр ч гэсэн хүсэл нь ууланд  
 Ижлийн манлайд тэмүүлнэ.

Ишгэдийн тэргүүнд санаархана.  
 Алагдай гэвэл уурлан давшилна  
 Аварга гэвэл инээн онгирно  
 Харсан бүхэнд “Би чадна”  
 Хавьтсан бүрд “Би мэднэ” гэнэ.

*Алагдай аварга яагаад биеэ тоосон бэ?  
 Түүний зөв үү? Бид ямар сургамж авч  
 болох вэ?*

Аясын салхи сэржгэнэсэн  
 Аялуун намрын нэг өглөө  
 Ааглуу омголон Алагдай  
 Анд нөхдөдөө хандаж:  
 “Хулан чихтийн унагатай  
 Хурд чадлаа үзэлцэнэ  
 Хумбан туурайтын үрстэй  
 Хувь заяагаа сорилцоно  
 Ганцхан өдөрт багтааж  
 Галавын говийг туулна  
 Оргилох шаргал тоосоор  
 Орчлон дэлхийг бүрхэнэ” гэхэд нь  
 Ээж аав хоёр нь  
 Ээлж дараалан үглэж  
 “Эрх бяцхан ишиг минь  
 Эргэцүүлж сайтар тунгаа  
 Харийн харгуй бартаатай  
 Хартан дайсан аюултай  
 Өглөө үдшийн бүрийгээр  
 Өлөн чоно гэтдэг шүү” гэхэд нь  
 “Би бол ишиг биш  
 Бие гүйцсэн ухна  
 Эгэл нэг ямаа биш  
 Эрх төгс аварга  
 Хэнээр ч хэлүүлэхгүй  
 Явах замаа тухайлна  
 Хэнд ч заалгахгүй  
 Яах ийхээ мэднэ” гээд  
 Ширүүн гэдэг нь тэнцэлгүй  
 Шийдэмгий гэдэг нь тогтолгүй  
 Аашны жолоогоо таталгүй  
 Авирлан муухай загнахад нь  
 Аав ээж хоёр нь  
 Аргадаж ятгаж цөхрөөд  
 Ах эгчийг нь дагуулан  
 Алсын замд мордуулав

Хүүхдүүд ээ, Алагдай аваргад юу тохиолдох бол?

Номоо хаагаад үйл явдлыг цааш нь таамаглан ярилцаарай.

Хулангийн газар зорьж  
Хурднаа нэг үзэлцэнэ гээд  
Онгиоро аварга оройлон  
Орогдой, Эрээдэй дагалдаад  
Задгай талд гартал нь  
Зайгуул чоно угтаж  
Амттай бэлэн хоолонд  
Амаа зэхэн дайрав  
Хэрцгий нүд нь жартайсан  
Хэдрэг шүд нь ярзайсан  
Зүүдэнд оршгүй муухай  
Зүхлийн дайсныг үзэхдээ  
Мээмний гурван ишиг  
Мэгдэж тэвдсэн нь хэмжээгүй  
Ухаан жолоогоо алдаж  
Ум хумгүй зугтаав.  
Овойж биеэ тоосоор  
Олох эрдмээс хоцорсон  
Сунаж тэрийж хэвтсээр  
Сургууль дасгалаа мартсан  
Олиг мууцыг бодвол  
Орогдой, Эрээдэй хоёр  
Харайх гүйхдээ хурдан  
Харах бараагүй талийв.  
Гайхал аварга Алагдай  
Гавьтай гүйж чадсангүй  
Хэдхэн харайсны эцэст  
Хийгүй бөмбөг шиг шолхойж  
Ахин дахин чармайвч  
Аахилан бахардан цуцаж  
Араатны хоншоорын өмнөхөн  
Амь тэмцэн ойчив.  
Амжиж энэхэн хооронд  
Ах эгч хоёр нь  
Аюул түгшүүрийн мэдээг  
Анчинд хүргэж чадсанаар  
Шүдээ хавиран дайрч  
Шүлсээ гоожуулан довтолсон

Ховдог чонын толгойд  
Холч бууны сум тусаж,  
Тарган цүзгэр Алагдай  
Танагтай үлдсэн боловч  
Сандарч айсны эрхээр  
Салганан бие нь чичирч  
Хөл нь эзэнгүй гуйвганан  
Хөлс нь тогтолгүй асгаран  
Уруу буруугаа унаж  
Ухаантай ухаангүй байв.  
Ах эгч хоёртоо  
Алагдай түшүүлэн явахыг  
Агаарын жигүүртнүүд үзээд  
“Аваргыг хараач та минь,  
Баахан мэдлэгтээ ташуурч  
Бардам сэтгэл баривал  
Сээтэн чонын зууш болж  
Сэвстэй гүзээ л үлдэнэ шүү” гэж  
инээлдэв.

Айдар баахан Алагдай  
Амь наана, там цаана  
Алхаж ядан гуйвсаар  
Арай чарай ирэхэд нь  
Сүргийн тэргүүн өвгөн сэрх  
Сүрхий түвшин дүрээр  
Сэлмэн эврээ сэжин байж  
Сэрвэн сахлаа имрэн байж:  
“Ямаан омог эрдэм биш  
Ярвагар зан чимэг биш  
Бэрхийг сурвал гайхамшиг  
Эрхийг сурвал гутамшиг  
Эцэг өвгөдийн захиасыг дага  
Эрдэмтэн мэргэдийн үгсийг сана  
Эеийн жолоог хүндэтгэ  
Эвийн холбоог бататга.  
Мэдлээ гэж бүү сагсуур  
Мэдлэгийн хүрээ хязгааргүй  
Сурлаа гэж бүү онгир  
Сурлагын далай захгүй” гэж  
Ижил сүрэгтээ хандан  
Илтгэж хэлсэн үг нь  
Ишгэн ухнад ч хэрэгтэй  
Идэр тамирчинд ч сургаалтай

1967 он

(Д.Цэвэгмид "Зохиолууд". УБ., 1974 он. 90-98 дахь тал.)

Дараах асуултын дагуу ярилцаж, ойлгож мэдсэнээ бататгаарай.

- А. Найраглалын гол дүрийн гурван ишиг хаагуур нутагладаг ямар малчны сүрэг вэ? Ишигний амьдардаг орчныг ингэж тодорхой дүрсэлснээр зохиолч ямар санаа гаргахыг зорьсон бэ?
- Б. Алагдай ямар тэмцээнд орж түрүүлээд аварга цол хүртсэн бэ? Үүгээр зохиолч юу илэрхийлэхийг зорьсон бэ?

**Өгүүлэгдэхүүний бүтэц, холбоо хамаарлыг дүрийн үйлдлээр тайлбарлая**

1. “Алагдай аварга” найраглалын үйл явдал хэдэн хэсгээс бүрдэж байгааг нөхөж бичээрэй.  
 А.Алагдай аваргын өсөлт буюу амжилт гаргаж байгаа хэсэг  
 Б.Алагдай аварга амжилтдаа эрдэн бардаж,  
 .....
2. Найраглалын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөл хэсгийг гүйцээж тэмдэглээрэй.  
 Эхлэл хэсэг: Эгэл малчны хотонд ихэр гурван ишиг мэндэлж, өсөж торниж байгаа  
 Зангилаа: Алагдай уралдаанд түрүүлж аварга цол хүртсэн  
 Өрнөл: .....  
 Туйл: .....  
 Тайлал: .....  
 Төгсгөл: Өвгөн сэрх сургаал айлдаж байгаа

**Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг тодорхойлъё**

1. Хүснэгтэд Алагдай аваргын тухай харьцуулж бичээд яагаад ийм ялгаатай болсныг дүгнэж бичээрэй.

Алагдай аваргын авхаалжтай сэргэлэн цагийн дүр дүрслэл, үйлдлийг түүвэрлэн бичээрэй.	Алагдайн аварга болсноос хойш үеийн дүрслэлийг түүж бичээрэй.
Асга дамжихдаа адтай Ирмэг дагахдаа идтэй Хөлөө дэвсэн эрвэлзэнэ Хүзүү сунган сэрвэлзэнэ ..... ..... гэх мэт	Гэдсээ цүндийтэл идээд Гэдийн хэвтэх нь олшров. ..... ..... гэх мэт
Дүгнэлт: Алагдай байгалиас заяасан хурд хүч, авхаалж самбаагаа өөрийн хичээл зүтгэлээр түр зуур хөгжүүлэн тэмцээнд түрүүлэн аварга цол авсан ч ..... .....	

2. Найраглалд гарч байгаа бүх хүн, амьтныг жагсаан бичиж зохиолд ямар үүрэг гүйцэтгэж байгааг дүгнээрэй.

№	Дүрүүд	Найраглалд гүйцэтгэж байгаа үүрэг
1	Алагдай	
2	Эрээдэй, Орогдой	
3	Аав, ээж нь	
4	Тэх янгир	



# IV БҮЛЭГ

## ГАДААДЫН УРАН ЗОХИОЛ

### Судлах зохиол:

#### 4.1. Дорнын уран зохиол

- Ү Чэн-энь Тансан ламын баруун этгээдэд аялсан тэмдэглэл
- Я.Кавабата “Ангийн даргын мөрдлөг”

#### 4.2. Өрнийн уран зохиол

- Э.Хэмингуэй “Өвгөн тэнгис хоёр”
- Ж.Роулин “Харри Поттер”

### Эзэмших чадвар:

#### УНШИХ

- Дорно, өрнийн уран зохиолоос мэдэрч ойлгох, тусган хүлээж авах
- Хүүрнэл зохиолын онцлогт тохирсон хэл найруулга, орчин, дүр, сэдэв, утгын задлал хийх
- Өөр өөр соёл, ёс заншлын үнэт зүйлийг ойлгож, хүндэтгэж сурах

#### БИЧИХ

- Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүр, дүрслэлийн талаарх мэдрэмж, сэтгэгдлээ уран дүрслэл ашиглаж бичих
- Зохиолд дүр, орчин нэмэх, харилцан яриа оруулах зэргээр дэлгэрүүлж бичих

#### ЯРИХ

- Зохиолын дүрийн талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярих
- Зохиолын гол санаа, дүрийн зан төрхийг ойлгож мэдэрснээ дүр бүтээж харуулах



## 4.1 ДОРНЫН УРАН ЗОХИОЛ



Уншихын өмнө

1. Романы тухай болон романы бүлгүүдийн товч агуулгатай танилцаарай.
2. Зохиолоос утгыг нь мэдэхгүй үгийг олж, бусдаас асууж тэмдэглээрэй.

Ардын үлгэр домгийг уран зохиол болгон боловсруулсны нэгэн гайхамшигт жишээ нь Ү Чэн-энийн (1500-1582) “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” уран сэтгэмжийн роман юм. Тэнгэр газар төрүүлсэн хувилгаан мичний тухай энэ зохиолыг “Мичин багшийн үлгэр” хэмээн нэрлэх нь ч бий. Хятадын уран зохиолын сонгодог бичиг болсон энэ зохиолыг Тан улсын буддын шашны хутагт Шюаньзан Энэтхэг оронд жуулчилсан түүхэн явдлыг эш үндэс болгон бичсэн тул монголчуудын дунд “Тансан лам баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” гэх нэрээр алдаршсан юм. Тус зохиолын монгол орчуулга манай Улсын Төв номын сан болон Гандан хийдийн номын санд хадгалагдаж буй.



Энэ зохиолд Хоншим бодисадын зарлигаар баруун тэнгэрийн Энэтхэг орны Аянгын дуут сүмээс бурхны ном залж ирэхээр “Үнэний номыг эс олбол үхэвч буцаж ирэхгүй” хатуу тангарагтай аянд гарсан зорчин аялагч Тансан ламын аян замын саад бэрхшээл хийгээд самбаа зоригт Мичин ван Сүн Үкүний хүний санаанд эс багтам үйлс гавьяаг өгүүлдэг. Зохиолын

баатрууд нь ардын үлгэр домгийн уран сэтгэмжит баатрууд бөгөөд гахай дүрт Жү Ба-жэ, Шороо буюу Шасэн болон бурхад хийгээд шуламсууд гардаг.

**Зохиолын товч агуулга**

Зүүн этгээдийн Үлэмж биет тивд Уулай гэдэг улс байж гэнэ. Тэр улс далайд ойр, далайн дунд нь навч цэцэг дэлгэрсэн Цэцэг жимст уул гэдэг сайхан уул байжээ. Тэр уулын оройд гурван алд илүү өндөр, хоёр алд илүү өргөн нэгэн хувилгаан чулуу байжээ. Мянга түмэн жилийн турш наран сарны шимийг хүртсээр тэр чулуу сахиулсны сүнстэй болжээ. Нэгэн өдөр энэ хувилгаан чулуу гэнэт дэлбэрээд чулуун өндөг гарчээ. Энэ өндөг салхин үзмэгц хувилаад таван цогц, дөрвөн мөч бүрэлдэн чулуун Мичин болж, үсэрч харайлан дөрвөн зүгт мөргөв.

**ТАНСАН ЛАМЫН БАРУУН ЭТГЭЭДЭД ЗОРЧСОН ТЭМДЭГЛЭЛ**

(Роман)

**Лусын ордныг ихэд түйвээсэн нь**

Мичин далай гэтлэн Бодисадад золгож, Сүн Үкүн хэмээх нэр хүртэж, далан хоёр зүйлээр хувилах увдис сурав. Мичин Цэцэг жимст уулнаа харьж ирээд, жарган суухад ганц цэргийн зэвсэг дутах тул тэр Лусын ордныг түйвээж, сэтгэлийг хангагч болд бэрээ олж авав. Үүнээс хойш Сүн Үкүн их үйл бүтээжээ.

**Хязгаар уул**

Мичин тэнгэрийн ордныг түйвээсний дараа Шагимуни увдисаар түүнийг Хязгаар уулын доор дарж, таван зуун жил там амсуулав. Бодисад түүний рид шидтэй бөгөөд авьяас чадвар бусдаас давахыг мэдэх тул Тансанг багш барьж, баруун газраас ном залахаар явахад нь хамгаалж яв гэсэнд үг дуугүй зөвшөөрөв. Тансанг Хязгаар уулын өмнүүр өнгөрөхөд Мичин Тансанг гуйж уулын орой дахь маанийн үсгийг авхуулж шавь оров. Гэвч Мичиний зан ааш бүдүүлэг болохоор Тансантай хэдэнтээ муудалцав. Үүнд Бодисад ухаан гаргаж толгойд нь алтан цагариг зүүлгэснээр түүнийг захирч чадах болов.

**Гаолоа тосгон**

Мичин Тансанг хамгаалж баруун газраас ном залахаар явах замдаа Гаолоа тосгоноор өнгөрөхөд тосгоны Гао Тайгүн гэгч охиноо урт хоншоортой, их чихтэй эрд сүйлэн өгсөн боловч, өөрөө энэ урагт дургүй учир буцаах гээд арга ядахдаа Мичинийг гуйжээ. Мичин үүлт агуйд тарган эрийг бариад хорьжээ. Энэ их эр бол Тансанг дагаж ном залахаар явалцсан Гахай багш юмсанжээ.

**Шороо гол**

Тансан багш шавь нарынхаа хамт баруунш ном залахаар явах замдаа Шороо голын шуламстай харгасанд Гахай дийлсэнгүй тул Мичин арга бус Хоншим Бодисадыг залж хавсруулав. Бодисад Мич нарын томилон шуламсыг даруулж, мөн шуламсыг Тансанд шавь оруулснаас Тансан гурав дахь шавь Шороогоо олов.

**Уран аргаар сайхан Мичин ванг хилэгнүүлсэн нь**

Тансан баруун газраас ном залах замдаа Гахайн үгэнд итгэн Мичинийг хөөж явуулав. Сүүлд нь Тансан аюулд учран, Шороо бас шуламст баригдав. Гахай арга буюу Цэцэг жимст ууланд очиж хилэгнүүлэх аргаар Мичинийг уулнаас буулган шуламсыг дарж Тансан болон Шороог аварсан байна.

**Жинхэнэ ба хуурмаг эрдэнийн хул**

Мичин Тансанг хамгаалж ном залахаар баруунш аялах замдаа Дэвсэг уулын Бадамлянхуа агуйгаар өнгөрөхөд Тансангийн махыг идвэл мөнхийн шид олно гэж сонссон Алтан эвэрт, Мөнгөн эвэрт шуламс багш шавь хэдүүлийг агуйдаа барьж аваачжээ. Бас Мичинийг шидэт хуланд хийж шүүс болтол уусгах гэсэнд Мичин багшаа аврахын төлөө хулаас шурган гарч, увдисаа гарган жинхэнэ хулыг сольж авснаар шуламсыг дараад аяллаа үргэлжлүүлэв.

**Улаан хөвүүн**

Тансан гурван шавиа дагуулан ном залахаар Одишар улсаас гарч, баруунш явж байхдаа Мичиний ятгалгыг эс сонссоны уршгаар Галт үүл агуйн Идэр богд, Их ван Улаан хөвүүн шуламст баригдав. Мичин рид гарган ялаа, тэр ч бүү хэл Үхэр шуламс ван болж хувилаад ч Тансанг аварч чадахгүйд хүрэв. Эцэстээ өмнөд далайн Бодисад Улаан хөвүүнийг номхотгосноор Тансанг аварчээ.

**Тэнгэр гол**

Тансан багш шавь дөрвүүл баруун газраас ном залахаар явах замдаа Тэнгэр гол хүрч Чэньжя тосгонд буудаллажээ. Тэнгэр голын шуламс тосгоноос жил бүр хүү хүүхэн хоёрыг барьж иддэг гэснийг сонсоод мичин гахай хоёр увдис гарган тэр шуламсыг цохижээ. Тэр шуламс заль мэх хэрэглэж Тансанг барьж аваачсанд Гахай, Шороо хоёр голд хэдэнтээ орсон боловч аварч чадсангүй. Эцэстээ Мичин Хоншим Бодисадыг залж, шуламсыг даруулж багшаа аварчээ.

**Уран аргаар алтан хонхыг хулгайлсан нь**

Тансан шавьтайгаа дөрвүүл Зүч улсаар дайрахдаа Алтан ордот хатан нь шуламст уулга алдсаныг сонсоод Мичин алтан хонх эрдэнийг хууран авч, Алтан ордот хатныг авраад хааны зовлонг арилгаж өгөв. Мичин ачийн хариуг бодолгүй Тансанг хамгаалж үргэлжлэн баруунш аялав.

**Арслант улс**

Тансан багш шавь дөрвүүл баруунш явсаар Арслант улсаар дайрч өнгөрөхөд гурван шуламсын ван увдис гарган Тансан, Шороо, Гахай гурвыг барив. Мичин арга буюу Шагимуни бурхныг гуйхаар очсонд Манзушир, Самандбадрааг томилон хар арслан, цагаан зааныг, өөрийн гурав дахь шуламсын ван гардийг номхотгов. Багш шавь нар дахин нүүр золгож баруунш аялав.

**Хааны хуурмаг хадам эцгийг дарсан нь**

Тансан шавь нартайгаа баруун газраас ном залахаар явах зам зуур Аяга тахимлаг улсаар дайрчээ. Улсын хаан нь шуламст мэхлэгдэн мунхарч, мянга нэг зуун арван нэгэн хүүхдийн зүрхээр эмийн хөлөг хийж уувал мөнхөрнө гэж итгээд хүүхдийн амь хороодог болжээ. Тансан хүнийг хорлон амь хороож болохгүй гэж нигүүлсэнгүй сэтгэлээр хааныг ятгасан боловч хааны хадам эцэг нь шуламс болох учир Мичин аргаар тэмцэн дийлж, нэг улсын хүүхдүүдийг аварчээ.

**Өрх агуй**

Тансан баруунш ном залахаар явах замдаа Хөндий ууланд хүрээд нэг хүлээстэй охиныг аварчээ. Энэ охин нь харин алтан хамарт цагаан хулганын шуламс байсан тул аргаар Тансанг бариад өрх агуйдаа аваачин хорсолтойгоор тамлаж байх үед Мичин мэргэн арга цэцэн ухаанаар Тансанг аварсан байна.

**Алтан дуулгат агуй**

Тансан шавьтайгаа хэдүүл явсаар Алтан дуулгат уулыг өнгөрөхөд шуламсын ван арга хэрэглэж Тансан, Гахай, Шороо гурвыг барьж агуйдаа аваачив. Мичин шуламстай байлдсан боловч болд бэрээ нь шуламсын очир бугуйвчийг үл дийлэх

учир тэнгэрийн олон сахиулсан жанжин, гал усны эздийг залж шуламсыг даруулах гэв. Тэд нар мөн зэр зэвсгээ хураагдан хоосон хоцорчээ. Хожим нь тэр шуламс бол Дилобын хөх үхэр болохыг мэдээд Дилобыг залж шуламсын ванг даруулжээ.

### Жинхэнэ хуурмаг хоёр мичин

Тансан багш шавь дөрвүүл Кис Корганы охин улсаар өнгөрөхөд Мичин хоёр дээрэм алснаас Тансан их унтууцаж, Мичинийг хөөж явуулав. Зургаан чихт хөгшин самж энэ далимд Мичинээр овлож, Тансанг зодож шархтуулаад, замын тэмдэг бичгийг нь булааж, баруун газар очиж ном хулгайлах гэжээ. Жинхэнэ Мичин Хоншим бодисадын үгээр хуурмаг мичинтэй тулалдаад хэн нь ч дийлж чадалгүй Шагимуни бурхны дэргэд ирээд зургаан чихт самжийн уг дүр илэрсэнд Мичин нэг л бэрээгээр амийг нь эцэслүүлжээ. Ном залах замдаа багш шавь сэтгэл нэгтэй явбал чөтгөр шуламс та нарын маргааныг далимдуулан хор хүргэж чадахгүй гэж Шагимуни дахин давтан захив.

### Гал уул

Тансан багш шавь нарын хамт баруунш явсаар байгаад Гал ууланд хашигдав. Мичин Хөх үүлт уулын агуй дахь Төмөр дэвүүрт гүнжид нэг дэвбэл гал унтрааж, хоёр дэвбэл салхи дэгдээж, гурав дэвбэл бороо оруулдаг дэвүүр байна гэж мэдээд зээлэхээр очив. Гэвч Төмөр дэвүүрт гүнж эр эм хоёул өшөө бодож, дэвүүрээ зээлж өгөөгүй мөртөө Мичинтэй байлдав. Мичин арга ухаанаа шавхан байдаг чадлаа гаргаж, зүг бүрийн сахиулсны тусалснаар төмөр дэвүүрт гүнж болон түүний эр Үхэр ванг номхотгоод, дэвүүрээр галыг унтрааж, Тансанг хамгаалан, Гал уулыг даваад тэр газрын ардыг галын аюулаас аварсан байна.

### Хуурмаг бурхны орон

Тансан шавь нартайгаа баруунш аялсаар шуламсын цогцолсон хуурмаг Аянгын дуут сүмд хүрчээ. Тансан үнэн худлыг мэдэлгүй орж мөргөх гэсэнд Мичин хэчнээн хориглоод дийлсэнгүй мөртөө өөрөө харин шуламсын алтан цанд дарагдчихав. Тансан, Гахай, Шороо гурав бас шуламст баригдав. Мичин тэнгэрийн олон сахиулсны тусалснаар алтан цангаас оргон гарсан бөгөөд Майдар бурхны дэмжлэгээр Тансан нарыг авран гаргажээ. Мичин гал тавьж хуурмаг бурхны орныг чандруу болгов. Тансан шавь нартайгаа цааш замдаа орлоо...

*Мичин багшийн үлгэр. ӨМАХХ. товчлон Хөх хот. 1998 номоос авав*

3. Асуултын дагуу ярилцаж ойлгож мэдсэнээ бататгаарай.
  - А. Тансан лам хаанаас ямар ном залахаар аялж байгаа вэ?
  - Б. Юуны учир Сүн Үкүнь алтан цагариг зүүв?
  - В. Сүн Үкүний тухай уншиж байхдаа ямар хэсэг дээр гайхав? Ямар үйл явдлыг бишрэв? Юунаас эмээж байв?
  - Г. Тансан ламд Мичин багш тусалснаараа сэтгэл нь хангалуун байж чадаж байгаа болов уу? Та нар юу гэж бодож байна?
  - Д. Шороо багш, Гахай багш байгаагүй бол үйл явдал яаж өрнөх байсан бол?
  - Е. Тансан лам заримдаа Мичин ванг хөөн явуулдаг. Үүний гол зөрчил нь юу байдаг вэ?




### Үйл явдлын уялдаа холбоо нь эхийн утгад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлая

1. Зохиол хэдэн хэсэгтэй байна вэ?
2. Тансан ламд ямар ямар үйл явдал тохиолдов? Түүнийг яаж даван туулж байна вэ? Тэр өөрийнхөө хүчээр бэрхшээлийг даван туулж байна уу?
3. Түүнд хэн их тусалж байна вэ? Яагаад туслаад явна вэ? Үүгээрээ зохиолч юуг хэлэхийг хүссэн бол?
4. Та нарын бодлоор зохиолын гол үйл явдлыг хэн өрнүүлж байна вэ? Тансан лам уу? Эсвэл? Өөрийн хариултаа зөвтгөөрэй.
5. Ном залах замдаа багш шавь сэтгэл нэгтэй явбал чөтгөр шуламс та нарын маргааныг далимдуулан хор хүргэж чадахгүй гэж Шагимуни дахин давтан захисныг та нар юу гэж бодож байна? Зохиолын гол санаатай холбоотой гэж үзэх үү?

### Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг тодорхойлъё

1. Зохиолд ямар ямар дүрүүд гарч байна вэ? Тоочин хэлнэ үү. Багаараа ярилцан дүрүүдийг ангилаарай.
  - А. Гол дүр.....
  - Б. Уран сайхны хэтрүүлэлтэй дүрүүд.....
  - В. Бодит дүрүүд.....
  - Г. Бурхдын дүр.....
  - Д. Сайн дүрүүд.....
  - Е. Хорон санаат дүрүүд .....
  - Ё. ....
  - Ж. ....дүрүүд гэх мэт
2. Дүрүүдээс сонгон дараах асуултын дагуу оюуны зураглал хийгээрэй. Үүнд:
  - Зохиолын эхэнд ямар зорилготой байсан бэ? Зөв байсан уу? Эерэг байсан уу? Эргэцүүлж дахин уншаарай.
  - Зохиолын гол гол хэсгүүдэд сайн, муу ямар үйл хийв? Юу боддог учраас муу эсвэл сайн үйл хийв?
  - Зохиолын төгсгөл хэсэгт зорилгодоо хүрсэн болов уу? Эх зохиолыг уншаад дүгнэн ярилцаарай.



3. Дүр бүрийн үйлдэл, үг хэл, бодол санаа, тэмүүлэл, зорилгыг харьцуулан дүгнээрэй.



Зохиолын дүр	Юу бодож, төсөөлж, эргэцүүлдэг вэ? Жишээ татан бичнэ үү.	Ямар дүртэй юу ярилцав? Харилцан ярианаас юу бодогдов?	Юуны төлөө, хэний төлөө тэмүүлж байна вэ?	Зорилготой дүр мөн үү? Шүүмжлэлтэй хандаарай.	Энэ бүхнээс ямар зан чанартай дүр гэж тодорхойлох вэ?
Тансан лам					
Сүн Үкүн					
Сурагч таны сонгосон дүр					

4. Зохиол дахь дүрүүдээс хэний ямар зан чанараас суралцмаар байна вэ? Өөрийн зан чанартай харьцуулан суралцсан зүйлээ тоочин бичнэ үү.

**Орчин, нөхцөл байдлыг тайлбарлая**

- Зохиолыг уншихдаа үйл явдал хаана, хэзээ өрнөж байгааг төсөөлөн зурна уу. Сонгон ажиллана уу.
  - Тэнгэрт болж буй үйл явдал
  - Газарт, ууланд болж буй үйл явдал
  - Тосгон, эсвэл айлд болж буй үйл явдал
  - Голын эрэг дээр болсон үйл явдал гэх мэт
- Эдгээр орчинд дүрийн ямар зан чанар тодорч байгааг эргэцүүлэн ярилцаарай.
- Ямар орчинд Сүн Үкүнийг үзүүлснийг зохиолын эхлэл хэсгээс дахин уншиж тайлбарлаарай.


	Орчныг дүрслэхдээ ямар үг хэрэглэв?	Ийм орчинд ямар дүрийг зохиолч бүтээхийг зорив?	Ийм дүрийг бүтээснээрээ зохиолч ямар асуудлыг дэвшүүлэв?
Тайлбар			

**Зохиолын далд утгыг тайлбарлая**

- Сармагчин Тансан ламд хэрхэн тусалсан бэ? Ламд тусалж байгааг та нар юу гэж бодож байна?
- Зохиолд ямар ид шидэт зүйлс, ямар ид шидтэй үйл явдал гарч байна вэ? Монгол үлгэртэй харьцуулан ярилцаарай.
- Жинхэнэ хуурмаг хоёр мичний бүлэг дэх Шагимуни бурхны захиас сургаалыг хуулж бичээд, дэлгэрүүлэн ярилцаарай.



## Уншихын өмнө



(1899-1972)

## Кавабата Ясүнари

Японы нэрт зохиолч, Нобелийн шагналтан Я.Кавабата Осака хотод 1899 онд төржээ. "Мянган далавчит тогоруу", "Уулын чимээ", "Хуучин нийслэл", "Изүгаар яваа бүжигч бүсгүй", "Цасны орон" зэрэг зохиолуудаараа алдаршжээ.



## Унших чадвараа хөгжүүлэе

**Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя**

1. *Зохиолын нэрийг уншаад ямар сэтгэгдэл төрж байна вэ? Зохиолд юун тухай өгүүлэх бол? Таамаглан ярилцаарай.*
2. *Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглээд өгүүлбэрийн хам бүтцээс ойлгож тайлбар хийхийг зориорой.*

**АНГИЙН ДАРГЫН МӨРДЛӨГ****1.**

Даваа гараг бол хамгийн сонирхолтой байгалийн ухааны хичээл ордог өдөр. Хичээл эхлэхийн өмнө цэвэрлэгчийн хүү болох Шинкичи ангийн гадна бусдынхаа дунд орон их л нэр хүндтэй байх аж.

- Би өнөөдөр ямар туршилт хийхийг мэдэж байгаа юм чинь. Хагас сайн өдөр та нарыг харьсны дараа багшийн туршилтад бэлтгэж байхыг харсан юм хэмээн түүнийг сайрхан хэлэхэд "Нээрэн үү? Атаархмаар юм аа", "Сонирхолтой туршилт байна уу? Ямар багаж хэрэглэж байна, хэлээд өгөөч?" гэхчлэн бүгд л гарыг нь атган, мөрийг нь алгандан шалгааж туршилтын өрөөний цонхон дор шавчихлаа.

Газар зүйн хичээлээр олон орны үзэсгэлэнт байгалийн зураг болон тухайн газрын бүтээгдэхүүнтэй танилцах, түүхийн хичээлээр эртний баатар жанждын хөрөг болон дайн тулааны зургийг харах, байгалийн ухааны хичээл дээр амьтан ургамлын чихмэл, хатаамалтай танилцах гээд дунд ангийн хичээлүүд өнөөг хүртэл үзсэн бага ангийн хичээлүүдээс огт өөр, их сонирхолтойн дээр балчир оюунаа огцом тэлж, олон зууны түүх болоод өргөн уудам шим ертөнцийн үүдийг татан орох баяслыг хүүхдүүдэд төрүүлэхийн дээр бид том ангийнхан болсон шүү гэх бахдалыг мэдрүүлдэг билээ. Юутай ч байгалийн ухааны хичээлийн туршилт нь хүүхдүүдийн мэдлэгийн нүдийг шинэ гайхамшгаар нээдэг юм.

...Багшийг урьдынх шигээ ангийн даргаар туслуулан багаж хэрэгслээ тэврээд инээмсэглэн орж ирэх байх хэмээн хүлээж байтал эсрэгээр гэрлийн шил гурван ширхгийг барьсаар орж ирэхэд нь бүгд урам хугарсан янзтай Шинкичи рүү харцагалаа. Шинкичи ч гайхсан янзтай

- Үгүй ээ, гэрлийн шил огт байгаагүй хэмээн аяархан шивнэлээ.

- Мизүно!

Багш Шинкичигийн овгийг чангаар дуудан “Ярьж болохгүй шүү. Чимээгүй суу!” гэж анхааруулаад огт харж байгаагүй ширүүн нухацтай харцаар хүүхдүүдийг ширтэн

- Өмнөх хичээл дээр цахилгаан гүйдлийн талаар үзсэн. Өнөөдөр чийдэнгийн талаар ярих ёстой байлаа. Гэрэл бол цахилгаан гүйдлийг хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл цахилгаан гүйдэл дулаан үүсгэн, гэрэл гаргадаг. Үүнийг ашиглан өнөөдрийн энэ чийдэн бий болсон юм. Үүнийг тайлбарлахын тулд туршилт хийж үзүүлэн, хэрхэн гэрэл гаргадгийг батлах хэрэгтэй гэж бодоод өнөөдрийн туршилтын бэлтгэлийг хагас сайн өдөр хийгээд тавьсан байсан. Гэтэл хэн нэг нь ангид ороод багаж хэрэгслийг эвдээд хаячхаж. Зай хураагуур болоод бодис хадгалах дугуй шилэн савууд хагарч, хүхрийн хүчил гоожин, төмөр ялтаснууд алга болчхож. Тэгээд ч зогсохгүй өнгөрсөн улиралд үзүүлж байсан гүдгэр линз хулгайлагдсан байна.

...Багшийн үгийг сонсоод анги тэр аяараа нам гүм болж, дэмий л бие биеэ ширтэн, толгой сэгсэргээв.

- ...Хагас сайн өдөр номын санд суусан хүмүүс гараа өргө.

Долоон хүн гараа өргөлөө. Номын сан туршилтын өрөөний хажууд байдаг билээ.

- Та нараас хоёр цаг хүртэл үлдсэн хүн байвал гараа өргө дөө. Багш хэсэг хүлээснээ

- Ганц ч байхгүй юм биз дээ. Туршилтын өрөөнд очсон хүн ч байхгүй юу? Та нарт итгээд би хардахаа байя. Хэрэв энд хэлж чадахгүй байгаа хүн байвал дараа нь ангийн даргадаа хэлнэ биз. Кимүра! хэмээн ангийн дарга Фүмиог дуудлаа.

- Чи өөрөө сайн хайгаад үз. Нууж байснаас хурдхан буруугаа хүлээвэл өөрт нь ч, ангийнханд нь ч сайн гэдгийг мэдэж байгаа байлгүй.

- За багш аа хэмээн Фүмио өндөр дуугаар хариулаад тэр дороо бодолд автлаа. “...Бүгд эхлээд Шинкичиг хардаж байгаагаас зайлахгүй. Шинкичи цэвэрлэгчийн хүүхэд, тэгээд ч хагас сайн өдөр багшийн туршилтыг харсан гэсэн юм чинь. Дараа нь намайг сэрдэх нь лав. Ангийн дарга багшид туслан багаж хэрэгслийг гаргаж хийдэг. Бас түлхүүр нь хаана байдгийг мэддэг болохоор... За ямар ч байсан хариад хурдхан Сэйчитэй зөвлөөд үзье. Сэйчи нүд нь хардаггүй ч гэлээ, юм бүхнийг мэддэг юм чинь...” Багшийн дуу Фүмиогийн анхаарлыг хичээл рүү татлаа.

- Тийм болохоор өнөөдөр туршилт хийж чадахгүй нь. Өмнөхөө давтаад, чийдэнгийн талаар бага зэрэг зүйл ярья.

- *Туршилтын өрөөнд юу болсон бэ? Фүмио юу бодов?*
- *Хичээлийн туршилтын хэрэгслүүдийг хэн авсан юм бол? Та нар юу гэж бодож байна?*

## 2.

...Есөн сарын шинэ улирал эхлээд гурав хонож байгаа болохоор яахын аргагүй Сэйчид хэцүү байгаа. Фүмио бол “Чи үнэхээр сургуульд явж болох юм уу?” гэх мэт дотно найзынхаа хүсэл мөрөөдлийг үгүй хийх зүйл асуух нь битгий хэл, “Сэйчи нүд нь харахгүй ч гэлээ бүхнээс илүү сурч чадна. Түүнийг сургуульд явуулж өгөөч?” хэмээн Ошимото багшаас гуйхаар шийдчихээд байгаа хүүхэд билээ.

- Энийг хар даа. Нэгдүгээр улиралд биологийн хичээл дээр үзсэн далайн ургамлын зураг болон сувдан хясаа, дунгийн хатаамал.... Ёстой сонин гоё байсан тийм ээ. Тийм зүйлийг ахиад харахгүй гэхээр харамсалтай л байна. Гэхдээ нүд харахгүй болсноос хойш ой санамж илт сайжирсан шүү. Ээжээр өдөр бүр нэг нэг хичээл уншуулж, дасгал хийсээр байгаад газар зүй, түүхийн сурах бичгийг бүр цээжилчихсэн.

- Нээрэн үү? гэж Фүмио гайхан Сэйчиг ширтсэнээ

- Би ч бас очоод хичээлээ хийнэ ээ, хэмээн тэр үгэнд нь зоригжсон янзтай хэллээ. Зөвхөн хичээл ч биш, ямар ч зүйл дээр хараатай хүмүүсийн дор орохгүй гэж шийдсэн нь яах аргагүй Сэйчигийн төрөлх дайчин зангаас нь үүдэлтэй ч, нөгөөтээгүүр ээжийгээ зовоохгүй гэж шийдсэнтэй нь холбоотой.

Тэдний тосгон тутарга тариалах болон хураах үеэр амсхийх ч завгүй болж, бага сургуулийн хүүхдүүд хүртэл туслахаар талбайд гардаг болохоор сургууль нь арав хоногийн тусгай амралт олгодог тариачдын тосгон байв. Ээж аавтайгаа гурвуулаа амьдардаг Сэйчи хар багын л сайн тариачин байсан бөгөөд тутарга боловсрон өвдгөөр татам өндөр ургасан зуны амралтын эхний өдөр талбайн өвсийг зулгааж яваад, урсан гарах духныхаа хөлсийг арчих гэж огцом өндийхдөө хоёр нүднийхээ цөцгийг тутаргын навчинд исгэчихсэн юм.

Тутаргын навч шивээ өвсний толгой шиг нүдэнд аюултай билээ. Гэвч иймэрхүү осол гарах нь тун ховор, зэргэлдээ тосгонд тутаргын навчинд өрөөсөн нүдээ гэмтээсэн гэх нэг эмгэнээс өөр хүн үгүй атал, ямар үйлийн үр юм бүү мэд, Сэйчи хоёр нүдээ алдчихсан билээ. Ослоос хойш гурав хоногийн дараа Сэйчи

- Ээж ээ, өглөө болчихсон биз дээ. Хаалга үүдээ нээгээч, гэхэд ээж нь

- Онгорхой л байна шүү дээ хэмээн ажиггүй хэлчхээд дараа нь амаа барин

- Нар тусвал нүдэнд муу байх гэж бодоод цонхонд хар хөшиг татчихсан юм гэж билээ. Гэвч ээжийнх нь мэгшин уйлах дуу Сэйчид сонсогдохгүй байна гэж юу байх билээ. Бас дандаа орой, үргэлж хар хөшиг татаастай байна ч гэж юу байх билээ. Тэглээ гээд нулимсанд живэх нь ээжийнх нь нүд болохоор ээж нь Сэйчиг биш, эсрэгээр Сэйчи ээжийгээ аргадахгүй бол болохгүй юм.

- Ээж ээ, би хараагүй болсон ч хараатай ямар ч хүнд ялагдахгүй шүү.

Ингээд л хүмүүст үзүүлээд өгөхгүй бол болохгүй хэмээн юуны түрүүнд гэрийнхээ гал тогоо, хаалга үүд, гэрэл чийдэн, шүтээн тахилга зэргийн байр байдлыг гараараа тэмтрэн, хөлөөрөө хэмжиж явсаар удалгүй гэр дотроо бол урьдын адил чөлөөтэй алхахын сацуу өглөө гэрээсээ гараад үдэш харьж ирдэг боллоо.

- Хаачаад ирж байгаа юм бэ?

- Ээж ээ, би сургууль орчхоод ирлээ.

- ...Юу гэсэн үг вэ? Аюултай шүү дээ. Гэмтвэл яана?

- Зүгээр ээ, сургууль хүрдэг зам болон сургууль доторхыг би гэрээсээ дутахгүй сайн мэднэ. Завсарлаганаар Фүмио заал болон анги руу дагуулж явсан болохоор би яг л хараатай хүн шиг сайн мэдэж авсан.

- Чи тэгээд хичээлд суугаа юу?

- Тийм ээ, би хичээлээ хамгийн сайн хийсэн нь юм чинь.

• *Сэйчи яагаад хараагүй болсон бэ? Та нар өрөөдөж байна уу?*

• *"...Зөвхөн хичээл ч биш, ямар ч зүйл дээр хараатай хүмүүсийн дор орохгүй гэж шийдсэн нь яах аргагүй Сэйчигийн төрөлх дайчин зангаас нь үүдэлтэй*



*ч, нөгөөтэйгүүр ээжийгээ зовоохгүй гэж шийдсэнтэй нь холбоотой”... гэснийг уншаад чамд ямар сэтгэгдэл төрж байна вэ?*

### 3.

Ошимото багш Сэйчигийн ээжийг сургууль дээр дуудуулжээ.

- Сэйчигийн хичээл хийе гэсэн хүсэл зоригийн өмнө багш нар бүгд толгой бөхийн, нулимс унаган, өөрөө ч хичээлээ сайн хийж чадаж байгаа. Гэхдээ нүд муутай хүүхэд андуурч будилаад ямар нэг юм болбол, ар гэрт нь ч, Сэйчид өөрт нь ч хэцүү болох байх даа гэж санаад л...

- Тийм ээ, би сайн ойлгож байна. Миний л буруу. Өнөөдөр л болиульъя, маргааш л болиульъя гэж боддог ч, өглөө болохыг хүлээн яаран гарах хүүгээ харахаар өрөвдөөд байх юм.

- Харин тийм ээ. Би ч бас адилхан. Маргаашаас ирсний хэрэггүй шүү гэж яагаад ч хэлж чадахгүй. Тийм болоод л таныг дуудуулсан маань энэ. Сургуульд явалгүйгээр сурах өөр арга байгаа байх гээд л...

Энэ явдал болсны маргааш Фүмио тайтгаруулахаар ирлээ.

- Ошимото багшаас чиний тухай сонссон. Багш үнэхээр санаа нь зовж байна лээ. Би өнөөдрөөс эхлээд танайд ирж чиний хичээлийг давтуулж байя. Багшаас сонссон зүйлээ чамд яриад байвал би ч бас сайн цээжлэх байх.

- Баярлалаа, Фүмио багш аа.

- Юун багш? Шоолоод байвал больчихно шүү!

Сургуульд явахаа болилоо гээд хүсэл зорилгоо алдаагүй байгаа Сэйчиг хараад Фүмио юу юунаас илүү баярласан билээ.

Сэйчи ийнхүү Фүмиогоор дамжуулан хичээлээ үзээд явахын дээр, сэтгэл нь нүд шиг зам харгуй, гол горхийг хардаг юм болов уу гэлтэй өдөр бүр гэрээсээ гаран, энд тэнд харайж явдаг боллоо. “Өнөөдөр Сэйчиг голд сэлж байхыг хараад бүгд гайхацгаасан гэнэ” хэмээх үгийг хөрш нь ээжид нь дуулгасан орой Фүмио ч ирлээ...

...Сэйчи нүд нь хардаггүй ч гэлээ юм бүхнийг мэддэг юм чинь... хэмээн найздаа бүрэн итгэдэг Фүмиог үнэхээр алмайруулсан нэг явдал боллоо. Тэр бол хичээлийг нь давтуулах гэж өдөр бүр очих болсон Фүмио сургуульд заалгасан зүйлээсээ зөвхөн гурван зүйлийг Сэйчид ярьж чадахгүй байлаа. Физикийн хичээл дээр үзсэн сэдэв бол “Гэрэл” байв. “Гэрлийн ойлт”, “Хавтгай толь”, “Гэрлийн хугарал” гэсэн гурван сэдвийг Сэйчид ярьж зүрхлээгүй билээ. Хараагүй хүн гэж гэрэл гэгээг харж чаддаггүй хүнийг, гэрэл гэгээг алдсан хүнийг хэлдэг шүү дээ. “Гэрлийн тухай ярьж Сэйчиг шаналгахгүй ээ” гэж боджээ.

Гэтэл гурав дахь өдөр нь Сэйчи гэнэт

- Чи сүүлийн үед физикийн хичээлийн талаар ярихаа болчхов оо доо гэхэд нь Фүмио юу ч хэлж чадахгүй түгдэрлээ.

- Өнөөдөр багш гэрлийн хугарлын талаар ярьж, туршилт хийж үзүүлсэн биз дээ?

- Аа-ан? Хэнээс сонсоо вэ?

- Хэнээс сонсох юм бэ, би чинь дөрвөн нүдтэй юм чинь. Чиний өнөөдөр үзсэн туршилтын талаар би нэг яриад үзье. Алдвал засаарай. Нэгдүгээрт, саваа модыг ташуулдан усанд дүрэхэд мод хугарсан юм шиг харагддаг. Энэ бол гэрэл хугардгийн нотолгоо. Хоёрдугаарт түмпэнг наранд тавиад, ирмэгийн сүүдэр нь ёроолд нь хүрэх үеийг тэмдэглэн, усыг зөөлхөн хийхэд сүүдэр савны дотор тал руу



ойртон ирдэг. Энэ нь гэрэл агаараас ус уруу орох үедээ усны мандлаас холдох мэт хугардаг болохын баталгаа. Гуравдугаарт аяганы ёроолд зэс зоос тавиад...

- Яа... яагаад чи үүнийг мэдэж байдаг билээ? Би бүр гайхчихлаа. Уучлаарай, яриагүй нь миний буруу. Сэйчи мэрийлттэй болохоороо сэтгэлийнхээ нүдээр бүгдийг харчих юм аа.

Ийн хэлээд Фүмио өмнөх гурван хичээлээ болон гүдгэр линзний талаарх багшийн заасныг нэгд нэгэнгүй ярьж өглөө.

Туршилтын өрөөнд орсон гэж сэжиглэгдэх хүний тоонд нэгд цэвэрлэгчийн хүү Шинкичиг, хоёрт өөрийгөө оруулж бодоод гурав дахь хүнийг хайж байсан Фүмиогийн санаанд гэнэт Сэйчи орж ирлээ. Сэйчи гэрлийн хугарлын туршилтыг хараагүй мөртөө гардан хийсэн юм шиг л сайн мэдэж байдаг. Өмнө нь ангийн дарга байсан болохоор одоогийн Фүмио шиг түлхүүрүүдийн байрлалыг сайн мэдэж байгаа. Ангид хийсэн туршилтыг харж чадаагүй, тэгээд ч бас өөрөө ингэж их сонирхон шамддаг юм чинь багажуудыг барьж үзсэнээс гарцаагүй.

- Яана аа, хэрвээ тэр хүн Сэйчи байвал яана? гэж бодоход Фүмиогийн сэтгэл өвдлөө.

- *Фүмио юунд их баярлав? Та нар бас баярлаж байна уу?*
- *Сэйчигийн хажууд байвал та нар юу гэж хэлэх вэ?*
- *Туршилтын өрөөнд орсон хүн Сэйчи гэж таамаглаж байгаа Фүмиогийн зөв болов уу?*

#### 4.

Залуу мөрдөгчдийн бүлэг. Физикийн хичээл дуусав уу, үгүй юү сонирхолтой туршилт хийж чадаагүйн дээр ангиараа сэжиглэгдсэн хүүхдүүд бүгд л мөрдөгч болох нь тэр...

...Аль аль нь ахлагч Фүмиогийн бодсоноос хэтэрсэнгүй. Хэрэгтний ул мөр ч олдох янзгүй, бүгдэд хүндлэгдсэн Фүмиог хардах хүн ч гарсангүй. Сэйчиг гэж санах хүн бүр ч байхгүй болохоор Фүмио энэ нэрийг ганц ч дурдалгүй харьж ирэхэд Сэйчи мэдсэн ч юм шиг асуугаагүй байхад нь

- Өнөөдөр физикийн хичээл дээр ямар туршилт хийснийг би таах уу? гэх нь тэр.

- Төмөр ялтсыг утас шиг нарийхан хэрчээд, цэнэглэгчид холбосон зэс утсыг хоёр үзүүрт нь хүргэвэл цахилгаан гүйж, ялтасны нарийхан хэсэг улаан гал болон хайлна. Тэгээд харандаа шиг хурц үзүүртэй хоёр нүүрстөрөгчийн саваанд зэс утсаа ороон хуруу зайнд холбоод савааны үзүүрийг хөнгөхөн шүргүүлбэл гал шиг улаан болж гэрэлтдэг юм. Ингэж цахилгаан гүйдэл дулаан үүсгэн гэрэл гаргадаг үйлдлийг ашиглан чийдэнг бүтээсэн юм. Тийм биз дээ?

- Гэхдээ наад туршилтыг чинь хийж чадаагүй ээ. Хагас сайнд юм уу бүтэн сайнд хэн нэгэн туршилтын өрөөнд орж, багажийг нь эвдэн гүдгэр линз хулгайлсан байна.

- Юу уу?

Царай нь үнсэн саарал болсон Фүмио “Миний толгой өвдөөд байна. Баяртай” гэж хэлээд Сэйчигийн дуудан зогсоох гэснийг ч сонсолгүй гэр лүүгээ гүйн ирж, чанга дуугаар цурхиран уйллаа.

...Сэйчи хэчнээн сурч мэдэхийг хүсэж байгаа ч гэлээ яагаад ийм юм хийж байгаа юм бол оо? Би ингэж цорын ганц найзаа сэжиглэж болно гэж үү? Гэхдээ ангийн даргын хувьд, ангийнхныхаа төлөө хардахгүй байж болохгүй нь...

Фүмиод үнэхээр хэцүү байлаа. Сэйчигийн царайг харж чадахгүй, долоо хоног шахам давтлага ч өгөлгүй, хүнд өдрүүдийг өнгөрөөгөөд, даваа гарагийн физикийн хичээлд ирвэл, Ошимото багшийн царай үргэлжийн нүдэнд дулаан хэвээрээ, бас хагарч эвдэрсэн зүйлс цоо шинээрээ ширээн дээр өрөөстэй харагдлаа. Удалгүй багш хөнгөн инээмсэглэл тодруулан ийн ярилаа.

- Өнгөрсөн долоо хоногт та нарыг хардсанд үнэхээр уучлаарай! Өнөө өглөө арайхийн хэрэгтэн хэргээ хүлээлээ. Хэрэгтэн үнэндээ захирал байжээ. Инээж болохгүй шүү. Захирал яагаад физикийн туршилт хийх болсон юм бол? гээд яривал нулимс унагамаар сайхан яриа болно. Хагас сайн өдөр захирал гэртээ харьсан хойноо хуралд хэрэглэх бичиг баримтаа мартсанаа санаад буцаад иртэл, туршилтын өрөөний цонхон дор нэг хүү зогсож байж. Харвал танай ангийн дарга байсан Сэйчи “Ошимото багшийн туршилт хийхийг харж байна” гээд зогсож байжээ. Тэр үед туршилт дууссан байсан ч хараагүйн зовлон, хүү миний явсныг мэдэлгүй л зогсож байсан нь тэр. Тэргээр будаа зөөгөөд харьж явсан түүнээс захирал “Физикийн туршилтыг тэгж их хийж үзмээр байна гэж үү?” гэж асуухад нь “Тийм ээ, өмнө нь үүгээр өнгөрөхдөө гэрлийн хугарлын тухай лекцийг цаг орчим сонссон болохоор” гэж хариулжээ. Түүний сурч мэдье гэсэн чин хүслийг ойлгож хүндэтгэсэн захирал багш анги руу дагуулан орж, туршилт хийн үзүүлжээ. Тэгээд гарахдаа ширээгээ татаж унагаад, багажаа эвдлэн, линзээ хагалчихжээ. Өнөөдөр захирал учрыг нь хэллээ. Сэйчигийн энэ хичээл зүтгэл үнэхээр бахдууштай байгаа биз? Хүүхдүүд минь, та нар ч гэсэн ийм хичээл зүтгэлтэй байгаарай. Сурч мэдье гэх чин хүсэл, зорилго байвал хараатай байна уу, үгүй юу огт асуудал биш. Сэйчи хараатай биднээс ч илүү их зүйлийг бүтээх гайхамшигтай хүн болох нь дамжиггүй гэв.

Фүмио хамаг эрчээрээ гүйн ирж, Сэйчиг чангаар тэврэн авлаа.

- Уучлаарай! Сэйчи. Чамайг хардаж байсныг минь уучлаарай.


- Намайг ч бас. Захирал багшид төвөг удвал муухай байх гэж бодоод нуугаад дуугүй байсан юм, уучлаарай. Найзынхаа сайхан сэтгэлийг алдсан бол би сэтгэлийнхээ гэрэл гэгээг хүртэл алчих байсан юм шүү.

*(Япон хэлнээс орчуулсан Ц.Онон. “Хамар”. УБ., 2009, 85-112 дахь тал)*

3. Зохиолын утгыг мэдэрч, ойлгосноо асуултын дагуу ярилцаж бататгаарай.
- А. Сэйчигийн өөдрөг сэтгэлийн тухай ярилцаарай. Хэн түүнийг ийм сайхан өөдрөг болгосон бэ?
  - Б. Түүний хүсэл тэмүүлэл, найзыгаа гэсэн сэтгэлийн тухай уншаад юу бодож байсан бэ? Бусадтайгаа саналаа хуваалцаарай.
  - В. Фүмио яагаад Сэйчийг тэвэрч аваад уучлал хүссэн бэ? Чи Фүмиод юу гэж хэлэх вэ?
  - Г. Зохиолын аль хэсэгт сэтгэл чинь их догдолж, хөдөлсөн бэ? Яагаад?
  - Д. Сургуулийн захирлын хэлсэн үгээс чамд үргэлж санаж явах ёстой ямар сургаал байна вэ? Тэмдэглээд эргэцүүлэн хэлэлцээрэй.

**Өгүүлэгдэхүүний бүтэц, холбоо хамаарлыг дүрийн үйлдлээр тайлбарлая**

1. Дараах бүдүүвчийг ажиглаад, үйл явдлуудыг холбож байгаа зүйлсийн талаар ярилцаарай.



2. Сейчигийн чин хүсэл, зорилго, Фүмиогийн найзыгаа гэсэн сэтгэл, захирлын хэлсэн үгээс зохиолын гол санааг тодорхойлон бичнэ үү.

**Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг тодорхойлъё**

1. Ангийн даргын зан төрхийг тодорхойлохдоо 117 дугаар хуудасны хүснэгтийг дахин хэрэглээрэй.
2. Дүрийн зан төрхийн тухай ойлголтыг уншаад хосоороо ярилцаарай.

“Зан” гэдэг нь тухайн баатрын авир араншингийн давтагдашгүй шинж, “төрх” гэдэг нь тэрхүү ааш авир, бодол сэтгэлийн гадаад илэрхийлэл буюу намба төрх, үйлдэл, хэл ярианы онцлог юм”

3. Дээрх ойлголтыг ашиглан дүрийн зан чанараас төрх байдлыг төсөөлөн ярилцъя.


	Зан чанар	Хувь хүний давтагдашгүй онцлог шинж	Гадаад төрх байдал (нүдний харц, хөдөлгөөн, хурд)	Амьдралын нөхцөл байдал
Ангийн дарга				
Сейчи				

## 4.1 ӨРНИЙН УРАН ЗОХИОЛ



## Уншихын өмнө

1. “Өвгөн тэнгис хоёр” туужийг уншихын өмнө зохиолчийн намтар, уран бүтээлийн талаар товч мэдээллийг уншаад, хосоороо ярилцаарай. Өөрсдийн мэддэг зүйлийг нэмж ярилцаад, баяжуулан судлаарай.



(1899-1961)

## Эрнест Хэмингуэй

Америкийн их зохиолч Э.Хэмингуэй 1899 онд төржээ. “Зэр зэвсэг минь баяртай”, “Тавдугаар цуваа”, “Үдээс хойш үхсэн нь”, “Африкийн ногоон толгод”, “Өвгөн тэнгис хоёр”, “Хэний нь од харваж байна”, “Байх байхгүй” зэрэг олон өгүүллэг, тууж, жүжиг, роман бичжээ. 1952 онд “Өвгөн тэнгис хоёр” туужаа бичсэн нь дэлхийн олон улсад алдаршиж, 1953 онд Нобелийн шагнал хүртжээ. Энэ туужийг 1961 онд монгол хэлнээ хөрвүүлэн хэвлүүлжээ.

2. Зохиолын нэрийг уншаад үйл явдал хаана, юуны тухай өрнөхийг таамаглаж ярилцаарай.
3. Зохиолыг уншихын өмнө дараах үгийн утгыг мэдэж аваарай.  
Dentuso - аварга загасны аймгийн нэгэн загасны нэр  
Мако - аварга загасны аймгийн нэгэн загасны нэр  
Galanos - аварга загасны аймгийн нэгэн загасны нэр  
Тунц, макрель - жижиг загасны нэр



## Унших чадвараа хөгжүүлье

## Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя

1. “Өвгөн тэнгис хоёр” туужийг унших явцдаа танил биш үгийг тэмдэглэж, утгыг мэдэж аваарай.
2. Зохиолын хэсэг тус бүрд тавьсан асуултад хариулж ярилцаарай.

## ӨВГӨН ТЭНГИС ХОЁР

(Тууж)

Өвгөн гав ганцаар завиар явж, Гольфстримд загас агнажээ. Тэр наян дөрвөн өдөр тэнгист гарахдаа нэг ч загас бариагүй ажээ. Эхний дөчин өдөр өвгөнтэй нэг жаалхүү явжээ. Өдөр бүр гар хоосон ирээд байхаар нь хүүгийн эцэг эх “өвгөн лав сэло буюу огт ганзага нийлэхгүй хүн болсон байх” гээд ганзага нийлнэ гээд өөр загасчинтай явуулахад нь үнэхээр ч гурван сайн загас, эхнийхээ долоо хоногт барьжээ. Өвгөний өдөр бүр хэрхэн хоосон ирэхийг үзэх нь хүүд өрөвдмөөр хэцүү тул загасны хэрэглэл болох гох, жалан, шонд ороосон далбаагаа гэртээ аваачхад нь туслахаар эрэг дээр хүлээдэг байв.

Өвгөн биеэр туранхай ядруу, шилэн хүзүү нь гүн үрчлээс болсон, хацар нь халуун орны тэнгисийн гадаргуугаас ойсон нарны туяанаас үүсдэг арьсны өмөн үү хэмээх хоргүй өвчний хүрэн толбо болжээ. Өмөн үүгийн толбо хацрыг нь даган хүзүүнд нь хүртэл уруудаж, бас том загас татаж гаргахад татлагад хага зүсүүлсэн гүнзгий сорви нь аль хэдийн усгүй болсон цөл газрын ан цав мэт хуучин ажээ. Өвгөний нүднээс бусад нь цөм өтөлснийг илтгэх бөгөөд гагцхүү нүд нь тэнгисийн өнгөтэй адил. Хэр баргийн юманд бууж өгдөггүй хүний сэргэлэн нүд юм. Өвгөн хүү хоёр завины зогсоолоос замаар өгсөн явж байхдаа,

- Сантьяго, би одоо тантай дахиад тэнгист гарч чадна. Бид жаахан мөнгө олсон шүү дээ гэж жаалхүү хэлэв. Өвгөн, загас барихыг хүүд зааж өгсөн тул хүү түүнд хайртай билээ.

- Үгүй, чи ганзага нийлэх завь олсон болохоороо тэндээ бай гэж өвгөн хэлэв.

- Таныг наян долоон өдөр тэнгист гараад юу ч бариагүй ирэхэд дараа нь хоёулаа гараад гурван долоо хоног өдөр бүр том загастай ирж байснаа санаж байна уу?

- Санахгүй яах вэ. Чи намайг загас барьж чадахгүй гэж бодсондоо орхиод яваагүй л дээ. Би үүний чинь мэдэж байна гэж өвгөн хэлэв.

- Аан, намайг албадаж өөр хүнтэй явуулсан юм. Би одоохондоо бага хүүхэд болохоор аавынхаа үгийг дуулах ёстой.

- Тийм ээ, тэгэхгүй яаж болохов гэж өвгөн хэлэв.

- Аав ч таныг загас барина гэдгийг төдий л итгэхгүй байдаг шүү.

- Тийм. Харин чи бид хоёр барина гэдэгтээ итгэж байна. Тийм биз дээ?

- Тийм байлгүй яахав...

• *Хүү яагаад өвгөнийг өрөвдөв?*

• *Өвгөний гадаад дүр байдлыг дүрсэлснийг дахин уншина уу. Тэр хүчтэй хүн мөн үү?*

• *Өвгөн загасанд явахгүй байж болох болов уу? Заавал явахын учир нь юунд бол? Ярилцаарай.*

...Өвгөн, эргээс алс холдоно гэж урьд шийдсэн тул эх газрын үнэрийг ардаа орхиж, далайн өглөөний шинэ амьсгалын зүг сэлүүрдэв.

“... Магадгүй өнөөдөр аз дайрч мэднэ. Өдөр бүхэн адилгүй шүү дээ. Хүнд аз дайрах нь сайхан байлгүй яахав. Гэвч би өөрийнхөө ажилд яв цав байх нь зүйтэй гэж үзнэ. Харин аз заяа ирсэн цагт бэлхэн хүлээж авна даа” гэж өвгөн бодов.

...Нар улам улам хөөрсөөр, дорно зүг рүү харахад нүд төдий л гялбахаа байв. Сантьяго өвгөн илбээс загастай дэгээгээ хаяад, урсгал дагуу алгуурхан хөвөв.

...Өвгөн тэнгэр харж, фрегат шувуу тэнгис дээр дахин эргэлдэж байгааг үзээд

- Загас олж дээ гэж тэр дуугарлаа. Анх хэдийд ганцаараа ярих болсноо өвгөн эс санана. Жаалхүү одож, цор ганцаараа болсон цагаасаа хойш л ингэж ярьдаг болсон биз ээ.

... Нар хүчтэй халааж, дагзаа хэрхэн түлэгдэж байгааг өвгөн мэдэрнэ. Сэлэх үед хөлс нуруу руу нь урсана. “Би урсгалын дагуу хөвж, цаг тухайд нь сэрэхийн тулд хөлийнхөө эрхий хуруунд шижим утсаа уяад унтах юм бил үү. Гэтэл өнөөдөр наян тав дахь өдөр минь тул бэлхэн явах хэрэгтэй” гэж бодно. Яг энэ эгшинд нэг ногоон уурга чичирхийлэн, ус руу тонгойв.

- Уухай, мөн хө гээд завиа аягүйтүүлэхгүйг хичээн сэлүүрээ уснаас авлаа.



Өвгөн утас руу сарвайж баруун гарынхаа эрхий долоовор хоёроороо аяархан шүүрч барив. Тэхэд ямар ч хүч таталт гаргалгүй уг утсыг сулхан барив. Ахиад утас чичирхийлэв. Энэ удаа угзрах нь болгоомжтой хүчгүй байсан тул юу болохыг нь өвгөн яг таг мэдэв. Гох дэгээ том бус тунцын толгойноос цухуйж, үзүүр болоод толгойн цагариг нь сардин загасаар өнгөлөөстэй дэгээг тэнгисийн зуун сажин гүнд марлин загас залгиж буй ажээ. Өвгөн шижим утсыг хөнгөн барьж, зүүн гараараа болгоомжтойхон уургаас тайлав. Одоо шижим утас загсанд үзэгдэлгүй өвгөний хурууны хоорондуур гулсах бололцоотой боллоо.

“Эргээс ийм хол жилийн энэ улиралд баригдсаныг нь бодоход маш том загас бололтой. Үмх загас минь үмх, за үмхэж хайрла даа. Сардин загас шинэ усанд байхад чинь хүйтэн жаран фунт гүнд хүйтэн харанхуй шүү дээ. Харанхуй дотроо бас нэг эргээд, буцаж ирэхдээ үмх.”

Өвгөн болгоомжтой хөнгөн угзран улмаар нэлээд хүчтэй угзрахыг мэдсэнээс үзвэл нэг сардиныг гохноос салгахад бэрх байсан бололтой. Дараа нь нам гүм болов.

- За дахиад нэг эргээч. Үнэрлэ, сайхан биш байна гэж үү, сайн үмх, түүний дараа тунцыг амсах ээлж болохыг чи үзнэ. Тэр тунц хатуу сэрүүхэн амтай, идэж ханамгүй шүү. Загас минь бүү нэрэлх. Зоог барихыг хүснэм гэв. Загас нэг газраас нөгөө газар сэлэх тул өвгөн шижим утсыг эрхий долоовор хуруу хоёроороо бариад, түүний хамт бусад шидэмсийг нэг зэрэг дөнгөж мэдэх төдий татахыг нь мэдэрлээ.

- Илбээс залгиж байна. Залгих болтугай, ай бурхан гэж өвгөн дуугарав.

- Гэвч тэр загас дэгээг үмхэлгүй одсон тул утас дахин хөдөлгөөнгүй боллоо.

- “Тэр одох ёсгүй, тэнгэр минь, одох ёсгүй...” гэж өвгөн хэлэв. Гэтэл дахиад шижим утас нь татагдахад өвгөний сэтгэл уужрав.

- Зөв, эргэж байна гэж хэлсэн шүү дээ. Одоо зайлшгүй залгина! гэв.

Загас аяархан татахад өвгөн баярлаж байтал ер бусын хүчтэй татахыг мэдэв. Тэр асар том загасны жинг мэдэрч шижим утсыг тавьж, бэлтгэл нэг ороомгийг задлан улам доошоо гулгах боломж өглөө. Шижим утас хурууны нь завсраар доошоо гулсаж, өвгөн хэдийгээр түүнийг сулхан баривч, татаж буй лут хүчийг мэдэрсээр байв.

...Хоёр гараар ээлжлэн татан татсаар загасны угзрах болгонд гар биеийнхээ бүх хүчийг шавхан ажиллав. Загас аажуухнаар холдоход өвгөн ямх ч ойртуулж чадсангүй.

...Завь баруун хойшоо үл мэдэг хөдөлж эхлэв. Загас хөвсөөр хөвсөөр, тэд толь шиг тунгалаг усан дээгүүр аяархан хөдөлсөөр ажээ.

“Ай жаалхүү надтай цуг байсан болоосой доо. Загас намайг чирээд, би загасанд чирэгдээд явж ч байх гэж. Дэгээнийхээ утсыг завинаас уячихъя гэхээр загас тасалчихна. Иймд би түүнийг чанга барьж, хэрэгтэй цагт нь сулруулж байх ёстой...” гэж бодов.

“Удахгүй энэ загас үхнэ. Удаан хөвж чадахгүй” гэж өвгөн бодовч даруй дөрвөн цаг өнгөрөхөд загас ч алжаахыг мэдэхгүй тэнгис рүү одож, өвгөн, утас нуруун дээгүүрээ давуулан суудалдаа суусан хэвээрээ билээ.

Үд болж байхад үүнийг барьсан ч гэсэн одоо болтол барааг үзсэнгүй. ...Нар шингэтэл хоёр цаг үлджээ. Хэнтэй хүч үзэж яваагаа мэдэхийн тулд түүнийг нүднийхээ булангаар ч атугай харах сан” гэж бодов...

- *Загас барихын тулд өвгөн хэрхэн чармайж байна? Юу бодож байна? Та нар энэ хэсгийг уншаад юу бодов?*

...Одны байрлалаар өвгөний багцаалахад загас бүхэл шөнөжин чиглэлээ өөрчлөлгүй хөвжээ. Нар шингэснээс хойш хүйтэрч, өвгөний нуруу, мөрний хөлс хатаад хөл бие нь даарсхийв.

...“Энэ загас хэд насалсныг ганцхан тэнгэр л мэдэх гайхамшиг биш үү. Маш ухаантай учир цовхчихгүй яваа байж мэднэ. Хэрэв харайх буюу бүх хүчээрээ урагшаа давхих ахул намайг алах болно. Нэг бус удаа гох дэгээнд орсон тул амьдрахын төлөө ингэж тэмцэх нь илүүтэй гэж ойлгож яваа байж магадгүй. Түүний эсрэг ганц хүн, нэг өвгөн явааг яаж мэдэх билээ” гэж бодов.

Нэг удаа эм марлиныг барьснаа саналаа. Эр нь эмийгээ түрүүн хоолонд оруулах тул гохонд орсон эм нь айсандаа аймшигтай улангасан тэмцэж амархан тамирдахад, эр нь түүнээс нэг ч алхам хоцролгүй хөвж тэнгисийн гадарга дээр эргэлдсээр байж билээ. Эр загас нь тун ойртоход гар хадуур адил, хурц сүүлээрээ утсыг минь тасалчих вий гэж өвгөн эмээжээ. Өвгөн, эм загасыг гохоороо гохдож жад шиг арзгар шүдтэй амы нь татаж байгаад толгойны нь өнгө, толины ар талыг өнгөлдөг амальгамтай адил болтол бороохойдож, жаалхүүгийн тусламжтайгаар завь дээр гаргатал тэр загас хажууд нь байсан юмсан. Дараа нь өвгөн утсаа ороож сэрээн жад бэлтгэхэд эм загасныхаа ясыг үзэхээр эр завины орчим агаарт өндөр үсрэхэд, цээжнийх нь сэрвээний нэлдүү цайвар далавч дэлгэгдэж, нурууны нь өргөн нил судал тодхон үзэгдсээр ус руу гүн орж билээ. Өвгөн түүний цуутай гуа сайхныг огт мартсангүй. Тэр загас эцсийг нь хүртэл ханиа орхиогүй юм шүү.

“Миний бие, тэнгист үүнээс гунигтай зүйлийг нэг ч удаа үзээгүй билээ. Бас жаалхүү гуниглаж, хоёулаа эм загаснаас уучлал гуйгаад, түүнийг даруй хуваан авч билээ” гэж өвгөн бас бодов.

- Жаалхүү надтай яваагүй нь харамсалтай гэж өвгөн дуугараад, завины хушууны дугуй банзан дээр тохитой сууж, ямар нэгэн юм зорин тасралтгүй довтолж буй том загасны лут хүчийг мөрөө даруулсан утсаар дамжуулан цаг ямагт мэдэрсээр явлаа.

- Бодоход, энэ загас миний муу мэхнээс болж хувь зохиолоо өөрчлөхөд хүрчээ.

“Түүний хувь зохиол гэвэл элдэв илбээс өдөөл, хүний муу ов, алс далайн харанхуй гүнд байх билээ. Миний хувь зохиол гэвэл ганцаараа түүнийг агнахаар гарч, нэг ч хүний нэвтрээгүй газраас олох байжээ. Ертөнцийн хүн ганцхан биш. Одоо яг үд дундаас эхлэн бид хоёр хэн хэнтэйгээ холбогджээ. Бид хоёрт хэн ч туслах нь өнгөрчээ” гэж бодно.

Цаашилбал “Над загасчин болох хэрэггүй ч байсан байж мэднэ. Гэтэл би түүний тулд төрсөн. Үүрээр тунцаа идэхийг мартахгүй юмсан” гэх мэтээр бодов.

Нар мандахын өмнөхөн ар талын нь нэг өдөнд загас оров. Уурга хугарч, утас завины тэвшний ирмэг дээгүүр гулсах нь сонсогдов. Тэр, харанхуйд хутгаа хуйнаас нь сугалж, том загасны таталтын бүх хүчийг мөрөндөө шилжүүлж, ар тийшээ эргэн уг утсыг тас огтоллоо. Дараа нь хажуу талын утсаа тас огтолж, харанхуйд бэлтгэл ороомгуудынхаа үзүүрийг бат бэх залгаад сайн зангилаа гаргахын тулд ороомог утсыг хөлөөрөө даранхан, өрөөсөн гараараа чадмаг ажиллав. Өвгөн одоо саяын огтолсон хоёр утасны хос хос ороомог, загас гоходсон утасны хос ороомог, бүгд харилцан залгаатай зургаан бэлтгэл ороомогтой боллоо.

...Өвгөн утсыг сайтар татахыг оролдтол, загас барьсан цагаас хойш чинээндээ тултал татагдсан тул улам чангалахаар гэдийхэд нурууг нь өвтгөн ер бүтэхгүй санаа болох нь мэдэгдлээ.

“Угзарч болохгүй. Алив угзралт гох дэгээний гаргасан шархыг лавшруулж, загасны ил гаргахад гох мулт үсэрч мэднэ. Ямар ч гэсэн миний бие санаснаас дээр яваагаа мэдэрсээр бөгөөд нар гийж байхад энэ удаа түүнийг харах хэрэг алга” гэж бодно.

...Загас гэнэт ухасхийж, өвгөнийг завины хушуу руу унагасан ба хэрэв өвгөн завины хажууг гараараа тулж, барьсан утсаа тавиагүй бол нь завины ирмэг дээгүүр татаж гаргах сан билээ. Утсыг угзрахад шувуу нисэж хэрхэн түүний алга болсныг өвгөн ч ажсангүй. Тэр баруун гараараа утсаа тэмтрэхдээ гараасаа цус гарч байгааг үзэв.

- Загасанд өвчтэй болсон нь магад гэж дуугараад, загасыг өөр зүгт хандуулж чадах эсэхээ шалгахаар уг утсыг татлаа. Тэрхүү утсыг угт нь тулган татаад, урьдынхаа байдалд орж тайван болов.

...Зүүн гарын нь шөрмөс хэдий татсан боловч өвгөн түүнийг аяархан хөдөлдөг болгож амжжээ. “Хэрэв жаалхүү надтай явсан бол гарыг минь тохойноос доош үрж өгөх сөн. Гайгүй, ингээд өөрөө эдгэчихнэ” гэж бодоод, утасны ус руу орсон өнцгийн өөрчлөлтийг анзаарахаас өмнө баруун гарын нь татаж байсан хүч суларсан нь мэдэгдлээ. Тэр ар тийшээ гэдийж, зүүн гараараа хар хүчээрээ гуяа алгандангуут утас аажуухан дээшээ гарч байгааг үзэв.

- Гарч байна. Гар минь хурдан сэрээч!

Улам улам урт утас гарсаар, завины урд талын тэнгисийн гадаргуу овойж, нөгөө загас ил гарлаа. Тэр загас эх захгүй мэт гарсаар, гарсаар, хоёр талаар нь усны урсгал хуйларна. Түүний бүх бие нь наранд гялалзаж, толгой түрүү, нуруу нь хар ягаан, хурц гэрэлд хажуу талын нь судал маш өргөн, нэлдүү өнгөтэй мэт үзэгдэнэ. Түүний хамрын оронд бейсболын цохиур мод шиг урт, үзүүрээрээ жад шиг хурц илд байна. Тэр байдгаараа ил гараад, дахиад усчин шиг чимээ далд ороход, тарианы хадуур шиг иртэй асар том сүүл нь дөнгөж үзэгдэхээ баймагц ороомог утас маш хурдан тавигдаж эхлэв. Өвгөн:

- Миний завиас даруй хоёр фут урт юм гэлээ. Утас тэнгис рүү орсоор буй ч загас ер айж сандарсангүй бололтой жигдхэн доошилсоор байна. Өвгөн хоёр гараараа тэрхүү утсыг тултал нь татсаар байв. Өвгөн хэрэв ийм жигд эсэргүүцлээр загасны явцыг удаашруулахгүй бол бүх бэлтгэл утсыг нь дуустал тавиулж тасална гэдгийг нь мэднэ.

“Энэ аварга том загас юм. Би түүнд хүчтэй гэдгээ итгүүлэх ёстой. Тэрбээр миний тамиргүйг мэдэж, хэрэв дутаах ахул хүссэн бүхнээ бүрэлдүүлж чадах юм гэдгийг түүнд мэдэгдүүлж болохгүй. Хэрэв би түүний оронд байсан бол юм бүхнээ тодорхой болгоод, ямар нэгэн зүйл эвдэрч сүйдтэл урагшаа довтлох сон. Гэвч бурхны авралаар загас, хэдий хүнээс гавшгай, сайн төрөлтэй боловч, өөрсдийг нь алдаг хүмүүсээс төдий л ухаантай биш юм даа” гэж бодов.

Өвгөн энэ яваа насандаа олон том загастай золгожээ. Тэр, хоёр мянга илүү фунт жинтэй загас олныг үзсэн бөгөөд өөрөө хоёр тийм загас барьсан боловч, ганцаараа үйлдэж огт яваагүй билээ. Одоо их далайд урьд өмнө хэзээ ч үзэж хараагүй, хэзээ ч сонсож дуулаагүй тийм том загастай бат бөх холбогдоод, бүргэдийн атгасан савар мэтээр зүүн гарын нь шөрмөс таталдаж яваа ажээ.

Тэгээд юу ч идэхгүй яваа том загасыг өрөвдлөө. “...Энэ загас том тул үүнд их хоол хэрэгтэй. ...Би бүхэл бүтэн тунц идсэн. Маргааш макрель иднэ...”

...”Өвгөн минь чи унтаагүй шүү дээ. Хагас өдөр, нэг шөнө, бас нэг өдөр өнгөрөхөд чи унтсангүй. Загас дүрсгүйтээгүй талбиун тайван үед унтахыг бод.

Хэрэв чи унтахгүй бол ухаан санаа чинь самуурна”. ... Өвгөн завины ирмэгийг налж загасны таталтын хамаг хүндийг баруун гартаа үүрүүлээд унтлаа. ... Тэрхэн эгшинд загас ил гарч далайн гилгэр гадаргууг зад татсанаа дахиад тэнгисийн гүн рүү асар хүндээр живэв. Загас өвгөнийг завины хушуутай наалдтал татаж, нүүрийг нь макрелийн махтай нийлүүлсэн тул хөдөлж үл чадна.

...Түүний тэнгист гарснаас хойш гурав дахиа нар мандаж, загас ч холоуур дугуйран эргэж эхлэв. “... Хоёр гурван дугуйралтын дараагаар загас минийх болно. ...Би нэгэн загаснаас гэнэдэж үхэх гэж үү? Бүгд бүтэмжтэй байгаа энэ үед гол нь үхэх гэж үү. Бурхан тэнгэр, тэсвэрлэхэд минь тусал...” гэж үглэнэ.

...Тэр гурав дахин дугуйрахад нь загасыг үзэв. Загас завинд ойртохоос нэлээд өмнө хамаг хүчээ шавхан хар тэнхээгээрээ татлаа.

...Өвгөн утсаа хаяж хөлөөрөө гишгээд чадлынхаа хэрээр сэрээн жадаа дээш нь өргөж, түүнд байсан болоод тэр мөчид цуглуулж чадсан бүх хүчээ шавхан тэнгисээс дээш хүний цээжний хэртэй цухуйсан аварга сэрвээний ар хажуу руу шаав. Тэр төмөр зөөлөн маханд орж байгааг мэдрэн сэрээн жадаа тулж, бүх биеийнхээ жингээр туслан улам улам гүн суулгалаа. Тэгэхэд нь загас хэдийгээр үхлийн шарх олсон боловч өөрийн асар урт өргөн бие, бүх гуа сайхан, чадал тэнхээгээ үзүүлэх гэсэн мэт уснаас дээш үсрэв. Өвгөн завь хоёр дээр агаарт өлгөгдөх болсноо далайд нирхийн унаж, өвгөн ба завийг усны урсгалаар дарав. ...Сэрээн жадны бариул нуруунд нь ташуу санжганаж, зүрхний нь цусанд эргэн тойрны далай тэнгис ув улаан болжээ.

“...Завь ийм хүнд ачааг даахгүй, загасыг зах ирмэгт нь татаж бөх хүлээд ум хумгүй одох ёстой. ...Энэ загас хагас тонноос багагүй, нэлээд илүү ч байж мэднэ, хэрэв бүх жингийн гуравны хоёрыг мах гэж бодоход фунтийг нь гучин центээр өгвөл хэчнээн доллар болох вэ” гэж бодов.

Өвгөн загасыг завины хушуу, хитэг, суудалд уяв. Тэр загас завийг том хөлөг онгоцны ирмэгт уяв уу гэмээр тийм том ажээ...

- Бурхан хараг гээд хэдийгээр энэ загас гайхалтай боловч, түүнийг үхүүлэхийг ариун гэгээн эх дагина минь айлтга гэж залбирав.

Энэхүү залбирал уншаад, өвчин нь багасах байтугай магад улам хүчтэй болсон боловч бие нь хэдэн хувь сайжирсан мэт санагдаад завины хушууны туурга налан сууж, зүүн гарынхаа хуруугаар санамсаргүй дасгал хийж эхлэв. Хэдийгээр урин салхи аажуухан хүчтэй боловч нар төөнөсөөр байлаа.

- Тэртээ тэргүй би түүнийг том ч байсан, жижиг ч байсан, сайхан ч байсан ялна гэлээ. “Хэдийгээр энэ нь шударга бус үйл боловч, хүн юу чадах, юу тэсвэрлэн давахыг нь чамд үзүүлнэ” гэж дотроо боджээ.

- Би жаалхүүд, ер бусын өвгөн гэдгээ хэлсэн биз дээ. Одоо түүнийг нотлох цаг ирэв гэлээ.

- Үүнийг мянга дахин нотолсонд нь ямар ялгаа байна вэ? Одоо дахиад нотлох хэрэгтэй юу? Хийснээ тус бүрд нь шинээр тооцоолох тул өвгөн өнгөрснийг үл санана.

Энэ загас унтахлаар би ч бас унтаж, зүүдэн дотроо арслан үзэхийг хүснэм. Яагаад арслан миний санаанд төрсөн юмны дээж болж хоцроов” гэж бодов.

- Өвгөн минь бодол болох хэрэггүй. Банз налаад чимээгүй амар. Юуны ч тухай бүү бод. Загас хөдөлмөрлөсөөр байна. Чи одоохондоо аль болох бага хөдөлмөрлө гэж өөртөө захилаа.

Нар шингэх дөхөвч, завь аяархан, тасралтгүй хөвсөөр байна...



- *Өвгөн ямар үед хүүг санаж байна? Хэрэв чи өвгөний хажууд байсан бол ямар үед нь яаж туслах байсан бэ?*
- *Өвгөн өөрөө өөртэйгөө хэрхэн ярьж, өөрийгөө хэрхэн зоригжуулж байна?*
- *Өвгөнөөс биеийн болоод сэтгэлийн их хүч чадал гарч байгаа хэсгийг олж, тэмдэглээрэй.*
- *Ганзага хоосон олон өдрүүдийн дараа том загас барьсан өвгөний өмнөөс та нар баярлаж байна уу?*
- *Том загасыг барьснаас хойш өвгөн хэд дэх өдрөө унтаагүй явааг тооцоолж үзнэ үү. Үүний тулд нарны мандах шингэхийг өгүүлсэн өгүүлбэрүүдийг зурж тэмдэглээрэй.*
- *Тэнгист ганцаар яваа өвгөнд өөр ямар аюул тулгарч болох вэ?*

...Тэд хөвсөөр л байв. Өвгөн ухаанаа самууруулахгүйг хичээж гараа давстай усанд дүрнэ. Тэмээн үүл хурдан нүүж, түүн дээгүүр өдөн үүл хөвөхөд өвгөн бүхэл шөнөжин салхилахыг мэджээ. Тэр, үнэндээ зүүдлээгүй гэдгээ шалгахын тулд загасаа үе үе харна. Түүнийг түрүүчийн аварга загас гүйцтэл бүхэл бүтэн цаг өнгөрөв.

Аварга загас түүнийг санамсаргүй гүйцээд ирлээ. Загасны цус хар үүл мэт өтгөрч, усны бүхэл бүтэн миль гүнд нэвтрэхэд, их далайн гүнээс тэр аварга загас нэхэн хөвжээ. Тэр аварга загас, тэнгисийн толигор хөх гадаргууг ямар ч аймшиггүй зүсэж, наранд ил гараад маш хурдан хөвөн ахиад усанд шумбаж цусны үнэр аваад загас, завь хоёрын үлдээсэн мөрөөр хөвнө. Үе үе мөрийг нь алдавч, дахин түүнийг олох буюу мэдэгдэх төдий үнэр авч, шантралгүй нэхнэ. Энэ нь тэнгисийн хамгийн хурдан загас хөвөхийн адил тийм хурдан самрах тавилантай Мако угсааны том аварга загас бөгөөд амнаас бусад бүх бие нь гуа сайхан, нуруу нь илд загастай адил хөх, хэвэл нь мөнгөлөг, арьс нь гилгэр гуа, хэрэв одоо нягт жимийгээстэй асар том эрүүг нь бодохгүй бол бүх талаар илд загастай төстэй ажээ.

Тэр аварга загас, нурууныхаа өндөр сэрвээгээр усыг амархан зүсэж тэнгисийн гадаргууд маш хурдан хөвнө. Түүний амны нягт жимийгээстэй хос уруулын цаана ташуу суусан шүдний найман эгнээ бий. Шүд нь ихэнх аварга загасны жирийн гурвалжин шүдтэй адилгүй, араатны хумс шиг махийсан нь хүний хурууг санагдуулна. Уртаараа өвгөний хуруунаас богиногүй бөгөөд хажуу талдаа сахлын машины хутга шиг хурц хутгатай ажээ. Хөдөлгөөнтэй хүчтэй, сайн зэвсэглэсэн загаснаас эхлээд далайн бүх загасаар хооллохын тулд ямар ч дайснаас айхгүйгээр аварга загас бүтээгджээ.

Одоо тэр олз хишиг холгүйг үнэрлэн довтолж, нурууны нь цэнхэр сэрвээ усыг зүснэ. Өвгөн тэр аварга загасыг үзмэгц, юунаас ч айхгүй бөгөөд яаж заяаснаар нь үйлдэнэ гэдгийг ойлгожээ. Тэр сэрээн жадаа бэлтгэж, ойртохыг хүлээн аргамжийн үзүүрийг бэхлэв.

Өвгөн аварга загасыг хэрхэн ойртохыг ажиглах зуур том загасаа нэг ширвэлээ. Аварга загас бараг хитэгт тулж, загас руу довтолоход ангайсан ам, ер бусын нүдийг нь үзэж, загасны сүүлээс дээхнүүр маханд шигдсэн эрүүний хавирахыг сонслоо. Усан дээр аварга загасны толгой, улмаар нуруу нь ялгарч, том загасны арьс махыг хэрхэн дуутай шуутай таслахыг сонсоод, толгой дээр нь нүдийг нь холбосон шугам, хамраас нь дээш одсон шугам хоёрын бэлчир газар сэрээн жадаа зоов. Үнэндээ тийм шугам байсангүй. Зөвхөн хүнд хавчиг хөх толгой, том нүд, ...бүхнийг идэх



эрүүтэй ажээ. Гэвч тэр хэсэгт аварга загасны уураг тархи байгаа тул өвгөн сэрээн жадаа хатгасан ажээ.

Цус гартал зүсэгдсэн гартаа сэрээн жадаа атгаад хар хүчээрээ цохижээ. Түүнийг цохихдоо юунд ч найдахгүй, эрс шийдмэг уур хилэнгийн хорслоос цохижээ.

Аварга загасны эргэлдэхэд гал нь унтарсан нүдийг өвгөн үзэж, улмаар тэр загас эргэлдэн утсыг хоёр дахин биедээ ороожээ. Өвгөн үхсэнийг мэдсэн бөгөөд загас түүнтэй эвлэрэхийг хүсээгүй билээ. Нуруугаа хэвтээд, шарван эрүүгээ хавиран, уралдааны завь мэт цагаан хөөс цахруулав. Түүний сүүлээ шарвасан тэнгис цагаан болж, аварга загасны их биеийн дөрөвний гурав нь уснаас дээш өргөгдөөд утас нь сунаж чичирхийлсээр тасарлаа. Аварга загас усны гадаргуу дээр хэвтэхийг өвгөний харсаар байтал тун аажуухан дорогшлов.

- Загасны дөчин фунт орчим махыг авч одлоо гэж өвгөн дуугарлаа. “Энэ загас миний сэрээн жад, утасны минь үлдэгдлийг далайн ёроолд аван одож, том загаснаас цус гоожоод саяын аварга загасны мөрөөр бусад аварга загаснууд ирнэ” гэж нэмж бодов. Одоо тийнхүү зэрэмдэглүүлсэн загасыг дахин харахыг тэр эс хүсэв.

Аварга загасны том загас руу довтолох нь түүнийг өөрийг нь довтолсон мэт байж билээ.

“Гэвч би миний том загасыг довтолсон аварга загасыг ямар ч гэсэн сөнөөлөө. Энэ бол миний хэзээ нэгэн цагт үзсэн Дентусороос хамгийн том нь юм. Үнэн гэм. Би амьдралдаа нэг бус том аварга загастай тохиолдсон. Миний хэрэг үйлс хэтэрхий сайн бүтэж билээ. Цаашид тэгж бүтэх номгүй юм. Энэ бүхэн зүүд байж, би нэг ч том загас барилгүй, сонин дэвсээстэй орон дээрээ ганцаараа унтаж байхыг хүснэм” гэнэ.

- Гэвч хүн ялагдахын төлөө төрөөгүй юм. Хүчийг устгаж болох боловч түүнийг ялж болохгүй юм гэлээ.

“Том загасыг алсан минь харамсалтай. Миний бие сэрээн жадаа хүртэл гэсэн тул хэцүүднэ дээ. Dentusor бол гавшгай, хэрцгий, ухаантай, хүчтэй амьтан. Гэвч би түүнээс илүү ухаантай байжээ. Ухаантай биш ч байж магад. Зүгээр л илүү зэвсэглэсэн ч байж магад”

“...Би амьдралаа хамгаалж, түүнийг алсан. Тэгээд бас уран чадмаг алсан. Бүгд л хэн нэгнийг юм уу ямар нэг амьтныг алж байдаг. Загас агнуур яг үүнтэй адилаар намайг алж, үхэх бололцоо өгөхгүй байна. Жаалхүү, тэр л намайг үхүүлэхгүй байна. Өвгөн бүү нялгана” гэж бодлоо.

...Өвгөн алсын бараа харавч нэг ч далбаа, утаа, мөн түүнчлэн хөлөг онгоцны их биеийг үзсэнгүй. Гагцхүү хавтгай хоншоортой толгой, цагаан эмжээртэй сэрвээнүүдийг үзлээ. ...Galanos! гэж дуу алдав. Эдгээр нь бүх аварга загаснуудын хамгийн булай нь болох хүүр иддэг өмхий алуурчид бөгөөд өлссөн үедээ завины сэлүүр, залуурыг ч хазахад бэлэн. ...Тэд хөвж ирэхдээ макотой адил хөвж ирсэнгүй. Нэг нь гялсхийн усан доогуур орж, загасыг зулгаахад завь чичирхийлэхийг өвгөн мэдрэв. Нөгөө нь жартгай шар нүдээрээ өвгөнийг ажигласнаа амаа том ангайгаад, макогийн зулгаасан газар луу дайрлаа. Хүрэн толгойных нь нугасны нуруутайгаа нийлсэн газар луу сэлүүрт углаастай хутгаа зоогоод, дахин сугалаад муурын нүд мэт шар нүдэнд шаав. Аварга загас аахилан том загаснаас унаж, хазсанаа залгилан доошоо гулслаа.

Нөгөө аварга загас загасны доод талаас зулгаахад нь завь чичирхийлсээр байна. Өвгөн түүнийг аргалж загасан доороос гаргахын тулд далбаагаа буулган

завиа хажуугаар нь эргүүлээ. Үзмэгц завины ирмэг дээгүүр бөхийж хутгалаа. Зөөлөн газар нь оносон тул хатуу арьс нь гүн шигдэх боломж өгсөнгүй. Цохихдоо өвгөний гар төдийгүй, нуруу нь өвджээ. Гэтэл аварга загас амаа уснаас гарган ахин довтолоход, өвгөн хавтгар толгойных нь яг голд цохилоо. Тэгээд хутга сугалж яг тэр газраа дахин шаав. Аварга загас эрүүгээ тас зуун том загасанд өлгөөстэй хэвээрээ байхад, өвгөн хутгаа нүд рүү нь шаалаа...

...Үдэш болох ойртож, эргэн тойрон зөвхөн тэнгэр тэнгис хоёр л цэлийнэ. Салхи урьдынхаас ч хүчтэй салхилахад удахгүй газрын бараа үзнэ гэж найдав... “Манайхан ихэд санаа зовж байгаа байх даа. Тэгээд жаалхүү л санаагаа зовоож байгаа биз дээ. Тэр ч над лав эргэлзэхгүй. Би ч сайн улсын дунд амьдарч байгаа шүү” гэж бодно.

... Аварга загаснуудтай шөнө дөлөөр ахин тулалдав. Энэ удаа түүнийг тэд бүхэл сүргээрээ довтолжээ.

...Өвгөн үзэгдэх, сонсогдох, үнэртэх бүхнийг галзуу мэт бороохойдсоор, бороохой ч байхгүй болсноо мэджээ. Тэрээр залуур хөшүүргээ сугалаад хоёр гараараа барин дээр дээрээс нь цохиж балбажээ.

Аварга загаснууд олзоо дахин дахин эргэж довтолно. Нэгэн аварга загас том загасны толгойн тушаа ирэхэд өвгөн бүх хэрэг шувтарсныг сая мэджээ. ...Сүрэглэж довтолсон аварга загасны сүүлч нь тэр юм. Түүнд идэх юм юу ч үлдсэнгүй.

...Шөнө аварга загаснууд дахин ширээн дээрээс хоолны шавхруу хамах ховдог хомхойчуул адил том загасны мөлжүүлсэн араг яс руу дахин довтолжээ.

- *Аварга загастай тулалдсан өвгөний тэмцлийг төсөөлж байна уу? Өвгөн энэ удаад хэрхэх бол?*
- *Энэ бүхний эцэст өвгөн, аварга загас хоёрын аль нь ялах бол? Өөрсдийн бодлыг нөхөдтэйгөө хуваалцаарай.*

...Өвгөн завинаасаа өөр юуг ч анхаарахаа байжээ. Загасны лут хүнд жин саатуулахаа больсноос хойш завь хэчнээн хөнгөн, чөлөөтэй явах болсныг ч мэдсэн юм. “Сайн завь шүү...” гэж бодов.

...Өвгөн дулаан урсгалд орсноо мэдэрч, эргийн сууринуудын гал үзэгдэв. Тэр гэрийнхээ хаа орших, яаж хүрэхийг мэдэх тул харихад ямар ч бэрхшээлгүй болжээ. “Салхи бидний нөхөр болох нь магад, гэхдээ үргэлж биш. Их тэнгис бас бидний нөхөр, дайсан хоёроор дүүрэн юм...Дэвсгэр бол миний нөхөр. Ялангуяа жирийн дэвсгэр шүү. Ор дэвсгэртээ орно гэдэг агуу хэрэг. Ялагдсан хүний сэтгэл юутай хөнгөрнө вэ? Ийм хөнгөрөх юм гэдгийг би мэдээгүй. Өвгөн чамайг хэн ялав?” гэж сэтгэлдээ нэмж бодсоноо,

- Хэн ч ялаагүй. Би тэнгист хэтэрхий хол гарчаж гэж хариулав.

Түүнийг бяцхан зогсоолд хүрэхэд Террасын гал унтарсан байсан тул цөм унтаж байгааг нь мэдлээ.

Салхи улам ширүүссээр...Зогсоол дээр хэн ч алга. ...Өвгөн завинаасаа гарч завиа хаданд уялаа.

Шонгоо авч далбаагаа ороож уяад мөрөн дээрээ тавьж уул өгсөв. Тэр эгшин зуур зогсоод эргэж харахад, гудамжны дэнлүүний гэрэлд том загасны аварга сүүл, хэрхэн завины хитэг дээгүүр дээш өргөгдөж буй нь үзэгдэв. Сээр нурууны нь мөлжүүлсэн цагаан зурвас урагшаа гарсан илдтэй толгойны нь хар сүүдрийг үзэв.

...Овоохойгоо хүртэл даруй тав амарч хүрлээ. Тэр гэртээ ормогцоо шонгоо хана түшүүлээд харанхуйн дундаас шилтэй ус олж уув. Орондоо орж, бүтээлгээ мөр лүүгээ татаж, нуруу хөлөө хучаад нүүрээрээ сонин хатган гарынхаа алгыг дэлгэн сунгаад унтжээ.

Өглөө жаалхүү овоохой руу шагайхад тэр унтаж байв. Салхи маш хүчтэй үлээж нэг ч завь тэнгист гараагүй тул жаалхүү өглөө бүр өвгөний овоохойд ирдгээрээ иржээ. ...Завийг нь өдий төдий загасчин тойрч, түүнд юу уяатай байгааг цөм харж, нэг загасчин өмднийхөө шуумаг шуун усанд зогсоод араг ясы нь олсоор хэмжиж байна.

...Өвгөн сэржээ.

- Манолин, тэд намайг дийлсэн, тэд намайг ялсан гэхэд жаалхүү:

- Тэр таныг өөрөө дийлж чадаагүй шүү дээ. Загас таныг ялаагүй шүү дээ гэв.

Өвгөн тэнгисээс гадна ярилцах хүнтэй байгаагийн юутай тааламжтайг ухаарлаа...

(Товчлон авав)

(Э.Хэмингуэй. "Өвгөн тэнгис хоёр". Орчуулсан С.Сандагдорж, УБ., 1962)

3. Өвгөн, аварга загасыг агнах үед төрсөн мэдрэмжээ хуваалцаарай.

Бусадтай хамтран гүйцэтгээрэй.	
Өвгөн загас хоёрын тэмцлийн үед та нарт юу сонсогдсон бол? Өвгөний дуу хоолой ямар байсан бол? Тэнгис хэрхэн дуугарч, давалгаалж байсан бол? Загас дуугарсан болов уу?	
Аварга загасыг агнах үеийн тэнгисийн өнгө хэрхэн өөрчлөгдсөн бол? Унших үед юу харсан, түүнийгээ өнгөөр илэрхийлээрэй.	
Загасны биед хүрээд үзсэн гэж бодоход юу мэдрэгдэж байна? Зохиолоос үг хэллэг хэрэглэн төсөөлөөрэй.	

**Өгүүлэгдэхүүний бүтэц, холбоо хамаарлыг дүрийн үйлдлээр тайлбарлая**

1. Зохиол дахь зөрчлийг олж, тайллыг хэрхэн шийдвэрлэсэн бэ?
2. “Хүн ялагдахын төлөө төрөөгүй юм. Хүчийг устгаж болох боловч түүнийг ялж болохгүй юм” гэж өвгөний хэлсэн үгийг багаараа хэлэлцээрэй.
3. Бүдүүвчийн дунд үйл явдлын холбоог түлхүүр үгээр илэрхийлээрэй.

Өвгөн

Аварга загас



Бичих чадвараа хөгжүүлье

**Зохиолд үйл явдал нэмэн дэлгэрүүлж бичье**

Дараах зааврын дагуу үйл явдал нэмж бичээрэй. Үүнд:

1. Уншсан зохиолуудаас аль нэгийг үйл явдал нэмэн дэлгэрүүлэн бичих зорилгоор сонгоно уу.
2. Юуны тухай өгүүлэхээ төлөвлөөрэй, хэлэлцээрэй.
3. Уншигчдад юуг хэлэхийг хүсэж байна вэ? Хэлэлцээрэй.
4. Зохиоходоо ямар үгийг сонгож бичихээ бодоорой.

5. Зохиохдоо эхлэл, өрнөл, төгсгөл хэсгийн алинд нь нэмэхээ төлөвлөөрэй.
6. Ноороглож бичээд бусдадаа уншуулж, зөвлөж ярилцаарай.
7. Ноороггноо сийрүүлэн бичиж засварлаарай.
8. Үсгийн дүрмийн болон найруулгын оновчгүй байдлаа хянаарай.
9. Найруулгын алдааг засахдаа дараах шалгуурыг хэрэглэнэ үү.

	Тийм	Үгүй	Сайжруулах саналтай байна
Уншихад ойлгомжтой байна уу?			
Үгийн үндсэн утгыг шилжүүлж, өөр утгатай үгээр сольсон уу?			
Үгийг нэммээр байна уу? Ямар үг нэмэх вэ?			
Үгийг хасмаар байна уу? Ямар үг хасах вэ?			
Үгийн байрлалыг солимоор байна уу?			



Ярих чадвараа хөгжүүлэе

**Зохиолын дүрийн талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан сонирхол татаж сэтгэлд хүрэхээр ярь**

Ангийн хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг анхааралтай ажиглан сонсож, тодруулах асуулт тавьж оролцох

1. Сонгосон зохиолынхоо дүрийн зан чанарыг тодорхойлоорой.
2. Хэлэлцүүлэг хийхдээ
  - Асуудлаа олж хараарай. Тухайлбал, Өвгөн Сантьяго яагаад том загас сонгож авсныг хэлэлцээрэй.
  - Асуудлаа боловсруулаарай.
  - Асуудлаа нэгтгэн, шийдвэр гаргаарай.
3. Ярих чадвараа дараах шалгуураар дүгнээрэй.

	Маш сайн	Хангалттай	Дахин сайжруулах шаардлагатай гэж бодож байна.
Хэлэлцүүлэгт саналаа нэмэрлэсэн үү?			
Асуудлыг олж харж чадсан уу?			
Зохиолоос жишээ баримт татаж ярьсан уу?			
Шийдвэр гаргаснаа ойлгомжтой илтгэж чадсан уу?			



Уншихын өмнө



(1965)

**Ж.К.Роулин**

1965 онд Англид төржээ. Тэрээр "Харри Поттер", "Квиддичийн түүх", "Гайхалтай амьтад ба тэдний оршдог газар", "Бидлийн үлгэрүүд" зэрэг ном бичжээ. Түүний хүүхдийн уран зохиолд оруулсан хувь нэмрийг үнэлж Ханс Андерсений шагнал, Францын хүндэт легионы одонгоор шагнажээ.

*Зохиолыг уншихын өмнө зохиолд гарах дүрүүдтэй танилцана уу.*

**Хатагтай Дарсли** - Харригийн нагац эгч.

*Цайвар үстэй, туранхай, жирийн хүнийхээс бараг 2 дахин урт хүзүүтэй, энэ нь хамаг цаг заваа хөршийнхөө хашаа руу шагайж өнгөрүүлэхэд тусдаа байдаг аж. Тэрээр огт дүүгүй мэт дүр эсгэнэ. Тэднийд Поттерийнхэн ирээд хөршүүд нь элдэв юм ярих вий гэхээс жихүүдэс нь хүрч, байж яддаг.*

**Ноён Дарсли** - Өрөмний үйлдвэрийн эзэн, булчинлаг том биетэй, хүзүү гэх юмгүй эр. Харри Поттерийг үзэн яддаг

**Дарслигийн хүү Дадли** - Харригийн үеэл. Бүдүүн том биетэй, Харрид дээрэлхүү, залхуу,

**Рон** - Хогвартс сургуулийн сурагч, Харри Поттерийн найз

**Хермиони** - Хогвартс сургуулийн сурагч, Харри Поттерийн найз

**Дамблдор** - Хогвартс сургуулийн захирал

**Хагрид** - Хогвартс сургуулийн түлхүүр хадгалагч, хагас аварга биет

**Драко Малфой** - Хогвартс сургуулийн сурагч, Харри Поттерийн өшөөтөн

**Профессор МакГонагалл** - Гриффиндор тэнхимийн эрхлэгч, Хогвартсын дэд захирал

**Хэцүү нэрт/Волдеморт** - Зохиолын гол эсрэг дүр



Унших чадвараа хөгжүүлэе

**ХАРРИ ПОТТЕР**

“Хогвартс” ид шидийн ухааны сургуулийн тухай хэзээ ч сонсож байгаагүй Харри Поттер Улаан төгөлийн гудамжны дөрвөн тоотод амьдардаг байв. Нэг өдөр түүнд шаргалдуу цаасан дээр ногоон бэхээр бичиж, улаан лац дарсан захидал ирлээ. Гэтэл нагац ах эгч хоёр нь тэр даруй хураагаад авчихжээ. Удалгүй Харригийн 11 насны төрсөн өдрөөр Рубеус Хагрид хэмээх цох шиг гялалзсан хар нүдтэй аварга биетэн ирж, гэнэтийн гайхалтай мэдээ дуулгана. Харри Поттерыг шидтэн гээд түүнийг “ХОГВАРТС” ИД ШИДИЙН СУРГУУЛЬД элсэхийг урьжээ. Гайхамшигт адал явдал эхэллээ.



## Нэгдүгээр бүлэг. Амьд үлдсэн хүү

Нэгэн дүнсгэр саарал өглөө эхнэр нөхөр Дарсли нар цонхны цаагуур том хүрэн ууль далавчаа дэвсээр нисэж өнгөрөхийг анзаарсангүй. Дарсли ажилдаа явах, буцах замдаа гудамжны буланд суугаад газрын зураг болон Улаан төгөлийн гудамж гэснийг уншиж буй муур, маргад ногоон өнгийн хачирхалтай жанч өмссөн ахимаг насны хүмүүсийг гайхан, толгойгоо сэгсрэн өнгөрлөө. Тэдний ярианаас “Тийм, энэ бол Поттерынхон. Тийм ээ тэдний хүү Харри” гэж хэлснийг сонсоод хөшиж орхив. Ноён Дарсли унтаж чадалгүй хэсэг хөрвөөгөөд, ууль шувуу үзэгдсэн тухай мэдээлэл, өнөөдрийн харсан сонссон зүйлийн тухай эргэцүүлсээр “Энэ бүхэн Поттерынхонтой холбоотой байсан ч тэдэнд ийшээ ирэх шалтгаан үгүй шүү дээ” гэж сэтгэлээ тайвшрууллаа. Тэр үнэхээр том эндүүрчээ.



Ноён Дарсли ийнхүү тухгүйхэн нойронд автах зуур гадаа хашаан дээр суух муур хөшөө шиг хөдөлгөөнгүй суугаад гудамжны үзүүр өөд нүд цавчилгүй ширтэнэ. Шөнө дундын үед муурын харах зүгт газраас ургаад ирэв үү гэлтэй нэгэн дүрс чимээгүйхэн тодорно. Өндөр туранхай Альбус Дамблдор гэгч энэ хүн бүсэндээ хавчуулчхаж

болмоор урт мөнгөлөг үстэй, газар шүргэм урт хормойтой хөх ягаан жанч, өндөр өсгийтэй гархитай гуталтай аж. Тэрээр халааснаасаа мөнгөлөг өнгийн асаагуур гарган тагийг сөхөн товшиход гудамжны гэрэл унтрав. Ахин дахин товшиход дараа дараагийн гэрэл унтарч, харанхуй боллоо. Судалтай муурын зүг “Тантай энд тааралдана гэж бодсонгүй, профессор МакГонагалл” гэж хэлээд муур луу хартал өнөөх нь алга, харин жанч өмссөн, ширүүн төрхтэй эмэгтэй сууж байв. Тэр “Хэцүү нэрт” хэмээх Волдеморт Поттерынхон руу очсон болохыг, Харригийн ээж аав үхсэнийг, гэхдээ Харриг алж чадаагүйн тухай ярилцав. Өнчирсэн Харриг ноён Дарслигийн гэрт авчирч өгөх болсон тухай хэлэхэд профессор Мак Гонагалл “Ингэж болохгүй. Би тэднийг өдөржин ажиглалаа. Бидэнтэй огт адилгүй хүмүүс. Тэд бас нэг хүүтэй. Гудамжинд чихэр авхуулахын тулд ээжийгээ өшиглөж байхыг би харсан” гэж тэр айлд Харриг үлдээхгүй гэж цааргаллаа. Дамблдор тэдэнд захидал өгснөө хэлж, хүүг ноён Дарслинд үлдээхээр боллоо.

- Харри ноён Дарслигийн хэрхэн амьдарч байсныг, дээрлэхүүлсэн ч ямар бодол санаатай байсныг, сургууль дээрээ хэрхэн суралцсаныг, ээж аавыгаа яаж алдсаныг, өөрөө яагаад алдартай болсныг, Дарслигийнх яагаад Харригийн амьдралыг өөрт нь хэлэхгүй нуусныг дэлгэрүүлэн уншаарай.
- Хүүхдүүд та нар энэ зохиолоос тэнгэртэй шууд нийлсэн мэт үзэгдэх дээвэргүй тааз, ямар тэнхим (анги)-д орохыг сонгодог, ярьдаг хар малгай, хөрөг зураг дахь хүмүүс хажуугаар нь өнгөрч буй хүмүүсийн тухай ярих, баасан гарагт ердийнхөөсөө өөр газарт хүргэж өгдөг, эсвэл

дундаасаа алга болж харайхаас өөр аргагүй болгодог шат, зөв газар нь гижигдсэн тохиолдолд онгойдог хаалга, эелдгээр гуйвал онгойдог хаалга, эсвэл хаалга биш хуурамч хана, “Өдөр тутмын зөнч” нэртэй сонин, бүх юм нь хөдөлдөг Хогвартс сургуулийн орчны тухай, ид шидийн яам, захиа зөөдөг ууль шувуу, хуруугаа хүргэнгүүт хайлдаг хаалга, бичихээр өнгө нь хувирдаг бэх, марк шиг жижиг ном, хов хоосон хуудсуудтай ном, газар доорх галт тэрэгний замаас ч доор гүнд байх банкны тухай уншиж гайхамшигт ертөнцөөр аялаарай.

Банкны мөнгөн хаалган дээр

*“Үл таних хүү минь тавтай морил  
Үнэн сэтгэлээсээ тогтоож ав  
Хүний юманд нэг уран шувуу  
Харилг нь хатуу төлөх болно.  
Бусдын юмг авхаар ирсэн хүү  
Булааснаасаа шүр гайд угирна  
Будар сэтгэл агуулагч хэн бүрэн  
Буцалтгүй үүнийг мэдгэрэй”*

гэж бичсэн байна.

Харри тэдний шатны доорх шүүгээнд амьдарч, хүүгийнх нь багадсан хувцсыг өмсөхийн зэрэгцээ эргэн тойронд нь тохиолддог ер бусын зүйлд түүнийг буруутгаж, тайлбарыг нь үнэмшдэггүй байжээ. Нэг удаа духан дээрх муухай сорвийг нь нуух хэрэгтэй гээд туг үс үлдээгээд бараг халзан болоход нь хяргасан аж. Гэвч маргааш нь үс нь ургаад хуучин хэвдээ орсон байж. Үсээ яаж хурдан ургасныг мэдэхгүй гэж тайлбарлаад ч нэмэр болсонгүй, үүнийхээ төлөө долоо хоног шатны доорх шүүгээндээ хоригджээ. Өөр нэг удаа Дадлигийн муухай гэхэд багадмаар хуучин хүрэм өмсгөж, толгойд нь углахыг хичээх тусам хүрэм улам бүр агшсаар, эцэст нь хуруун хүүхэлдэйд таарахаар болжээ. Халуун усаар угааснаас боллоо гэж үзсэн учраас Харриг шийтгээгүй өнгөрсөн аж.

Харри сургууль дээрээ ч нагацын хүү Дадлигийн найз нарын “Харрийг агнах” тоглоомын эзэн болсоор сургуулиа төгслөө. Харригаас бусад нь хувийн сайн сургуульд суралцахаар болжээ. Түүнийг ахлах сургуульд ороход нь хамаатны эгч нь Дадлигийн хуучин хувцсыг хачин муухай үнэртэй усанд саарал өнгө оруулж, сургуулийн дүрэмт хувцастай болгожээ. Харри өнгө гарна гэдэгт эргэлзсэн ч маргахгүй байсан нь дээр, хөгшин зааны шир өмссөн юм шиг л харагдах байлгүй гэж бодоод өнгөрчээ. Тэгтэл тэднийд

*“Нойн Харри Поттер  
Шатны доорх шүрээ  
Улаан төгөлийн гудамж, 4 тоот  
Литтл Уинглин хөт, Суррей”*

гэсэн зузаан, хүнд, шаргалдуу илгэн цаасан дугтуйн дээр маргад ногоон өнгийн бэхээр хаягласан захидал ирлээ. Харригийн гар чичирсээр дугтуйг эргүүлтэл улаан лацаар лацадсан байв. Лацан дээр том “Х” үсгийг тойруулан арслан, бүргэд,

дорго, могой дүрсэлсэн сүлд харагдлаа. Харри захидлаа дэлгэн унших гэтэл Вернон ах шүүрч уншиж эхлэнгүүт гэрлэн дохионы өнгө солигдохоос ч хурдан час улайснаа ногоон болж, эгч Петуниа эхний мөрийг уншингуут ухаан алдаж унах нь уу гэмээр болж, хоолойгоо барин хүчлэн амьсгаадах нь тэр. Харрид 12, 24 удаа захидал илгээсэн ч захидлыг түүнд өгөхгүйн тулд муу арга сэдсээр байлаа. Тэгтэл гал зуухны яндангаар 30, 40 орчим захидал бууны сум шиг шунгинан ороод ирэх нь тэр. Дахин дахин ирэх захидал Харрид оччих вий гэсэндээ гэрээсээ хаа хүрэх нь тодорхойгүй зугтаж зочид буудалд хоносон ч 100 захидал Харрид ирсэн байв. Тэд арга ядан хотоос дайжин хүнгүй газар нэгэн байшин олж суурьшсан ч Хагряд хэмээх аварга биет ирж, Харрид ээж аавынх нь тухай, өөрийнх нь тухай ярьж өгөв. Эцэг эх нь сайн хүмүүс байсныг мэдсэн Харри ид шидтэний сургуульд элсэн суралцахаар болов.

### Арван хоёрдугаар бүлэг. Хүслийн толь

Зул сарын баяр дөхжээ.

Харри зул сараар Улаан Төгөлийн гудамж руугаа буцахгүй гэдэг нь ч үнэн л дээ. Долоо хоногийн өмнө профессор МакГонагалл амралтаараа сургуульд үлдэх сурагчдын нэрсийг бичиж авах үед Харри нэрээ өгчээ. Тэр үүндээ харамсаагүйгээр барахгүй энэ түүний амьдралд тохиолдох хамгийн сайхан зул сарын баяр болно гэдэгт эргэлзсэнгүй. Тэгээд ч Рон ах нартайгаа цуг үлдэхээр болжээ.

Профессор МакГонагалл, профессор Флитвик хоёр танхимыг зул сарын баярын гоёлоор чимэглэж байх аж.

- За алив Хагрид, сүүлчийн мод шүү. Тэр буланд тавьчих.

Танхим ер бусын гоёмсог болжээ. Ханын дагуу улаан жимсгэнэ бүхий мөчир, цаасан цэцгийн хэлхээ унжуулж, гялалзсан цагаан хяруу, хэдэн мянган лаагаар чимэглэсэн зул сарын арван хоёр том гацуур танхимд сүндэрлэнэ.

- Та нар хэд хоногийн дараа амрах билээ? гэж Хагрид асуув.

- Маргааш. Нээрэн тийм, Харри, Рон хоёр оо, цөмөөрөө үдийн хоолноос хагас цагийн өмнө номын санд очих ёстой юм байна шүү гэж Хермиони хэлэв.

- Тийм ээ, тэгэлгүй яах вэ гэж Рон хариуллаа.

Тэр саваанаасаа алтан бөмбөлөг гарган шинээр авчирсан гацуур модны мөчрийг чимэглэж буй профессор Флитвикээс нүд салгаж ядна.

- Номын сан гэнэ ээ? Амралт болох гэж байхад уу? Та нар хичээлдээ арай л хэтэрхий дуртай юм аа гэж Хагрид тэднийг даган танхимаас гарахдаа хэлэв.

- Бид хичээл хийх гээгүй. Таныг Никола Фламельын тухай дурссан цагаас хойш бид түүний тухай олж мэдэхийг хичээж байна гэж Харри хэллээ.



- Юу гэнэ ээ? Намайг сонс. Би та нарт үүнийг орхи гэж хэлсэн биз дээ. Нохойн юу хамгаалж байгаа нь та нарт хамаагүй гэж Хагрид цочирдон дуу алдав.

- Бид зөвхөн Николас Фламель гэж хэн болохыг мэдэх гэсэн юм. Ердөө л тэр гэж Хермиони хэлжээ.



- Та бидэнд хэлээд өгөх юм биш биз дээ? Бид олон зуун ном шүүж үзсэн ч олоогүй л байна. Зүгээр л хэлээд өгөөч. Би энэ нэрийг хаа нэгтээ харснаа санаад байгаа юм гэж Харри хэллээ.

- Би юу ч хэлэхгүй гэж Хагрид эрс шийдэмгий өгүүлэв.

- За, тэгвэл өөрсдөө л эрж олохоос доо гэж Рон хэлээд, бухимдангуй байгаа Хагридыг орхин номын сан руу яарцгаалаа.

Тэд үнэхээр Хагрид Фламельын нэрийг хэлсэн цагаас хойш олон номоос эрж үзлээ. Снейпийн юу хулгайлах гэснийг өөрөөр яаж мэдэх билээ дээ. Асуудлын гол нь Фламель номд дурдагдахаар ямар үйл бүтээснийг мэдэхгүй тул хаанаас эхлэхээ мэдэхгүй байлаа. Түүний нэр «Хорьдугаар зууны агуу шидтэнүүд», «Манай цаг үеийн алдарт шидэт нэрс» номд байсангүй. «Орчин үеийн ид шидийн хөгжил судлал», «Ид шидийн сүүлийн үеийн нээлтүүд» номд ч алга. Өөр нэг асуудал нь номын сан ном эгнүүлэн өрсөн олон мянган тавиур бүхий хэдэн зуун нарийхан эгнээтэй тул хэр баргийн номыг олоход бэрх аж.

Хермиони үзэх номынхоо жагсаалтыг гаргасан бол Рон эгнээний дагуу явж тавиураас таамгаар ном шүүрэн авч, хуудсыг нь сөхөн эргүүлэхийг илүүд үзжээ. Харин Харри Хориотой хэсэг рүү зүглэв. Фламель энгийн хэсэгт байхгүй бол тэнд л байх магадлалтай. Харамсалтай нь, номын сангийн Хориотой хэсгээс ном авахад багшийн гарын үсэг шаарддаг болохоор энэ бүтэшгүй ажил билээ. Тэнд хүчтэй хар шидийн тухай номууд хадгалагддаг учир зөвхөн хар шидээр гүнзгийрэх гэж буй дээд ангийн сурагчид л авч уншихыг зөвшөөрнө.

- Хүү минь, чи юу хайгаа вэ?

- Юу ч биш ээ гэж Харри хэллээ.

Харригийн өмнө тоосны өдөн гөвүүр барьсан номын санч хатагтай Пинс зогсож байв.

- Эндээс явсан чинь дээр шүү. Алив гар!

Харри тэр даруй ямар нэг худлаа юм зохиогоод хэлж чадаагүйдээ харамсан номын сангаас гарахаар явлаа. Рон, Хермиони, Харри гурав Фламельын тухай хатагтай Пинсээс асуухгүй гэж хэдийн тохиролцжээ. Хатагтай Пинс энэ тухай мэдэж байж болох ч тэд юу хийж байгаагаа Снейпэд мэдэгдчих эрсдэлтэй.

Харри номын сангийн хонгилд зогсоод нөгөө хоёрыгоо хүлээнэ. Ер ямар ч найдлага төрөхгүй ажээ. Тэд арван дөрөв хоногийн турш эрж хайсан ч гэлээ зөвхөн хичээл хоорондын завсарлагаанаар л зав зай гарах учир өнөөг хүртэл юу ч олоогүйд нь гайхах явдалгүй. Хамгийн гол нь тэд хатагтай Пинсийг эзгүй үед номын сангаар сайтар эрэл хайгуул хийх хэрэгтэй байлаа.

Таван хормын дараа Рон, Хермиони хоёр толгойгоо сэгсэрсээр гарч ирэв. Тэд үдийн хоолонд орохоор явлаа.

- Та нар намайг явсан хойно үргэлжлүүлэн хайна биз дээ? Хэрэв олох юм бол над руу ууль явуулаарай гэж Хермиони найдангуй хэлэв.

Харин чи эцэг эхээсээ Фламелийн тухай асууж болно шүү дээ. Эцэг эхээсээ асуухад ямар ч аюулгүй гэж Рон санал болгов.

- Тэд хоёулаа шүдний эмч юм чинь бүр ямар ч аюулгүй л дээ хэмээн Хермиони доогтой хэлжээ.

Амралт эхлэхэд Рон, Харри хоёр Фламелийн тухай бодох завдалгүй цагийг зугаатай өнгөрүүлж байв. Тэд унтлагынхаа өрөөнд хоёулхнаа үлджээ, хичээлтэй үеийг бодвол нийтийн өрөөнд ч хүн цөөн болсон тул галын өмнөх сандал дээр

тухлан сууна. Зууханд зүсэм талх, бин, зефир зэрэг юу олсноо төмөр шоронд сүлбээд галд шаран хэдэн цагийн турш амтархан иднэ. Ингэж суух зуураа Малфойг сургуулиас хөөлгөх олон арван арга, төлөвлөгөө зохиожээ. Үүний бүтэх эсэх хамаагүй, хамгийн гол нь энэ тухай ярихад хөгжилтэй байлаа. Үүний зэрэгцээ Рон, Харрид шидэт шатар зааж өгчээ. Маглуудын шатартай адилгүй нь, шатрын дүрсүүд амьд агаад тоглогч нь тулалдаанд цэргүүдээ удирддаг жанжинтай адил үүрэг гүйцэтгэнэ. Рон шатрын дүрсүүдээ сайн мэдэх тул тэднээр хүссэн зүйлээ ядах юмгүй хийлгэж дөнгөнө.

Харин Симусээс түр зээлсэн шатрын дүрсүүд нь Харрид нэг л итгэхгүй байв. Тэр өөрөө ч шатар сайн тоглодоггүй тул дүрсүүд түүний нүүдлийг эсэргүүцэж “Намайг тийш нь битгий явуул. Морь байгааг харахгүй байна уу? Харин түүнийг явуул. Бидэнд түүнийг алдахад гарзгүй” гэх мэтээр зөвлөгөө өгнө.

Зул сарын өмнөх өдөр Харри орондоо орохдоо “Маргааш сайхан хоол унд идэж хөгжилдөнө дөө” гэж бодсон ч бэлэг сэлт ер хүлээсэнгүй. Гэвч маргааш нь өглөө эрт сэрээд хамгийн түрүүнд харсан зүйл нь орны хөлд овоолсон багахан бэлэг сэлт байлаа.

- Зул сарын мэнд гэж Рон Харрийг орноосоо босон нөмрөгөө углах зуур нь нойрмогоор хэлэв.

- Чамд ч гэсэн баярын мэнд. Үүнийг хараач. Надад бэлэг ирсэн байна гэж Харри хашхирлаа.

- Бэлэг ирэлгүй яах юм бэ? Ямар манжин ирэлтэй биш гэж Рон наргин хэлээд өөрийнх рүүгээ харлаа. Түүний бэлэг Харригийнхаас хавьгүй их ажээ.

Харри хамгийн дээд талын боодолтой зүйлийг авч задлав. Бэлэг ороосон зузаан бор цаасан дээр “Хагридаас Харрид” гэж бичжээ. Дотроос нь өөрөө хийсэн боллолтой, болхидуу хийцтэй модон лимбэ гарчээ. Харри үүнийг үлээвэл уультай адил авиа гарчээ.

Хоёр дахь жижигхэн бэлэг дотор нэгэн зурвас байв.

*Бид чиний мэндчилгээг авсан.  
Чамд зул сарын бэлэг явууллаа.  
Вернон ах, Петунна эгч хоёроос нь  
Зурваст тавьтмын зоос наажээ.*

“Хагридаас бэлэг ирсэн, нагац ах, эгч хоёроос ч бэлэг ирсэн, өөр хэн надад бэлэг явуулдаг байна аа?” гэв. Хэн гэдгийг нь би мэдэх байх” гэж Рон улайсхийн хэлээд, боодолтой бэлэг рүү зааж: -Ээж маань. Чамд бэлэг явуулах хүн байхгүй гэж би ээждээ хэлчихсэн юм. Өө, үгүй ээ, ээж чамд манай гэр бүлийн цамц нэхчихэж гэв. Харри бэлгийг задалтал гараар нэхсэн маргад ногоон өнгийн ноосон цамц, том хайрцагтай гэрийн амттан гарлаа.

- Ээж маань жил болгон бидэнд цамц нэхэж өгдөг юм. Надад үргэлж интоорын өнгө оногддог гэж Рон хэлэв.

- Ээж чинь үнэхээр сайн хүн юм гэж Харри хэлээд бурмаас идэв. Үнэхээр сайхан амттай ажээ.

Түүний дараагийн бэлгээс ч амттан гарав. Хермиони түүнд том хайрцагтай шоколадан мэлхий явуулжээ. Одоо зөвхөн ганц боодол үлдлээ. Харри бэлгийг



автал маш хөнгөн байв. Дотроос намирсан мөнгөлөг саарал зүйл шалан дээр хуниралдан унав. Рон дуу алдаж, янз бүрийн амттай үрлэн чихрээ газар унагаав.

- Энэ миний бодож байгаа зүйл бол маш ховор үнэ цэнтэй юм байх ёстой.

- Юу юм бэ? гээд шалан дээрээс авч хүрэхэд нэг л хачин, усаар нэхсэн мэт санагдав.

- Далдын хар нөмрөг байна. Өмсөөд үз дээ гэж Рон биширсэн дуугаар хэлэв. Харри нөмрөгийг мөрөн дээгүүрээ нөмрөхөд Рон дуу алдлаа.

- Тийм байна! Доошоо хараач!

Харри доошоо харлаа. Хөл нь үзэгдэхээ больжээ. Тэр толь руу ухасхийлээ. Толинд тусгал нь харагдах нь ч харагдаж байна аа. Гэхдээ бие нь үзэгдэхээ больж, ердөө толгой нь агаарт хөвөх юм санж. Далдын нөмрөгийг толгой дээгүүрээ нөмрөхөд бие нь тэр чигээрээ үзэгдэхээ болилоо.

- Энд нэг зурвас байна. дотроос нь уначхаж гэж Рон гэнэтхэн хэллээ. Зурвасыг угалзарсан гоёмсог бичгээр дараах мөрийг бичжээ.

*Аав чинь нас барахаасаа өмнө үүнийг надад үлдээсэн юм. Одоо хүүг нь буцааж өгөх цаг нь болжээ. Ухаалгаар амиллаарай. Зул сарын мэнд хүргэе.*

Захидалд гарын үсэг байсангүй. Харрид нэг л хачин санагджээ. Тэгэхэд Рон энэ нөмрөгийн төлөө байгаа бүхнээ өгмөөр санагдана.

Харри амьдралдаа ийм сайхан зул сарын бэлэг авч, оройн зоог харж байсангүй. Ширээн дээр цацагт хяруулын шарсан мах, уул шиг овоолсон чанасан, шарсан төмс, тавагтай зайдас, цөцгийтэй вандуй, сүмсээр амталсан мах, цангис жимсний өтгөн сүмс эгнүүлжээ. Шидэт цаасан буунууд хаа сайгүй харагдана. Нагац ахынх нь авдаг цаасан буутай адилгүй аж. Шидэт цаасан бууг буудуулахад “пан” гэхийн оронд их буу шиг нүргэлэн, өтгөн хөх утаа суунаглуулснаа усан цэргийн даргын малгай, хэд хэдэн амьд цагаан хулгана гаргаж байлаа. Харри цаасан буунаас гарсан тоглоом болох хагардаггүй гэрэлтдэг бөмбөг, өөртөө үү ургуулагч, шинэ шидэт шатар барьсан байлаа.

Энэ бол Харригийн амьдралд тохиолдсон хамгийн сайхан баяр байлаа. Гэсэн ч өдрийн турш нэг юм мартсан юм шиг санагдаад болдоггүй. Орондоо орсон хойно далдын хар нөмрөг болон түүнийг илгээсэн хүн сэтгэлийг нь зовоогоод байсныг ойлголоо. Нөмрөг түүний эцгийнх... торго шиг зөөлөн, агаар шиг хөнгөн нөмрөгийг барингаа бодов. Дахин туршиж үзэхээр шийдэж, орноосоо босон өмсөв. “Ухаалаг ашиглаарай” гэснийг саналаа. Харрид гэнэтхэн санаа төрөв. Энэ нөмрөгтэй байгаа цагт Хогвартсын бүх хаалга түүнд нээлттэй. Харанхуйд чимээгүй зогсох зуур баяр хөөр түүнийг нөмрөн авлаа. Тэр хүссэн газар луугаа хаашаа ч хамаагүй явж болно шүү дээ.

Энэ удаа Роныг сэрээлгүй ганцаар туршихаар шийдэв. Тэрээр унтлагын өрөөнөөс гараад шат уруудан хөргөн нүхээр гарлаа. Нэгэн тарган хатагтайн зурагтай, байнга өөрчлөгддөг нууц үг хэлж байж ордог хаалгаар гарах үед “Энд хэн байна?” гэж Тарган хатагтай асуув. Харри юу ч хэлсэнгүй цааш явах үед Тарган хатагтай юу ч харагдаагүйд гайхаж байв. Харри хаашаа явахаа мэдэхгүй түр зогсон бодолхийлэхэд зүрх нь хурдан цохилж байлаа. Тэгтэл нэг санаа орж ирлээ. Номын сангийн “Хориотой хэсэг”. Тэрээр хүссэн хугацаагаараа ном эргүүлж Фламелийг хайж болох шүү дээ. Номын санд нүх шиг харанхуй, аймшигтай

байв. Дэнлүү асаан гартаа бариад явтал агаарт хөвж байгаа мэт харагдана. Харри түүнийг гартаа барьж яваагаа мэдэх ч агаараар яваа дэнлүү түүнд нэг л эвгүй аймшигтай санагдана. Хориотой хэсгийн номын нэрийг унших гэтэл алтан үсгээр бичсэн, ховхорч унах шахсан нэрийг мэдэхгүй хэл дээр бичжээ. Зарим нь хавтсан дээрээ ямар ч бичиггүй. Нэг ном цусанд будагдсан гэмээр бараан толботой. Номууд танихгүй хүн орж ирсэнд дургүйцэн хоорондоо шивнэлдэх мэт санагдана. Мөнгөн үсэгтэй том хар ботийг аваад нээтэл ном хашхирч байлаа. Хаасан боловч өнөөх дуу намдсангүй. Харри сандран дэнлүүгээ гараар цохин унагахад хаалган дээр хөлийн чимээ сонсогдоход айсандаа номоо байранд тавиад зугтаалаа. Хаашаа зугтааж байгаагаа мэдсэнгүй. Нэгэн давчуу хонгилд хөөж байгаа хүмүүстэй мөргөлдөх нь тодорхой болов. Далдын нөмрөг түүнийг харагдуулахгүй ч биегүй болгохгүй шүү дээ.

Харри ухарсаар онгорхой хаалга таарангуут орж, өнөө хоёроос нэг салж амарлаа. Ашиглагдаагүй удсан өрөө бололтой, ширээ сандал хураасан, хогийн сав хөмөрсөн байдалтай харагдана. Хананд алтан хээ угалзтай хүрээ, тааз тулам өндөр, гайхамшигтай сайхан толь байв. Хүрээний дээд талд “АН ЛУУР АХЬ НИЧ ГЙИЛ СҮХ ШИБЬ НИЧ ГЙ АРАЦ ДМА ЧИБ” гэсэн бичиг сийлжээ. Толь руу дөхөн очив. Тэгснээ хашхирахгүйн тулд амаа барив. Учир нь толинд зөвхөн өөрийгөө төдийгүй ард нь зогсох өөр хүмүүсийг ч харлаа. Гэвч өрөө хоосон аж. Харри оволзон амьсгаадсаар толь руу буцаж алгуурхан эргэлээ.

Толинд түүний айж цонхийсон дүрснээс гадна арваад хүний дүрс үзэгдэнэ. Ард нь зогссон эмэгтэй инээмсэглэн түүн рүү гар даллана. Харри арагш гараа явуулж үзэхэд хоосон байв.

Эмэгтэй маш царайлаг ажээ. Хар хүрэн үстэй, нүд нь ... “Нүд нь минийхтэй адил юм” гэж Харри бодоод бага зэрэг толь руу ойртов. Бүсгүйн нүдний өнгө, хэлбэр дүрс нь Харригийнхтай усны дусал шиг адилхан агаад эмэгтэй уйлж байхыг анзаарлаа. Эмэгтэйн царайд баяр гуниг сүлэлдэн байх аж. Түүний дэргэд хар үстэй, өндөр, туранхай эрэгтэй мөрөн дээр нь гараа тавин зогсжээ. Эрэгтэй нүдний шилтэй, үс нь ч Харригийнх шиг арзгар юм.

Харри толинд хамраа тулах шахам ойртов. Тэгснээ бүгдийг ойлгож:

-Ээж ээ? Аав аа? гэж шивнэлээ. Харри анх удаа гэр бүлийнхнээ харжээ. Поттерийнхон инээмсэглэн өөдөөс нь гар даллахад тэрээр шилийг нэвтлэн тэдэнд хүрэх гэсэн мэт гараараа толин дээр даржээ. Хөлгүй их баяр хөөр, тэсэшгүй уйтгар гуниг зэрэгцэж, сэтгэл нь шимшрэн урагдах шиг боллоо. Гадаа чимээ гарах үед Харри ээжээсээ харцаа салган, “Би буцаж ирнээ” гэж шивнээд өрөөнөөс яаран гарлаа.

- Чи намайг сэрээчихгүй дээ, би чиний ээж аавыг хармаар л байна шүү дээ гэж Рон сэтгэл дундуур хэлэв.

- Чи өнөө шөнө надтай хамт явж болноо. Харин би танай гэр бүлийнхнийг ч гэсэн харъя гэв.

Харри Рон хоёр нөмрөгөө хуваалцаж өмсөөд тольтой өрөө чиглэн явлаа. Өрөөнд орж Харри дахиад ээж аавтайгаа уулзав. Рон харин толинд Харригаас өөр хэнийг ч харсангүй. “Анхааралтай хар, миний оронд зогс” гэж байраа солин зогсоход Рон ихэд гайхан “Намайг хараач” гэж хэллээ. Гэр бүлийнхэн чинь чамайг тойроод зогсож байна уу” гэж Харриг асуухад “Үгүй ээ, би ганцаараа байна. Гэхдээ би өөр болчхож... Одоогийнхоосоо хөгшин... Сургуулийн тэргүүний сурагч болчхож!” гэв.

- Юу гэнэ ээ? гэж Харри гайхан асуулаа.

Маргааш нь Харри тольтой өрөө лүү дахин явах хүсэл төрсөөр. Хүсэлдээ автан шөнөжин ээж аавтайгаа байхаар шийдэн өрөөнд орон толины өмнө шалан дээр суух агшинд ард нь хэн нэгэн "Харри, чи ахиад л энд байна уу? гэв. Альбус Дамблдор аж.

- Би яарсандаа анзаарсангүй гэхэд Дамблдор:

- Хүн үл үзэгддэг болчихоороо баргийн юмыг анзаарахаа больчихдог нь хачирхалтай шүү гээд

- Тэгэхээр чи өөрөөсөө өмнөх хэдэн зуун хүний адил "Хүслийн толь"-ны сэтгэл татам гайхам шидийг мэджээ дээ? гэв.

- Би энэ толийг тэгж нэрлэдгийг мэдсэнгүй, эрхэм ээ. Энэ толь миний гэр бүлийг харуулдаг.

- Рон сургуулийн тэргүүний эрэгтэй сурагч болсон шүү дээ Дамблдор хэлэхэд

- Та яаж мэдэв ээ? гэж Харри гайхан асуув.

- Надад үл үзэгдэгч болоход нөмрөг хэрэггүй. Чи хүслийн толийг юу үзүүлдэг гэж бодож байна? хэмээн Дамблдор аядуухан асуухад, Харри толгой сэгсрэв.

- За, би тайллыг хэлж өгье. Энэ дэлхий дээрх хамгийн жаргалтай хүн л Хүслийн толийг ердийн толь шиг ашиглаж чадна. Өөрөөр хэлбэл тэр толинд өөрийгөө байгаагаар нь л харна. Одоо ойлгож байна уу? Харри бодлогоширсноо удаанаар:

- Толь бидэнд... хүссэн зүйлийг маань үзүүлдэг байх нь ээ гэлээ.

- Тийм ч байж болно, үгүй ч байж болно. Толь бидэнд илүү ч үгүй, дутуу ч үгүй сэтгэл зүрхний маань гүн дэх далд хүслийг үзүүлдэг юм. Гэр бүлийнхээ хэзээ ч харж байгаагүй чиний хувьд тэднээрээ хүрээлүүлэн зогсож байгаагаар харсан. Харин дандаа л ах нарынхаа сүүдэрт дарагдаж байсан Рон өөрийгөө тэднээс бүгдээс нь илүү болсноо харсан. Гэвч толь бидэнд мэдлэг өгч, үнэнийг өгүүлдэггүй юм. Толийг маргааш өөр газар шилжүүлнэ. Дахин битгий хайгаарай. Зүүд мөрөөдөлдөө умбаж, бодит байдлыг мартаж хэрэггүй шүү. Үүнийг санаж яваарай.

Харри босож зогсон:

- Танаас би юм асууж болох уу? Та толинд юу олж хардаг вэ?

- Би юу? Би өөрийгөө гартаа зузаан ноосон оймс барьснаар олж хардаг. Харри гайхан харлаа.

- Хүнд оймс хэзээ ч илүүдэхгүй. Ахин нэг зул сар өнгөрч байхад би ганц ч хос оймс авсангүй. Хүмүүс надад яагаад ном бэлэглэдэг юм бол бүү мэд...

*(хэсэглэн авав)*

*(Харри Поттер ба философийн чулуу. Ж.К.Роулин.орч Н.Энхнаран.*

*Монсудар хэвлэлийн газар. 2017 он)*




Унших чадвараа хөгжүүлье

Зохиолын утгыг мэдэрч, ойлгосноо харуулах

1. Хүүхдүүд ээ, ид шидийн сургуульд сурдаг Харри Поттерын тухай кино үзсэн үү? Үзээд ямар сэтгэгдэлтэй байсан бэ?
2. Харри ямар айлд өссөн бэ? Бага насны амьдралын тухай уншаад түүнийг өрөвдсөн үү? Яагаад?

3. “Шүүгээн дотор өглөө болгон сэрэхдээ аалзыг хардаг” гэж бичсэн байдаг. “Нугасны муухай дэгдээхий” зохиолын утга санаатай төстэй байна уу?
4. Зохиолын ямар ямар хэсгүүд гайхширлыг чинь төрүүлж байна вэ? Бодит амьдралд байдаг болов уу?
5. Харригийн тухай уншаад түүнийг ямар хүүхэд гэж бодсон бэ? Тольтой өрөөн дэх хэсгийг уншаад айсан уу? Эсвэл Харритай адил бодолтой байсан уу?
6. Хэрвээ чи хүслийн толь руу харсан бол юу харагдах байсан бол?
7. Хогвартсын сургуулийн тухай олж мэдсэнээ ярилцаарай. Тэр сургууль 4 тэнхимтэй. Хуваарилагч бүрх малгай чамайг аль тэнхимд хуваарилах байсан бол? Төсөөлөөрэй.



8. Хэрвээ чи ид шидийн сургуульд сурахаар бол яаж суралцах байсан бэ? Хэнтэй нь илүү найз байх байсан бэ?

**Үйл явдлын уялдаа холбоо нь эхийн утгад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлая.**

1. Энэ зохиолыг бүрэн эхээр нь уншиж, үйл явдлын уялдаа холбоог тодруулаарай.
2. “Хүслийн толь” хэмээх 12-р бүлгийн үйл явдлын дарааллыг тодруулж гүйцээгээрэй.

1. Зул сарын бэлтгэл ба Харригийн бодол
2. Номын сан дахь хүүхдүүдийн эрэл
3. ....
4. ....
5. ....



3. Дээрх үйл явдал тус бүрд зохиолч ямар утгыг тодруулж бичсэн бол? Дахин уншин ярилцаарай.
4. Дээрх хэсгийн төгсгөл дэх Дамблдор Харри хоёрын харилцан яриаг дахин уншаад, толины талаарх сэтгэгдлээ илэрхийлнэ үү.

**Дүрийн зан төрх, бодол санаа, үйлдэл, үг яриаг тодорхойлъё**

1. Хамгийн тусархаг дүр хэн бэ? Найзынхаа төлөө юу хийсэн бэ?
2. Роны ээжийн дүр та нарт таалагдсан уу? Яагаад?
3. Харри Поттерын зан чанарыг тодруулсан хэсгийг зохиолоос олж батлаарай.

Харри Поттерын зан чанар	Энэ зан чанар нь зохиолын аль хэсэгт илэрсэн бэ? Жишээ татна уу.
Алив юмны учрыг олох гэсэн эрмэлзэлтэй	
Найзыгаа хүндэлдэг	
Сурагч та өөрөө тодорхойлж болно.	
.....	

4. Харри Поттер ганцаардсан уу? Тийм бол яаж мэдэв?
5. Номын санд Рон, Харри, Хермиони нарын ялгаатай зан чанарыг үзүүлсэн хэсэг бий. Түүнийг олж уншаад, зан чанарын ялгаатай талыг тодорхойлоорой.
6. Зохиол дахь дүрүүдээс хэний ямар зан чанараас суралцмаар байна вэ? Өөрийн зан чанартай харьцуулан суралцсан зүйлээ тоочин бичнэ үү.

**Орчин, нөхцөл байдлыг тайлбарлая**

1. Зохиолд гарч байгаа үйл явдлын дарааллыг зурахдаа орчныг тодруулаарай.
2. Хэрвээ зохиолд далдын нөмрөг, тольтой өрөөний тухай бичээгүй байсан бол ямар утга гарахгүй байсан бэ?

**Зохиолын далд утгыг тайлбарлая**

1. Өөрийн хүчээр биш ямар нэг эд зүйлийн юм уу эсвэл бусдын хүчээр амьдардаг хүн байдаг уу? Тийм хүн байдаг бол Дамблдорын “Хүн үл үзэгддэг болчхоороо баргийн юмыг анзаарахаа больчихдог нь хачирхалтай шүү” гэж хэлсэн шиг бусдыгаа, өөрийгөө анзаарахаа больдог болов уу? Та нар юу гэж бодож байна?
2. Дээрх хэсгийн төгсгөл дэх Дамблдор Харри хоёрын харилцан ярианаас “Хүн байгаа бүхэндээ сэтгэл хангалуун байх” тухай ярилцсан гэдэгтэй санал нийлж байна уу? Дараах сэтгэгдлийг уншаад саналаа солилцоорой.

Харри ээж ааваа хараад, өөрт нь байгаагүй амьдралаараа амьдрах гэж өөрөөр хэлбэл үргэлж толинд ээж, аавыгаа харж сэтгэл хангалуун байхыг хүсдэг болсон байдаг. Тийм ч учраас найз нараа тоохгүй, Хагрид дээр очихыг ч хүсэхгүй, гурван толгойтын нууж байгаа зүйлийг ч хайхрахаа больсон байдаг. Энэ л үед нь Дамблдор “Гэвч толь бидэнд мэдлэг өгч, үнэнийг өгүүлдэггүй юм. Толийг маргааш өөр газар шилжүүлнэ. Дахин битгий хайгаарай. Зүүд мөрөөдөлдөө умбаж, бодит байдлыг мартаж хэрэггүй шүү. Үүнийг санаж яваарай” гэж хэлдэг. Тийм ч байж болох байсан гэсэн харамсал үргэлж тээхгүйгээр, ээж аавтайгаа ч байсан бол гэж бодохгүйгээр бодит байдлаа хүлээн зөвшөөрч, тэмцэж амьдрах ёстой юм байна гэсэн санааг энэ хэсэг агуулж байна.



**ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ**

1. Зөв тохируулаарай
  2. Ү Чэнь-энийн                      a. Харри Поттер
  3. Кавабата Ясүнари                b. Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл
  4. Эрнест Хэмингуэй                c. Өвгөн тэнгис хоёр
  5. Ж.К.Роулин                         d. Ангийн даргын мөрдлөг
2. Дүрүүдийн үнэт зүйл нь юу байв? Харьцуулна уу.

Дүрүүд	Үнэт зүйл
Сүн Үкүнь	
Тансан лам	
Сэйчи	
Сантьяго өвгөн	
Харри Поттер	
Дүгнэлт	

3. Уншсан зохиолоос аль нэгийг сонгоод өгүүлэгдэхүүний бүтцийг тодорхойлоод үйл явдлын холбоо хамаарлыг дүрийн үйлдлээр баталж тайлбарлаарай.

Өгүүлэгдэхүүний бүтэц	Сонгосон зохиолын нэр ..
Эхлэл	
Зангилаа	
Өрнөл	
Туйл	
Тайлал	
Төгсгөл	

**ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ**

	Маш сайн	Сайн	Сайжруулах шаардлагатай
Эзэмшсэн мэдлэг ойлголтоо асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах ямар ч нөхцөлд хэрэглэдэг.			
Таамаглал (асуудал, асуулт) дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг.			
Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг.			
Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож, дүгнэлт гаргадаг, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс оновчтой илэрхийлдэг.			

## НОМ ЗҮЙ

1. Ахтаан Б. Бүргэд найраглал (Түүвэр зохиол). Б.Бааст монголчлов. УБ., 1957
2. Галбаатар Д. Уран зохиолын нэвтэрхий толь. УБ., 2012
3. Галсан Т. Жирмийн сүлжээ. УБ., 2001
4. Дамдинсүрэн Ц. Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой. (Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган) V боть II дэвтэр. УБ., 2017
5. Дамдинсүрэн Ц. Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой. (Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган) IV боть, I дэвтэр. УБ., 2017
6. Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой. УБ., 1959
7. Дулаан. Монгол хүмүүн шүлгийн түүвэр. ҮХХ., 2004
8. Дулам С. Хонгор нутгийн домог тахилгат газрууд. УБ., 2004
9. Дулам С. Баянхонгорын түүх домгийн чуулган. УБ., 2011
10. Кавабата Ясүнари. Хамар. Япон хэлнээс орчуулсан Ц.Онон. УБ., 2009
11. Монгол аман зохиолын дээж бичиг. УБ., 1978
12. Монгол ардын зан үйлийн аман зохиол. УБ., 1987
13. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. УБ., 1978
14. Монгол ардын үлгэр. ШУАХЗХ. УБ., 198
15. Монгол домог. Эмхэтгэсэн Х.Сампилдэндэв, редактор Д.Цэрэнсодном. ШУА ХЗХ. УБ., 1984
16. Монголын сонгомол яруу найраг. Эмхэтгэсэн Г.Аюурзана нар. УБ., 2008
17. Монголын уран зохиолын дээжис. II боть. УБ., 1994
18. Монголын уран зохиолын дээжис. V боть. УБ., 1995
19. Монголын уран зохиолын дээжис. VIII боть. УБ., 1994
20. Монголын уран зохиолын дээжис. IX боть. УБ., 2005
21. Монголын шилдэг яруу найраг. УБ., 1981
22. Монголын эртний уран зохиолын дээж бичиг-1. Эмхэтгэсэн Б.Энхээ. УБ., 2017
23. Мичин багшийн үлгэр. ӨМАХХ. Хөх хот. 1998
24. Мэнд-Ооёо Г. Оюун санааны хээр тал. УБ., 2016
25. Ринчен Б. "Гүнж", Монголын зохиолчдын хорооны хэвлэл. УБ., 1969 он, 97-105 дахь тал
26. Роулин Ж.К. Харри Поттер ба философийн чулуу. Орчуулсан Н.Энхнаран. Монсудар хэвлэлийн газар. 2017
27. Түмэнбаяр Ц. Дөргөнэ хатны алтан зоос (өгүүллэгүүд). УБ., 2014
28. Хамар (Япон хэлнээс орчуулсан Ц.Онон). УБ., 2009
29. Цоодол Д. Сөгдөж айлтгая (Шүлэг, дууль, найраглал). Тэргүүн дэвтэр. Редакцын зөвлөл Д.Цэдэв нар, "Мөнхийн Үсэг" ХХК. УБ., 2015
30. Цэвэгмид Д. Зохиолууд. УБ., 1974 он, 90-98 дугаар тал
31. Чоймаа Ш. Оюуныг нээгч Оюунтүлхүүр нэрт шастир оршвой. УБ., 2011
32. Эрнест Хэмингуэй. "Өвгөн тэнгис хоёр" тууж. Орчуулсан С.Сандагдорж. УБ., 1962

### Цахим хэрэглэгдэхүүн

1. budda.mn
2. mongolcom.mn
3. touristinfocenter.mn
4. google.com